



МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИ
ЦУВРАЛ II



Боловсролын
Философийн
Тухай
Эргэцүүлэл

БОЛОВСРОЛЫН
ФИЛОСОФИЙН ТУХАЙ
ЭРГЭЦҮҮЛЭЛ

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН



МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИ
ЦУВРАЛ II



БОЛОВСРОЛЫН
ФИЛОСОФИЙН ТУХАЙ
ЭРГЭЦҮҮЛЭЛ

УЛААНБААТАР ХОТ

2024 он



МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИ

Ерөнхий редактор:

Дэндэвийн Бадарч
Миеэжавын Итгэл

Редактор:

Жамбалдоржийн Энхтүвшин
Гомбодоржийн Баярмөнх

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

Гомбодоржийн Баярмөнх

ISBN 978-

Цаасны хэмжээ: 60x108/16

Хэвлэлийн хуудас: 10 хх

ГАРЧИГ

ТАЛАРХАЛ	4
ӨМНӨХ ҮГ	6
НЭГ. МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИЙН АСУУДАЛД	8
1.1 БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ХИЙХ ИХ НҮҮДЭЛ СУУДАЛ	9
1.2 МОНГОЛ СЭТГЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭЛ	13
ХОЁР. ДЭЛХИЙН БОЛОН ЗАРИМ УЛС ОРНЫ БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИ	18
2.1 БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИ	19
2.2 ХЯТАД ХҮНИЙ СЭТГЭЛГЭЭ, СОЁЛЫН ОНЦЛОГ	23
2.3 ЯПОНЫ БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИЙН ТҮҮХ, АСУУДАЛ	27
2.4 ОРОСЫН БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИ	32
ГУРАВ. МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН НОМЛОЛ	34
3.1 ҮНДЭСНИЙ БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИЙН АСУУДЛААРХ ЗАРИМ ЭРГЭЦҮҮЛЭЛ	35
3.2 МОНГОЛ ХҮН ГЭЖ ХЭН БЭ?	39
3.3 МОНГОЛ БИЧИГ ЯЗГУУРААСАА МОНГОЛЧУУДЫН БИЧИГ БОЛОХ ТУХАЙД	43
3.4 БОЛОВСРОЛ БА СЭТГЭХ СОЁЛ.	49
3.5 ЛИБЕРАЛ БУЮУ ШИНЖЛЭХ УХААНЫ БОЛОВСРОЛ	53
3.6 ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ЭРИН ДАХЬ БОЛОВСРОЛ	57
3.7 БОЛОВСРОЛЫГ ЭРГЭН ХАРАХ НЬ	61
ДӨРӨВ. БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ ЗАЛУУ ҮЕИЙНХНИЙ БОДОЛ	66
4.1 БОЛОВСРОЛ БОЛ ЭРХ ЧӨЛӨӨ ГЭДГИЙГ ОЙЛГОСОН	67
4.2 БОЛОВСРОЛ БОЛ НИЙГМЭЭ ИЛҮҮ САЙН САЙХАН БОЛГОХ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА	69
4.3 БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ	70
4.4 БОЛОВСРОЛ БОЛ ХЭЗЭЭ Ч ЗОГСДОГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА	72
4.5 БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭЛ БА ИРЭЭДҮЙН ТААМАГ	73
4.6 БОЛОВСРОЛ ДАХ БАГШИЙН НӨЛӨӨ	75
4.7 БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МИНИЙ БОДОЛ	76
4.8 БОЛОВСРОЛ ГЭЖ ЮУ ВЭ?	78



БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИ БОЛ МОНГОЛ ХҮН БҮРИЙН СЭТГЭЛД ШИНГЭСЭН БАЙХ УЧИРТАЙ

Олон жилийн турш боловсролын философийн асуудал судлаачдын хүрээнд маш бага орон зай эзэмдэж ирсэн бөгөөд багш бэлтгэх хөтөлбөрүүдэд боловсролын философийн асуудлыг огт хөндөхгүй явж ирсэн байна.

Боловсролын философи бол боловсролтой холбоотой олон янзын асуудлуудыг философийн арга хэрэглэн, шинжлэх ухааны салбар хоорондын хил хязгаарыг чөлөөлж, боловсрол судлаачид болон философичдыг нэгтгэдэг онцлогтой.

Өнөөдөр боловсролын философийн асуудал яагаад ийм өндөрт тавигдах болж байна вэ?

Их өгөгдөл, гүйцэтгэлд суурилсан үнэлгээ, эмперисизм, ирээдүй судлалын шинжлэх ухааны эрин үед боловсролын философийн ач холбогдол урд өмнөхөөс илүү чухлаар тавигдаж эхэллээ. Боловсролын философийн шинэ хандлага нь боловсролын онолоос боловсролын практикт, боловсролыг ойлгохоос түүнийг өөрчлөхөд, боловсролын онолыг цоо шинээр авч үзэхэд чиглэж байна. Энэ шинэ хандлага нь боловсролын философийн асуудлын цаашдын ирээдүйг илүү гэрэл гэгээтэй болгож байна. Нэгд, боловсролын философи нь мэдлэгийн системүүд дээр түшиж, салбар дундын, тодорхой асуудалд анхаарах шаардлага тулгарч байна. Түүнээс гадна бүх нийтийн түгээмэл үнэ цэнэ ба уламжлалт мэдлэгийн хоорондын нийцэл, зөрчлийг авч үзэх шаардлагатай болж байна. Нөгөө талаас, хиймэл оюуны технологи хүний амьдрал ба боловсролд хүчтэй нөлөө үзүүлэх болж байгаа нөхцөлд боловсролын философи нь боловсролын үнэ цэнэ, ёс зүйн асуудлыг гүнзгий авч үзэх шаардлага тулгарч байна.



УИХ -ЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД

Л. ЭНХ-АМГАЛАН

Сургууль, их сургууль зэрэг сургалтын байгууллагууд сурагч, оюутан залуучуудад маш их хэмжээний мэдлэгийг өгч, амьдралдаа сонголт хийхэд нь тусалж байдаг. Гэхдээ өнөө үед хүлээж авч байгаа мэдлэгийн хэмжээ чухал бус харин түүнийг ойлгох, улмаар амьдралдаа ашиглаж чадах нь чухал гэж боловсрол судлаачид, философичид, сэтгэл судлаачид зэрэг эрдэмтэд маргалдах болж байна. Энэ мэтгэлцээн дунд боловсролын философийг цоо шинээр тодорхойлж, улс орны хэмжээнд боловсролын системийн өөрчлөлт шинэчлэлийг хийхэд түлхэц үзүүлэх болно.

МУИС-ийн Боловсрол судлалын тэнхим, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн хамтран боловсролын асуудлаар судалгаа хийж, сэтгэл зовниж, санал бодлоо илэрхийлж явдаг үе үеийн эрдэмтэн судлаач нартай уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, улмаар тэдний санал бодлыг нэгтгэн боловсролын философийн асуудлаар энэхүү эмхэтгэлийг бэлтгэсэн байна.

Энэ ажлыг санаачлан ажилласан МУИС-ийн ректор профессор Д.Бадарч, Боловсрол судлалын тэнхимийн эрдэмтэн багш нар болон Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн хамт олонд талархлаа илэрхийлье.

БШУ-НЫ САЙД Л.ЭНХ-АМГАЛАН




Философи нь бидний өдөр тутмын амьдралаас хол, тасархай, хийсвэр зүйл мэт санагддаг байж болно. Саяхан манай оронд уригдаж ирсэн АНУ-ын Оакландын их сургуулийн профессор Барбара Оакли Монголын багш нарын 8-р их хуралд тавьсан товчхон илтгэлдээ тархи судлалын шинжлэх ухаан эрчимтэй хөгжиж, та бидний тархинд танин мэдэхүйн үйл ажиллагаа, мэдлэг мэдээллийг хадгалах, эргэж санах талаар шинжлэх ухааны үндэслэлтэй мэдлэгтэй болсон өнөө үед сургуулийн зорилго бол мэдлэг дамжуулах төдийгүй, суралцахуйд сургах арга барилыг зааж, сурагчид өөрийн сурах үйл ажиллагаагаа хөтөлж авч явах улмаар аливаад шимтэн суралцах ур чадвартай болгохыг чухалчлан тэмдэглэж хэлсэн юм. Ийм хүчтэй дүгнэлт нь боловсрол судлаачид төдийгүй, боловсрол сонирхогчдын дунд мэтгэлцээнийг төрүүлэх нь дамжиггүй юм.

Барбарагийн дүгнэлтийг дэмжсэн, эргэлзсэн, эсэргүүцсэн мэтгэлцээн бол боловсролын философийн асуудал юм. Энэ дүгнэлтийг зөв буруу гэхээсээ өмнө өнөөдрийн боловсрол бидний амьдралын шаардлагад нийцэж байна уу, бидний сургалтын арга барил өнөөдрийн суралцагчдын хэрэгцээг хангаж чадаж байна уу, багшийн үүрэг зөвхөн мэдлэг дамжуулах явдал мөн үү гэх зэрэг асуултуудын талаар эргэцүүлэн бодох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Өнөөдөр улс орон бүр өөрийн гэсэн боловсролын тогтолцоог бүрдүүлж, засгийн газрууд боловсролыг тэргүүлэх чиглэл гэж зарлаад, асар их хэмжээний хөрөнгийг боловсролд зарцуулж, боловсролын чанарыг дээшлүүлэх талаар олон талын арга хэмжээ хэрэгжүүлж байна.

Нөгөө талаас, олон улсын байгууллагууд ч боловсролд онцгой анхаарал хандуулж, ялангуяа ядуу буурай болон хямралд өртсөн орон нутгийн хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон охидын



боловсролд түлхүү анхаарч тусламж дэмжлэг үзүүлж байна. Нэг өнцгөөс харвал боловсрол нь асар том бизнес болсон байна. Тэгвэл боловсрол гэж юу вэ? гэсэн үндсэн асуултын талаар нэгдсэн ойлголттой болж чадсан уу гэсэн философийн асуулт аяндаа гарч ирнэ.

Манай улсад боловсролын философийн асуудлыг анх 1997 онд тэр үеийн боловсролын сайд Ч.Лхагважав, философич Батчулуун нар хөндөж тавьж байсан байна. Гэвч энэ асуудлыг цааш нь өлгөн авч гүнзгийрүүлэн судлаагүй орхисон бололтой.

Харин 2021 онд ЮНЕСКО-оос гаргасан “Ирээдүйгээ хамтдаа төсөөлөхүй: Боловсролын талаарх нийгмийн шинэ гэрээ” гэсэн илтгэлийг судалж байх явцад боловсролын философийн асуудал гарч ирж, энэ асуудлаар МУИС, Боловсролын үндэсний судалгааны хүрээлэнгээс хамтран манай орны боловсрол судлаачдын ахмад үеийнхэн, дунд үеийнхэн, залуу үеийнхэн, оюутан залуучуудын дунд хэд хэдэн хэлэлцүүлгийг зохион явуулсан юм. Түүнээс гадна боловсролын талаар үнэтэй санал гаргаж, бичдэг залуу эрдэмтэн зохиолч, бүтээлч сэтгэлгээтэй зарим хүмүүстэй уулзаж ярилцлага хийсэн болно.

Эдгээр хэлэлцүүлэг, ярилцлагын дүнд оролцогчдод боловсролын философийн талаар өөрийн санал бодлоо бичиж өгөхийг хүсэж, тэдний бичсэн эссэ өгүүллүүдийг шүүн хянаж, эмхэтгэн та бүхний гарт хүргэж байна. Эрдэмтдийн санал бодлыг тэр чигээр нь оруулж өгснөөр боловсролын философийн асуудлаар өргөн олны дунд мэтгэлцээн өрнүүлэх замаар монголын боловсролын философийн талаар нэгдсэн нэг ойлголтод ойрын ирээдүйд хүрнэ гэсэн алсын бодол тээж энэхүү эмхэтгэлийг бэлтгэсэн болно.

Та бүхэн гэгээн оюун ухаандаа тунгаан болгооно уу?

Д.БАДАРЧ

М. ИТГЭЛ

Transforming education гэдгийг өөрчлөлт, шинэчлэл гэж ойлгож болохгүй. Тэр тусмаа “хувьсаж буй боловсрол” гэж хүнээс хамааралгүй өөрчлөгдөж байгаа мэт буруу ойлголт өгөхөөр тайлбарлаж таниулж яавч болохгүй. Сүүлийн үед “боловсролын хувирган өөрчлөлт” гэж нэрлэх болсон нь бас л онож чадахгүй байна. Хувирган өөрчлөх гэдэг нь өнгөцхөн “cosmetic change” гэсэнтэй ижилхэн бууж байна. Миний ойлгож байгаагаар энэ нь одоо байгаа системийг өөрчлөх, шинэчлэх хувиргах асуудал бус, харин боловсролын системийн зорилго, боловсролын тухай бидний ойлголт, итгэл үнэмшлийг цоо шинээр эргэж харахыг хэлж байгаа юм.

Өөрөөр хэлбэл, боловсролын системийг бүхэлд нь сэтгэлгээний цоо шинэ талбарт аваачих их нүүдэл суудал гэж нэрлэх нь манай орны нөхцөлд илүү зохимжтой гэж хувь хүнийхээ хувьд үздэг юм

Д. Бадарч

“Монгол сэтгэлгээ” гэх ойлголт оршин байна. Гэхдээ бусад сэтгэлгээнээс юугаараа ялгаатай? юугаараа ижил вэ? гэсэн асуултын хариултыг тодруулах хэрэгтэй байна.

Монгол сэтгэлгээг даяарчлалын нийгэмд ихээхэн хэрэгцээтэй байгаа Resilience - мятариггүй чанар, Adaptability - дасан зохицох чадвар, Thinking outbox - задгай сэтгэх, Creative thinking – бүтээлч сэтгэхүй, Problem solving – асуудал шийдвэрлэх гэсэн чадамжуудыг агуулсан байдлаар биш боловч, хамааралтай байдлаар тодорхойлж болно.

М.Итгэл

БҮЛЭГ I

НЭГ. МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИЙН АСУУДАЛД

Боловсролын салбарт хийх их нүүдэл суудал



МОНГОЛ УЛСЫН АРДЫН БАГШ, ДОКТОР, ПРОФЕССОР
МУИС-ИЙН РЕКТОР

Д. БАДАРЧ

БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ХИЙХ ИХ НҮҮДЭЛ СУУДАЛ

Сүүлийн гучаад жилд манай нийгэмд боловсролын талаар хэтэрхий нэг талыг барьсан хурц шүүмжлэл, сөрөг үзэл бодол, нөгөө талаас үр дүн, үр нөлөөг нь гүйцэд таньж мэдээгүй байж гаднын шинэ санаа санаачилгыг сайтар судлахгүйгээр илт хоосон магтаж, ятгах, тулгах зэрэг маш хол зөрүүтэй туйлшрал нийгмийн болон шинжлэх ухааны сэтгэлгээнд тогтжээ. Нөгөө талаас боловсролын салбарт хийж байгаа өөрчлөлт шинэчлэл нь зөвхөн хэлбэр хөөсөн, гүнд нь орж агуулга, арга зүйн шинэчлэл хийхийн оронд бодлого боловсруулж, шийдвэр гаргах олон шат дамжлагатай тогтолцоог шүтсэн, бүтэц зохион байгуулалтаар хөөцөлдсөн, эрх мэдлийн хуваарилалтад чиглэж явж ирсэн нь боловсролын салбарыг сэхээж сэргээхэд тус үзүүлж чадахгүй байна.

2022 онд дэлхийн улс орнуудыг хамарсан “Transforming education” хөдөлгөөнийг НҮБ, ЮНЕСКО-оос санаачлан, уур амьсгал, хүрээлэн буй орчин эрс өөрчлөгдөж, технологийн дэвшил эрчимтэй хөгжиж, бидний амьдралд гүнзгий нэвтэрч байгаа өнөөгийн нөхцөлд боловсролын салбарыг цоо шинээр авч үзэж, өнөөдрийнхөөс тэс өөр түвшинд шилжүүлэх шаардлага тулгарч байгааг анхааруулсан юм.

Сүүлийн 30 жилд манай орны боловсролын салбарын оршин тогтнох асуудал дор хаяж хоёр удаа босож ирсэн гэж үзэхэд болно. Юуны өмнө, ерээд оны ардчилсан хувьсгалын дараахан боловсролын систем хөл дээрээ сөгдөхөд хүрсэн бол түүнийг боловсролын системийг либералчлах, зах зээлийн тогтолцоонд шилжүүлэх замаар шийдэж ирсэн. Хэдхэн жилийн өмнө дэлхий нийтийг хамарсан цар тахлын үед боловсролын салбарын тасралтгүй үйл ажиллагааг хангах асуудал босож богино хугацаанд

шийдвэр гаргах хүндхэн асуудлыг улс орны өмнө тавьсан билээ.

Энэ хоёр хямралын сөрөг үр дагавар өнөөг хүртэл бидэнд мэдрэгдсээр байгаа бөгөөд манай боловсролын системд оршиж байгаа доголдол дутагдалтай талуудын учир шалтгаан ч үүнтэй холбоотой гэж үзэж байна.

Тэгвэл бид боловсролын салбарт олон улсын байгууллагуудаас анхааруулж байгаа шилжилтийг хэрхэн хийх ёстой вэ?

Transforming education гэдгийг өөрчлөлт, шинэчлэл гэж ойлгож болохгүй. Тэр тусмаа “хувьсаж буй боловсрол” гэж хүнээс хамааралгүй өөрчлөгдөж байгаа мэт буруу ойлголт өгөхөөр тайлбарлаж таниулж явч болохгүй. Сүүлийн үед “боловсролын хувирган өөрчлөлт” гэж нэрлэх болсон нь бас л онож чадахгүй байна. Хувирган өөрчлөх гэдэг нь өнгөцхөн “cosmetic change” гэсэнтэй ижилхэн бууж байна. Миний ойлгож байгаагаар энэ нь одоо байгаа системийг өөрчлөх, шинэчлэх хувиргах асуудал бус, харин боловсролын системийн зорилго, боловсролын тухай бидний ойлголт, итгэл үнэмшлийг цоо шинээр эргэж харахыг хэлж байгаа юм.

Өөрөөр хэлбэл, боловсролын системийг бүхэлд нь сэтгэлгээний цоо шинэ талбарт аваачих их нүүдэл суудал гэж нэрлэх нь манай орны нөхцөлд илүү зохимжтой гэж хувь хүнийхээ хувьд үздэг юм.

Нүүдэлчин монголчууд бидний санаанд энэ ойлголтыг их нүүдэл суудал гэж ойлговол арай дөхөмтэй болох юм. Монголчууд түүхэндээ дэлхийг хамарсан их нүүдэл суудлыг хийж байсан ард түмэн. Бид хаашаа, хэзээ нүүх, юугаа авч явах, юугаа хаях, яаж нүүх зэрэг олон асуудлыг урьдчилан нухацтай бодож үзээд нүүдэл хийдэг уламжлалтай. Өөрөөр хэлбэл, өнөөдөр хүчтэй хөгжиж, хэрэглэх болсон

ирээдүй судлалын шинжлэх ухааны боломжит хувилбаруудыг тооцож байж шийдвэрээ гаргадаг аргачлалтай агаар нэг юм.

Энэ их нүүдэл суудлыг хийхдээ боловсролын системийг системийн онолын үүднээс авч үзэх шаардлага гарч ирж байна. Боловсролын систем бол харилцан уялдаа бүхий олон дэд системүүдтэй. 2023 онд батлагдсан боловсролын багц хууль нь боловсролын дэд системүүдийн уялдаа холбоог цогцоор нь харах гэж оролдсон анхны алхам гэж үзэж байна. Нөгөө талаас боловсролын системийн дэд системүүд нь шаталсан бүтэцтэй бөгөөд тэдний оролт, гаралтыг хянаж удирдах шаардлагатай байдаг. Түүнээс гадна боловсролын систем бол дотоод үйл ажиллагаагаа тогтвортой явуулах, өсөлт сэргэлтийг дэмжихдээ гаднын нөөцийг авч байдаг нээлттэй систем юм. Ер нь боловсролын систем бол нарийн төвөгтэй зохион байгуулалттай “том” системийн шинжийг агуулж байдаг учир дэд системүүд нь өөр өөрийн гэсэн зорилготой, тэдний оролтод ирж буй өгөгдлүүд нь янз бүрийн үр дүн, үр дагавар, үр нөлөөнд хүргэж байдаг. Тийм ч учраас бодлого боловсруулагчид болон шийдвэр гаргагчид системийн сэтгэлгээний арга технологийг боловсролын системд хэрэглэх оролдлого хийж эхэлсэн юм. Энэ аргачлалыг хэрэгжүүлэхдээ дор хаяж дараах 3 төрлийн үйл ажиллагааг ухаалгаар явуулах хэрэгтэй гэж эрдэмтэд үзэж байна.

Юуны өмнө, өөрчлөгдөж байгаа өнөөгийн нөхцөлд боловсролын зорилго, хөгжлийн хэтийн чиглэлийн талаар багш, сурагчид, эцэг эхчүүд, төрийн бус байгууллагууд, төр, засгийн газар нэгдсэн ойлголттой болох явдал бол боловсролын салбарын нүүдэл суудлыг жинхэнэ утгаар нь хийх үндэс болно гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, улс орон бүхэн бүх нийтээрээ хүлээн зөвшөөрсөн өөрийн гэсэн боловсролын философитой байх ёстой гэж тодорхойлж байна. Ийм философийг бий болгохын тулд өргөн хүрээтэй мэтгэлцээн, оюун ухаанаа уралдуулан байж нэгдсэн үзэл санааг томьёолж чадна гэж үзэж байна.

Дараа нь хиймэл оюун, тархи судлалын эрчимтэй хөгжил нь сурах, сургах үйл ажиллагааг дахин дизайн хийх бас нэг чухал хүчин зүйл болж байна. Уламжилж ирсэн сурган заах арга зүй, сурагч, багш, агуулга, нөөцийн хоорондын уялдаа холбоог системийн үүднээс эргэн харж, боловсролын системийн “гал тогоо” болсон багшлахуй, суралцахуйг дахин дизайн хийхийг сүүлийн үеийн нейросайнсын ухаан шаардаж байна. Бид өөрсдийнхөө тархины үйл ажиллагааг улам нарийн мэдэж авснаар сурах үйл ажиллагааны үр өгөөжийг эрс нэмэгдүүлж, хүн нэг бүрийг насан туршдаа сурах арга технологиор зэвсэглэж өгөх болно. Түүнээс гадна сургах, сурах үйл ажиллагааны талаар дэлхий

дахины тэргүүний ололт амжилт, инновацыг шууд хуулбарлах, дуурайх замаар бус, зөвхөн өөрийн онцлог нөхцөл, боловсролынхоо философидоо тохируулан ухаалгаар нутагшуулах ур чадварыг эзэмших явдал чухал юм. Шууд хуулбарлах, дуурайх замаар яваад амжилтад хүрэхгүй гэдгийг бид яс махандаа тултал ойлгосон гэж бодож байна. Эцэст нь боловсролын системийн бүхий л дэд систем, нэгж хэсгүүд тухайлбал, хөтөлбөр, хүний нөөц, их өгөгдөл, засаглал, санхүүжүүлэлт зэрэг нь хамтдаа бие биеэ дэмжиж ажиллаж байж боловсролын системд хийх нүүдэл суудал үр өгөөжөө өгөх болно. Өөрөөр хэлбэл, сайн багштай, сургалтын сайхан орчинтой байлаа ч засаглал нь улс төрөөс хамааралтай байвал доголдож ирдгийг сүүлийн жилүүдийн олон гашуун туршлага харуулж байна. Тиймээс боловсролын системийн бүх нэг хэсгүүдийг буюу эко-системийг бүхлээр нь системийн сэтгэлгээний өнцгөөс харж, ухаалгаар хэрэгжүүлж чадваас сурах, сургах үйл ажиллагааг бүрэн дэмжиж улмаар боловсролын системд хийх нүүдэл суудлыг амжилттай хэрэгжүүлж чадна.

Боловсролын философийн тухай эргэцүүлэл Монголын боловсролын цаашдын хөгжлийг онол арга зүй, философийн үүднээс эргэцүүлэн тунгаан бодох шаардлага бий болж байна.

Нэгд, аливаа асуудал нь мэдлэгийн явцуу нэг салбарын хүрээнээс хальж мэдлэгийн олон салбарын уулзвар ухааныг хэрэглэх өөрөөр хэлбэл орчин үеийн шинжлэх ухааны танин мэдэхүйн үйл ажиллагааны ээдрээтэй байдлаас үүдэн боловсролын асуудалд философийн үүднээс хандах хэрэгцээ шаардлага бий болж байна. Эндээс боловсролын философи бол боловсролыг системийн сэтгэлгээний үүднээс авч үзэх хэрэгсэл болж байна.

Хоёрт, манай боловсролын систем олон улсын боловсролын системд ойртох үйл явц маш эрчимтэй явагдаж байна. Өнгөрсөн гучаад жилд бид боловсролын салбарт гадаадын улс орнуудын онол, практикийн уламжлал, туршлагаас шууд хуулах оролдлогыг хийсэн боловч дийлэнх нь амжилтад хүрч манай нийгмийн оюуны хөрсөнд бууж өгсөнгүй. Үүний гол шалтгаан бол бид монголын боловсролын философийн сэтгэлгээг хөгжүүлж чадаагүй байна гэж үзэж болно. Гэхдээ олон улсын туршлага, шинэ үзэл санаатай танилцаж танин мэдэхүйн шинэ боломжуудыг өөртөө нээж өгсөн юм.

Гуравт, Дэлхийг хамарсан цахим шилжилтийн орчин үед дэлхийн боловсролын системд цоо шинэ үзэл санаа, чиг хандлагыг тодорхойлох шаардлагатай тулгарч байна. Энд олон улсын байгууллагууд, тухайлбал, ЮНЕСКО-гоос 2021 онд боловсролын ирээдүйн талаар “Ирээдүйгээ хамтдаа төсөөлөхүй: Боловсролын талаарх нийгмийн шинэ

гэрээ” гэсэн тайланг, Олон улсын Эдийн засаг хамтын ажиллагааны байгууллага (OECD) -ээс 2021 онд “Суралцахуйн луужин” (Learning compass), Дэлхийн эдийн засгийн форумаас 2023 “Боловсрол 4.0-ийг тодорхойлох нь: Суралцахуйн ирээдүйн таксоном” (Defining Education 4.0: A taxonomy for the future of learning), дэлхийн банкнаас 2018 онд “Суралцахуй: Боловсролын амлалтыг хэрэгжүүлэх нь” (Learning: to realize Education’s promise) зэрэг дэлхий нийтийн анхаарлыг татсан боловсролын философийн бүтээлүүдийг гаргасан байна.

Өөрөөр хэлбэл, боловсрол бол заах арга зүй, сэтгэл судлалын ухааны цар хүрээнээс хальж нийгэм соёлын онцгой үзэгдэл болж байгаа нь боловсролын асуудалд шинжлэх ухааны үүднээс, тэр тусмаа боловсролын философийн талаас гүнзгий судлах шаардлагыг бий болгож байна.

Манай алдарт зохиолч Л.Түдэв гуай бичихдээ “Үндэстэн бүхний онцлогт тохирсон үндсэн хууль гэдгийг гараагүй сураг чимээгүй байх тэр эртийн цаг дор амнаас ам дамжин явж, үеэс үед өвлөгддөг “аман хууль” бий болжээ” гэсэн байдаг. Гэхдээ энэ аман хууль нь хориг цээр гэхээсээ илүүтэй хүнийг хүн болоход тус болохуйц философийн үндэс байсан гэж үзэж болох болов уу. Бидний аж амьдралын өвөрмөц онцлогоос урган гарсан зүйр цэцэн үгс, ертөнцийн гурав, үлгэр домог зэргийг сайтар ухаж үзвээс нүүдэлчин малчны сэтгэхүй, ахуйн өвөрмөц шинжийг агуулсан мэдээлэл, сургаал, нэг үгээр хэлбэл бичигдээгүй хуулийг олж болох мэт санагдана. Улс орны маань хувь заяа түшиж, эдийн засаг, нийгмийн шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлж байгаа өнөө үед сэтгэлгээний шинэ сэргэлтийг хөхүүлэн дэмжиж, гадаад нөлөөн дор “тархиа угаалгасан” он жилүүдээс өмнөх үеийн монгол сэтгэлгээний түүх рүү өнгийж үзэж, уламжлалт философио сэргээх явдал чухал санагдана. Тийм ч учраас сүүлийн жилүүдэд манай эрдэмтэд боловсролын философийн асуудлыг сонирхон судлах болсон нь ирээдүйтэй цаг үеэ олсон үзэгдэл гэж үзэж байна.

Боловсролын философийн асуудлыг хөндөхөд юуны өмнө “Боловсрол гэж юу вэ?”, “Боловсролтой хүн гэж хэн бэ?” гэсэн хоёр тулгуур асуултад хариу өгөх шаардлага тулгарна.

2000 оны эхнээс мэдлэгийг нээлттэй болгох хөдөлгөөн АНУ-ын Массачусетсийн Технологийн их сургуулиас эхэлж, улмаар ЮНЕСКО энэхүү санаачилгыг дэмжиж, сургалтын нээлттэй нөөц эх материал гэсэн нэр томъёог эргэлтэд оруулж, энэ асуудлаар дэлхийн хэмжээний хоёр ч бага хурлыг зохион байгуулсан юм. Өнөөдөр татвар төлөгчдийн мөнгөөр бий болсон мэдлэгийг олон нийтэд үнэ төлбөргүй түгээх, хүргэх талаар төрөл бүрийн санал санаачилгууд гарч байна. Нөгөө талаас, өнөөдөр

мэдлэг хүний тархинаас гарч интернэтийн сүлжээнд өдрөөс өдөрт тархан дэлгэрч байгаа нь мэдлэгийг бүх нийтийн баялаг болгож байна. Ийм нөхцөлд мэдлэгтэй хүнийг боловсролтой хүн гэж хэлэх нь хангалтгүй болж байна. Харин мэдлэгээ амьдралд хэрэглэж чаддаг хүнийг боловсролтой хүн гэж үзэх хандлага газар авч байна.

Мэдлэгээ амьдралд хэрэглэж чадна гэдэг бол мэдсэн зүйлээ эхлээд ойлгож авч чаддаг байна гэсэн үг. Ойлгох гэдэг нь тухайн мэдлэгийн учир шалтгааныг тайлж чадсанаар тухайн мэдлэгийн үнэн, худлыг ялгах боломжтой болно. Гэхдээ учир шалтгааныг олж мэдэх явдал бол танин мэдэхүйн нарийн төвөгтэй үйл ажиллагааг шаарддаг. Жишээ нь бид өдөр шөнө солигддог тухай мэдлэгийг олж авснаар яагаад гэдэг асуултыг аяндаа өөртөө тавина. Тэгвэл дэлхий эргэлдэж байдаг гэсэн хялбархан тайлбар нь өдөр шөнө солигдохоос ч олон нэмэлт мэдлэгийг ойлгоход тус болно.

Ойлгож авсан мэдлэгээ ухаарч, эргэцүүлэн бодож, ур өмнөх мэдлэг, туршлагатайгаа холбож тунгаан бодож үзвэл таны оюун санаа улам тэлж сэтгэлгээний шинэ түвшинд хүрэх болно. Хэрэв та дэлхий эргэлддэг гэсэн ойлголтоо гариг ертөнцийн тухай урд өмнө мэдэж авсан мэдлэг, нарны аймаг, орчлон ертөнцийн тухай мэдлэгүүдтэй уялдуулан эргэцүүлэн бодож үзвээс манай гаригийн зүй тогтол, агаар мандал, дулааралт, уур амьсгалын өөрчлөлт гээд маш олон ойлголтуудын уялдаа холбоог мэдэж, өөрийн мэдлэгээ хил хязгааргүй өргөтгөн тэлэх боломж бий болно. Хүний сэтгэлгээ бол зах хязгааргүй бөгөөд олж авсан мэдлэгээ баталгаажуулж, үнэн мөнгийг тогтоож, мэргэн санаа төрөх нөхцөлийг бүрдүүлж өгдөг.

Сэтгэж сурах суурь зарчмыг Аристотель анх томъёолсон байдаг. Аливаа асуудлын цөмийг нь ойлгож, хэсэг тус бүрийг нь сайтар шинжилж, тэдгээрийн уялдаа холбоог тунгаан олж мэдсэнээр цааш нь сэтгэх, шинэ мэдлэг олж авах, шинэлэг шийдэлд хүрэх хаалга нээгдэнэ. Тэгвэл өнөөдөр боловсролтой хүн гэж сэтгэлгээний өндөр соёл эзэмшсэн, мэргэн ухаантай хүнийг хэлэх цаг болжээ. Мэргэн цэцэн хүн гэж тусдаа хүн байдаггүй юм байна. Харин сэтгэх, бодох чадвараа байнга ашиглаж, аливаа зүйлийг ухаарч, тунгааж сурах хэрэгтэй. Хүн бүрд байгалиас сэтгэн бодох ур чадвар заяасан. Гэхдээ хүн бүр тэрхүү онцгой ур чадвараа ашиглах, улмаар хөгжүүлэх талаар санаа тавьдаггүй байна.

Пифагор оюун санааг оюун ухаан, сэтгэлгээ, хүсэл тэмүүлэл гэж гурав хувааж, оюун ухаан, хүсэл тэмүүлэл бараг бүх амьд биетэд бий болдог бол сэтгэлгээ нь зөвхөн сэтгэгч бодгальд л байдаг гэж хэлсэн байдаг. Цаашлаад чухамдаа сэтгэлгээ л хүнийг хүн болгодог ба учир нь түүнийг хэрэглэснээр


явагдаж буй үйл явцыг ухааран ойлгох, түүнд хариу үйлдэл хийх тухай хүний авьяас чадварын тухай ярьж болно. Эндээс сэтгэлгээний үйл явц нь хүнийг цэцэн мэргэнд дурлахад хүргэж, эцсийн дүндээ философийн үндэслэл нь болдог гэсэн гаргалгаа гарч ирдэг.¹ Тэгвэл орчин үед сэтгэн бодох ур чадвартай хүнийг боловсролтой хүн гэж үнэлдэг жишиг дэлхий дахинаа тогтож байна

Сэтгэн бодох ур чадвараа хэрхэн хөгжүүлэх вэ гэсэн асуулт аяндаа гарч ирнэ. Тэгвэл хүний сэтгэлгээг төрөлх хэл нь тодорхойлж байдаг. Төрөлх хэлээ төгөлдөр эзэмшсэн хүн сэтгэлгээний өндөр соёл, ур чадварыг амархан эзэмшинэ. Яагаад гэвэл бидний сэтгэлгээ төрөлх хэлтэйгээ нягт холбоотой байдаг. Монголдоо англи хэл төгс эзэмшээд англиар төгс сэтгэдэг болно гэхэд учир дутагдалтай. Яагаад гэвэл, нөхцөл байдал, түүх, ёс заншил, амьдралын хэв маяг гээд маш олон зүйл сэтгэлгээнд шууд

нөлөөлж байдаг. Ямар үгийг хэзээ хэрэглэх вэ гэсэн энгийн жишээнээс тухайн орны соёл, ёс заншилтай холбоотой үг хэллэгийг өөр улсаас мах цусандаа ортол ойлгож мэдэрч авна гэхэд их хүнд, бараг боломжгүй. Нөгөө талаас, монгол хэл бол залгамал хэл бөгөөд ерөнхийгөөс тодорхой руу утга санааг илэрхийлдэг. Гэтэл англи хэл бол аналитик хэл бөгөөд нарийнаас ерөнхий рүү тодорхойлж байдаг. Тухайлбал бид бүхэн англи хэл дээр өөрийнхөө нэрээр биш, аавынхаа нэрээр дуудуулж, бичүүлдэг учир хэн гэдгийг нь танихад төвөгтэй байдаг.

Эндээс үзэхэд боловсролтой хүн гэж юуны өмнө төрөлх хэлээрээ зөв бичиж, зөв сэтгэж, утга санаагаа уран илэрхийлж чаддаг хүнийг хэлж байна. Энэ бол монголын боловсролын философийн өмнө тавигдаж байгаа нэг том асуудал гэж хэлэхэд хэтрэхгүй болов уу?

¹ Ц.Алтантуяа, Н.Энхцогт. Философи дахь гайхамшигт 50 санаа.(Философийн түүхийн сэдвүүд). Соёл урлагийн их сургууль. Улаанбаатар. 2016



МОНГОЛ СЭТГЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭЛ



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ, ДОКТОР

М.ИТГЭЛ

МОНГОЛ СЭТГЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Удиртгал

Монголчуудын нийгмийн болон судалгааны орчинд “Монгол сэтгэлгээ” гэж ихээхэн бичих боллоо. Нэг хэсэг нь “Монгол сэтгэлгээ” л агуу, бусдаас илүү гэж магтаж байхад, зарим нь бүр адгийн мууг нь тоочно. Гэтэл бүр зарим нь ахуйн түвшинд ийм зүйл байна, харин ахисан түвшинд буюу “дээд эрэмбийн” гэх сэтгэлгээнд байхгүй гэнэ. Бүр нөгөө хэсэг нь “Орос сэтгэлгээ”, “Хятад сэтгэлгээ”, “Америк сэтгэлгээ” гэж байхгүй тиймээс “Монгол сэтгэлгээ” гэж байхгүй гэж ч онолдоно.

Асуулт 1. “Монгол сэтгэлгээ” оршин байна уу?

Санаа 1.

Нэгэн удаа Д. Нацагдоржийн “Дөрвөн цаг” шүлгийн гар ноорог олж хараад үүнийг л “Монгол сэтгэлгээ” гэнэ дээ гэсэн бодол надад төрсөн юм.



(Зураг 1)

санаа” гэдгийг “жанжин шугам” гэж орчуулж болох юм шиг санагдаж билээ.

(Зураг 1). Энэ зурагт дөрвөн хэсэгт хуваасан нь дөрвөн улирал, дугуй бүр нь харгалзах бадгуудын түлхүүр үгнүүд байгааг Та бүхэн анзаарсан биз ээ. Тус зургийг нэгэн ахмад багшид үзүүлэхэд шүлгийнхээ “жанжин шугамаа гаргах”-даа жинхэнэ “Монгол сэтгэлгээ”-ээр гаргажээ хэмээсэн нь миний сонирхлыг бүр татсан юм. Бидний “big idea” буюу “гол санаа, ерөнхий

Үр дүн:

Мөн энэ зургийг “Дөрвөн цаг” шүлгийн эх нооргийг Монгол болон гадаадын хүмүүст харуулахад ихээхэн сэтгэл огшиж өөрийн эрхгүй “Монгол сэтгэлгээ” гэсэн сэдэв рүү ордог болохыг би олон удаагийн яриа, хэлэлцүүлэг, семинарын үр дүнгээр батлан хэлж чадна.

Дүгнэлт:

Яагаад заавал “Монгол сэтгэлгээ” гэж яриад байна гэсэн гэнэн бодол төрөв.

Санаа 2.

Б. Шаравын “Монголын нэг өдөр” зургийг Монгол сэтгэлгээгээр зурсан зураг гэж олон Монгол зураачийн ярианаас сонсжээ.



(Зураг 2)

Үр дүн: Олон зургийг ийм Монгол сэтгэлгээгээр зурсан байна уу? гэж асуухад яг Монгол сэтгэлгээ биш эсвэл холимог юм байна, огт биш гэсэн хариултауд авч байв.

Дүгнэлт: Зураг зурахад Монгол сэтгэлгээ гэсэн ойлголт байна.

Санаа 3.

(2004 онд Монгол судлаач Гольмантой хуучилсан ярианаас) 15-р зууны үед Барууны нэгэн жуулчин Монгол нутгаар аялаад нутагтаа очоод ингэж ярьжээ. Монголчууд их өвөрмөц сэтгэдэг (үзэлтэй) үндэстэн байна.

Жишээлбэл, мэндлэхдээ,

- Эхлээд Байгаль дэлхийгээ эхэлж асуудаг,
- Дараа нь ан амьтан, мал сүргээ ,
- Тэгээд садан төрөл, гэр бүлийг нь,
- Хамгийн сүүлд нь өөрийнх мэндийг асуудаг гэжээ.

(Сайхан хаваржиж байна уу? Сүрэг тарган байна уу? Таны гэр бүл амгалан байна уу? Та сайн байна уу?)

Үр дүн:

Одоо ч гэсэн Монголчуудын мэндчилгээ ийм хэлбэртэй байдаг. Ялангуяа цагаан сараар золгох энэ мэндчилгээг харж болно.

Дүгнэлт:

Өвөрмөц сэтгэдэг үндэстэн гэдэг нь бусад үндэстнээс ялгаатай сэтгэдэг гэж дүгнэж байна. Мөн энэ үзлийг орчин үед Тогтвортой хөгжлийн үзэл гэж би боддог.

Санаа 4. (МУИС-ийн нэгэн багшийн яриа)

Монгол ба Солонгос оюутнууд майхан барих болжээ. Гэтэл тэд майхныхаа гадсыг орхиод ирсэн байв. Гэтэл Монголчууд нь гадсаа өөр зүйлээр орлуулаад майхнаа босгочихсон, харин Солонгосчууд гадасгүй тул майхан барьж чадсангүй гээд багшийгаа хүлээж байсан.

Үр дүн: Солонгос багш нь Монгол багшид ингэж хэлжээ. Танай хүүхдүүд гадас ямар үүрэгтэй вэ? гэдгийг маш сайн мэдэж байна. Харин манай хүүхдүүд гадсаар л майхныг тогтоодог өөр зүйлээр тогтоож болохгүй гэж ойлгоод байна.

Дүгнэлт: Монголчууд маш олон зүйлийг энэ мэт орлуулж хэрэглэдгийг мэднэ. Үүнийг баруунд “(thinking out box)” буюу шууд орчуулбал “хайрцагнаас гарч сэтгэх” гэдэг бөгөөд Монголчууд “задгай сэтгэх” гэж ойлгож ч болох юм.

Санаа 5.

Ц.Балхаажав (1997), Н. Эрдэнэцогт (2008), Ц.Өнөрбаян (2022), Д. Бадарч (2023) судлаачид “Монголчууд ерөнхийгөөс тусгай руу, томоос жижиг рүү сэтгэдэг” гэж бүтээлдээ бичжээ.

Дүгнэлт: Дээрх санаануудаас “Монгол сэтгэлгээ” гэх ойлголт оршин байна. Гэхдээ бусад сэтгэлгээнээс юугаараа ялгаатай? юугаараа ижил вэ? гэсэн асуултын хариултыг тодруулах хэрэгтэй байна.

Асуулт 2. “Монгол сэтгэлгээ” ямар шинжтэй вэ?

Шинж 1. Ерөнхийгөөс тусгай руу сэтгэдэг.

2008 онд нэгэн Япон хүн, хэлмэрч Япон оюутантайгаа машинаар Улаанбаатараас Төв аймгийн төв Зуунмод явах болжээ. Тэгээд Яармагийн автобусны буудал дээр зогсож байсан 30 орчим насны эмэгтэйгээс яаж Зуун мод орох тухай асуухад, Та тэр уулын баруун талаар даваад, цааш засмал зам явж байгаад хоёр сална. Баруун талаар нь биш, чигээрээ явна. Тэгээд явж байтал Зуунмод орно гэжээ. Тэр хоёр япон эхлээд юуг ч ойлгоогүй. Дараа нь хэлсний дагуу яваад очсон байна. Тэд дараа нь надад ярихдаа их баярласан гэж хэлэв. Учир нь уулын баруун тал, зам сална, чигээрээ гэсэн гуравхан мэдээллээр би бүхэл бүтэн 40 км төөрөлгүй явсан гэв. Энэ мэт тохиолдлууд зам асуухад Монголын хот, хөдөөгүй тааралдана. Тэгвэл Монголчууд зам заахдаа хаана хүрэх хэдхэн цэг заадаг бөгөөд ямар замаар, яаж явахыг нэг бүрчлэн заадаггүй ажээ.

Шинж 2. Системийн сэтгэлгээтэй.

2017 оны хавар нэгэн малчныд очиход 5 настай жаал манайх 1000 гаруй хонь, ямаатай. Хоёр азарга буюу 40-өөд адуутай гэж ярьж байв. Гэхдээ тэр жаал 100 хүртэлх тоолж, 3+2 хэд вэ гэдгийг мэдэхгүй байв. Тэгвэл энэ жишээ нь системлэг сэтгэлгээтэй боловч, аналитик сэтгэлгээ сул байгааг харуулж байна.

Шинж 3.

Аливааг зүйрлэхдээ “Зүйр цэцэн үг” хэрэглэн оновчилдог.

2011 онд МУИС-ийн Математик, Компьютерийн Сургуулийн багш, оюутнуудад “Шашин ба математик” гэсэн нэртэй чөлөөт лекцийг доктор Р. Энхбаг уншиж билээ. Тэнд “минимаксийн зарчим” гэх тоглоомын онолын нэлээн хүнд агуулгатай теоремийг ярихад доктор Ц.Дашдорж түүнийг “Могойг гурав хуваасан ч гүрвэлийн дайтай гэдэг” үг байдаг. Тэгвэл энэ үг “хамгийн бага урттай могойг гурав хуваахад хамгийн их урттай гүрвэлтэй тэнцүү байна” гэсэн үг. Энэ л минимаксийн зарчим юм байна гэж хэлээд бүх оролцогчид бөөн баяр болж байсныг санахад таатай байна. Энэ жишээгээр Монголчууд аливаа зүйлийг зүйр цэцэн үгээр маш хураангуй байдлаар ерөнхийлөн ойлголцдог гэдгийг илэрхийлэх гэсэн юм.

Шийдлүүд:

Монгол сэтгэлгээ гэх мэдрэмжийг орчин үеийн аргатай хослуулан гаргасан хэд хэдэн судалгааны болон судалгааны бус хандлагатай шийдлүүд гаргав.


Шийдэл 1.

Монголчуудын оюун санааны онцлог (2022)

Ерөнхий санаа. Монголчууд оюун санааны хувьд ямар онцлогтой ард түмэн бэ? гэсэн асуултад

Дүгнэлт: Монгол суралцагчийн дүр төрх нь

- Хүн төрөлхтний соёлыг хүндэтгэдэг, дэлхийн соёлоос суралцдаг “Дэлхийн хүн”,
- Үндэсний соёл, уламжлал, ёс заншлаа өвлөн



(Зураг 3)

хариулах зорилготой нотолгоонд тулгуурлан судалгаа хийв.

Арга зүй: Монгол угсаатны сурган хүмүүжүүлэх ухааны 164 эх сурвалж дээр тулгуурлан ирээдүй судлалын Янусын конус аргыг хэрэглэн дүрслэв.

Үр дүн: Зураг 3

Дүгнэлт:

Бид цаашид “Монгол сэтгэлгээ” гэх ойлголтыг ирээдүйн ур чадварын нэг болох асуудал шийдвэрлэхэд чиглүүлэн хөгжүүлэх шаардлагатай байна.

Шийдэл 2.


Монгол суралцагчийн дүр төрх (2023)

Ерөнхий санаа: Нацагдоржийн Дөрвөн цаг шүлгийн санаанаас эхний санааг гаргав. (Зураг 4) Ингэхдээ даяарчлалын хувьд VUCA, OECD-ийн боловсролын үнэт зүйлийн ангилал, хүний эрхийн түгээмэл тунхаглал, НҮБ-ийн Transforming Education хүлээн зөвшөөрч, Дангаарчлалын хувьд Үндсэн хууль, Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, хувьсаж буй боловсрол хэлэлцүүлгийн үр дүнг тооцон, дөрвөн улирал гэсэн хэсэг нь

1. Боловсрол нь ямар том системийн дэд хэсэг вэ? гэдэг нь Экосистем
2. Тус экосистемээс Боловсролын Чиглэх алтан гадас нь Алсын хараа
3. Алсын хараа руу хөтлөх луужин нь Үнэт зүйл
4. Нийгэмд төлөвших хүн нь Монгол суралцагч гэсэн санааг гаргав.

хөгжүүлдэг “Соёлыг уламжлагч”

- Ардчилсан, хүмүүнлэг, иргэний нийгмийг цогцлооход хувь нэмрээ оруулдаг “Хүнлэг иргэн”,
- Нийгмийн болон гэр бүлийн “Хариуцлагатай гишүүн”



- Бие дааж, насан туршдаа суралцдаг “Тасралтгүй суралцагч” байна.

Шийдэл 3. БСҮХ-ийн стратегийн зорилго

Ерөнхий санаа:

Археологич Эрдэнэбаатарын (2006) Хүннүгийн тамгатай шагай (Зураг 5) гэсэн олдвороос “тамганы цуглуулга” гэж нэрлэсэн дүрсээс, түүхч Нямаа Монголын 44 хаан тамгаа авсан гэсэн судалгааны өгүүлэл байдаг гэсэн мэдээллийн тухай ярилцаж байгаад, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн (БСҮХ)-ийн зорилгыг үйл үгээс биш,



(Зураг 5)



байгууллагын дүр төрхөөр нь илэрхийлж болох санаа гарсан.

Үр дүн:

Дүгнэлт: БСҮХ нь 2023-2027 оны стратеги төлөвлөгөөний зорилгыг

- судалгааны чиглэлээр – эрдэм судлалд түүчээлэгч,
- арга зүйн ажилд – хүртээмж, чанарыг эрхэмлэгч,
- хамтын ажиллагааны хувьд хариуцлагатай, ёс зүйтэй түншлэгч,
- гарах бүтээгдэхүүнд – инноваци, шинийг санаачлагч,
- баримтлах гол үзэл нь тогтвортой хөгжлийг дэмжигч,
- боловсон хүчний хувьд хүний нөөцийг хөгжүүлэгч гэсэн дүр төрхтэй байгууллага болон хөгжих шийдлийг гаргасан.

Шийдэл 4.

“Санаа төрөх” агшинг Монгол соёлын хүрээнд үгэн илэрхийллийн нэгэн хувилбар (энэ бол судалгаа бус мэдрэмжийн илэрхийлэл)

Цаг хугацааг үл огоорсон өглөө, өдөр, оройны богинохон агшнуудад


Энэ бүхнийг ажиглан,
Хөх тэнгэрээр аялах мэт сэтгэлдээ нисэн
Тоологдом бодолд сүлэлдэн байтал,
Хэсэг бодлууд цойлдож эхлэв.
Эдгээрээс заримыг нь бугуйлдан
Тархиндаа тарлаж эхэлтэл,
Цээжинд нь гарч ирсэн нь “хонин холбоо” шиг
цэгцрэн
“Нэгэн бяцхан санаа” оч болон аслаа.

Таамаглал

Монгол сэтгэлгээг даяарчлалын нийгэмд ихээхэн хэрэгцээтэй байгаа **Resilience - мятаршгүй чанар**, **Adaptability - дасан зохицох чадвар**, **Thinking outbox - задгай сэтгэх**, **Creative thinking – бүтээлч сэтгэхүй**, **Problem solving – асуудал шийдвэрлэх гэсэн чадамжуудыг агуулсан байдлаар биш боловч, хамааралтай байдлаар тодорхойлж болно.**

Ерөнхий дүгнэлт

Бид цаашид “Монгол сэтгэлгээг” судалгааны түвшинд хөгжүүлэх хэрэгтэй байна.



ТЭМДЭГЛЭЛ

A large rectangular area with horizontal lines, intended for writing a summary. The lines are evenly spaced and cover the majority of the page below the title.

Бодож, сэтгэх хувь тавиланд төрсөн хүн гэгч бодгаль цаг ямагт тарган үнээ, дулаан оромжийн талаар боддоггүй. Ийм учраас Эртний Грекийн философичид “Гахайнд л философи хэрэггүй, түүнд хангалттай идэи тэжээл, дулаан саравч байхад л болно” гэдэг байж.

Тэгээд ч боловсрол, мэдлэг нь танин мэдэхүйн үйл ажиллагааны үр дүн юм бол англи хэлт орнуудын утга зохиолд эпистемологи, орос утга зохиолд голдуу гносеологи гэсэн үгээр илэрхийлдэг тэр зүйлтэй холбогдох нь гарцаагүй. Философийн танин мэдэхүйн онол хэмээн нэрийддэг салбар. Ингээд үзэхээр боловсролыг философигүй төсөөлөх аргагүй л дээ

Б.Батчулуун

Тэгвэл хятад хүний сэтгэлгээ, соёл ямар онцлогтой вэ? Хятад хүний сэтгэлгээний онцлог шинжүүдийн нэг нь тойруу дугариг сэтгэлгээ юм.

Тиймийн учир дорно дахины буюу хятад хүний сэтгэлгээг алсхи тойруу, харин өрнө дахины сэтгэлгээг асхан шулуун хэмээдэг.

М. Чимэdcээ

... Дайнд ялагдсаны дараахан япончууд улсынхаа онцлогийг хадгалж, Боловсролын тухай эзэн хааны айлдварыг ч халахгүйгээр ёс суртахууны боловсролыг олгох бодол тээж байсан ч, америкчуудын улс төрийн бодлого, түүнчлэн дотоодын шинэтгэгч талынхны эсэргүүцэлтэй тулгарснаар эдгээр санаа хэрэгжээгүй юм.

М.Тэмүүлэн

... шинжлэх ухаан, боловсрол, үйлдвэрлэлийн уялдааг хангах, хүний эрх чөлөө, үнэт зүйлсийг дээдлэх Өрнө ба Дорнын соёлын харилцан нөлөөллийг нийгмийн болон хүний хөгжлийн хэрэгцээнд нийцүүлэн боловсролын үзэл баримтлалд тусган хэрэгжүүлсэн байна.

Б.Алтангэрэл

БҮЛЭГ II

ХОЁР. ДЭЛХИЙН БОЛОН ЗАРИМ УЛС ОРНЫ БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИ

БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИ



ФИЛОСОФИЧ, ДОКТОР
Б.БАТЧУЛУУН

БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИ

Философи, тэр тусмаа боловсролын философи юунд хэрэгтэй юм бэ?

Мэдлэг, боловсрол хэрэгтэй гэдэг нь мэдээж. Боловсролтой инженер, эмч, багш өгөөжтэй ажиллаж, ихийг бүтээдгийг бүгд мэднэ. Тэгвэл боловсролын философи юунд хэрэгтэй юм, боловсролын философи гэж юу юм, ер нь философи амьдралд ямар хэрэгтэй юм бэ? Философи нь тарга, хүч сайтай шинэ үүлдрийн мал, сүүтэй үнээ, шинэ сортын тариа будаа гаргаж, ургацын гарцыг нэмэгдүүлдэггүй юм бол хэрэг байна уу! Нийгэм улам бүр прагматик шинжтэй болоод буй өнөө үед иймэрхүү асуулт гарахаас ч яах вэ гэж бодмоор.

Тэгвэл физик, хими, математик, биологи гээд шинжлэх ухааны аль нэг салбарын судалгаа гүнзгийрч, нарийсах тусмаа философидождог эхэлдгийг тухайн салбарт гүнзгийрсэн судалгаа эрхэлж байсан хэн бүхэн мэднэ. Математик, физик, биологийн философи ингэж л үүсдэг. Үүнтэй адил боловсролын талаар ихийг уншиж, бодож, эргэцүүлж, санаа зовнисон хэн ч гэсэн өөрийн эрхгүй боловсролын философи асуудлыг хөнддөг ажээ.

Бодож, сэтгэх хувь тавиланд төрсөн хүн гэгч бодгаль цаг ямагт тарган үнээ, дулаан оромжийн талаар боддоггүй. Ийм учраас Эртний Грекийн философичид “Гахайнд л философи хэрэггүй, түүнд хангалттай идэш тэжээл, дулаан саравч байхад л болно” гэдэг байж.

Тэгээд ч боловсрол, мэдлэг нь танин мэдэхүйн үйл ажиллагааны үр дүн юм бол англи хэлт орнуудын утга зохиолд эпистемологи, орос утга зохиолд голдуу гносеологи гэсэн үгээр илэрхийлдэг тэр зүйлтэй холбогдох нь гарцаагүй. Философийн танин мэдэхүйн онол хэмээн нэрийддэг салбар. Ингээд үзэхээр боловсролыг философигүй төсөөлөх аргагүй л дээ.

Чухам тэгээд боловсролын философи гэж яг юу юм бэ?

Нэг бодлын амархан, нөгөө бодлын хэцүү асуулт. Нэлээн хэв шинжит гэмээр хариулт өгье. Боловсролын талаарх ойлголт, бодомж, сэтгэлгээ дараах шаардлагуудыг хангасан байх юм бол боловсролын философи болно хэмээн бодогдож байна.

Нэгд, хэлэлцэгдэж буй ойлголт, нэр томьёо, онол, арга зүй нь философитой байх, эсвэл философиос урган гарсан байх. Хоёрт, сургалтын явц дахь аар саар, жижиг биш харин, тулгуур суурь, үндсэн асуудлыг авч үзсэн байх. Гуравт, боловсролын агуулга, хэл, логикийн асуудалд анхаарал тавьсан байх. Дөрөвт, боловсрол нь тухайн улс-орон, хүн амын эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцэж буй эсэхийг авч үзсэн байх. Энэ бүхэн нь хэн нэг багшийн толгойд санамсаргүй орж ирсэн бодол санаанаас арай өөр, гүнзгий суурь агуулгатай асуудлууд билээ.

Боловсролын философийн түүхэн тойм

Яах аргагүй, эртний Грекийн Сократ, Плато, Аристотелиос эхэлнэ. Өрнөдөд боловсролын философийн үүслийг Сократаас софистуудтай хийсэн маргаантай холбон авч үздэг. Плато, Аристотель нарын “Бүгд Найрамдах Улс”, “Улс төр” бүтээлд боловсролтой холбоотой олон санаа бий. Эдгээр мэргэд хүмүүст боловсрол олгох талаар хамгийн их санаа тавьж, оролдлого хийн, түүнээсээ болж, амиа ч алдаж байсан билээ. Сократ зах зээл, олимп гээд хаана хүн олноор цугласан байна, тэр газар очиж, хүмүүсийг соён гэгээрүүлж, боловсруулах ажлыг байнга хийдэг байв. Гэтэл түүнийг чухам залуучуудыг аливааг бодож эргэцүүлж, шүүмжлэлт сэтгэлгээнд сургалаа гэж

Афины ардчилагчид цаазаар авсан, сонин юм шүү. Плато, Аристотель нарын анх байгуулсан Академи, Лицей нь хүн төрөлхтний хувьд өнөөг хүртэл боловсрол, сургалт, судалгаа шинжлэх ухааны төв болсоор ирсэн юм.

Энэ гурваас арай хожим Ромын сэтгэгч Кюнтиллианы (MT-ын 35-95 он) “Уран илтгэх сургууль”, Дундад зууны Августины “Оюутан”, Шинэ үед Жон Локкийн “Боловсролын тухай зарим бодомж”, “Хүний ойлголтын тухай эссэ” ном гарсан нь бүгд боловсролын философийг бий болоход зохих хувь нэмрээ оруулсан бүтээлийн тоонд орно.

Боловсролын философийн системт эх үндсийг Ж.Ж.Руссогийн “Эмиль” бүтээл тавьсан гэж үздэг. Тиймээс ч түүнийг боловсролын философийн эцэг хэмээдэг аж. Ойролцоогоор энэ үед И.Х.Песталоццийн (Швейцарь, 1746-1827 он) “Гертруд хүүхдэдээ хэрхэн боловсрол олгосон бэ?”, Ф.Фрейбелийн (Герман, 1782-1852 он) “Хүний боловсрол” зэрэг бүтээл гарчээ.

20-р зуун бол боловсролын философийн хувьд онцгой зуун байлаа. Учир нь, хүн төрөлхтний хувьд өмнө нь газар тариалангийн хийгээд аж үйлдвэрийн гэсэн хоёр том хувьсгал гарчхаад байсан бол энэ зууны 50-иад оноос шинжлэх ухаан, боловсролын хувьсгал эхэлсэн юм.

20-р зуун дахь боловсролын философийн томоохон төлөөлөгчдийн тоонд АНУ-ын философич Ж.Дью, Английн философич Б.Рассэль ордог. Ялангуяа өгүүллийг тэрлэгчийн хувьд Нобелийн шагналт, философич, математикч, логикч Бэртран Рассэльд онцгой хүндэтгэлтэй ханддаг тул дараагийн хэсэгт боловсролын талаарх түүний үзэл бодлыг арай дэлгэрэнгүй авч үзнэ.

Энэ зуунд боловсролын философийн салбарт гарсан томоохон бүтээлүүдийн тоонд Иван Ильич “Сургуульгүй нийгэм” (1971 он), С.Боулс, Г.Жинтис “Капиталист Америк дахь сургууль” (1976 он), Пол Уиллис “Ажил, хөдөлмөрт суралцахуй” (1977 он), А.Х.Халсэй, А.Хэйт, Ж.М.Риж “Гараа, бариа: Орчин үеийн Англи дахь гэр бүл, анги, боловсрол” (1980 он) орно.

Тэгэхээр боловсрол гэдэг маань өөрөө юу юм бэ?

Янз бүрийн тодорхойлолт байдаг. Миний хувьд “ХҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ИХЭСГЭДЭГ МЭДЛЭГ” хэмээн тодорхойлбол хамгийн ончтой мэт санагддаг. Энд юуг онцлох гээд байна вэ гэвэл боловсрол гэдэг бол мэдлэгтэй салшгүй холбоотой гэхдээ, тэр мэдлэг нь амьдрал болон үйл ажиллагаанд ач тусаа өгдөг байх ёстой гэдгийг л цохон тэмдэглээд буй хэрэг. Хэчнээн их мэдлэг цуглуулж, хуримтлуулсан ч амьдрал, ажил хэрэгт нь тус болохгүй юм бол түүнийг боловсрол гэхэд хэцүү. Хүн мэдэхийн тулд мэддэггүй.

Английн философич Г.Спенсерийн (1820-1903 он) хэлснээр “Боловсролын үндсэн зорилго бол үйл ажиллагаа”. Хүн, хүний нийгэм амьд байж, оршин тогтнохын тулд үйлдэж, үйлдвэрлэж, бүтээж байх шаардлагатай. Гэхдээ хүн хийж буй хөдөлгөөн, үйлдэл, үйлдвэрлэл, бүтээх ажиллагаагаа ямагт үр дүнтэй байгаасай хэмээн хүсдэг. Тэгвэл үр дүнтэй болгодог зүйл бол мэдлэг, боловсрол юм.

Боловсролын талаар уламжлалт гэмээр тодорхойлолтууд ч бий. Муугүй, ухаалаг тодорхойлолтууд: Хүн төрөлхтөн болоод тухайн үндэстний цуглуулж, боловсруулсан байгаль, нийгэм, хүн, техник, технологийн талаарх танин мэдэхүйн үр дүнг (мэдлэг, дадлага, хандлагыг) үеэс үед дамжуулан бусдад эзэмшүүлэх явдал. Товчдоо, боловсрол гэдэг нь хүний ажиллаж, амьдрах ухаан соёлыг бусдад дамжуулах үзэгдэл.

Эртний Грект боловсролыг “полис”-доо (хот-улс, нийгэмдээ) амьдрах нөхцөл, иргэн болох хэрэгсэл хэмээн үзэж байж. Одоо ч мөн адил, аль ч улс-орны иргэд тухайн нийгэмдээ амьдрахад гарцаагүй шаардлагатай мэдлэг, чадвар, дадал, зуршлыг олгох явдал боловсролын үндсэн зорилго мөн.

Гэхдээ түүхэнд улс-үндэстнүүд боловсролын зорилгыг янз бүрээр тодорхойлж байв. Энэтхэгийн уламжлалт боловсрол метафизикч, шашинлаг, “нөгөө ертөнц” рүү хандсан шинжтэй бол Хятадынх практик амьдралд илүү хандсан шинжтэй учраас мэдлэгээс гадна ёс суртахууныг боловсролын нэгэн гол зорилго болгосон байх жишээний. Японы уламжлалт боловсрол үндсэрхэг үзэл дээр тулгуурласан цэрэг дайны мэдлэг чадварт анхаарсан байдгаараа эртний Грекийн спартуудынхтай нэлээн төстэй байжээ. Спартуудын хувьд боловсролтой хүн гэдэг бол ердөө цэрэг, зэвсэг, байлдааны талаарх мэдлэг, чадвартай хүн. Тэгвэл дундад зууны Европт боловсролтой хүн гэж бурхан, шашны талаар мэдлэгтэй хүнийг хэлдэг байв.

Монголчуудын уламжлалт боловсрол голдуу эмпирик ажиглалтаар бий болсон байгаль, цаг уур, газар зүй, мал аж ахуйн талаарх мэдлэгийг практик дадал юм уу, эсвэл амаар дамжуулан олгох явдал байв. 13-14-р зуунд цэрэг байлдааны боловсрол зонхилох шинжтэй болж ирсэн үе бий. Тэгснээ 17-р зуунаас боловсролын агуулгыг буддизм бүхэлд нь бүрдүүлэх болсон. Харин 1921 оноос ерөнхийдөө зөвлөлтөжсөн боловсрол Монголд ноёрхох болов. Боловсролын энэ системийн дутагдлын талаар сүүлийн үед нэлээн яригдсан тул орхизноод, Б.Рассэлийн боловсролын тухай санаагаа бага зэрэг дэлгэрүүлэе.

Б.Рассэль 1926 онд “Боловсролын тухай” хэмээх шашдираа гаргажээ. Түүнийхээр боловсрол гэдэг үзэгдлийн хамгийн гол утга учир ӨӨРИЙГӨӨ

ХӨГЖҮҮЛЭХ ПРОЦЕСС гэдэгт оршино.

Тэрээр, орчин үеийн дээд боловсролын үндсэн дутагдал бол тодорхой (мэргэжлийн. Зох.) мэдлэг эзэмшиж, ажил хийх чадвартай болохын тулд хэт их сургуулилж байна, суралцаж байх энэ хугацаанд хүний оюун ухаан, зүрх сэтгэл маш бага хөгжиж байна гэж үзсэн. Мөн үндэсний үзлийг боловсролд туйлын хортой хэмээн үзэв. Хэдийгээр, тэрээр либертари үзэлтэн байгаагүй ч боловсрол дахь төрийн оролцоог хурцаар шүүмжилж, боловсролыг индивидуализмтай нягт холбон авч үзжээ. Бага, дунд сургуулийн хувьд хүүхдийг эцэг, эх, багшийн дарамтаас чөлөөлөхийг голчилсон. Хүүхдийг дуулгавартай субъект болгохгүйн тулд аль болох чөлөөтэй бодож, сэтгэхэд сургах ёстой гэж байв. Түүний дахин дахин хэлж байснаар боловсролын зорилго бол боловсрол бус, (1) хүн оюун ухаан, бие махбодын хувьд эрүүл чийрэг (2) мэдлэгтэй болсныхоо ачаар айдсаас чөлөөлөгдөж, өөрийгөө хүндэтгэдэг, (3) бага уншиж, бага сонссон ч их зүйлийг олж авдаг сэтгэлгээний чадвартай, оюун ухаан нь хөгжсөн хувь хүн юм. Онцолж хэлэхэд, тогтоох, цээжлэх бус, харин сэтгэх чадвартай болгох нь маш чухал. “Усанд сэлж сурах гэж буй хүнд хөлгүй ус орчин нь болдог шиг (гүехэн усанд хүн хэзээ ч сэлж сурахгүй. Зох.) мэдлэг нь оюун ухааны хувьд хөлгүй байх ёстой” аж.

Энд яригдсан бүхнийг хураангуйлан дүгнэж, БОЛОВСРОЛЫН ЗОРИЛГО, АГУУЛГЫГ дараах байдлаар тодорхойлж болно:

- Нийгэмд амьдрахад нь зайлшгүй шаардлагатай мэдлэг-ухаан, дадлага-чадвар, хандлага-туршлагыг хүмүүст олгох;
- Тодорхой (мэргэжлийн) ажил хийх мэдлэг, чадвар, дадлага, туршлага олгох;
- Мэдлэгт тэмүүлж, түүнд сонирхон татагдаж, тэгснээрээ өөрөө улам хөгждөг болгох;
- Суралцагчдыг идэвхгүй субъект бус, шүүмжлэлтэй сэтгэдэг, аливаа зүйлд эргэлздэг болгох;
- Суралцагчдыг хүн төрөлхтний бүтээсэн үнэт зүйлийг ойлгож, мэдэрч, хүндэтгэж, үнэлдэг болгох.

Сүүлийн үед боловсролын салбар дахь зарим судлаач “боловсролын хямралын” тухай их ярих болж. Тэд шинжлэх ухаан, техникийн ололт, нээлтийн хурдац, хөгжлийг боловсрол гүйцэхгүй байна гэсэн үндэслэгээ гаргадаг. Энэ үндэслэлд тэр бүр найр тавих аргагүй. Шинжлэх ухаан, техник, технологийн ололт нээлт, дэвшил гарангуутаа нийтийн хүртээл болно гэж байдаггүй, энэ утгаараа “боловсролын хямрал” бол мөнхийн үзэгдэл. Тэгээд ч, тэдгээр ололт нээлт нийтийн хүртээл болох

түвшнийх гэж байдаг бол өөр өндөр дээд эрэмбийн ололт нээлт гэж байх аж. Тэр бүхнийг нийтийн боловсролын агуулгад багтаах гэж оролдох нь бэрхшээлтэйгээс гадна үр ашиг нь ч бага байж болох юм.

Боловсролын философийн талаарх энэ бэсрэг эссэнд асар олон зүйл орхигдох шинжтэй: Их сургууль, профессор, багш, сурагч, оюутан, докторант, үнэлгээ-дүн, сургалтын төлөвлөгөө, сургалтын арга, техник гээд. Гэхдээ орхичхож боломгүй нэг ерөнхий том сэдэв бол сургууль. Энд University хэмээх үнэхээр нэг том сэдэв орхигдож байна, утгаа University нь манайхны ойлгож, ярьдаг сургууль гэдгээс тэс өөр институци л дээ.

Боловсрол ба сургууль

Одоо нийтээр шахуу, боловсрол олгодог ганц байгууллага бол сургууль хэмээн ойлгож байна. Сургуульгүйгээр маш сайн боловсрол олсон олон хүн байдгийг анзаарахгүй байна. Ер нь, боловсролд сургуулийн гүйцэтгэх үүргийг бууруулан авч үздэг судлаачид ч байдаг. Тэдний гаргасан de-schooling society хэмээх ойлголт бол оргүй хоосон зүйл бас чиг биш. Түүхэнд нийгмүүд иргэдээ боловсруулж, иргэншүүлдэг янз бүрийн арга байж. Дуу-бүжиг, домог-яриа, ёс заншил, шашны зан үйл, гэр орны хүмүүжил, дасгал сургууль, дайн байлдаан, ан гөрөө, анги-танхим гээд. Тэдгээрээс шигшигдэж үлдсэн нь анги-танхимын сургалт, тиймээс ч боловсрол гэдгийг явцуу утгаар нь сургууль хэмээн ойлгох болж.

Бид сургуулийг боловсролын үндсэн байгууллага гэж үзэхдээ боловсрол олгодог бусад газар, орчинг орхих ёсгүй. Тухайлбал, номын сан боловсрол олох маш чухал газар. Өрнөдийн орнуудад номын санг “Их сургуулийн тархины цусан хангамжийн төв” хэмээн нэрлэдэг. Энд хувь хүний авьяас чадвар, оюун ухаан, тэсвэр тэвчээр голлох үүрэг гүйцэтгэнэ. Мөн тодорхой боловсролтой хүмүүсийн орчин (аав, ээж, ах дүү, гэрийн сайн номын сан гээд) бүрэлдсэн байх юм бол гэр орон ч боловсрол олох сайн газар болж чадна. За, тэгээд ашиглаж чадах аваас, музей, мэргэжлийн клубүүд, хэвлэл мэдээлэл зэрэг ч чухал үүрэгтэй.


Одоо хийх хамгийн том өөрчлөлт бол сургууль нь “багш сургаж, сурагч сурдаг” гэсэн өрөөсгөл хандлагатай газар байхаа болих ёстой хэмээн хаа сайгүй ярьж байна. Монголын ерөнхий боловсролын тогтолцоог хараад байхад 12-р анги төгсөж буй хүүхдүүдээс хэн нь багш болж байна, тэд их, дээд сургуульд орохдоо хэддүгээрт жагсаж байж багш болж байна, эргээд тэдний заасан хүүхдээс ямар нь багш болж, ямар нь зах зээлийн болон оюуны үйл ажиллагаа илүү их шаарддаг сургуульд орж байна гэдгийг бодох хэрэгтэй.

Хэцүү сэдэв, “би ЕБС төгсөхдөө ангидаа дундуурхан сурдаг байсан, тэгээд багш болсон хэрэг, миний заасан хүүхдүүдээс хамгийн сайн сурдаг, сэтгэдэг нь багш болдоггүй, харин дундуурхан сурлагатай нь багш болдог, мөн түүний сургасан хүүхдүүдээс мөн адил тийм хүүхдүүд багш болдог” гэх мэтчилэн төгсгөлгүй үргэлжилдэг орчилд орчхоод байна. Манай боловсрол, тэр тусмаа ерөнхий боловсрол “чөтгөрийн тойрогт” орчхоод байгаа юм биш биз гэдгийг эргэцүүлэх, хэлэлцүүлэх шаардлага гараад нэлээн удаж байна гэж бодогддог!

Эцэст нь, боловсролын талаар хүмүүсийн хэлсэн онч мэргэн үгсээс хавсаргая, тэдгээрт боловсролын философи санаа байгаа юм шүү.

- Боловсрол бол эрх чөлөөний алтан хаалга. Жорж Вашингтон (АНУ-ын анхны Ерөнхийлөгч, 1732-1799 он)
- Боловсрол бол ирээдүйд очих паспорт, энэ паспортыг авсан хүнд маргаашийн хаалга нээлттэй. Малкольм Х (АНУ, Хүний эрхийн төлөө тэмцэгч, 1925-1965 он)
- Боловсрол бол танаас хэн ч булаан авч, хулгайлж үл чадах тийм зүйл.
- Элин Нордегрэн (АНУ, Шведийн загвар өмсөгч, психологич, 1980 онд төрсөн)
- Боловсрол нь үргэлж хаалттай байдаг оюун ухааныг нээлттэй болгож өгдөг. (Малкольм Форбес, АНУ-ын бизнес эрхлэгч, улс төрч, “Форбес” сэтгүүлийн эрхлэгч, 1919-1990 он)
- Боловсрол бол ертөнцийг өөрчлөх хүчирхэг зэвсэг. Нельсон Мандела (ӨАБНУ, Арьс өнгөөр ялгаварлахын эсрэг тэмцэгч, Ерөнхийлөгч агсан, 1918-2013 он)

- Уншдаггүй хүн бичиг үсэг мэддэггүй хүнээс ялгаагүй. Марк Твэйн (АНУ-ын зохиолч, 1835-1910 он)
- Өөрийн боловсролын тухай бодож буй хүн юуны түрүүнд багшийн тухай боддог. Түүнээс биш сургалтын арга, техникийн тухай боддоггүй. Тэгэхээр багш бол боловсролын системийн амин сүнс мөн байгаа биз. Сиднэй Хуук (АНУ-ын философич, 1902-1989 он)
- Зүрхээ боловсруулаагүй байж тархиа боловсруулах аваас тэр ерөөсөө боловсрол биш. Аристотель
- Багшилна гэдэг бол мэдэж буйгаа бататгана гэсэн үг. Жозеф Жоубэрт (Францын ёс зүйн онолч, зохиолч, 1754-1824 он)
- Тархи бол ямар нэг зүйлээр дүүргэх ёстой сав биш, дүрэлзэн асах ёстой цог цучил шиг зүйл. Плутарх (Грекийн философич, түүхч, зохиолч, 46-119 он)
- Хүүхдэд ямар нэг зүйлийг мэдүүлж, сургах нь гол биш сэтгэж сургах нь гол юм. Маргарет Мийд (АНУ-ын соёлын антропологич, 1901-1978 он)
- Өөрөө сурч мэдэж сурах нь цорын ганц боловсрол мөн. Исаак Азимов (АНУ-ын зохиолч, биохимийн профессор, 1920-1992 он)
- Хичээл ангиас гарахад дуусдаг бол боловсрол насан турш үргэлжилнэ. Фредерик Уилям Робертсон (Английн шашны зүтгэлтэн, 1816-1853 он)



Хятадын соёлын онцлог



МУСЗ. ХЭЛБИЧГИЙН УХААНЫ ДОКТОР, МУИС
ХЯТАД СУДЛААЧ, ОРЧУУЛАГЧ

М.ЧИМЭДЦЭЭ

ХЯТАД ХҮНИЙ СЭТГЭЛГЭЭ, СОЁЛЫН ОНЦЛОГ

Аливаа нэг үндэстний соёл боловсролын тухай ярихад тухайн үндэстэн угсаатны сэтгэлгээнээс ангид авч үзэхийн аргагүй. Учир нь сэтгэлгээ, хэл, соёл нь өөр хоорондоо харилцан шүтэлцэж, харилцан нөлөөлж, харилцан нөхцөлдөж байдаг зүй тогтолтой ажээ.

Соёл хэмээхүй нь цар хүрээ нь өгүүлшгүй өргөн, агуулга хэлбэр нь үлэмж баян, нэн ээдрээ адармаатай нийгмийн үзэгдэл юм. Соёл нь тухайн үндэстэн угсаатны өөрийгөө үнэлэх үнэлэмж, сэтгэлгээний онцлог, амьдралын хэв маяг, аж төрөхүй ёсон, мэдлэг боловсрол, сүсэг бишрэл, ёс суртахуун, зан заншил зэрэг олон талыг багтааж байдаг бөгөөд тухайн улс орны түүх, уламжлалтай салшгүй холбоотой ажээ.

Хятадын соёлыг 5000 жилийн түүхтэй хэмээдэг. Урт удаан түүхийн нугачаан дунд тасалдаж бөхөлгүй эдүгээ хүртэл уламжилж ирсэн цорын ганц эртний соёл иргэншил болбоос хятадын соёл хэмээн үздэг. Английн нэрт түүхч А.Ж.Тойнби судалгааны бүтээлдээ тэмдэглэхдээ, сүүлийн 6000 жилийн түүхэнд дэлхий ертөнц дээр хүн төрөлхтний соёл иргэншлийн 26 төлөв байдал бүрэлдэн тогтож байсан бөгөөд тэдгээрийн дотор Хятадын соёл иргэншил нь урт удаан хугацаанд огт тасалдалгүй үргэлжлэн хөгжсөн цорын ганц соёл иргэншил мөн гэдгийг онцолсон байна. Хүн төрөлхтний нэн эртний 3 бичиг үсгийн нэг хэмээгддэг ханз үсэг бичгийн ул мөр, үүх түүх мөнхүү 5000 жилээр тоологдож байна. Эртний Сүмэрийн шаантаг бичиг, эртний Мисирийн дүрс бичиг нь олон мянганы урсгал дунд эс хэрэглэгдэхийн учир шалтгаанаар орхигдон мөхөж, харин эртний Хятадын утга бичиг болох ханз үсэг олон мянганыг дамжин ихэд өөрчлөгдөн хувирсаар энэ цаг үед уламжлан ирээд эдүгээ хэрэглэгдсээр байна.

Хятадын эртний хийгээд эдүгээгийн гүн ухаан, сэтгэлгээ, үндэсний уламжлалт соёл боловсрол гэсэн ойлголт ухагдахуун нь эртний их сэтгэгч Күнзийн нэртэй шууд холбогддог. Хятадын үндэсний уламжлалт гүн ухаан, сэтгэлгээ, соёлын тухай яриваас, Күнзийн гүн ухаан, сэтгэлгээ, соёлын тухай заавал ярих хэрэгтэй болдог.

Күнз (НОТӨ 551-479) 30 настайдаа, хүн төрөлхтний түүхэнд бараг анхны өөрийн номын сургуулийг үүтгэн байгуулж, сургах гэгээрүүлэх ажлыг орд өргөөнөөс олон түмний дунд түгээн дэлгэрүүлж, хэдэн арван жил хичээн зүтгэсээр шавь нарынх нь тоо 3000 хүрч байсан бөгөөд түүний дотор ном эрдэмд цолгорч тодорсон шавь 72 байсан тухай түүх шастирт тэмдэглэн үлдээсэн байдаг. Тийм учраас Күнзийг их сэтгэгч төдийгүй, их сурган хүмүүжүүлэгч, соён гэгээрүүлэгч гэж үздэг.

Күнз сургах гэгээрүүлэх ажилдаа уян хатан, олон янз хэлбэрийн арга ухааныг хэрэглэж байсан ажээ. Тухайлбал, хүн хүний авьяас билигт нь тохируулан сургах, сургах хийгээд суралцах хоёрыг хослуулах, харилцан суралцаж өсөж дэвжих, алхам дараатайгаар ахиж дэвших, нэг санаанаас нөгөө санааг ургуулан бодох, хэлэхийн хүслэн байвч, хэлж эс чадах хязгаарт хүрээгүй аваас эс сургах зэрэг шинжлэх ухаанч шинжтэй сургах арга ухааныг өвлүүлсэн гэж үздэг.

Хүн хүний авьяас билигт нь тохируулан сургах гэдэг нь Күнз “Эрдэм сургахуйд элдэв ялгал үгүй” (“Шүүмжлэл өгүүлэл-Вэй улсын Лин гүн хэмээхүйн арван тавдугаар бөлөг”) хэмээн сургаж, шавь нарынх нь ухаан бодол, зан чанар, хүсэл сонирхол өөр өөр ялгаатайн учир хүн хүний авьяас билигт нь тохируулан сурган гэгээрүүлэх аргыг бүтээлчээр нээсэн гэдэг.

Ухааруулж гэгээрүүлж сургах гэдэг нь Күнз ухааруулж, гэгээрүүлэх аргыг шавь нарыг сургах гэгээрүүлэх хэрэгт хамгийн эрт хэрэглэж байсан соён гэгээрүүлэгч хэмээдэг. Шавь нараа сургахдаа ердийн нэг дамжуулах аргаар бус, харин ухааруулж гэгээрүүлэх замаар сургаж байсан бөгөөд “Мэдэхийн хүслэн байвч нэвтэрч эс чадах хязгаарт хүрээгүй аваас бүү хэлэгтүн, хэлэхийн хүслэн байвч хэлж эс чадах хязгаарт хүрээгүй аваас бүү сургагтун. Нэгэн зүгийг зааж өгсөн атал нөгөө гурван зүгийг эс мэдэх аваас дахин бүү заагтун” хэмээн сургаж байжээ. Шавь нараа сургахдаа бие даан сэтгэх, нэгийг мэдвэл нөгөөг ухаарах, нэгийг асууж, хоёрыг мэдэх, нэгийг асууж арвыг мэдэх, “Урьд өмнийн хэргийг өгүүлэхүйд, ирээдүй хойчийн хэргийг угтан мэдэх”-ийг номлож байжээ.

Алхам дараатайгаар урагш хөтөлж сургах гэдэг нь Күнз шавь нарыг нэгэн сэтгэлээр, сэтгэл шулуудан, алхам дараатайгаар суралцах хэрэгт залж хөтлөн, “Алив эрдмийг мэдэгч хүмүүнээс ашид түүнд дурлагч хүмүүн дээр. Ашид тийн дурлагч хүмүүнээс асар эрдмээр баясагч хүмүүн дээр” хэмээн сургаж байсан ажээ. Харилцан суралцаж, хамтдаа өсөж дэвжих гэдэг нь Күнз шавь нараа сургаж гэгээрүүлэхдээ харилцан зөвлөлдөх, хамтдаа хэлэлцэхийг машид чухалчилдаг байжээ. Күнз асууж лавлах, тодруулах, ухаж ойлгохыг ихэд чухалчилдаг байсан гэх агаад “Хэрэг тохиохуйд “хэрхэн хийнэм”, “хэрхэн хийнэм” хэмээн эс бодох хүмүүнийг хэрхвээс зохилтойг би бас эс мэднэм” (“Шүүмжлэл өгүүлэл-Вэй улсын Лин Гүн хэмээхүйн арван тавдугаар бөлөг”) гэж сургасан байдаг.

Чиглүүлж хандуулж сургах гэдэг нь Күнзийн сургах гэгээрүүлэх үйл нь туйлын чиглэсэн шинжтэй байсан бөгөөд шавь нар нь өршөөл, ачлал, засаглал, эрдэмт сайд зэрэг олон сэдвээр асуухуйд яг нэгэн адил хариулт өгсөн зүйл бараг үгүй, бүгд өөр өөр, тухайн хүн хүнд нь чиглэсэн шинжтэй байдаг ажээ. Жи Кан Зы хэмээгч нэгэн хэргэмтэн засаглалын хэргийг асуухуйд, Күнз “Засаглал хэмээгч нь төв шударгууг хэлмүй. Өөрийн биеэр оройлон төв шударгуу байваас өөр бусад хүмүүн төв шударгуу бус байж яахин зүрхлэх буй?” (“Шүүмжлэл өгүүлэл-Янь Юань хэмээхүйн арван хоёрдугаар бөлөг”) хэмээн хариулсан нь чухам эрх хэргэмтэнд чиглэсэн сургаал хэмээдэг. “Өөрийн бие төв шударгуу бус аваас өрөөл бусдыг төв шударгуу болгохуй нь бэрх, өөрөө төв шударгуу бус атал өрөөл бусдыг яахин төв шударгуу болгож чадах буй” хэмээн сургаж байжээ.

Күнз сурах, сэтгэх хоёрыг хослуулахыг туйлын чухалчилж байсан ажгуу. Тэрбээр “Суравч эс сэтгэвээс төөрөлдмүй, сэтгэвч эс сурваас мунхармуй” (“Шүүмжлэл өгүүлэл-Засаглахуй хэмээхүйн хоёрдугаар бөлөг”) хэмээн сургаж,

сурах, сэтгэхийн диалектик холбоог маш оновчтой тодорхойлон өгүүлж, суралцахын тулд ном бичиг үзэх, ном бичиг үзсэнээр дүн шинжилгээ хийж сэтгэх ёстой бөгөөд “сурахуй” нь “сэтгэхүйн” үндэс суурь, “сэтгэхүй” нь “сурахуйн” амин сүнс хэмээн үзэж байжээ. Ном бичиг үзэхийн зорилго нь эрдэм ухааныг эзэмших явдал мөн бөгөөд гагцхүү сэтгэх замаар л ном бичиг дээрх эрдэм ухааныг эзэмшиж, өөртөө мэдлэг болгох учиртай ажгуу. Тийнхүү бүх юм сэтгэхээс, сэтгэлээс үүдэлтэй хэмээн үзэж, “сэтгэлийг төвшитгөхийн” чухлыг дурдаж, “Сэтгэл төвшин бус ахул, харав чиг эс үзэгдмүй, чагнав чиг эс сонсогдмүй, амтлав чиг эс мэдрэгдмүй” (“Их суртахуй”-долоодугаар бөлөг”) хэмээн сургасан байдаг.

Тэгвэл хятад хүний сэтгэлгээ, соёл ямар онцлогтой вэ? Хятад хүний сэтгэлгээний онцлог шинжүүдийн нэг нь тойруу дугариг сэтгэлгээ юм. Тиймийн учир дорно дахины буюу хятад хүний сэтгэлгээг алсхи тойруу, харин өрнө дахины сэтгэлгээг асхан шулуун хэмээдэг.

Хятад хүн хоолыг савхаар идэх агаад гаднаас дотогшоо савхдана. Өрнийн хүн хутга сэрээ хэрэглэнэ.

Хятад хүн нударга хавсран цээжнээ авч, дотогшоо мэхийн мэндчилдэг. Өрнийн хүн гар сунган гадагшаа мэндчилнэ.

Хятадын ханз үсгийг гаднаас нь дотогшоо хандсан хөдөлгөөнөөр бичдэг. Өрнө дахины бичиг үсэг нь зүүнээс баруун тийш гадагшаа (араб бичиг баруунаас зүүн тийш) бичнэ.

Энэ хэдхэн жишээнээс харахул хятад хүний үйл хөдлөл ямагт гаднаас дотогшоо хандсан байх ажээ. Олон мянганы өнө урт түүхийн явцад бүрэлдэж тогтсон үндэстэн угсаатны амьдралын хэв маяг, аж төрөх ёс зэрэг нь тухайн үндэстний өвөрмөц соёлын илрэл болж байдаг. Иймээс хятад хүн алга хавсран бөхийж мэндчилдэг тэрхүү соёл нь хятад хүний сэтгэлгээ “дотогшоо хандсан” байдагтай холбоотой ажээ. Эндээс үзэхүл өрнө дахин дэлхий ертөнцийг шулуун, зэрэгцээ шугамаар харж сэтгэдэг бол хятад хүн муруй, тойрог шугамаар харж сэтгэдэг ажээ.

Сэтгэлгээ хэлэнд тусаж, хэлээр дамжин илэрч, үндэстний өвөрмөц соёлыг цогцлоодог хэмээн судлаачид нотолдог. Өрнө дахины хүн өөрийн үзэл бодол, үнэлэлт дүгнэлтээ тухайн өгүүлэл нийтлэлийн бүлэг зүйлийн эхний өгүүлбэрээр илэрхийлдэг бол хятад хүн байр суурь үзэл бодлоо хамгийн эцэст нь өгүүлдэг байна. Хэрэв дуустал уншихгүй бол үнэлэлт дүгнэлтийг нь олж мэдэж чадахгүй. Хятадын уран зохиолын тайлал нь ямагт төгсгөлд нь байдаг. Зохиол тийнхүү шугаман шинжтэй өрнөлийн хүрээ хязгаараас хальж давж, эх адаг нь нэвт сүлэлдэн холбогдож, эхлэл нь далд битүүлэг өрнөсөөр, төгсгөл нь эхлэл болж байдаг.

Энэ нь хятад хүний тойруу дугариг сэтгэлгээ, цаг хугацаа, орон зайн ухамсарын илэрхийлэл, хятадын уламжлалт хүүрнэл зохиолын нэг онцлог юм.

“Хүнтэй уулзаад байдгаа бүү дэлгэ, хэлэх үгээ хэлэн дороо нуу” хэмээсэн хууч үг байдаг нь чухамдаа хятад хүний дугариг тойруу, далд битүүлэг сэтгэлгээний илэрхийлэл юм. Алдарт “Улаан асрын зүүд” зохиолд “Худлыг үнэн болгохуйд үнэн бас худал болмуй, үгүйг буй хэмээхүйд буй бас үгүй болмуй” хэмээн өгүүлсэн байдаг. Хятад хүний үг ярианы байдал, үйл хөдлөл нь театрын тайзан дээрх жүжигчин хүнтэй төстэй хэмээдэг. Угтаа бол зорьсон газар нь хоёр гуравхан алхаад хүрчих тийм ойрхон байсаар атал хятад хүн урт ханцуйгаа сажлан, уран хээнцэр ойр ойрхон намс намс алхлан, нэг бүтэн тойрог эргэж, сая зорилгодоо хүрэх нь тойруу дугариг сэтгэлгээний нийтлэг нэгэн дүр төрх гэдэг. Тийм учраас өрнө дахины соёлын бэлгэдлийг “загалмай хэрээс” хэмээн үздэг бол хятадын соёлын бэлгэдэл нь “тайжиту” хэмээх зураг юм. Загалмай нь нэг цэгээс дөрвөн зүгт тэлсэн хэрээс дүрс бөгөөд энд “төвөөс зугаах хүч” агуулагдаж байдаг ажгуу. Тэгвэл хятадын соёлын бэлгэдэл болох “тайжиту” зураг нь хоёр туйл нэгэн цагираг хүрээнд нэгдэн нийлж харилцан нөхцөлдсөн дүрс байх бөгөөд энэ нь Хятадын соёлын гүн чанадад “төвд тэмүүлэх хүч” оршдог жам ёсныг илэрхийлдэг ажээ.

Хятадын уламжлалт соёлоос нь тунаж, хятад хүний мах цусанд шингэж үлдсэн гэж хэлж болохоор сэтгэлгээ соёлын нэг онцлог болбоос хятад хүний сэтгэлгээний “далд битүүлэг байдал” (Үүнийг хятадаар “ханьшү” гэх бөгөөд “битүүлэг, гүн, далд” гэсэн утга илэрхийлдэг) гэдэг.

Хятад хүн өөрийн үзэл бодлыг хэзээ ч ил тод, шулуун шууд хэлдэггүй, ямагт дөлж тойруулж, далд битүүлгээр илэрхийлдэг. Тийм учраас хэн хүн тэр болгон хятад хүнтэй хичнээн ярилцаад ч сэтгэлийх нь цаад гүнийг нээж, уг санааг нь ухааж ойлгоход нэн бэрх.

Тайваний эрдэмтэн, нийтлэлч Бай Ян “Хятад хүнтэй ярилцахад гун хэцүү, хичнээн удаан ярилцаад ч дотроо юу бодож байгааг нь мэдэх аргагүй байдаг гэж гадаадын олон нөхөд надад ярьдаг. Үүнд гайхах зүйлгүй, гадаадын та нар байтугай, хятад хүн хятад хүнтэйгээ ярилцаад дотоод сэтгэлийг нь нээж чаддаггүй юм гэж би хариулдаг” (Бай Ян “Муухай хятад хүн”) хэмээн бичсэн байдаг.

Хятадын нэрт эрдэмтэн, профессор И Жунтянь “Хятад хүн бол нэгэн оньсого, хятадын соёл бол бас нэгэн оньсого. Тийм болохоор хятадын соёл дахь сэтгэлгээний дотоод цөм нь оньсогын доторх оньсого мөн” (И Жунтянь “Хятад хүний тухай сул яриа”) хэмээн бичжээ.

Хятад хүний үг яриагаа цэнэдэг, далд битүүлэг байдлаар илэрхийлдэг ийм сэтгэлгээ соёл нь

өнө эртний уламжлалтай, Күнзийн сэтгэлгээ соёлын “ёслол журам”, өршөөл энэрэл” хэмээх ухагдахуунтай салшгүй холбоотой бөгөөд зонхи дийлэнхи хятад хүн орчлон ертөнцөд оршин амьдрахуйн нэгэн ухаан болбоос даруу хичээнгүй, далд битүүлэг, тойруу дугариг байх явдал хэмээн үзэх болж, өөрийн үг яриа, үйл хөдлөл хийгээд өөр бусадтай харилцах явдал мөрийг “ёслол журмаар”-аар хянах болж, хятад хүний сэтгэлгээ соёлын далд битүүлэг, шууд бус, тойруу дугариг төрх байдал бүрэлдэн тогтдог гэдэг.

Хятад хүний сэтгэлгээ соёлын нэг чухал онцлог бол “нэр төрийн үзэл” буюу “нэр төрөө эрхэмлэх үзэл” юм. Хятадаар “миан зы” гэх бөгөөд монголчлон орчуулбаас “гадар”, “өнгөн тал”, “нүүр царай” гэсэн шууд утгаас гадна “нэр нүүр”, “нэр төр” “нэр хүнд” хэмээсэн шилжсэн утга илтгэдэг. Англи хэлний “reputation, face, prestige” орос хэлний “лицо, честь” хэмээх үгстэй дүйдэг.

Хятадын эртний “Турван зүйлийн үгээр хавсаргасан нэрт эрдэмтний хураасан бичиг” гэдэг номд “Хээрийн галуу нисэн үл хүрэх газарт хүмүүн нэр ашгийн тул эрсдэмүй” хэмээн бичсэн байдаг ажээ.

Эдүгээгээс 100 гаруй жилийн тэртээ Америкийн христийн шашин дэлгэрүүлэгч Артур Хэндэрсон Смит (1845-1942) хэмээх нэгэн санваартан Хятадад 22 жил амьдран суухдаа, “Хятад хүний зан төрх” (Arthur Henderson Smith “Chinese Characteristics”) хэмээсэн нэгэн ном бичсэн нь өрнө дахинд ихэд алдаршжээ. Тэрбээр уг номдоо хятад хүний зан төрхийн 20 гаруй онцлогийг заан дурдсаны дотор тэргүүн бөлөгт “нэр нүүрээ эрхэмлэдэг” тухай өгүүлж, “Хятадад “нэр нүүр” хэмээх ганц үг нь хэрэг дээрээ ээдрээтэй олон үгийн нийлбэр цогц агаад түүний агуулж буй утга санаа нь бидний дүрслэн өгүүлж чадах хийгээд мэдэрч чадах утга агуулгаас хавьгүй гүн гүнзгий юм. “Нэр нүүр” хэмээхүй нь хятад хүний олон чухал зан төрхийн учир битүүлэг цоожийг нээх түлхүүр болой” хэмээн бичсэн байна. Тийнхүү хятад хүний “мианзы” буюу “нэр нүүр” хэмээх ойлголтыг анх түрүү өрнөдахинд хөндөж тавьсан түүхтэй юм.

Хятадад хүмүүс хоорондын харилцааны хамгийн чухал хүчин зүйл бол нэр нүүр хэмээн үздэг. Нэр нүүрийг ихэд эрхэмлэхийн учир шалтгаанаар маш олон “жаяг журам” (rules on face) тогтжээ.

Хятад хүн аливааг шууд хэлдэггүй, ямагт тойруу замаар эерүүлж илэрхийлдэг, бусдын муу тал, гэм дутагдлыг шууд нүүрэн дээр нь хэлдэггүй, бусдын үзэл бодлыг эс зөвшөөрсөн ч шууд илэрхийлдэггүй. Тийм учраас хятад хүний санал бодлыг эрс тэс няцаах нь нэр нүүрийг нь эс бодсон хэрэгт тооцогддог. Хятад хүн өөрөө бусдад ямар сэтгэгдэл төрүүлж буйгаа ихэд анхаарахаас гадна

бусад хүн өөрийг нь хэрхэн үнэлж буйг машид чухалчилдаг. Бусад хүн өөрийг нь дорд үзэхийг ер тэвчдэггүй. “Мод үндсээ гэмтэхээс эмээнэ, хүмүүн сэтгэл гэмтэхээс эмээнэ” гэсэн утгатай зүйр үг байдаг нь чухамдаа “нэр төрөө эрхэмлэх сэтгэл”-ийг өгүүлсэн хэрэг юм.

Өрнө дахинд хувь хүний эрх чөлөөг ихэд эрхэмлэн, өөрөө өөрийгөө ямагт тэргүүнд тавин, бие даасан бодгаль хэмээн үздэг бол хятад хүний хувьд бусад хүн өөрийг нь хэрхэн үзэж буйг эн тэргүүнд чухалчилдаг. Өрнийн хүний “нэр төрөө эрхэмлэх сэтгэл” нь “хүн хүн өөрийн замаар, бусад хүн намайг юу гэх нь ер хамаагүй” гэсэн маягаар илэрдэг бол, хятад хүний хувьд бусдаар бахдуулж, бусдын бахдал, үнэлэмжийг олсноор “нэр төрөө эрхэмлэх сэтгэл” нь илэрдэг байна. Тиймийн учир “Бусдыг бахдах нь хүний эрхэм ёс суртахуун, нэгэн зүйлийн соёл боловсрол, нэгэн зүйлийн чадвар, бас орчлон ертөнцөд оршин амьдрахуйн нэгэн арга зам” хэмээн үздэг. Тийм учраас Хятадад “Хүн намайг тохой хүндлэвээс, би хүнийг алд хүндэлнэ” гэсэн хууч үг байдаг. Нэгэн бяцхан түүх байдгийг өгүүлбээс:

Хавар Намар Байлдаант улсын үед (НОТӨ 770-221) олон ханлиг улс эрх мэдлийн төлөө арцалдан тэмцэлдэж байжээ. Чи улсын Хуань Гүн эрч зоригоо хөвчлөн, улс гэрээ засаж, Чи улс ч бусад ханлигуудын дотор хамгийн хүчирхэг нь болжээ. Чи улсын эзэн Чин Гүний үед ихээхэн хүчирхэгжиж, Жинь, Лу, Вэй, Цао зэрэг бусад зэргэлдээ улс дагаар орж, жил бүр ихээхэн өргөл барьц өргөн барьдаг байжээ. Нэгэн жил дээрх 4 ханлиг улс нэгэн зэрэг 4 элч томилон, Чи улс руу илгээсэн байна. Гайхалтай нь дээрх 4 улсын элч бүгд зэрэмдэг хүмүүс байж. Жинь улсын элч нүд өрөөсөн, Лу улсын элч толгой хожгор, Вэй улсын элч хөл доголон, Цао улсын элч нуруу бөгтөр байж гэнэ. Чи улсын эзэн Чин Гүн зэрэмдэг элч нараар зориуд доог тохуу хийж, өөрийн эхийг баясгасугай хэмээн сэтгэжээ. Тийнхүү сохор, хожгор, доголон, бөгтөр хүн тус бүр нэгийг олж ирүүлж, элч нарыг зориуд асруулж харгалзуулжээ. Хатан эх хийгээд ордны эмс тэднийг хараад ихэд хөхин баясаж, элдвээр элэглэн шоолж гэнэ. 4 улсын элчис нэр нүүрийг нь ихэд доромжлон гутаасанд машид уурлан хилэгнэж, Чи улсыг дайлан мөхөөх тухай зөвшин хэлэлцжээ. Тийнхүү 3 жилийн дараа, 4 улс нэгдсэн холбоо байгуулан, Чи улсыг их хүчээр дайлаар мордож, Чи улс ч ихэд ялагдан доройтож, дахин ер сэхээгүй гэдэг.

Энэ болбоос бусдыг дорд үзэн, нэр нүүрийг нь гутааж доромжилсоны хариуд хүртсэн гашуун сургамжийн тухай түүх гэдэг.

Хятад хүний аж амьдралын гол амин зуулга нь өнө эртнээс нааш газар тариалан байсаар ирсэн түүхтэй. Газар тариалан бол хятад хүний

оршин тогтнохуйн эх үндэс юм. Тийм учраас газар тариалангийн үйлдвэрлэлийн хэм хэмнэл нь хятад хүний өдөр тутмын амьдралын хөг хэмнэлтэй зохицон нийцэж байдаг ажээ. Уламжлалт олон зан заншил, баяр ёслол нь шашин суртахуунтай холбогдох нь бараг үгүй, үндсэндээ газар тариалангийн ажил үйл, цаг улирлын хэмнэл мөчлөгтэй холбоотой хэвшиж бүрэлдсэн байна.

Хятад хүний хувьд ертөнцийн бодит хэрэг үйлийг эрхэмлэдэг янагуух сэтгэлгээ нь ертөнцийн гаднах зүйлийг чухалчилдаг чанагуух сэтгэлгээнээс хэзээ ямагт давамгайлж ирсэн хэмээдэг. Энэ нь хятадын уламжлалт соёлын хөрс суурь нь чанагуух чанар бүхий шашин суртахуун биш харин янагуух чанар бүхий бодит байдлыг эш үндэс болгодог Күнзийн сургаал номлол мөн болохыг илтгэн харуулдаг.

XX зууны Хятадын томоохон сэтгэгч, нэрт гүн ухаантан Пэн Юлань “Күнзийн сургаал номлол болбоос нийгмийн зохион байгуулалтын гүн ухаан, тиймийн учир өдөр тутмын амьдралын гүн ухаан юм. Харин Даогийн сургаалтан хүний дотоод сэтгэлийн аяндаа үүсдэг зүйлийг онцолдог. Күнзийн сургаалтан “дотогшоо аялдаг” учраас нэлээд янагуух байдаг, Даогийн сургаалтан “гадагшаа аялдаг” учраас нэлээд чанагуух байдаг. Энэ хоёр хандлага харилцан эсрэгцэх боловч бас харилцан нөхөлддөг.” (Пэн Юлань “Хятадын философийн товч түүх”) хэмээн бичжээ.

Хятад хүний сэтгэлгээ машид прагматик байдаг. Үүнийг бид аж сэтгэлгээ хэмээн оноож орчуулдаг. Хятадад ийм нэгэн бяцхан үлгэр байдаг. Нэгэн гүн ухаантан гол дээгүүр завиар аялж явжээ. Тэрбээр завьчинаас “Та гүн ухаан гэж юу болохыг мэдэх үү? хэмээн асуужээ. Завьчин “Би мэдэхгүй” гэхэд “Та тэгвэл амьдралынхаа тэн хагасыг алдаж байгаа юм байна даа” хэмээжээ. Төдөлгүй хүчтэй салхи шуурга дэгдэж, завь хөмрөх аюул тулгарахад завьчин өнөөх гүн ухаантнаас “Та усанд сэлж чадах уу?” хэмээн асуухад гүн ухаантан “Чадахгүй” гэжээ. “Та тэгвэл бүх амьдралаа алдаж байгаа юм байна даа” хэмээн завьчин хэлсэн гэдэг. Энэ бол хятад хүний аж сэтгэлгээний (прагматик сэтгэлгээ) тухай өгүүлсэн жишээ хэмээдэг.

Өрнө дахины хүний хувьд логик сэтгэлгээ давамгайлдаг бол дорно дахин буюу түүний дотор хятад хүний хувьд диалектик сэтгэлгээ давамгайлдаг байна. Өөрөөр хэлбэл, өрнийн хүний рациональ сэтгэлгээ (rational knowledge) илүүтэй хөгжсөн байдаг бол хятад хүний хувьд хүртэн мэдэрч ухааж ойлгох сэтгэлгээ (perceptual knowledge) илүүтэй хөгжсөн байдаг ажээ.

Япон
Философи
Түүх



“ЯПОНЧУУДЫГ БҮТЭЭСЭН БОЛОВСРОЛ”-ЫН НОМЫН
ОРЧУУЛАГЧ

М.ТЭМҮҮЛЭЙ

ЯПОНЫ БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИЙН ТҮҮХ, АСУУДАЛ

Японы боловсролын философийг судлах нь:

Миний хувьд Японы боловсролын түүхийг судлах болсон нь 1990 онд Монгол улсад өрнөсөн ардчилсан хувьсгалтай холбоотой. Нэг нийгэм нөгөөгөөр солигдоход өмнөх нийгмийн үнэт зүйлс үгүйсгэгддэг ажээ. Япон улсад суралцах боломж гарахад, Мэижигийн шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлж дөчөөд жилийн дотор Азид анхлан орчин үеийн улс болж хөгжсөн Япон улсын нууцыг япон хүнийг бүтээсэн боловсрол талаас нь судалж, улмаар монголчууд бид цаашид ямар үзэл санаа, үнэт зүйлд тулгуурлан монгол хүнийг бүтээж, ёс зүйтэй иргэдтэй, баян чинээлэг улс болж хөгжих вэ гэдэг асуултыг өөртөө тавьсан юм.

Ингээд Киото хотын Доошиша их сургуулийн боловсрол судлалын тэнхимд Японы сэтгэлгээний түүх, Японы боловсролын түүх судлаач Окита Юкүжи¹ профессорын удирдлага доор бакалаврын дипломын ажлаа “Японы орчин үеийн боловсрол дахь элитүүдийг бэлдэж ирсэн боловсролын түүхийн судалгаа”, магистрын ажлаа “Бакүмацү, Мэижигийн үеийн гооши давхарга²-ын үзэл санааны төлөвшлийн талаарх боловсролын түүхийн судалгаа” сэдвээр тус тус бичсэн.

Би 2023 онд удирдагч багш Окита Юкүжигийн “Япончуудыг бүтээсэн боловсрол: Уламжлал ба орчин үежилтээс даяаршил руу”³ номыг орчуулан гаргасан бөгөөд энд гол төлөв уг бүтээлээс эшлэн та бүхэнд хүргэж байна.

Окита Юкүжи Японы орчин үеийн боловсролын философийн түүхийг судлахдаа уламжлал болон тэрхүү уламжлал ондоо (*барууны*) соёлыг хэрхэн хүлээн авч ирсэн талаар судалсан байдаг.⁴ “Япончуудыг бүтээсэн боловсрол” номын гарчгийг харахад дээрх судалгааны арга бас харагддаг юм.

Японы боловсролын уламжлал бүрэлдэн тогтсон хугацааг Эдогийн үе (1603-1868) гэж үздэг. Эдогийн үе бол Япон улс дотроо дайн тулаангүй энх тайван байдлаа хадгалж, дэлхийд хаалттайгаар⁵ хөгжсөн 265 орчим жилийн түүх байдаг. Нийслэл Киотод эзэн хаан залравч, үнэндээ Эдо (одоогийн Токио)-д байрлах шёогүн буюу цэргийн жанжнаар удирдуулсан 270 орчим хошуудтай, хошуу ноёд тухайн орон нутагтаа эрх мэдлээ хэрэгжүүлж, харьцангуй бие даасан засаглал явуулж ирсэн цаг үе байдаг. Хошуу ноёд харьцангуй бие даасан засаглал хэрэгжүүлж байсан нь боловсролын үйл ажиллагаанаас нь харагддаг.

¹ Окита Юкүжи нь Японы сэтгэлгээний түүх болон Японы боловсролын түүхээр давхар мэргэшихдээ зөвхөн тодорхой он цаг дотор судлах бус, өргөн хүрээтэй судалгаа хийж ирсэн эрдэмтэн юм. Гол бүтээлүүдээс нь дурдвал “Японы орчин үеийн боловсролын сэтгэлгээний түүхийн судалгаа – Глобалчлал ба сэтгэлгээний суурь” (1992), “Япон хүнийг бүтээсэн боловсрол – Тэракояа, шижүкү, ханко сургуулиуд” (2000), “Япончуудыг бүтээсэн боловсрол: Уламжлал ба орчин үежилтээс даяаршил руу” (2017), Ёкон Шёонан (2021) зэрэг болно.

² Гооши давхарга (郷土層) - Шёоя буюу тосгоны ахлагчдаас голдуу бүрдэх орон нутагтаа нөлөө бүхий чинээлэг тариачдыг хэлнэ. Удирдагч анги болох самураи болон энгийн тариачин ардыг холбох үүрэг хүлээж байснаас гадна, Эдогийн үеийн сүүлчээр тодорхой хэмжээний хөрөнгө чинээтэй болсон гооши нар орон нутгийн удирдагч давхаргын хувьд өөрсдийгөө боловсруулах, үр хүүхдүүдээ сургах боловсролын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох болсон байв. Японы орчин үежилтийн амжилтыг удирдагч самураи ангийн манлайлалтай холбосон судалгаанууд олон ч, ард түмний дунд байж тэднийг зөв залж ирсэн дундаж ангийн төлөөлөл болсон гооши нарын үүрэг ролийг гаргаж ирсэн судалгаанууд сүүлийн үед гарсаар байна.

³ 沖田行司『日本国民をつくった教育：寺子屋からGHQの占領教育政策まで』2017年、ミネルヴァ書房

⁴ Окита Юкүжи “Японы орчин үеийн боловсролын сэтгэлгээний түүхийн судалгаа – Глобалчлал ба сэтгэлгээний суурь” (1992)

⁵ Зөвхөн Голланд, Хятад улстай тогтсон хэдхэн газраар холбогдож байсан.

1853 онд Америкийн цэргийн усан онгоц Японы эрэгт хүрч ирэн улсаа нээхийг шаардахад, Япон улс тэрхүү уламжлалт тогтолцоог шинэчилж, асар хурдан орчин үежих шаардлагатай тулгардаг. Орчин үежих процесс амжилттай хэрэгжсэнийг Япон улсын Чин улс (1894-1895 он) болон Орос улс (1904-1905 он)-тай хийсэн дайнуудын ялалт баталдаг билээ. Харин 1945 онд дэлхийн хоёрдугаар дайнд Япон улс ялагдал хүлээхэд, тэд “дахин төлөвших” шаардлагатай тулгардаг. Энэхүү шаардлага дотоодоос төрөн гарсан гэхээсээ илүү гаднын нөлөөгөөр үүсэж, Америкийн бодлогоор хийгдэнэ. Эдийн засгийн өндөр өсөлтийн жилүүд (эдийн засгийн хөөсрөл)-ийн дараа буюу 1990-ээд оноос япончууд даяаршилтай тулгарсан.

Япон улсын боловсролын түүхээс улс төрийн үзэл санаа, боловсролын үзэл санаа хоёр холбоотой явж ирснийг харж болно. Монголчууд бид 30-аад жилийн өмнө ардчилсан тогтолцоо руу шилжсэн ба бараг энэ шилжилттэй давхцаад даяарших процесстэй нүүр тулсан. Уламжлалаа эргэн харж, үнэлж дүгнэх, ардчилал, даяаршлыг ялангуяа боловсролын салбарт хэрхэн хүлээн авах вэ гэдгийг үзэл санааны хувьд гаргаж тавих, хэлэлцэх ажил юу юунаас илүү чухал байгаа билээ.

Эдогийн үеийн сургалтын хэлбэрүүд, боловсролын үзэл санаа

Төрийн сургууль Гакүмонжэ⁶ (Эрдмийн өргөө) нь, 1630 онд күнээч Хаяаши Разаныг нийслэл Киотод хувийн гэрийн сургууль болох Тахилгын сүмийг байгуулахад анхны шёогүн Токүгава Ияясү газар олгож дэмжсэнээр анх суурь нь тавигджээ. Цэргийн жанжин ийнхүү боловсролын үйл ажиллагааг дэмжих болсон шалтгааныг, язгууртнуудын засаглалаас цэргийн эрхтний засаглал руу шилжих шилжилтэд улс орныг удирдах самураи ангид шинэ дүр төрх хэрэгтэй болсонтой холбож үздэг. Нийгмийн дээд давхаргыг төлөөлөхийн хувьд тэд доор нь байгаа тариачин, гар урлаач, худалдаачин давхаргад ёс суртахууны хувьд үлгэр дуурайлал үзүүлж, нийгмийн хэв журмыг сахиулах үүрэг хүлээдэг. Тиймээс ч ёс суртахууныг нэн тэргүүнд тавьдаг Күнзийн сургаалын нэг урсгал болох Жузын сургаалын сургуулийг дэмжсэн байв.

Харин олон янзын эрдмийн урсгал хөгжих болсноор самураи нарын дунд эрдмийн бүлгээс үүдэлтэй засаглалын тэмцэл гарах болсон тул, 1790 онд Жузын сургаалыг “зөв сургаал” хэмээн бусад эрдмээс ялгаж, Гакүмонжэ (тухайн үед Тахилгын сүм)-д бусад сургаал номлолуудыг заахыг хоригложээ. Бүши буюу самураи нарыг хүмүүжүүлэх гол үзэл санаа Эрдэм мэдлэг, эрэлхэг

чанарыг хослуулах (文武兩道) хэмээх үгэнд багтаж байв. Самураи тулаанд суралцахаас гадна, эрдэм номд бас суралцах ёстой байв. Гакүмонжэд суралцсан олон самураи хожим нь тус тусын хошуунд буцаж, хошуу сургууль ханко (藩校)-хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулжээ.

Дээр дурдсанчлан, Эдогийн үед хошууд харьцангуй бие даасан засаглал явуулж байсан бөгөөд байгуулагдсан цаг хугацааны хувьд янз бүр боловч, Мэижигийн шинэчлэл хүртэл нийтдээ 276 хошуу 280 хошуу сургууль болох ханког байгуулж, хошууныхаа удирдагч, албан хаагчдыг бэлддэг байв. Ихэнх ханко хошууны засаглалын шинэчлэлийн жилүүдэд (1750-1870) байгуулагдсаныг Ишикава Мацүтарогийн судалгаа харуулдаг. Хошууны засаглалын шинэчлэл сургуулийн үйл ажиллагаа хоёр салшгүй холбоотой явж ирснийг үүнээс харж болно. Ханко сургуульд ерөнхийдөө тухайн хошууны самураигийн хүүхдүүд суралцах бөгөөд дээд албан тушаалын самураигийн хүү, ялангуяа гэр бүлийн эрх мэдэл, цалин пүнлүүг өвлөх ууган хүү байх тусам заавал суралцах үүрэг хүлээж байв. Бакүмацүгийн⁷ үе руу ойртох тусам самураигийн үр хүүхдээс гадна, хошууны засаглалын үзүүрт тариачдыг удирдаж байсан шёоя (тосгоны ахлагч) нарын хүүхдийг ч хамтад нь сургах явдал ихэсжээ. Ханко бол хошууны элитүүдийг бэлдэх сургалтын байгууллага байсан хэмээн Окита Юкүжи цохон тэмдэглэсэн байдаг.⁸ Ханкод Күнзийн сургаалын дөрвөн ном болох “Шүүмжлэл өгүүлэл”, “Их суртахуй”, “Мэнз”, “Хэв дундын ёсон” зэрэг номуудыг Жузын сургаалыг үндэслэгч Жу Ши-гийн эмхэтгэсэнээр судлан, ёс суртахуунд тулгуурлан төрийн хэргийг явуулахыг чухалчилж байв. Гэхдээ цаг хугацаа наашлан, Мэижигийн шинэчлэл руу ойртох тусам тухайлбал, Сацүма хошууны ханкод анхандаа Жузын сургаалыг заах дүрэмтэй байсан ч, дараа дараагийн хошуу ноёдын бодлогоор Япон судлалыг, адмирал Перригээр удирдуулсан Америкийн усан онгоц Японы эрэгт хүрч ирснээс хойш барууны шинжлэх ухааныг сургалтдаа нэмжээ. Голланд судлал, барууны анагаах ухаан, шинжлэх ухааны сургалтыг ханкогийн сургалтад оруулсан Сацүма хошууны ноён Нариакира эрдэм мэдлэг зөвхөн тухайн эрдмийн төлөө оршиж, бодит нөхцөл байдлаас тусдаа байх биш, харин эрдэм номд тухайн цаг үеийн асуудлыг тусгаж суралцсанаар жинхэнэ эрдэм болно гэж үзэж байв.

Ханко нь дунд, дээд боловсролын байгууллагын үүргийг гүйцэтгэхдээ, дээр дурдсанчлан удирдагч анги болох самураи нарын үр хүүхдүүдийн заавал суралцах газар, ерөнхийдөө Жузын сургаалыг

⁶ 1797 онд Хаяаши гэр бүлээс салгаж Гакүмонжэ нэртэй болгосноор жинхэнэ утгаараа төрийн сургуулийн үүргийг гүйцэтгэх болдог.

⁷ Бакүмацүгийн үе – 1853 онд Перригээр удирдуулсан хар усан онгоц Японы эрэгт ирж, улсаа нээхийг шаардсан цаг үеэс Мэижигийн шинэчлэл эхэлсэн 1868 оныг хүртэлх хугацаа.

⁸ Окита Юкүжи “Япончуудыг бүтээсэн боловсрол” хуудас 85

гол болгосон сургалтын хөтөлбөртэй, хошуунаас байгуулсан сургууль байв. Адилхан дунд, дээд боловсролын байгууллагын үүрэг гүйцэтгэх ч анги давхарга хамаарахгүйгээр тухайн сургуулийн үйл ажиллагааг эрхлэн явуулагч багшийн эрдмээс суралцах хүсэлтэй буюу суралцагчийн өөрийнх нь сурах хүсэл эрмэлзэл дээр суурилсан хувийн сургууль болох шижүкү (私塾) гэж байв. 1872 оны Боловсролын яамны бүртгэлд 1500 шижүкү бүртгэгджээ. Мэижигийн шинэчлэлийг гардан гүйцэтгэсэн төр нийгмийн олон зүтгэлтнийг төрүүлсэн “Мацүшита сонжүкү”, Японы орчин үежилтийн оюун санааны эцэг хэмээгддэг Фүкүзава Юкичигийн суралцсан “Тэкижүкү” гээд одоо ч нэр нь дурсагддаг энэхүү сургалтын байгууллага нь эрдэм номын эрх чөлөө, олон талт шинжийг агуулж байснаараа хуучнаас шинэ нийгэмд шилжих шилжилтийг гардан гүйцэтгэх манлайлагч түүхэн хүмүүсийг төрүүлсэн байдаг. Шижүкүд төрийн сургууль Гакүмонжэ болон хошуу сургууль ханкод үзэх боломжгүй Жүзын сургаалыг шүүмжлэх Сораи сургууль (徂徠学), Күнзийг Жү Шигийн тайлбараар бус эхийг нь уншихыг сургадаг коги сургууль (古義学), Япон судлал (国学), Күнзийн сургаалын бүх урсгалуудаас сайн талыг нь авч өөрийн эрдэм болгохыг сургадаг холимог сургууль (折衷学), барууныг судлах Голланд судлал (蘭学) зэрэгт суралцах боломжтой байв. Түүнчлэн шижүкүг эрхлэгч багш бүр өөр өөрийн онцлог сургалтын арга зүйтэй байв.

Эцэст нь эдгээр дунд, дээд боловсролын байгууллагуудын доор бага боловсрол эзэмшүүлэх жирийн ардын эрхэлдэг хувийн сургууль болох тэракоя (寺子屋) хэмээх сургалтын байгууллагыг товч танилцуулъя. XIX зууны эхэнд япончуудын бичигт үсэгт тайлагдсан байдал 70 гаруй хувьтай байсан гэдэг. Үүнд тэракоя сургуулийн нөлөө их. Тус сургуульд хүүхдүүд 7,8 насандаа элсэж, 4-өөс 5 жил анхан шатны бичиг үсэг, тоонд суралцахаас гадна гэр бүлийн эрхэлдэг аж ахуй, ажил мэргэжлийг эрхлэхэд хэрэг болох ажил мэргэжлийн анхан шатны мэдлэгийг гар бичмэл сурах бичгүүдээр дамжуулан олж авдаг байв. Ийнхүү жирийн ард үр хүүхдээ бичиг үсэгт сургах болсон шалтгааныг XVIII зууны дундуур ХАА-н технологи сайжирснаар худалдааны зориулалттай тариалалт хөгжиж, нутаг нутгийн бүтээгдэхүүн орон даяар нийлүүлэгдэх боломжтой эдийн засаг бүрэлдсэнтэй холбодог. “Японы боловсролын түүхийн материал”-д нийт тэракоягийн тоо 15,000 гаруй гэж бүртгэгдсэн байдаг ч, сүүлийн жилүүдийн судалгаануудын үр дүнд энэ тоо хоёр дахин их болжээ. Энэ нь хүн амын

тоотой харьцуулбал, одоогийн бага сургуулийн тоотой дүйцэх ажээ.⁹

Орчин үежилт (модернизаци) ба боловсролын шинэчлэл

Гаднын түрэмгийлэгчдийн эсрэг зогсож чадаагүй Бакүфү (цэргийн эрхтний засгийн газар)-д нөлөө бүхий хошуу ноёд шахалт үзүүлэх болсноор шөөгүн засгийн эрхээ эзэн хаанд эргүүлэн өгч, 1868 онд эзэн хаан тэргүүтэй засгийн газар байгуулагдав. Шинэчлэлийн засгийн газар Япон улсыг орчин үеийн улс болгох Мэижигийн шинэчлэлийг эхлүүлжээ. Шинэчлэлийн засгийн газрын гол бодлого дотооддоо тогтвортой нэгдсэн улсыг байгуулах, олон улсад өөрийн бүрэн эрхийг хадгалж “Чинээлэг улс-Хүчирхэг арми”-ийг уриа болгож, барууны орнуудын нэгэн адил орчин үеийн төрт улсыг байгуулахад оршиж байв. Үүний тулд япон үндэстнийг бүтээж, улсын хөгжилд хувь нэмрээ оруулах чадварлаг боловсон хүчнийг бэлдэхийг чухалчилна. Ингээд 1872 онд Францын сургуулийн тойргийн тогтолцоо, Америкийн боловсролын агуулгаас хуулбарласан боловсролын тогтолцоог бүрдүүлдэг. Ингэхдээ дээрх тогтолцоонуудыг шууд хуулбарлаагүй бөгөөд Японы нөхцөл байдалд тохируулан өөрчилжээ. Шинэ тогтолцоог олон нийтэд зарлахын өмнө “Эрдмийг хөхиүлэн дэмжихтэй холбоотой зарлиг”-ийг олон нийтэд хүргэжээ. Уг зарлигаар эрдэм боловсролоор дамжуулан нийгэмд байр сууриа эзлэх (立身出世) боломж дөрвөн ард¹⁰ -д бий гэдгийг зарлав. *Шинээр бий болсон боловсролын тогтолцооны гол онцлог гэвэл, хүн бүр өөрийн суралцах чадвар болон санхүүгийн боломждоо тааруулан ямар нэгэн байдлаар боловсрол эзэмших боломжтой байхаар бүрдүүлсэнд бий.*

Бага сургуулийн боловсрол эзэмших хүртэл ерөнхийдөө бүгд нэг замаар дэвшин суралцах боловч, түүнээс дээшээ бол олон салаатай буюу их сургуульд элсэн суралцах, эсвэл дунд сургуульд суралцаад цаашаа анагаах ухаан, инженер, ХАА-н чиглэлээр дээд түвшний мэргэжлийн сургуульд суралцах, нэг бол бага сургууль төгсөөд ХАА, худалдаа, аж үйлдвэрийн чиглэлээр суралцах зэрэг ажил мэргэжилд хүрэх маш олон боломж бүхий тогтолцоог бүрдүүлж өгчээ. Ийм тогтолцоог олон салаат тогтолцоо гэх бөгөөд уг тогтолцоог ардчилсан бус гэх нь бий ч, *бүх хүнийг нэг “зам” дээр уралдуулж, үр дүнд цөөн хэдэн ялагч төрдөг тогтолцооноос ялгаатай, нийгэмд байр сууриа эзлэх олон боломжтой, явсан “зам” бүрдээ орой дээр нь гарах боломж бүхий тогтолцоо гэж Окита Юкүжи үздэг.*

⁹ “Япончуудыг бүтээсэн боловсрол” хуудас 26

¹⁰ Бүши буюу самурай, тариачин, гар урлаач, худалдаачин гэсэн 4 ардаас орчин Мэижигийн шинэчлэлээс өмнөх феодалын нийгэм бүрдэж байв

Орчин үеийн сургуулийн тогтолцоо бүрэлдээд удаагүй байсан үед сургуульд мэдлэг олгохыг чухалчлав. Учир нь барууны шинжлэх ухаан, технологийг нэвтрүүлж, орчин үеийн аж үйлдвэржсэн улс болоход ёс суртахууныг чухалчилсан уламжлалт боловсролоос илүү мэдлэг олгох нь чухал байв. Хаант засаглалыг сэргээж байгуулагдсан Шинэчлэлийн засгийн газрын үйл ажиллагаанд эхэндээ Шинто шашны зөвлөл нөлөөтэй байв. Тиймээс ч уламжлалт Шинто шашны номлолыг гол түшиг тулгуур болгон япон үндэстнийг төлөвшүүлэхийг оролджээ. Харин өрнийн соёл иргэншил, тэгш эрх, эрх чөлөөг магтан дуулсан үзэл түгэх болсноор, Эрх чөлөө ардын эрхийн хөдөлгөөн¹¹ өрнөх болж, дотоодод эмх замбараагүй байдал үүсэх нөхцөл бүрдэв. Засгийн газар энэ байдалд дүгнэлт хийн, сонины болон жагсаал цуглаан зохион байгуулах журам зэргийг гаргаж, хувийн сургуулиудыг байгуулахыг хязгаарлах болжээ.

Эзэн хааны зөвлөх күнзэч Мотода Нагазанэ төрийн шашныг бий болгохыг оролдсон ч, ерөнхий сайд Ито Хиробүми үүнийг эсэргүүцэв. Ер нь бол эзэн хааны дэргэдэх япон судлаач (国学者), күнзэч (儒学者) бүлэглэлүүд болон Засгийн газрын тэргүүн Ито Хиробүми тэргүүтэй өрнийн соёл иргэншлийг баримталдаг төрийн албан хаагчдын бүлэглэлүүдийн хооронд эрх мэдлийн төлөөх зөрчилдөөн боловсролын асуудлаарх зөрчилдөөн болон илэрч байв. Энэхүү зөрчилдөөн дунд 1890 онд “Боловсролын тухай эзэн хааны айлдвар” гарчээ. Тус айлдвар нь 1945 онд Япон улс дайнд ялагдах хүртэл ард түмний ёс суртахууныг чиглүүлэх луужин болж ирсэн. Агуулгын хувьд, уламжлалт хүн хоорондын харилцааг дээдэлж, “эцэг эхдээ ачлалтай, ах дүү нар хоорондоо эвтэй, эхнэр нөхөр нийцтэй, анд найзууд итгэлцэлтэй байж, биеэ энгийн даруу авч яван, хайр энэрлийг өргөн түмэнд түгээх”-ийг сургасан байдаг ч, эдгээр ёс суртахууны эрхэм чанаруудыг эзэн хаанд үнэнч байхтай холбож, эзэн хааны сүр хүчийг ашиглан төрийн ёс суртахуун (国家道德) болгосонд айлдварын онцлог оршдог¹².

Айлдвараас хойш 20 жил өнгөрөхөд Япон улс хоёр ч том гүрэнгэй хийсэн дайнд ялалт байгуулж, олон улсад өөрийн байр суурийг бэхжүүлдэг. Нөгөөтэйгүүр, улс дотор хөдөлмөрийн маргаан дэгдэх болж, социализмын үзэл санаа нэвтэрч, гэр бүл тосгоноос “салж”, бие даасан хувь хүмүүс төрж эхлэхэд зөвхөн үндэстний ёс суртахууныг тунхагласан Айлдвараас гадна, дэлхийн түвшинд хүлээн зөвшөөрөгдөхүйц түгээмэл ёс суртахууныг

бүтээх хэрэгтэй гэж үзэх хүмүүс ч гарч иржээ.

Боловсролын байгууллагад ёс суртахууныг юунд үндэслэн заах вэ гэдэг асуудал дээр тухайн үеийн сэтгэгчид, шилдэг сэхээтнүүд янз бүрийн байр суурьтай байсан боловч, хэн нь ч уг асуултад хариу өгч чадаагүй юм.

Дэлхийн II дайны дараах боловсролын шинэчлэл

Япончуудыг дайнд буулгаж авсан Америк тэргүүтэй Холбоотны хүчний дээд командлалаас (GHQ) Боловсролын тухай эзэн хааны айлдварыг ард түмний үүргийг чангатгаж, милитаризмд турхирах гол үзэл санаа болсон хэмээн үзэж, 1948 оны 6-р сард хориглох шийдвэрийг парламентын дээд, доод танхимаар гаргуулна. Мөн түүнчлэн олон салаат боловсролын тогтолцоог “феодал маягийн төдийгүй милитаризмын шалтгаан болсон”¹³ гэж үзсэн тул халж, дан хэлбэрийн тогтолцоонд шилжүүлсэн. Өөрөөр хэлбэл, боловсролын тогтолцооны оройд их сургууль оршдог тогтолцоонд шилжсэн.

1946 оны 11-р сард ардчилсан үзэл санаанд тулгуурласан Үндсэн хууль батлагдаж, 1947 оны 3-р сард дээрх Үндсэн хуульд суурилсан Боловсролын суурь хууль батлагдав. Боловсролын суурь хуулиар хувь хүний онцлогийг дээдэлсэн, энх тайвныг эрхэмлэгч иргэний төлөвшүүлэхийг зорилго болгов. Дайнд ялагдсаны дараахан япончууд улсынхаа онцлогийг хадгалж, Боловсролын тухай эзэн хааны айлдварыг ч халахгүйгээр ёс суртахууны боловсролыг олгох бодол тээж байсан ч, америкчуудын улс төрийн бодлого, түүнчлэн дотоодын шинэтгэгч талынхны эсэргүүцэлтэй тулгарснаар эдгээр санаа хэрэгжээгүй юм. Америкчууд Япон хүнийг дахин төлөвшүүлэх бодлого -ыг хэрэгжүүлэх болж, ялангуяа Японы ард түмэнд дайныг өдөөсөн гэмт төр –тэй явсныг ойлгуулж, өөрсдөөр нь гэмшүүлэх бодлого баримталжээ. Америкчуудын зүгээс ёс суртахууны хичээлийг хориглож, харин нийгэм судлалын хичээлээр дамжуулан хувь хүний нийгэмд гүйцэтгэх үүрэг, иргэний эрх үүргийг сургах болжээ. Ёс суртахууны боловсролыг тусдаа нэг хичээлээр бус, сургалтын бүх хөтөлбөрөөр дамжуулан олгох бодлого хэрэгжсэн юм.

Даяаршил ба төгсгөлд нь

1980-аад оны сүүлчээс 90-ээд оны эхэн хүртэл Японы эдийн засаг огцом өсч, япончууд нийтээрээ элбэг хангалуун амьдралыг үзэв. Харин дэлхийн II дайнаас хойш боловсролын салбарт үйлчилсэн өрсөлдөөний зарчим, үүргийг нь орхигдуулж эрхийг

¹¹ 1870-аад оноос арваад жил үргэлжилсэн.

¹² “Япончуудыг бүтээсэн боловсрол” хуудас 189

¹³ “Япончуудыг бүтээсэн боловсрол” хуудас 233

чухалчилсан хувь хүний эрх, эрх чөлөөг дээдлэх үзэл тухайлбал, сургуулийн орчинд дээрэлхэл, түүнээс үүдсэн амиа хорлолт зэрэг нийгмийн асуудлуудыг дагуулав. Тиймээс Боловсролын яам 1980-аад оноос Алгуур боловсрол (ゆとり教育)-ын бодлогод шилжихээр шийдвэрлэж, 2002 онд боловсролын тогтолцоонд нэвтрүүлснээр хүүхдүүд долоо хоногийн 5 өдөрт суралцдаг болж, сургалтын агуулга ч 30 хувиар буурсан юм.

Даяаршил хүчтэй яригдах болсон 2006 онд Боловсролын суурь хуульд шинэчлэл хийгдэж, Японы уламжлал, соёлоос улбаатай ёс суртахуун, нийтийн төлөө үзэл зэрэгт сургахаар тусгажээ. Харин их дээд сургуулиудад Америкийн дээд боловсролыг шууд хуулбарласан шинэчлэл явагдаж, уламжлал үгүйсгэгдсээр байна.

Германы нийгэм судлаач Фердинанд Тённис тэртээ 1876 онд бичсэн “Гемейншафт ба гезельшафт” бүтээлдээ уламжлалт нийгэм болон орчин үеийн нийгмийн асуудлыг дэвшүүлсэн байдаг. Гемейншафт буюу нутаг нуга, ураг удмын холбоо бүхий бүлгэмдлээс, эдгээр холбооноос тасарсан хувь хүн буюу гезельшафт хэмээгдэх нийгэмшилт-д шилжих үеийн асуудал нь боловсролын асуудлыг давхар дагуулдаг. Япон улсын хувьд орчин үежилт гэдэг нэг талаас төрөөс ялангуяа хуучны тосгодыг задлахыг оролдсон үйл явц байв.¹⁴ Хэдийгээр орчин үежилт гаднын нөлөөгөөр эхэлсэн ч, дотооддоо түүнийг хөгжүүлэх суурь буюу уламжлал эдийн засаг, боловсролын салбарт Эдогийн үед бүрэлдэн тогтсон байв. Энэхүү уламжлал хотод бол захиргааны хамгийн бага нэгж болох чёо буюу хороо, хөдөөд бол тосгон хэмээх хүмүүсийн бүлгэмдэл дээр оршин тогтнож ирсэн ба орчин үежилтээс даяаршилтай нүүр тулах хүртэл сургуулийн боловсролоос гадна эдгээр хороо, тосгодын оролцоотой зохион байгуулагддаг эртнээс уламжлагдсан элдэв баяр, арга хэмжээнүүд болон гэр бүлийн баяр ёслол, арга хэмжээнүүдээр дамжуулан япон хүнийг төлөвшүүлсээр иржээ.

Сүүлийн үед Финландын боловсрол дэлхийн анхаарлыг татах болов. Багш бүх хүүхдэд ижил агуулгаар нэгэн зэрэг хичээл оролгүй, хүүхэд бүрийн түвшинд тохируулан чиглүүлж, суралцагч өөрөө оролдож, эсхүл бусадтайгаа ярилцан хамтдаа суралцах зэргээр ангидаа биеэ чөлөөтэй авч яваа Финландын сургалтыг харуулсан зургууд сошиал орчинд түгэх болжээ. Эдогийн үеийн тэракояагийн зургаас бас үүнийг олж харах боломжтой. Өөрсдийн уламжлалыг мэдэж, түүнээс суралцах нь даяаршил болон түүнтэй зэрэгцээд яригдах болсон ондоошилд чухал болохыг бид Японы боловсролын түүхээс харах боломжтой.



Зураг. Иссүн Шиханосатогийн 1844-1848 онд зурсан тэракояад суралцаж буй хүүхдүүдийг харуулсан зураг.



¹⁴ “Япончуудыг бүтээсэн боловсрол” хуудас 255



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ. ДОКТОР, Ph.D
Б.АЛТАНГЭРЭЛ

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИ

ОХУ (ЗХУ)-д 1940-1950 онд боловсролын бодлогын философийн онолыг Л.С.Выгостскийн нийгмийн сэтгэл судлалын онолд тулгуурлан боловсруулж эхэлсэн.

1950-1960 онд боловсролын философийн үзэл баримтлалтад үйл ажиллагааны онол (А.Н.Леонтьев), субъектив үйл ажиллагааны онол (Э.В.Ильенков), мэргэжил дундын хандлагыг чухалчилсан. Энэ үеэс “Хүн” төвтэй Хүмүүнлэгийн онолыг боловсролын философийн чухал тулгуур болгон үзэх болсон.

1960 оноос ОХУ (ЗХУ)-д “Олон соёлын харилцааны” онол (В.С.Библер) оюуны үйл ажиллагааг үе шаттай хөгжүүлэх онол (П.Я), боловсролын эрх чөлөөний (В.А.Сухомлинский) онолд тулгуурлан боловсролын үзэл баримтлалыг хөгжүүлэн хэрэгжүүлж ирсэн.

1970-аад оноос технологид суурилсан боловсролыг хүний оюун санааны хөгжилтэй нягт уялдуулан хөгжүүлэх чиглэлийг гол болгосон. Цаашилбал боловсролын хүмүүнлэгийн ба нийгэм соёлын асуудлыг боловсролын үзэл баримтлалд илүүтэй анхаарах болсон.

ОХУ-д 1990 оноос боловсролын үзэл баримтлал, философийн онол, арга зүйг шинэчлэн боловсруулж эхэлсэн. Энэ хүрээнд боловсролын нийгэм, соёлын асуудал, даяаршлын хүчин зүйлийг онцгойлон авч үзэхийн хамт, хүнийг төлөвшүүлэх асуудлыг чухалчлан боловсролын үзэл баримтлалд парадигмын шинэчлэл хийв.

Энэ хүрээнд боловсролын хөгжлийн бодлого боловсруулахад улс төр, эдийн засгийн болон нийгэм, соёлын хүчин зүйлүүдийг нягт уялдаатай авч үзэж, боловсролын хүрээнд ардчиллын үнэт зүйлсийг эрхэмлэх, нийгмийн инновацыг хэрэгжүүлэхэд боловсролын гүйцэтгэх үүргийг онцгойлон авч үзэх болсон.

Дээд боловсролын хүрээнд зах зээл, арилжааны механизмыг хэрэглэх, геополитикийн хүчин зүйлийг харгалзан үзэх чиглэлээр бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлсэн.

Мөн шинжлэх ухаан, боловсрол, үйлдвэрлэлийн уялдааг хангах, хүний эрх чөлөө, үнэт зүйлсийг дээдлэх Өрнө ба Дорнын соёлын харилцан нөлөөллийг нийгмийн болон хүний хөгжлийн хэрэгцээнд нийцүүлэн боловсролын үзэл баримтлалд тусган хэрэгжүүлсэн байна.

References

1. Для цитирования: Береговая О.А.Философия образования в современной России//Вестн.Сев. (Арктич.) федер.ун-та. Сер..Гуманит. и соц.науки.2017. С.31-39. DOI:10.17238/issn2227-6564.2017.3.31
2. Огурцов А.П., Платонов В.В.Образы образования. Западная философия образования. XX век. СПб., 2004.520 с.
3. Арташкина Т.А. Генезис и структура целеполагания в системе деятельности высшей школы: моногр. 2006.621 с

ТЭМДЭГЛЭЛ

A large rectangular area with horizontal lines, resembling a page of lined paper or a form for writing. The lines are evenly spaced and extend across the width of the page. The background is a light gray color.

Тайдмен “Монгол бол миний хамгийн их хүсэл сонирхлыг татдаг улс. Еврейчүүдийн үзэл баримтлал, итгэл үнэмшил чухамдаа монголчуудаас авсан, Монголын оюун сэтгэлгээний ололтоос буулгасны өгөөж юм шүү. Чингис хааны өрлөг, хөлөг, хишиг гэдэг удирдлагын тогтолцоо бол ямар ч супер үндэстэн авч хэрэгжүүлэх тогтолцоо. Үндэсний язгуур ашиг сонирхол нь боловсролд хөлөглөн баримтлах зарчим, үүнийг хэрэгжүүлэхгүй бол тэнгэр газрын дунд хоосон болно” хэмээгээд...

Д.Гантөмөр

Аливаа үндэстний амин чанарын чөмөг нь хэл юм. Эх хэл нь бичгийн урт удаан хугацааны уламжлалтай, түүгээр ярилцагч ард түмэн нь хэлэндээ хайртай, түүнийгээ гарамгай эзэмшиж, түүгээрээ мэдлэгийн ертөнцийг бүтээн, дэлхийд хувь нэмрээ оруулж буй эсэх нь чухал байдаг. Энэ утгаараа монгол хэл бол өнөө цагийн хөгжлөөс огт хоцроогүй, эрчимтэй хөгжиж яваа хэл. “Чихний чимэг болсон аялгуу сайхан монгол хэл”-ийг монгол хүүхдүүддээ сайтар эзэмшүүлэх нь боловсролын хамгийн гол зорилго болох юм. Хэлээ мартсан ард түмэн сэтгэлгээгээ бүрэн алдахад хүрэх аюултай.

П.Наранбаяр

Энэ бүхнийг нуруусны эцэст ахин дүгнэхэд: уйгур галиг, бичгийн тиг анх уг бичгийг авах үеийн монгол хэлд ямар ч асуудалгүй тохирч байжээ. Тодорхой хэлбэл, VIII зуунаас хойш согд бичгээ бүрмөсөн хэрэглэхээ больсон согдуудаас VI-VII зууны үед бичиг үсгийг нь авсан байж таарах уйгурууд тэр үедээ бол монгол хэлтэн байжээ. Тиймээс энэ бичигт өөрчлөлт орсонгүй хэдэн зууныг элээжээ гэж үзэх бүрэн үндэслэл байна.

Г.Аюурзана

... сэтгэлгээний соёл нь тухайн бүлэг - нийхмийн тухайд нэгнийхээ бодол санааг нөгөө бусад нь бүгдээрээ хүндэтгэн үзэж, түүнийг хөгжөөн дэмждэг байхуйц орчин бүрдэхийг хэлнэ.

Ц.Дэмбэрэл

Аливаа шинжлэх ухааны утга учир шинэ мэдлэг, ялангуяа тухайн салбар ухааны өмнө тулгарсан зангилаа асуудлуудаар шинэ мэдлэг бүтээх явдал.

Л. Мөнх-эрдэнэ

Боловсрол нь тухайн хүний өөрийн амьдарч байгаа нийгэм буюу өөрийнх нь хамтран амьдрах хүмүүстэй нийлэмжтэй болгож өгөх хэрэгтэй. Энэ нь нийгмийг тогтоон барих эх үндэс болно. Монгол ухаанд суурилсан боловсрол гэж хүмүүс ярьдаг нь үнэн хэрэг дээрээ энэ юм

Оргилболд

... үнэлэх зарчмыг, цааш нь сурвал зохих мэдлэгтээ үндэслэн хэрхэн задалж ойлгож байгааг, ойлгосныхоо хэрэг тусыг хэрхэн гаргаж байгаагаар тодорхойлдог болгон сайжруулбал, сурах чөлөөт сэтгэлгээг дэмжихэд тустай юм. Нэг үгээр хэлбэл, юуг мэдсэнийг үнэлэхээсээ яаж мэдсэнийг үнэлэх явдал чухал болно.

Э.Энхпүрэв

БҮЛЭГ III

ГУРАВ. МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН НОМЛОЛ

Боловсролын философи



ДОКТОР (SC.D)
Д.ГАНТӨМӨР

ҮНДЭСНИЙ БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИ АСУУДЛААРХ ЗАРИМ ЭРГЭЦҮҮЛЭЛ

Боловсрол хэмээх үйлийг улс орныхоо язгуур эрх ашгийн үүднээс хөгжүүлэх үзэл санаа, бодлого, түүний зарчим, агуулга, хэлбэр, хэрэгжүүлэх үе шат, оролцогчдын эрх үүрэг, хэм хэмжээний цогцыг илэрхийлсэн ойлголтыг “боловсролын тогтолцоо” хэмээн тодорхойлж, “үндэсний” хэмээх тодотголд хамааруулах хүчин зүйлсийг тодорхойлох нь онол, арга зүйн эрэлтэй асуудал болно. Тодорхой орон зай, цаг хугацаанаас хамаарч аль нэг төр улсын бодлогоор тухайн үндэсний хэв шинж, онцлогийг тээсэн “үндэсний боловсролын тогтолцоо” хэмээх хамаарлыг бий болгодог. Боловсролын тогтолцоонд хамаарах түгээмэл хүчин зүйлс нь орон зай (газар зүй, геополитик), цаг хугацаа, улс төр, эрхшээл, үнэлэмж, философи баримтлал тэргүүтэн төрөл бүрийн нөхцөлтэй уялдсан байна. Энэхүү нийлэмж нь чухамдаа аль ч улс үндэстний хувьд хүчин төгөлдөр байхуйц боловсролын ерөнхий тогтолцоог бий болгон хүн төрөлхтний сайн жишиг, шалгарсан арга, зарчмуудыг өөртөө тусган төгөлдөржүүлж байдаг.

Үндэсний язгуур эрх ашиг гэдэг бол тухайн улсын тусгаар орших асуудалтай холбоотой. Аливаа улс орны нийгэм, эдийн засаг, соёл, улс төрийн нөхцөл хийгээд хөгжлийн үндсэн хөдөлгүүрийг боловсролын өгөөжөөс хамаагуулан ухаарч, өнөөгийн хүн төрөлхтний өмнө тулгарч буй асуудлууд болох нийгмийн тэгш бус байдал,

ядуурал, уур амьсгалын өөрчлөлт, хүн байгалийн хийгээд хүн хоорондын харилцааны хямралууд, технологийн хэрэглээнээс үүдэлтэй сөрөг үр дагавар зэрэг шалтгаан-үрийн хамаарлыг мөн л боловсролын асуудалтай холбож үзэхээс аргагүй. Тиймээс ч ЮНЕСКО-оос боловсрол бол бидний амьдрал оршихуйн нэгэн баталгаа, ирээдүйн хөгжлийн залуур хэмээн үзэхдээ, боловсролын асуудал нь аль нэг салбарын, тогтолцооны гэхээс илүү хүн төрөлхтний оршихуйн суурь асуудал болгон хөндөж, чухамхүү өнөөгийн бидний амьдралын чанар, хүртээмж, хүсээгүй үр дүн бүхний үндэс нь өчигдрийн тарьсан үр¹ гэж дүгнэсэн.

Боловсролын үр өгөөж нь хувь хүний эзэмшсэн мэдлэг, мэргэжил, диплом, гэрчилгээ эсвэл түүнийг олгодог сургууль, хүрээлэн, академик байгууллагуудын үйл ажиллагаа; сургалтын хөтөлбөр, агуулга, хамтын ажиллагаа; стандарт зэрэг үү? Боловсрол хэмээх ойлголтын илэрхийлэл нь хүн төрөлхтний бүтээсэн нийгэм, соёлын хөгжлийн нэгэн феномен, кодчлол² гэж болох юм. Хүн хүрээлэн буй байгаль дэлхийг танин мэдэх хэрээр эзэмдэж, өөрчлөн хувиргаж ашиглах хэрэгцээ суурин хийгээд барууны соёлын хүрээлэлд хүчтэй дэлгэрч ахул дорнын соёлын ахуйд сав шим ертөнцийн шалтгаан, уг чанарыг хүн өөрийн дотоодоос тодорхойлж, энэхүү

¹ UNESCO (2021) Reimagining our futures together; A New social contract for education. Report from the International Commission on the futures of education. p.30.

² Англи хэлнээ “Cultural code” буюу соёлын кодыг тодорхой соёлын хүрээнд хамаарсан утгын систем-бэлгэдлийн илэрхийлэл гэж өргөн утгаар нь томъёолдог. (Cultural codes are defined as symbols and systems of meaning that are relevant to members of a particular culture).

шүтэлцээнд нь өөрийгөө таних, өөрийн хүсэл, хэрэгцээг удирдах дотогш чиглэсэн боловсрол хөгжсөн байдаг. ЮНЕСКО өнөөдрийг хүртэл хөгжиж буй боловсролыг “боловсрол өөрөө удаан хугацаанд эдийн засгийн өсөлт модернизацийг чиглэсэн хөгжлийн парадигм болж иржээ”³ хэмээн дүгнэжээ.

Боловсролын амин сүнс: Сэтгэлгээний түүхэнд Ш.Монтескье хуулийн амин сүнс, О.Конт позитивизмын амин сүнс гэсэн ойлголтыг ашигласан байдаг. Би боловсролын амин сүнс гэдэг ойлголтоор үндэсний оюун санааны төлөвшилд боловсролын салбар чухал үүрэгтэйг илэрхийлж байна. Философид оюун санаа хэмээх ойлголтыг өргөн хэрэглэдэг. Англи хэлний “spiritual”-ийг “оюун санаа, сэтгэл, сүнс, сүлд хийморь, сүнслэг оршихуй, дотоод эрчим” гэх мэтээр орчуулж болно. АНУ-ын төвөд судлаачид болон Бутаны зарим эрдэмтэд төвөд хэлнээ “སེམས་དོང་རིག་སྒྲུབ་-sems dong rig pa” буюу “сэтгэлийн угийн ухаан” хэмээн нэрлэж байна. М.Хайдэггэр “Ахуй ба цаг хугацаа” (1927) бүтээлдээ “Spirit нь тодорхой цаг хугацаанд алга болдоггүй. Харин баримт илрэл нь алга болдог, зуурын олзонд автагддаг. Энэ байдал нь цаг хугацаанаас үл хамааран орших феномен илрэл” гэсэн байна. Г.В.Хегель (Phänomenologie des Geistes:1807) оюун санааны зөрчил ба диалектикийн асуудлыг авч үзсэн.

“Nation’s dignity” хэмээх “үндэсний эрхэм чанар” хаана оршиж, хэрхэн, юугаар тодорхойлогдох вэ? гэдэг нь чухамдаа үндэсний оюун санаа (nation’s spirituality)-ны талаарх хэлэлцүүлэг⁴ болой. Философид оюун санаа (spirit) хэмээх нь сүнс, амь, субстанц, материаллаг зүйлийн нөгөө тал, сэтгэл хөдлөл, оюун зэрэг утгаар хэрэглэж ирсэн. Үндэсний оюун санааны талаар философид шашны, феноменологи, постмодернизмд зэрэг чиглэлд ялгаатайгаар авч үздэг. Ерөөс спиритизм (spiritism) нь философид аливаа тогтолцооны нэгэн язгуур шинж, мэдрэхүйд үл мэдрэгдэх материаллаг бус бодит байдлын оршихуй хэмээх суурь ойлголтоос эхтэйгээр ялгаатай маргаантай баримтлалыг үүсгэсэн байдаг. Ялангуяа хөгжлийн оюун ухааны

хүчин зүйлийг спиритизмтэй холбон авч үзэх ахуй “үндэсний оюун санааг төлөвшүүлэх боловсрол” хэмээх асуудлыг хөндөх нь зүйтэй. Энэ бол боловсрол дахь сүнслэл, далдын ид шидийн тухай, ямар нэг шашны боловсролын асуудал огт биш, харин боловсролын амин сүнсээ (spirit of education) тухайн үндэстэн хэрхэн илэрхийлж, хэрэгжүүлэн буулгаж буй тухай асуудал. Чамгүй олон судалгаанд ч энэ талаар хөндөн тавьсан нь бий.⁵

Үндэсний боловсролын тогтолцооны амин сүнс нь тухайн ард түмний “оюун санааны сайн сайхан байдал”-ыг бүрдүүлэх, амьдралын чанарыг нь өөрчлөхөд чиглэх ёстой юм. Оюун санааны сайн сайхан байдал гэдэг нь боловсрол нийгэмд хэрхэн ашиг тусаа өгөх талаарх утилитар, прагматик баримтлал. Оюун санааны сайн сайхан байдал нь (spiritual well-being) нийгэмд эрхэмлэн дээдлэх үнэт зүйлээ хэрэгжүүлэхэд түлхэц болдог. Боловсролоор дамжуулан оюун санааны бүрдлүүд болох урлаг, соёл, шашин, ёс суртахууныг төлөвшүүлснээр нийгэм тогтвортой хөгжлийн эх сууриа олддог. Тэгэхээр боловсролын амин сүнс нь “хүн болох эрдэм” гэж болно.

Хүмүүн олон салаа сонголттой нүүр тулгарч, үл тайлагдах ертөнцийн элдэв өгөгдөл, танин мэдэхүйн явц дунд зөв, бурууг ялгах үнэлэмжийн тухай мэдлэг, “зөв”-ийг эргэцүүлэн тунгааж “сайн”-ыг үйлдэх нь хүмүүний уг чанартай холбоотой хүсэл эрмэлзэл байсан гэмээр. Зөв, буруу, сайн мууг ялгаж, үйлдэх нь ёс зүй хэмээх эрдэм. Эртний Грекийн философич Плато ёс суртахууны мөн чанар бол ухаарагдах бодол, энэ нь өөрөө оршдоггүй хэмээн үзэхдээ⁶ ёс суртахууны санаа (moral eidos) хүмүүнд байх агаад боловсрол ч ёс суртахуунд үндэслэх шаардлагатайг илэрхийлнэ. “Мораль” хэмээх латин үгийг “ёс суртахуун” гэж орчуулж хэвшсэн бөгөөд философид “зөв буруу, сайн мууг тунгааж үйлдэх ухамсар” хэмээх ерөнхий утгаар тодорхойлжээ.⁷ Ёс зүйд сайн зан байдал, хандлага буюу “сайн эрдмийг ухаараад эзэмшсэн чанар” (virtue-ethikē aretē⁸) хэмээх ойлголтуудаас демаркаци хийвээс, универсаль ёс суртахууны нийтлэг шалгуур хэмжүүр (common-sense norm), ёс

³ Alexander A. Shestakov (2008) Cultural code concept contemporary world. Bergen.

UNESCO (2021) Reimagining our futures together; A New social contract for education. Report from the International Commission on the futures of education. p.42.

⁴ Lennart Nordenfelt (2021). The concept of Dignity: An Analysis. Tullinge.

⁵ Temir Olimov (2020) The role of national spirituality and values in the development of civil culture in future specialists with higher education. European Journal of Research and Reflection in Educational Sciences. Vol. 8 No.12. Leena Chandran Wadian (2021) The Spirit of National Education Policy 2020. The Pole Star for Implementers. Implementation of NEP 2020 to Transform Higher Education in India. New Delhi. Pam Nilan (2009): The ‘spirit of education’ in Indonesian Pesantren, British Journal of Sociology of Education, 30:2, 219-232. Julian Stern (2018) The Spirit of religious education, Journal for the Study of Spirituality, 8:2, 180-187, Abraham Joshua Heschel (1953) The Spirit of Jewish Education, Journal of Jewish Education, 24:2, 9-62в. Philip D. Peterson (2012) Spirituality and Education. lib.unb.ca.

⁶ (1997) Plato: Complete Works. J.M. Cooper & D.S. Hutchinson (eds.), Indianapolis: Hackett.

⁷ Moral theory. <https://plato.stanford.edu/entries/moral-theory/>. 2024.03.15.

⁸ (2011) Aristotle’s Nicomachean Ethics. Translated by Robert C. Bartlett and Susan D. Collins. The University of Chicago Press дэлгэрүүлж үзнэ үү.

суртахууны үнэлэмжид хөтлөх сонголтын талаар олон янзын баримтлал, зөрөлдөөнтэй санал байдаг.

Мораль эрдэм дээр үндэслэсэн үндэсний боловсролын үзэл баримтлалыг тодорхойлох нь тухайн үндэстний “эрхэм чанар” (dignity) хүсэл эрмэлзлийн тухай асуудал. Хүний эрхэм чанарын (dignitas humana) асуудал Аристотелиос эхлээд шашны философи, улмаар И.Кант хүртэлх сонгодог философичдын бүтээлд чухалчлан хэлэлцэгдэж, хүний амьтнаас ялгарах сэтгэхүйн өгөгдөл, иерархи (hierarchy) хийгээд эрх чөлөөт хэм хэмжээ, хүмүүний мөн чанар, түүний өөртөө хийгээд супер хүчинд (тухайлбал, Бурханд) дээдлэгдэх шалтгаан, үндэслэл зэргээр хэлэлцсэн байдаг. Америкийн философич Херберт Шпигельберг (1904-1990), Марта Нуссбаум (1947) нар энэ асуудлаар тухайлан үзсэн. Юутай ч өнөөгийн улс орнууд Үндсэн хуулийн үзэл баримтлалаа тогтоохдоо үндэсний эрхэмлэх зүйлсээ тодорхойлж, хууль ёсыг дээдлэх ёс суртахууны зарчмаа зөвшин тогтоосон. Шульцтайнер & Карми нар 150 гаруй Үндсэн хуульд үндэсний эрхэм чанарыг хэрхэн тусаж буйг судлан үзээд бэлгэдэл тунхаглалын шинжтэй; хэрэгжих удирдамжтай; жам ёсны эрхийг үл зөрчих хязгаарлалт бүхий удирдамжтай хэмээн ангилан үзсэн нь бий⁹. Аливаа үндэстэн өөрийн эрхэм чанар, адилсалдаа суурилан боловсролыг тодорхойлох нь зайлшгүй.

Боловсрол ба соёлын ахуй. Ямартай ч боловсрол бол хүмүүний ёс суртахууны үнэт зүйлд суурилан тодорхойлогдоно хэмээн үзэх үндэстэй учраас үндэсний боловсролын философийн судалгаанд энэ асуудал зайлшгүй яригдах ёстой. Ёс суртахууны үйлдэл бол универсаль шинжтэйгээс гадна үндэсний соёлын ахуйн онцлогийг (cultural landscape feature) ч өөртөө шингээнэ. Тиймээс үндэсний боловсролын тогтолцоонд ёс суртахууны философийг тулгуур болгож үзэх нь үнэлэмжийн хувьд ач холбогдолтой.

Эрдэм гэдэг бол “wise” хэмээх герман гаралт үгтэй ижил юм уу дөхөм утгатай гэвэл энэ нь мэдлэг, чадвар, нэр төрийн цогцыг багтаасан ёс суртахууны зарчим дээр тулгуурласан гэж хэлнэ. «Оюун түлхүүр»-г бичигдсэнээр хаан хүний 35 эрдэм дотроос хайрлах сэтгэл нэн эрдэм, хатан хүний 15 эрдэмээс сайхан ааль нэн эрхэм, түшмэл хүний 9 эрдэмээс нигүүлсэнгүй сэтгэл нэн эрхэм хэмээсэн буй. Монгол хүний эрхэмлэх 9 эрдэм хэмээвээс

“Элбэрэл, хайр, энэрэнгүй сэтгэл, төв шударга зан, бат журам, ёс төгс, цэвэр ичимхий даруу чанар, уужуу талбиун сэтгэл, Эвийг эрхэмлэх”¹⁰ зэрэг болно. Тиймээс эрдэм мэдлэгийг дээдлэх уламжлалд суурилсан боловсролын тогтолцоо нь гуманист агуулгатай, олон улсын жишиг дагуу сургалт хөгжүүлэхэд чиглэгдэх нь дамжиггүй.

Боловсролын талаарх хэлэлцүүлэг голдуу мэдлэг, чадварын дэс дараалал, түүнийг олгож буй шаталсан сургууль, сургалт, танин мэдэхүй, арга зүй буюу багшлах, суралцах, удирдах үндсэн үйлүүд, тэдгээрт нөлөөлөх объектив, субъектив хамаарал хүчин зүйлийн талаар авч үзэх нь элбэг.

Үндэсний оюун санаа, хүсэл эрмэлзлээ ягштал хэрэгжүүлэн дэлхийг удирдан чиглүүлж буй еврейчүүдийн боловсролын талаар олон судалгаа, түүний амжилтын үндсийг жүүдийн хуучин судар, “Торах сургаал” өрхийн боловсрол, ээжийн үүрэг, аавын үлгэрлэлийг чухалчлан суралцагч-төвтэй хэлцэмжийг хамааруулах нь элбэг. Ялангуяа еврейчүүдийн талаарх ийм таамаг, яриа “Гэгээрсэн еврейчүүдийн протокол” хэмээх баримтаг эхийг дэлхий даяар тархах үед ялангуяа түүний 9, 16-р заалтуудад тодорхой буй.

Нидерландын нэртэй хуульч, эдийн засагч, банк хөрөнгө оруулалтын зөвлөх, Төв Азийн стратеги судлаач Сандер Тайдмен¹¹ бээр АНУ, Их Британи, Голланд, Францын их сургуулиудад багшилж, тогтвортой манлайлал (sustainable leadership) хэмээн сэдвийн хүрээнд нэлээд ном, бүтээл гаргасан. Түүний “Буддист эдийн засаг”, “Бизнес: Нийгмийг өөрчлөх инструмент болох нь. Далай ламтай хийсэн яриа”, “Юмсын цаадах сэтгэл” хэмээх бүтээл нь өнөөгийн улс төр, эдийн засгийн лидерүүд төдийгүй академик судалгаанд эрэлттэй байдаг. Тайдмен “Монгол бол миний хамгийн их хүсэл сонирхлыг татдаг улс. Еврейчүүдийн үзэл баримтлал, итгэл үнэмшил чухамдаа монголчуудаас авсан, Монголын оюун сэтгэлгээний ололтоос буулгасны өгөөж юм шүү. Чингис хааны өрлөг, хөлөг, хишиг гэдэг удирдлагын тогтолцоо бол ямар ч супер үндэстэн авч хэрэгжүүлэх тогтолцоо. Үндэсний язгуур ашиг сонирхол нь боловсролд хөлөглөн баримтлах зарчим, үүнийг хэрэгжүүлэхгүй бол тэнгэр газрын дунд хоосон болно” хэмээгээд “Итгэмжлэгдсэн манлайлал: Хямралын дараах эдийн засаг, нийгэм, байгаль орчны үнэ цэнийг бий болгох сэтгэлгээ, чанарууд” хэмээх номоо¹² дурсгаж билээ.

⁹ Doron Schulzinger & Guy E. Carmy (Spring 2014) Human Dignity in National Constitutions: Functions, Promises and Dangers. The American Journal of Comparative Law. Oxford University Press. Vol. 62, No.2, pp. 461-490.

¹⁰ Дамдинсүрэн Ц. (2017) Монголын уран зохиолын дээж зуун билиг оршвой. Эрхлэн хэвлүүлсэн Цендина А.Д., Отгонбаатар Р. Улаанбаатар, Соёмбо принтинг.

¹¹ <https://www.sandertideman.com/> дэлгэрүүлэн үзнэ үү.

¹² Tideman S.G. & Arts M.L (2013) Empowered Leadership: Mindsets and Qualities to Create Post-Crisis Economic, Social and Environmental Value. Nyenrode Business University Press.

Үндэсний оюуны чадавх, соёлын дархлаа хэмээх тулгуур зарчмыг багтаасан боловсрол, ёс зүй, эдийн засгийн салбаруудын зохицол, аюулгүй байдал, тогтвортой байдал гэсэн чиглэлүүдээр илэрхийлжээ. Энэ утгаараа боловсролын тогтолцоо нь үндэсний язгуур эрх ашиг буюу тухайн улсын тусгаар орших асуудалтай холбоотой юм. Ер нь барууны боловсролын тогтолцооны үнэлэмж, хэмжүүрээр боловсролын институтийг голлон үнэлдэг. Бусад орны үндэсний оюун санааны дархлаа бүхий концепцийг шууд хуулбарлах замаар боловсролын талаар баримтлах бодлогын баримт бичгээ боловсруулах нь үндэсний язгуур ашиг сонирхолд нийцэлтэй эсэхийг нягтлах шаардлагыг ямагт нэхнэ.

Монгол Улсын үндэсний боловсролын философи асуудлыг авч үзэх өөр нэг тал нь соёлын ахуй, ялангуяа соёлын уламжлал шинэчлэл, онцлогийн тухай бөгөөд бид дээр соёлын кодчлол хэмээхийг дурдсан. Боловсрол өөрөө соёлыг бүтээж, хувиргаж шинэчилж байхын хамт тухайн соёлынхоо илэрхийлэл, нэгэн үр дагавар болдог бөгөөд ерөөс мэдлэгийн нийгэм-соёлын уг чанарын талаарх Д.Баттөмөрийн судалгаа¹³ нь нийгэм соёлын ертөнц хийгээд мэдлэгийн ертөнц хоёр нь харилцан огтлолцдог болохыг авч үзсэн. Тиймээс мэдлэг бол гагц тусгалын үр дүн биш, харин “ойлгохуй”, “тэмдэглэхүй”, “бэлгэдэхүй”, “хөөрөлдөхүй”, “бясалгахуй” зэрэг тодорхой үе шат бүрэлдэхүүнийг өөртөө багтаасан ердийн мэдлэг ба онолын мэдлэг (буддын янагуух хийгээд чинагуух мэдлэг)-ийн харилцан шилжилт, сэтгэлгээний үе шатууд ажээ.

Боловсрол ба хэл. Боловсролын философи асуудлын нэгэн чухал аспект нь сургалтын хөтөлбөрийн (curriculum) хэл, мэдлэгийн хэл, багшлахуйн хэл, сэтгэхүйн хэлний тухай асуудлууд болно. Иймд үндэсний боловсролд хэл ба харилцааны асуудлыг тухайлсан хэлний философийн судалгаа бас нэгэн тулгуур болно. Сургалтын хөтөлбөрийн хэл (Language curriculum development) гэдэг бол хөтөлбөрийн агуулга, оноолтыг суралцагчдын хэрэгцээ шаардлага, нөхцөл байдал хийгээд боловсролын глобал ба үндэсний хүчин зүйлстэй¹⁴ хамааруулан, сурах үйл ажиллагааны зорилго, зорилтыг тодорхойлох, хичээл зохион байгуулалт, мэдлэгийн агуулга, илэрхийлэл, тэмдэглэгээг төлөвлөх зэрэг үндсэн асуудлыг тусгасан утгат чанарын илэрхийлэл. Лингвистик философид зохиомол хийгээд эх хэлний бүтэц, хэлний илэрхийллүүдийн утгат чанар хийгээд утгын тэмдэглэгээг судлан үздэг. Тиймээс ч прагматик, үйлдэлд захирагдсан бидний сэтгэхүйн хэв маяг нь танин мэдэхүй, суралцахуйн үйлийн дэс гэж үзнэ. Боловсролын нэг чухал зорилго нь шинжлэх ухааны мэдлэгт суралцахуй хэмээн үзэхүл, Л.Виттенгштэйнийхээр (1889-1951) шинжлэх ухааны мэдлэг нь субъект тухайн шинжлэх ухаанд холбогдох өөрийн мэдрэхүйн зүйлс ба сэтгэхүйн янз бүрийн үйлдэл хоёроо илэрхийлсэн өгүүлбэр. Хэлний хязгаар нь мэдлэгийн хязгаар хэмээн үзсэн байдаг. Тиймээс глобал боловсролын хэл дэх үндэсний сэтгэлгээ, соёлын онцлогийг нягтлах нь чухал. Дорно дахины уламжлалт ухаан дахь амьдралын орчноос суралцах, үлгэрлэн дагуулж сургах арга нь боловсролын орчин үеийн парадигмын зарчмуудтай нийцэн зохицох боломжтой юм.

¹³ Баттөмөр Д. (1988) Математикийн баталгааны логик-эпистемологийн судалгаа. Доктор (Sc.D)-ийн зэрэг горилсон диссертац, МУИС-ийн Нийгмийн Ухааны Факультет. (1988) Эрдэм шинжилгээний бичиг. №4 (133). 73-78 дахь тал.

¹⁴ Гантөмөр Д. (2022) Үндэсний боловсролын тогтолцоонд хамаарах зарим хүчин зүйлс. ШУА-ийн Философийн хүрээлэн Монголын боловсролын философийн асуудал, хандлага. 94-111 дэх талд үзнэ үү.

Ном зүй

1. Alexander A. Shestakov (2008) Cultural code concept contemporary world. Bergen.
2. (2011) Aristotle's Nicomachean Ethics. Translated by Robert C. Bartlett and Susan D. Collins. The University of Chicago Press.
3. Doron Schulzinger & Guy E. Carmy (Spring 2014) Human Dignity in National Constitutions: Functions, Promises and Dangers. The American Journal of Comparative Law. Oxford University Press. Vol. 62, No.2, pp. 461-490.
4. Lennart Nordenfelt (2021). The concept of Dignity: An Analysis. Tullinge.
5. Temir Olimov (2020) The role of national spirituality and values in the development of civil culture in future specialists with higher education. European Journal of Research and Reflection in Educational Sciences. Vol. 8 No.12.
6. Tideman S.G. & Arts M.L (2013) Empowered Leadership: Mindsets and Qualities to Create Post-Crisis Economic, Social and Environmental Value. Nyenrode Business University Press.
7. (1997) Plato: Complete Works. J.M. Cooper & D.S. Hutchinson (eds.), Indianapolis: Hackett.
8. UNESCO (2021) Reimagining our futures together; A New social contract for education. Report from the International Commission on the futures of education. p.30.
9. UNESCO (2021) Reimagining our futures together; A New social contract for education. Report from the International Commission on the futures of education. p.42.
10. (1997) Plato: Complete Works. J.M. Cooper & D.S. Hutchinson (eds.), Indianapolis: Hackett.
11. Дамдинсүрэн Ц. (2017) Монголын уран зохиолын дээж зуун билиг оршвой. Эрхлэн хэвлүүлсэн. Цендина А.Д., Отгонбаатар Р. Улаанбаатар., Соёмбо принтинг.
12. Moral theory. <https://plato.stanford.edu/entries/moral-theory/>. 2024.03.15.

МОНГОЛ ХҮН ГЭЖ ХЭН БЭ?



ОЛОН УЛС СУДЛАЛЫН ДОКТОР
П. НАРАНБЯЯР

МОНГОЛ ХҮН ГЭЖ ХЭН БЭ?

Тусгай бүр ерөнхий тодорхой хэмжээнд өөртөө агуулдаг нь ойлгомжтой. Философийн “Ерөнхий ба тусгай”-н категорийн харилцаагаар үүнийг онолжуулдаг. Алим тодорхой, тусгай хэлбэрээр ямагт орших бөгөөд ердөөсөө “Ерөнхий алим” гэж яг энэ гэж шууд оноон хэлэх бараг боломжгүй. Харин алимны нийтлэг шинжүүдийг тодорхойлон, ерөнхийг багцаалдаж болно. Тиймээс Тусгайг ерөөсөө л ийм гээд Ерөнхийд тэр чигээр нь хамаатуулах нь туйлшралд хүргэнэ. Нийгмийн ухаан ийм туйлшралаас зайлсхийх ёстой агаад чингээгүй тохиолдолд жишээ нь “Монгол хүн ерөөсөө л хүн чанар муутай, хувиа бодсон, бүдүүлэг. Эсвэл монгол хүн дээд тэнгэрээс заяатай, оюун ухааны хувьд бусад үндэстнээс давуу” гэх мэт алдаа туйлшралд хүргэх аюултай.

Энэхүү бэсрэг өгүүлэлд гарчиг болгон тавьсан асуулт өөрөө ийм туйлшралд хөтлөх аюултайг уншигч дотроо тунгаана буй за. Тиймээс зохиогч миний бие уг асуултыг өөртөө тавих дургүй, бусдад ч тулгах дургүй гэдгээ түрүүлээд хэлье. Иймийн учир, Тусгайд хэт баригдаагүй атлаа Ерөнхийд ойртох зорилготой асуултуудыг тавих замаар сэдэвтээ хариулах гэж оролдов.

Эдгээр асуултууд нь,

1. Монголчуудын түүхийн онцлог
2. Монголчуудын гарал үүсэл
3. Монгол хэлний онцлог
4. Монголчуудын ахуй амьдралын онцлог
5. Монголчуудын сэтгэлгээний онцлог
6. Уламжлал шинэчлэлийн зөрчил, нэгдэл

болно.

Дээрх нь тус тусдаа түүх, хэл шинжлэл, антропологи, философи гэсэн шинжлэх ухааны хэрэглэгдэхүүнийг ашиглах нь ойлгомжтой. Үүнээс өөрийн хэмжээнд утган авч, чөлөөтэй хүүрнэе.

Бидний түүхийн онцлог

Монгол хүн бүр XIII зуунд эзэнт гүрэн байгуулсан түүхээрээ бахархдаг. Харин энэ түүхийн цаана эрх чөлөөний хүчирхэг үзэл байдгийг хүмүүс тэр бүр ярьдаггүй. Монголын эзэнт гүрэн байгуулагдаад шашин шүтэх, худалдаа хийх эрх чөлөө, зам тээврийн аюулгүй байдал, татварын таатай орчныг дэлхийд бий болгож, хүн төрөлхтөнд цоо шинэ үеийг нээж өгсөн билээ. Монголын нууц товчоо болон Их засагт ард иргэдээ амар жимэр амьдруулах сайн засаглалын талаар олонтаа дурдсан нь Монголын Эзэнт гүрний нэг онцлог шинж мөн. “Гар газар хөл хөсөр амар жимэр жаргаана”, “Хожмын үед өөхөнд ороовч нохой тоож шиншихгүй хүн гарвал чаддагт нь улсыг өгч захируул”, “Үзтэл үнэнээр явагчийг үргэлж өөд нь дэмжигтүн” гэх мэт зарчим бол бидний түүхийн бахархам нэг хэсэг.

Монголчуудын бүтээсэн түүх бол нүүдэлчин иргэдийн эрх чөлөөний мэдрэмж бахархлаар дүүрэн түүх болно. Тиймээс ч Египет, Грек, Месопотами, Ром зэрэг эртний улсууд боолын нийгмийг туйлд нь хүртэл хөгжүүлсэн байхад Монголын эртний улсуудад аян дайны олзлогчдогчдоос өөрөөр боолчлол оршсон түүх үгүй. Угаасаа эрх чөлөөний мэдрэмж өндөртэй өвөг монголчуудад боолчлол орших үндэс байсангүй. Монгол овог аймгууд өвөр зуураа байлдан олзлолдож, алалцан хядалдсан түүх бий боловч хүн амаа төр нь өөрөө зохион байгуулалтай устгасан явдал ч байсангүй. Харин хожим 1930-аад Коминтерний шахалтаар монголчуудыг ангич үзлээр хуваан хядаж, айдас хүйдэс, үл итгэлцлийг үүсгэсэн гашуун түүх үүдсэн билээ.

Үнэнд ойртсон Монголын түүхийг 1990 оноос хойш 30 жилийн хугацаанд монголчууд өөрсдөө

бичих боломжтой болсон агаад түүнээс өмнө 1934 онд бичсэн А.Амарын “Товч түүх”-ийг ашиглаж болохуйц эх сурвалж гэж үзэх нь зүйтэй. 1950-аад оноос ЗХУ-ын эрдэмтэд, марксизмын онол арга зүйд үндэслэсэн түүх бичлэгийг манайд тулгасан нь өнөөгийн шаардлагад нийцэхгүй. Монгол Улсын өнөөгийн хөгжлийн маруухан тал, монголчуудын муу чанар бүхнийг манж Чин гүрэн тийм болгосон гэдэг ч юм уу, Зөвлөлт болон Коминтерний дарамт шахалтаар ийм болсон гэж гомдоллох нь бурууг бусдаас хайх, өөрсдийн арчаагүйг зөвтгөх гэсэн хайгуул төдий гэлтэй.

Ерөөсөө түүхээ зөв цэгнэсэн ард түмэн орчин үеийг зөв үнэлж, ирээдүйгээ амжилттай бүтээдэг гэж би боддог. Монголын түүх бол эрх чөлөөг эрмэлзсээр ирсэн бахархал дүүрэн хүмүүсийн түүх болой.

Монголчуудын гарал үүсэл

Монголчуудын гарал үүслийн тухай Эргүнэ Кунгийн домог гэх мэт зүйл бий. Аль ч үндэстэнд өөрийн төр улсын гарал үүслийн домог байдаг. Японд Кожики буюу Эртний явдлын тэмдэглэл, Скандинавт Один бурхны домог, Англид Артур вангийн гэх мэт. Эргүнэ Кунгийн домогт өгүүлэхдээ, дайсны дайралтад өртөн хядуулсан овгийн нэгэн хүү азаар амьд гарч, Эргүнэ Кунгийн хөндийд ирээд өсөж үржсээр уг газартаа багтахая байгаад уулыг галын хөөргөөр хайлуулан тэгш талд гарч ирсэн хэмээдэг. Уг домог нь Монголын өндөрлөг тал нутагт овог аймгууд өвөр зуураа олзлолдон булаалдаж, ялагдсанаа хүйс тэмтэрсэн нүүдэлчдийн дунд байдаг түгээмэл домгийн нэг хувилбар. Түрэгийн гарал үүслийн домог ч адилавар агуулгыг өгүүлдэг.

Монголын өндөрлөг тал нүүдэлчдийн амьжиргаа, цэрэг, нүүдлийн явдлын амин сүнс болсон адуу, хонийг өсгөхөд таатай агаад дөрвөн цагийн улиралд дураараа нүүх нутаг бүхий өргөн уудам хээр тал, уул хөндий, гол мөрний өлгий нутаг юм. Эртний Грекийн Херодотын түүхэнд дурдагддаг скифүүд болон Хятадын Сы Мацяний Түүхэн тэмдэглэлд дурдагддаг хүннү, Хятадын бусад түүхүүдэд тод томруун бичигдсэн сяньби, түрэг, нирун, уйгур, киргиз, хятан, чингээд монголчууд энэхүү өндөрлөг талыг эзэгнэж иржээ. Монголын өндөрлөг тал төдийгүй зүүн хойд Хятад, Шар мөрөн хүртэлх газар нутагт монгол, зүрчид, солонгос угсааныхан эзэн сууж, төр улсаа байгуулж ирсэн түүхийг сүүлийн үеийн Монголын болон Япон, Солонгос, өрнийн бусад судлаачид эрдэм шинжилгээний эргэлтэд идэвхтэй оруулах болсон нь сайшаалтай.

Монголчуудын гарал угсааны асуудалд эрс хурдтай хөгжиж буй генетик судлалын шинжлэх ухаан баттай хариулт өгөх нь лавтай. Миний бодоход дээр дурдсан нүүдэлчдийн төр улсууд бүгд

бидний өвөг дээдэс агаад хүн ам зүйн хувьд бид нүүдэлчдийн холимог үндэстэн байх магадлалтай.

Монгол хэлний онцлог

Хэл шинжээч Рамстедт монгол хэлийг анх Алтай хэлний овогт харьяалуулжээ. Уг хэлний овогт хоёр том төлөөлөл буй нь түрэг хэл, нөгөө нь монгол хэл. Япон, солонгос хэлийг бүтэц талаасаа төстэй болохоор нь уг хэлний овогт харьяалуулах явдал байсан ч энэ нь сүүлийн үеийн судалгаагаар үндсэндээ няцаагдсан гэж би ойлгодог.

Дундад эртний монгол хэлнээ түрэг үг нэлээд байсан агаад мөн түрэг хэлнээ ч монгол үг цөөнгүй. Нэг газарт төр улсаа байгуулж байсан хоёр нүүдэлчин угсаа болохоор энэ нь ч аргагүй. Монгол хэлний төлөөлөл дотор эдүгээ мөхчихсөн манж хэлийг хамаатуулдаг. Манж хэлнээс монгол хэлнээ орсон үгийн судалгаанаас харахад харьцангуй цөөн үг байдаг. Судалгаанаас үзэхэд ердөө 100 орчим үг л байдаг бололтой. Эдгээр нь ихэвчлэн “залан, занги, эфү, хууль” гэх мэт засаг захиргаа, албан тушаалын үгүүд байхаас гадна “халим, сугас, орхоодой” гэх мэт загас, зарим нэг ховор ургамлын нэр харагддаг. Харин манж хэлнээ монгол үг нэлээд орсон бололтой. Энэ нь ч аргагүй. Манж нар монгол бичгийг тэр хэвээр нь зээлдэн, дээр нь бинт хэмээх зарим гийгүүлэгчийг ялгах тэмдэг тавьсан төдийгөөр Чин гүрэн мөхөн мөхтлөө хэрэглэж байв. Монгол хэлнээ түгээмэл буй гадаад үг гэвэл шашнаар дамжин орж ирсэн самгарди, түвэд, уйгур нэр томъёонууд, суурин ахуйтай ихэвчлэн холбоотой хятад үг (жишээ нь цонх, яндан, байцаа, лууван гэх мэт үгс), техник технологитой ихэвчлэн холбогддог орос үг, сүүлийн үед орж ирсэн англи үг нэлээд байна.

Монгол хэлний сэтгэлгээ нь ерөнхийгөөсөө тодорхой руу явдгийг хэл шинжээч нар хэлдэг. Энэтхэг-Европынхэлнийовгийнхонтодорхойгоосоо ерөнхий рүү чиглэдэг. Он сарыг хэлдэг дарааллаас л энэ нь шууд харагдана. Мөн монгол хэлнээ үнэндээ олон тоо, ганц тоо гэж байхгүй, тодорхой тоо, ерөнхий тоо л гэж байдаг хэмээн Б.Ренчин үзсэн нь буй. Ухаандаа “Хонь бэлчиж явна” гэхэд монгол хүн ганц хонь бэлчиж явна гэж бодохгүй, сүрэг хонийг төсөөлнө. Харин тодруулах шаардлагатай үед бидний хэлж заншсан олон тооны нөхцлийг авдаг. Жишээ нь “Хэнтий, Хангай, Саяны өндөр сайхан нуруунууд”. Уулсыг нэрлэхсэн тодорхой буй учир “-ууд” нөхцлийг авах жишээтэй. Хэлний иймэрхүү сэтгэлгээ бидний далд ухамсарт зарим нэг хэмжээгээр нөлөөлдөг байж мэднэ.

Өнөөгийн монгол хэл халх аялгуунд суурилан хөгжсөн нь Умард Юань улсыг дахин мандуулж, монгол угсаатныг нэгтгэсэн Мандухай сэцэн хатан, Батмөнх Даян хааны (1464 - 1517) улс төрийн үйл ажиллагаатай холбоотой. Даян гэдэг Да Юань

буюу Их Юань гэсэн утгатай үг гэж түүхчид үздэг. Тухайн үед бий болсон “Зургаан түмний магтаал” шүлэг нь ард иргэдээ шинэ зохион байгуулалтад оруулсныг илтгэдэг. Уг магтаалаас хөдөлмөрийн хуваарь ч харагдана. Сонирхуулбал, Урианхай түмнийг худаг ус гаргагч, Еншөөбү түмнийг айраг таргийн хөрөнгө гаргагч гэжээ. Ямартаа ч халх түмэн өнөөгийн Монгол Улсын суурь үндэс болсон нь энэ үеэс болой. Халх аялгууг харахад эгшиг зохицох ёс тогтож, урт эгшиг үүсэн, эгшиг болон гийгүүлэгч задран олон болсон нь монгол бичиг дуудлагаасаа зөрөхөд хүрч, тод үсэг, али-гали үсэг, вагиндарагийн үсэг үүсэх үндэс болжээ. Япон хэл жишээ нь эрт үедээ олон гийгүүлэгч, эгшигтэй байгаад тэр нь яван цөөрсөөр өнөөгийн япон хэлний авиа зүй болон тогтсон байдаг. Хэл гэдэг сонин.

Монгол хэл бол хэлний хамгийн тогтвортой хэсэг болох дүрэм, бүтцийн хувьд өөрийн шинж чанараа тогтвортой хадгалсаар буй хэл. Аливаа үндэстний амин чанарын чөмөг нь хэл юм. Эх хэл нь бичгийн урт удаан хугацааны уламжлалтай, түүгээр ярилцагч ард түмэн нь хэлэндээ хайртай, түүнийгээ гарамгай эзэмшиж, түүгээрээ мэдлэгийн ертөнцийг бүтээн, дэлхийд хувь нэмрээ оруулж буй эсэх нь чухал байдаг. Энэ утгаараа монгол хэл бол өнөө цагийн хөгжлөөс огт хоцроогүй, эрчимтэй хөгжиж яваа хэл. “Чихний чимэг болсон аялгуу сайхан монгол хэл”-ийг монгол хүүхдүүддээ сайтар эзэмшүүлэх нь боловсролын хамгийн гол зорилго болох юм. Хэлээ мартсан ард түмэн сэтгэлгээгээ бүрэн алдахад хүрэх аюултай.

Монголчуудын ахуй амьдралын онцлог

Өнөөгийн байдлаас харвал нүүдэл, суурьшлын зааг дээр бид байна. Суурин иргэншил байгалиасаа хол байдаг ч соёл боловсрол, шинжлэх ухааны хөгжил, ихээр үйлдвэрлэж ихээр хэрэглүүлдэг өнөөгийн үйлдвэрлэлийн арга хэлбэр, эдийн засгийн өсөлтийг дэмждэгээрээ ч даяаршилтай эерэг хамааралтай байдаг. Хот суурин эрчимтэй нэмэгдсэн нь даяаршлын нэг шууд үр дагавар. Хөрш Хятадын харахад л цөлжилтийн эсрэг тэмцэх үр дүнтэй арга хэмээн хотжилтыг эдийн засаг, улс төр, засаг захиргааны аргаар дэмжиж ирэв. 2005 онд Киргизид гарсан Алтан зул цэцгийн хувьсгалыг харахад цаад учигт нь суурин амьдардаг киргиз, узбекууд болон нүүдэлчин киргиз хоорондын зөрчил байсан юм.

Монгол Улс нүүдлийн соёл, амьдрал ахуйг хадгалан авч үлдсэн цөөн улсын нэг. Гэхдээ энэ нь гадаад, дотоодын жуулчинд үзүүлэх төдий соёл биш юм. Энэ соёл бол монголчуудын байгальтайгаа ойр, зэрэгцэн орших нийтлэг ухаан болой. Нүүдэлчид эртнээс газар ухаахыг цээрлэж ирсэн нь газар тариалан эрхэлж хөрсийг эвдлэхээс сэргийлж ирсэнтэй холбоотой. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ

300 мм ч хүрэхгүй Монголын тал нутаг бичил биетэн идэвхижиж органик үлдэгдлийг задлан хөрс болгоход шаардлагатай дулаан температуртай үе жилийн тавдугаар сараас есдүгээр сар хүртэл ердөө таван сар үргэлжилдэг учир экосистемийн хувьд маш эмзэг. Тиймээс хүний нөлөөг аль болох гүехэн, тархуу байлгаж, байгалийн өөрийгөө нөхөн сэргээх хүчийг ухаалгаар ашиглаж ирэхийг нүүдлийн мал аж ахуй өөрийн үндэс суурь болгодог болой.

XX, XXI зуун бол суурьшлын эрин байв. ЗХУ-ын модернизацийн нөлөөгөөр монголчууд суурин амьдралыг үүсгэж, орчин цагийн эмнэлэг, боловсрол, хүнд хөнгөн аж үйлдвэртэй болсон нь том ололт юм. Гэвч бидний цаад чанар нь нүүдэлчин хэвээр байлаа. Оросжилтыг илт дэмждэг байсан Ю.Цэдэнбал хүртэл нас ахих тусам монгол уламжлалдаа ойртож, Зөвлөлтийн талаар таагүй үг унагаж байсныг түүний намтар түүхээс харж болно.

Өнөөдөр Монголын хүн амын 40 хувь нь нүүдлийн мал аж ахуй эрхэлж байна. Тэд бидний салшгүй нэг хэсэг, язгуур чанар юм. Бид энэ соёлоо нандигнан хадгалахын сацуу түүнийхээ салшгүй хэсэг гэдгийг ямагт боловсрол сургалтдаа оруулж, хүүхэд багачууддаа мэдрүүлэн ойлгуулж байх нь чухал. Хот суурин газраас малтай айлыг зайлуулж, тариалангийн бүсэд мал ойртуулахгүй хаших болсноор бэлчээр хомсдон, хадлан авах боломжгүй болсон малчид зуданд малаа олноор нь алдах болов. 2024 оны өвөл хавар тохиосон зуданд 3-р сарын эхний 10 хоногийн байдлаар 4 сая мал хорогджээ.

Байгалийн эрхшээлийг хүний ухаанаар давдаг нь зүй ёсны жам. Тэглээ ч гэсэн бид нүүдлийн соёлоо шинэ түвшинд хөгжүүлэхдээ байгальтай ойр байх зарчмыг эвдэхгүй байх ёстой. Харин уг соёлыг тээж явах залуу малчдыг сурган боловсруулдаг төрөлжсөн ахлах сургуулиудыг бий болгох нь Монголын цаашдын хөгжилд жинтэй хувь нэмэр оруулна.

Монголчуудын сэтгэлгээний онцлог

Бидний сэтгэлгээний нийтлэг тал юу вэ? Энэ талаар олон судлаачид, нийтлэлчид дурдсаар иржээ. Нэгэн нэрт нийтлэлч нүүдлийн мал аж ахуй бүхий монголчуудыг “хувиа аргацаасан, би болж байвал бусдад хамаагүй, бусдыг боддоггүй, өөрийн эрх ашгийг тэргүүнд тавьдаг, бүдүүлэг, мухар сүсэгт баригдсан, шинжлэх ухаанч рациональ сэтгэлгээнд дадаагүй, цуу үгээр ертөнцийг төсөөлдөг, бурангуй, төлөвлөлтгүй, зохион байгуулалтгүй, төрийг дээдэлж сохроор дагадаг” хэмээн эрс шүүмжилдэг. Иймэрхүү төсөөллийг зарим нэг өрнийн судлаачид, Монгол нутгаар аялсан хүмүүс бичиж үлдээсэн нь тухайн зохиогчид нөлөөлсөн биз ээ. Хятадын түүхнээ монголчуудыг “бараан шувууд шавалдах мэт гэнэт цугладаг, бурхан мэт гарч ирээд чөтгөр мэт алга болдог, ёслол журамгүй, өвгөд хөгшдөө

ачлах ёсыг мэдэхгүй” гэх мэтээр бичсэн нь буй. Монголчуудыг шүүмжилдэг дээрх шүүмжлэлд Оросын болон өрнийн сүм хийдийнхний нэмэрлэсэн “тамын орноос ирсэн татаарууд”, “харгис хэрцгий” гэсэн муу үг хамт дайгдана. Энэ бүхэн нь шинжлэх ухаанч үндэсгүй, заримдаа улс төр, түүх бичлэгийн зорилгоор монголчуудыг харлуулах зорилгоос үүдсэн гэж бодогддог.

Нүүдэлчид байгалийн хатуу ширүүн сорилтыг даван туулахын тулд харин ч туслах, дэмнэхийг эрхэмлэж “айл хүний амь нэг, саахалт хүний санаа нэг” зарчмыг барьдаг. Худаг дээр мал таарвал услаад явдаг, ховоогүй бол ховоо тавиад явдаг уламжлал өнөөдөр ч байна. Өөрөөр хэлбэл, Америкийн эрдэмтэн Патнамын тодорхойлсон итгэлцлийн хэмжүүр буюу Social Capital хэмээх ойлголтоор бол Монголын уламжлалт нийгэм хамгийн баялаг болж таардаг. Төрийг дээдэлдэг монгол уламжлалын тухайд бид тусад нь авч үзэн судлан үзэх учиртай. Энэ нь XVI зуунд Монголд дахин дэлгэрсэн төр төвтэй шашин болон төрийг гэршүүлэх, хүншүүлж харах эзэн Чингис хааны үеэс улбаатай болов уу.

Монголын нэртэй зохиолч Дармагийн Батбаяр нүүдлийн мал аж ахуйн уг үндсийг гярхай ажиглаж, нүүдэлчид бол хэдийн төгс хэлбэрээ олсон амьдралын хэв маягаа өөрчлөх дургүй, өөрчлөх ч шаардлагагүй дэлхийн хамгийн хүчтэй консерватив үзэлтэнгүүд гэсэн дүгнэлтийг хийжээ. Япончууд монгол хүний уян хатан, нөхцөл байдалд хурдан дасан зохицож чаддаг чадварыг өндөр үнэлсэн байдгийн дээр монголчуудын аливаа хуваалцах, дундаа эзэмшдэг чанарыг ажигласан судалгааны бүтээлүүдийг туурвисан байдаг.

Хуваалцах, дундаа эзэмших нь өмчлөлийн нэг хэлбэр бөгөөд энэ нь зардал, цагийг хэмнэж, өмчийн ашиглалтыг сайжруулдагаараа тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үүднээс ч өнөөдөр хөгжингүй орнуудад анхаарал татаж байна. Ухаандаа машин авлаа гэхэд 2-3 өрх айл дундаа хэрэглэх нь гараашид хоосон байлгахгүйн дээр мөнгө, цагт ч хэмнэлттэйг хэн ч хүлээн зөвшөөрнө. Монгол хүүхэд хажууд байгаа баллуурыг эзнээс нь асуухгүй шууд л авч хэрэглэх нь түгээмэл харагддаг. Харин япон хүүхэд заавал асууж байж хэрэглэнэ. Асуухгүй хэрэглэж байна гэдэг нь нүүдэлчин түмний хуваалцах сэтгэлгээ цухалзаад байгааг илэрхийлнэ.

Сэтгэлгээнийхээ онцлог давуу байдлыг боловсролын хөтөлбөрт суулган, хүүхдэд сайтар ухааруулах хэрэгтэй. Чингэхдээ шүүмжлэхийн тулд шүүмжлэх бус бүтээлч шүүмжлэлийг өрнүүлдэг, авах гээхийн ухаанаар ханддаг, аливааг үнэлж дүгнэн, цэгнэж чаддаг монгол хүнийг бүтээх нь чухал билээ. Монгол хүний нандин чанар дэлхийн хүний салшгүй хэсэг болой.

Уламжлал шинэчлэлийн зөрчил, нэгдэл

Уламжлал, орчин үеийн хөгжлийн зөрчил, нэгдлийг дотроо агуулаагүй улс гэж үгүй. Япон гэхэд л эзэн хаанаараа төвлөрсөн, эзэн хаанаа тахин шүтсэн, үндсэрхэг үзлийн уламжлалыг 1945 онд халсан ч эзэн хаан нь эдүгээ ч төрийн тэргүүн хэвээр байна. Монголчууд бидний хувьд уламжлал, шинэчлэлийн зөрчил, нэгдэл нь хаана орших вэ?

1990 он гармагц бид гадны нөлөөгөөр няцаан үгүйсгэж, заримдаа дайсагнасан ч гэмээр хандаж байсан хоёр том элементийг эргүүлэн сэргээж, хоймортоо залжээ. Нэг нь Чингис хаан, нөгөөх нь буддизм. Бид 1990 он гармагц Чингис хаанаас уламжлалаа сэргээж, Зөвлөлтийн нөлөөн доор түүнийг үгүйсгэж ирснээсээ татгалзав. 1990-ээд онд төрсөн хүүхдүүдэд Монголын нууц товчоонд байдаг нэрс их байдаг нь үүнтэй холбоотой.

Мөн 1990 он хүртэл хавчигдаж байсан шарын шашныг сэргээсэн нь монголчуудын уламжлал сэргэх нэг сэжүүр болов. 400 гаруй жилийн өмнө Монголд дахин орж ирэн дэлгэрсэн буддизм өнөөгийн Монголын салшгүй нэг хэсэг, оюун санааны нэгэн ундарга болжээ. Түвэдүүд ууландаа, монголчууд тал нутагтаа угаас бясалгаж ирсэн ард түмэн. Энэ утгаараа ч дэлгэрэх нь амар байсан биз. Далай ламын хувийн эмч надтай нэгэнтээ уулзахдаа “Монголчууд та бүхэн бясалгал гэж тусдаа сурах шаардлагагүй санагдана. Зүгээр л тал нутагтаа энэ сайхан байгалийн дунд чимээгүй суух нь хамгийн сайн эмчилгээ, хамгийн сайн бясалгал” гэж хэлж байж билээ. Өнөө цагт Монголд дэлгэрсэн буддизмыг хэт мухар сүсгээс ангижруулан, санамсар ухамсраараа гэгээрлийг ойлгох, хүрэх зам болгохыг шашныг шинэчлэгч лам нар оролдож байгаа нь сайшаалтай хэрэг мөн.


Шинээр ирсэн нэг элемент бол ардчилал. Бид эрх чөлөөг эрхэмлэдэг нүүдэлчин уламжлалтай. Тиймээс ч ардчиллын салхи Берлиний хана нурахад нааш салхилаад Цагаан хэрэм тулан зогсоход монголчууд уг тогтолцоог нутагшуулж чадсан гэж би боддог. Ардчиллын цаана нь хувь хүний хариуцлагын тогтолцоо оршдог. Үүнд бид харин 30 жил суралцаж байна. 1990 оны үеийн ардчиллаас одоогийнх хамаагүй өөр түвшинд хүрчээ. Ардчилал бол хоёр хүчирхэг хөршийн дундах Монгол Улсын хувьд геополитикийн алслагдсан бүс, тусгаар тогтнолын хөдөлшгүй баталгаа юм. Ардчиллын тогтолцооны үндэс нь парламентын ардчилал болно. Үүнийг Монгол Улсын Үндсэн хуульд хөдөлшгүйгээр тунхагласан нь өнөө үеийнхний бий болгосон том ололт билээ.

Өнөөдрийн Монголын нийгэмд суурьшил, нүүдлийн соёл хоорондын зөрчил эсрэгцэл явагдаж байна. Суурьшил ч, нүүдэл ч аль нь бидэнд хэрэгтэй. Хамгийн гол нь байгальдаа ээлтэй агаад

аж үйлдвэрээ дэмждэг тогтвортой буюу тулхтай хөгжлийн үзэл баримтлалд энэ хоёр соёл хоёул уягдах учиртай юм. Монгол Улс өөрийн нүүдлийн соёл, бий болгосон түүх, эх хэлээрээ бахархдаг, дэлхий даяар тархан суурьшсан монгол туургатны

өлгий нутаг болох учиртай. Ардчилалд шилжээд 30 жил боллоо. Дараагийн 30 жилд бүс нутагтаа ардчиллын үндсэн зарчмуудыг хэдийн бат бэх шингээсэн агаад эдийн засгийн хувьд хүчирхэг Монгол улс бий болгосон байна гэдэгт би итгэдэг.

МОНГОЛ БИЧИГ ЯЗГУУРААСАА МОНГОЛЧУУДЫН БИЧИГ БОЛОХ ТУХАЙД



ЗОХИОЛЧ
Г.АЮУРЗАНА

МОНГОЛ БИЧИГ ЯЗГУУРААСАА МОНГОЛЧУУДЫН БИЧИГ БОЛОХ ТУХАЙД

Газар дундын тэнгис орчимд аж төрж асан финикууд анх авианы бичиг үсэг зохиосон нь үнэхээр том дэвшил байв. Авианы бичиг нь хүний хэлж буй үгийг цөөн тооны үсгээр бүрэн тэмдэглэх боломжтой, өөр хэлний аялгууг ч тэмдэглэж авах нэгдмэл зүй тогтолтой учраас хүн төрөлхтөний эрдэм боловсролд онцгой үүрэг гүйцэтгэсэн юм. Тэр бүхнийг нарийвчлан дурдах нь илүүц. Харин анхны тэр л финик бичгээс арамей бичиг, арамей бичгээс согд бичиг, согдоос уйгур бичиг үүсэн гарсан нь л бидэнд чухал. Уйгур бичгээс манай монгол бичиг үүссэн гэгцгээдэг ч яг үнэндээ үүсээд ч байсан юмгүй, ердөө нэг л бичиг шүү дээ.

640-өөд оны үед Зүүн Түрэгийн хаант улс мөхөж газар нутгийг нь Уйгурын хаант улс эзэмшжээ. Харьцангуй богино настай энэ улсын түүх монголчуудын эрдэм боловсролд маш чухлаар яригдах учиртай. Финик-арамей-согд гэсэн бичиг үсгийн буухиаг Монголын өндөрлөгт нутагшуулсан өндөр соёлт угсаатан бол чухамхүү Уйгур гэдгийг нэн тэргүүнд бид онцгойлон санаж, тэдний угсаа гарвал, хэлний тухай баримтуудад ч тун хянуур хандах ёстой юм. Уйгурууд маш боловсронгуй авианы бичиг үсэгтэй болж, түүгээрээ албан бичиг хөтлөн, ном зохиол бичиж, гадаад хэлнээс шашны судар орчуулж байсан нь тал хээр нутгийн нэгэн том бахархал билээ. Тэр ч байтугай Бурханы шашныг согд лам нараар дамжуулан тал нутагт анх түгээсэн соён гийгүүлэгчид нь уйгурууд байх магадлалтай.

Уйгур улс Монгол нутгийг эрхшээж байх үед бусад монгол аймаг уйгуржин үсгийг авсан

бололтой. Нүүдэлчин улс аймгуудад бичиг үсэгт тайлагдсан сэхээтнүүд нь язгууртан анги дотроо л тусгай байх тул дийлэнх ард иргэдийн бичиг үсэг үл мэдэх байдлыг хавтгайруулан тэмдэглэсэн эртний хятад мэдээнүүдэд төдийлөн ач холбогдол өгөх хэрэггүйг түүхэн туршлага харуулдаг. Ер нь нүүдэлчин нийгэмд элит ба массын зааг ялгаа ихээхэн тод билээ.

Нэрт эрдэмтэн гүүш Зава Дамдин “Хор Чойнжун” хэмээх Монголын түүхийн бүтээлдээ Чингис хаанаас даруй долоон зууны өмнөөс монгол, уйгур, согдууд өөр хоорондоо найрсаг дотно харилцаатай байсныг дурдаад, “Согдын мэргэн багш нар уйгур хийгээд монголчуудад үсэг бичиг унших ба Бурханы дээд зарлигуудыг өөр өөрийн хэлээр орчуулах ёсыг үзүүлж сургав. Бас согдууд Энэтхэг орноос бурханы номыг Монгол оронд залж ирсэн бөгөөд энэ шалтгаанаар номын хэлэнд энэтхэг, уйгур, монгол үг холимоогоор оршсоор байна...” хэмээжээ. Тэгэхээр энэхүү мэдээллийг агуулсан хуучны судар ном ч байдаг л болж таарна.

Уйгурууд бүх талаар хүчирхэгжиж, согдуудаас бичиг үсэг авч өөрийн хэлнээ зохиомжлон нийцүүлснээр монгол нүүдэлчдийн ярианд “ном”, “дэвтэр” хэмээх перс угшилтай согд үгс, “судар”, “эрдэнэ”, “шүлэг”, “бадаг” зэрэг самгард угшилтай энэтхэг зүгийн үгс, “сүм”, “суварга”, “билиг”, “хөрөг”, “эрдэм” гэх зэрэг уйгур үгс гүн суусан байна.

Харин уйгуруудыг түрэг язгуурын хэлтэн гэж ихэнх эрдэмтэн үздэг тул, түрэг хэлтний бичгээр

монголчууд үндэсний бичгээ хийхэд хүрсэн нь хэр үндэслэлтэй болохыг давын өмнө шинжиж үзэцгээе.

Түүхэн баримтуудыг харгуулахад, хоёр зүйлийн эргэлзээ эрхгүй төрдөг.

Нэгдүгээр нь, түрэг хэлтний өөртөө таацуулан авч зохиосон бичгийг монголчууд яагаад тийм амархан өөриймшүүлж чадав аа?

Ийн эргэлзэх шалтгаан нь, монголчууд уйгур бичгийг хэзээ, хэрхэн авсан тухай баримт хэмээн тооцож ирсэн нэгэн үйл явдалд хамаатай. Олон эх сурвалжийн мэдээг харахад, 1204 онд Найманы Таян хааны ордноос бичгийн түшмэл Тататунгаа уйгур үсэг бүхий тамга авч зугтах гэж байгаад баригдсан нь үнэхээр тохиолдсон бодот явдал бололтой. Чингээд хан хөвүүдэд сайх түшмэлээр уйгур бичиг заалгажээ. Ердөө л хүүхдүүдээ сургуульд өгсөнтэй ижилхэн, багш шавь бололцсныг л өгүүлсэн ийм мэдээг монголчууд анх бичиг үсгийн бараа яаж харсныг гэрчлэх түүхэн баримт мэтээр тайлбарладаг нь үнэхээр инээдтэй хэрэг шүү. Хан хөвгүүд бичиг сурч эхэлснээс хоёрхон жилийн дараа 1206 онд нэгдсэн Монгол улсыг тунхаглахад уйгур үсгийг “Улсын бичиг” гэж зарласан байдаг. Тэрхүү улсын бичгээрээ төрийн бүх албан хэргийг хөтөлж, бүр 1220-иод онд “Монголын нууц товчоон” буюу Чингис хааны намтар зохиолын үндсэн эхийг биччихсэн байдаг. Бичиг үсэг авч өөриймшүүлээд, бүр дээд түвшний утга зохиол бичиж туурвих хэмжээнд хүрэхэд ийм ахархан хугацаа хангалттай байж чадах уу?

Энэ сэжүүрээс судлаачид он цагийн эрэл хийж үзэж л дээ. Монгол бичгээр бид ярианаасаа нэлээд ялгаатай бичдэгийг, ихэнх гийгүүлэгч дэвсгэрлэдэггүй, ардаа эгшиг авдгийг та давын өмнө санах хэрэгтэй. Монголчууд ингэж задгай голдуу үеүдээр ярьдаг байсан маань хэдий үеийн явдал юм бол?

Эрдэмтэн судлаачид XIII зууны яриг тусгасан дөрвөлжин бичгийн галигтай харьцуулж үзээд, бүр тэр үед л монголчуудын ярианы хэл бичгийн хэлээсээ зөрүүтэй болчихсон байсныг баталчихсан юм. Тэгэхээр монгол бичиг монгол хэлний харьцангуй эрт үеийг тусгасан нь тодорхой. Энэ илэрхий гажуу сонин баримтын учрыг зарим эрдэмтэн “Монголчууд бичгээ түрэг хэлт уйгуруудаас биш, харин тэднийг анх бичиг үсгээ зохиох үед л, тэдэнтэй нэгэн зэрэг согдуудаас авчээ” гэсэн таамаглал дэвшүүлж тайлбарлахад хүрсэн нь аргагүй.

Ер нь академич Б.Ринчений хэлсэнчлэн “хаяа дэрлэсэн нангиад түмэн хэдэн мянган жилийн бичиг үсэгтэй, тамгатай цаастай байхад, XIII зууны үес сая бичиг тамгыг Тататунгаас санамсаргүй олж үзээд бичигтэй болсон хэрэг яасан ч биш. Түүгээр ч үл барам мандаж байсан улс мөхөж байсан буюу

мөхсөн улсын бичиг үсэг огт хамаагүй шүүрэн авдаггүйг бодвол...” нарийн учир нь тодрох байх. Яг энэ эшлэл хэсгийг агуулсан монгол бичгийн тухай өгүүлэлдээ Б.Ринчен гуай “Алтан товч” нэртэй хэд хэдэн судрын нэгэнд Бодончар Сүн улстай найрамдалт харилцаатай байж, бичгийн эрдэм хөгжүүлсэн тухай баримтыг мөн дурдсан байдаг юм.

Гэхдээ монголчууд уйгуруудтай нэгэн зэрэг согдуудаас бичиг үсэг уламжлан авсан гэдэг бахархалтай хэдий ч аанай л эргэлзээтэй санаа. Үнэхээр л өөрсдөө Уйгуртай зэрэгцээд авч, Уйгураас хамааралгүйгээр хэлдээ тохируулж нутагшуулсан юм бол яагаад уйгур үсэг гэж ямагт нэрлэсээр ирсэн хэрэг вэ? Уйгуруудаас аваагүй юм бол яагаад уйгур тигээр л ямагт бичсээр ирсэн хэрэг вэ? Чингис хааны нэрийг мөр тэтгэсэн Есүнхэ мэргэний гэрэлт хөшөөн дээр ч тэр, Их Монгол улсын Далай хааны тамган дээр ч тэр яагаад өөрийн онцлогоо шингээлгүй, бахь байдаг нөгөө л уйгуруудын тигийг баримталсан болж таарах вэ? Төрт ёсны хамгийн дээд шүтээн болох хааныхаа тамган дээр яагаад уйгураас ондоо тигтэй үсэг сийлж болсонгүй вэ? Хожим нь, бүхнээс хүчирхэгжсэн Юань улсын үедээ ч яагаад чухам “Уйгураас үсэг зээлсэн” гэж төрийн түвшинд үүх түүхээ мэдээлээд байсан хэрэг вэ? Ил хаадын албан захидлууд ч хуучны уйгур тигээрээ л бичигдсээр байсны учир юу вэ? Хоёрдугаар эргэлзээ энэ.

Монгол хэлний XIII зууны аман ярианаас зөрүүтэй байна аа гэдэг бол энэ бичиг цаг хугацааны хувьд 1225 оны Есүнхэ мэргэний гэрэлт хөшөөнөөс хавьгүй өмнөх үед цэгцэрч төлөвшчихсөнийг шууд илтгэнэ. Бид монгол бичгээр “агула” гэж бичдэг ч, “агула” эсвэл “а’ула” гэж хэлдэг асан үе гэвэл бүр VII-VIII зуун бололтой. Тэгэхээр уйгур бичиг монголчуудын хэрэглээнд орж монгол хэлнээ зохицсон нь юун 1200-аад он? Наанадаж VIII зууны явдал болж таараад явчихна. Татаж яриад тэр шүү дээ!

Бичурин монгол бичгийн үүслийг 920-иод онтой холбож бичсэн нь уйгуржин монгол бичиг, хятан авианы бичиг хоёрын дунд жаахан самуурсан хэрэг байх л даа. Гэхдээ хятан бичгийн нууц одоо хэр тайлагдаагүй. Хэдийгээр ханзны дүрс зурлагыг голчлон авсан ч жинхэнэ зарчим нь уйгур бичгийн тогтолцоонд суурилсан байж мэднэ. Ийн хэлэхийн учир нь авианы зарчимтай хятан бага бичгийг зохиосон Елюй Диела хэмээгч нь Хятаны анхны хаан Елюй Абаожийн дүү бөгөөд уйгур бичиг сурч байсан баримт “Ляо судар”-т тэмдэглэгджээ. Даниел Кане энэ жишээг Хятаны бага бичгийг уйгур үсэг дээр тулгуурлан зохиосны шууд нотолгоо болгож “The Kitan Language and Script” хэмээх номдоо оруулсан байдаг (2009 оны англи хэлээрх хэвлэлийн 35 дахь

талд буй). Хятан бичгийн ханзархуу зурлагуудын утга огт тайлагдаагүй учраас үсгийн тухайд бол лавшруулж ярих боломж хараахан бүрдээгүй байна.

Уйгур бичгээс өмнө уйгуруудын хэлний тухайд зарим зүйлийг тодруулах хэрэгтэй. Бас уйгур ба түрэг хэлний харьцаа, түрэг хэлтнүүдийн орон зайг ч хөндөх хэрэгтэй. Түрэг хэл монгол хэлнээс салсан юм уу? Эсвэл монгол хэл нь түргээс салсан юм уу? Эсвэл салж салбарласан тухай ойлголт ерөөсөө байхгүй юм уу? Энэ мэт маш олон асуултад хариулт байдаггүй. “Судрын чуулган” Уйгурыг Огузад дагасан маш ойр дотно угсаатан гэдгээр нь л түрэг хэмээн баталдаг. Гэвч мөнхүү сударт ерөөс нийт монголчуудыг анхандаа толгой дараалан түрэг угсаатан байсан гэж зүтгэдэгийг ч бас мартаж болохгүй.

Монгол хэлтэн Хятан улс монгол угсаатнуудаа нэгтгэж захирахыг л хамгаас шаргуу эрмэлзэж байсныг түүхэн баримтуудаас харж болдог. Хятаны Ляо улс нь монгол угсаатны төр учраас монгол угсаатнуудаа захиран, тэднээр хүлээн зөвшөөрүүлэхэд юу юунаас илүүтэй анхаарал хандуулж байсан юм болов уу гэмээр зах зухын жишээ гэвэл:

Юань гүрний үед монгол зохиогчийн бичсэн “Ляо улсын судар”-т өгүүлсэн он дарааллын тэмдэглэлд Хятан улстай хамгийн ойр дотно, Хятанд бүрэн дагасан монголчуудаас ч илүү нягт харилцаатай, байнга алба барих элчин ирүүлдэг улс бол Уйгур байсныг бүр дахин дахин сануулсан байна. Уг сударт монгол аймгуудаас гагц Урианхайг л Хятаны хараат нэгэн муж хэмээн цохлон дурдагджээ. Үүнээс эргэцүүлэн үзвэл, Уйгур нь Хятантай монгол аймгуудаас илүүтэй нэн ойр шадар байх шалтгаан нь мөн л монголжуу угсаатан байсных болов уу.

Юутай ч, Хүннүгийн хойчис гэдэг нь мадаггүй нотлогддог Уйгур яг ч түрэг хэлтэн байгаагүй нь олон зүйлээр илэрхий болдог юм. Гэхдээ зориуд анхааруулахад, Уйгурын хаант улсыг байгуулсан хүчирхэг уйгуруудыг Таримын баянбүрдүүд тийш шахагдан нүүсэн, улмаар түрэгжсэн, хожмын буурай угсаатантай адилтгах хэрэггүй. Яагаад?

Чамгүй маргаантай үндэслэл сөхөж байгаа тул, жаахан тогтож ярилцъя.

Уйгуруудын уугуул нутаг хаа билээ?

Өнөөдрийн Туул голын ай сав. XIV зууны хятад эрдэмтэн Юй Жи гэгч уйгуруудын гарал үүслийн нэгэн домгийг түүхэн сурвалжуудаас олж тэмдэглэжээ. Тэнд дурдсанаар бол “Уйгуруудын уугуул нутагт Хорум хэмээх их уул бий. Тэр уулаас Туул, Сэлэнгэ хэмээх хоёр их мөрөн урсана...” хэмээсэн байна. Туул бол Хэнтийн нуруунаас, Сэлэнгэ харин Хангайн салбар уулсаас эх авч урсдаг. Тэгэхээр уйгуруудын уугуул нутаг Туул, Орхон,

Сэлэнгийн бэлчир болж таарна. Хорум нэрт уулаас Туул эх авч урсдаг гэсэн нь харин сурвалжийн алдаа байх. Орхоны хөндийд Хархорум байгуулсны нэрийн улбаа уйгуруудын Ордубалыктай хамаатайн нэг сэжүүр л энэ домогт мөн агуулагдаа болов уу.

Уйгурууд Орхон ба түүний цутгал арван голоор нутагладаг тухай Рашид-ад-дины “Судрын чуулган”-д, Туул, Орхон, Сэлэнгийн нийлсэн цутгалуудаас хойшилж нутагладаг тухай Жувейнийн “Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх”-д ч тов тодорхой байгаа. Эдгээр баримтаас харахад л уйгурууд түрэг хэлтний нутгаас холуур, зүүн тийш нутаглаж ирсэн угсаатан болж таараад байдаг юм.

Түргүүдийн уугуул нутаг хаана болохыг эрдэмтэд янз янзаар хэлдэг ч үндсэндээ хоёр газар оноожээ. Эхнийх нь Алтайн уулсаас урагш Тэнгэр уулаас хойш Зүүнгарын хотгор. Удаах нь Алтай, Хөхүйгээс хойш Сибирийн өмнөд хэсэг. Хөх түргүүд Монгол нутгийн баруун хэсгээс өнөөгийн Казахстаны тал руу нүүдэллэхэд, тэндээс аварууд шахагдаж баруун тийш одсон гэдэг шүү дээ. Аль ч хувилбараар нь бодсон эртний түрэг хэлтний орон зайн зүүн хязгаар нь Алтайн салбар уулс болж таарна. Орхоны хөндийд тулсан нь, цаашлаад өнөөгийн Налайх, Чойр руу шахсан нь ч чухам л хүчирхэг улс байгуулсан цорын ганц учир шалтгаанаар болой.

Тэгэхээр уйгурууд түрэг хэлтний тодорхой орон зайгаас гадуур, зүг чигийн хувьд зүүн хойд талд нь нутаглаж байжээ.

Одоо тэгвэл яг түрэг хэлтэн мөн үү гэдгийг мөшгөө.

XI зуунд Махмуд-аль-Кашгари хэмээх хүн араб-түрэг хэлний толь зохиосон юм билээ (Тэрхүү “Диван Лугат ат-Тюрк”-ийг “Сэргэлэн экспедишн” хэмээх судалгааны багийнхны зүгээс эртний монгол хэлний толь бичиг хэмээн тайлбарлаад буй. Угаасаа хэлзүйн хувьд нэг тогтолцоотой хэлүүд учраас тэгж тайлбарлагдах сэжүүр ч олон гардаг байх л даа). Мөнхүү толь бичгийг би орос орчуулга бүхий хувилбараар л үзсэн бөгөөд тайлбар маягаар оруулсан ойллого дотор нь “Уйгурууд түрэг хэлтэй ч өөр хоорондоо ярилцдаг ондоо хэлтэй. Харилцаандаа хорин дөрвөн үсэгтэй түрэг бичиг хэрэглэдэг ч ёслол хүндэтгэлдээ хэрэглэх, зөвхөн дээд лам нар нь л мэдэх ариун судрын ондоо бичигтэй...” гэсэн үгс дурайж байдаг юм.

Өөр хоорондоо бол, мэдээж, унаган хэлээрээ л ярилцаж таарна шүү дээ. Бичгийн хувьд бол энд уйгуржин бичгийг хэлсэн нь эргэлзээнгүй. Тэгэхээр түрэг хэл уйгуруудын эх хэл биш, өөрөөр хэлбэл, уйгурууд язгуурын түрэг хэлтэн огтоос биш болж таарч байна!

Ердөө Түрэгийн хаант улсыг залгамжилж улс

байгуулсан учраас л түрэг хэл, соёлыг өвлөжээ. Яг ийм үзэгдэл Түрэгийн хаант улсад өөрт нь ажиглагдсан шүү дээ. Анхандаа Түрэг хаант улс монгол хэлээр албан хэргээ явуулж байсны хамгийн чухал баримт нотолгоо бол Бугатын хөшөөний брахми бичиг ба Хүйс толгойн брахми үсгээр монгол хэлээр бичсэн тайлгын өргөл бичээс болно.

Төв Азид хамгийн анх илэрч буй бичиг нь монгол хэлээр бичигдсэнийг тийн нотлохоос өмнө бол “түрэг хэлэнд зориулагдсан (Орхон-Енисейн рүни) бичгээр л нүүдэлчид анхлан хэлээ тэмдэглэсэн” гэж үзсээр ирсэн байдаг. Тэр үзлээр бол, Ферганы хөндий хавьд төвлөрсөн соёлын голомтоос тархсан согд бичгийн нөлөөн дор түрүү Түрэгийн нийтлэг хэлний үсэг зүйн хөгжил тогтсон гэж тооцож байжээ. Энэхүү согдоос түрэг хэлийг тэмдэглэх рүни бичиг салбарлаж хөгжсөн, мөн согдоос уйгурууд бичиг авсан, тэд ч мөн түрэг хэлтнүүд учраас бичиг үсэг нь нэгэнт тогтсон суурь дэвсгэр дээрээ тулгуурлан амархан нэвтэрч нутагшсан гэж тооцсон бололтой.

Харин түрэг хэлэнд зохицуулж зохиосон бичиг нь монгол хэлэнд яв цав сайхан таарчихсанд хачирхсан зарим эрдэмтэн монголчууд уйгуруудаас буюу түрэг хэлээр дамжуулж бус, харин тэдэнтэй цуг согдоос бичиг авсан гэж хэлэхээс өөрцгүйд хүрчээ.

Төрөл гэгдэхүйц шинжтэй ч бие даасан өөр хэлүүдийн бичиг нэг нэгэндээ төгс зохицох нь бараг л үгүй юм билээ. Тодорхой жишээ гэвээс манжууд монгол бичгийг шууд аваад хэрэглэж үзсэн түүх байна. Дусал бинтгүй монгол бичгээр манж хэлийг тэмдэглэхэд яагаад ч бүрэн нийцэж өгөхгүй доголдоод байсан учраас сүүлдээ бичгээ шинэчилж, манж хэлний авиаг тэмдэглэхэд дөхөмтэй болгон өөрчлөхөд хүрчээ. Монголчуудыг ч мөн адил уйгур бичиг тэр чигээр нь авч хэрэглэж байгаад нийцэхгүйд хүрэхээр нь саж бандид Гунгаажалцангаар шинэчлүүлсэн (1243) гэж маргах хүн гарч магадгүй. Тэгвэл Чингисийн чулууны бичиг (1225), эсвэл “Монголын нууц товчоон” өөр дотроо бичигдсэн он цагаа (1228-1240) мэдээлж байдаг хөдөлбөргүй бичвэрийг үгүйсгэх хэрэг гарна. Гэхдээ уйгуржин бичигт дунд үеийн бус, эрт үеийн монгол аман ярианы хэл туссан байдгийг нэгэнт ярилцсан учраас ийм маргаан өөрөө утгагүй болох биз ээ.

За, ингээд 1204 оны орчим монголчууд гэнэтхэн л тухайн цагийн аман ярианаасаа сүрхий зөрүүтэй, харин эртний мартагдсан яриатай нь ойрхон, этгээд бичгийг уухайн тас аваад хэрэглэж эхэлсэн байж хэрхэвч таарахгүй учраас эрдэмтэд маань эртний ярианд ойрхон мөнөөх бичгийг Уйгураас бус, Согдоос авсан гэх дуулиант таамаг дэвшүүлэхээс өөр замгүй болж. (Энэ тухай дээр нэгэнт хэлсэн

ч ахин сануулж буйн учир нь их чухал ойлголтыг хөндөх гэж байгаагийнх юм шүү!) Энэ санал бол уйгуруудын угсаа гарвал, язгуур хэлнийх нь тухайд ямарваа өөр таамаг дэвшүүлээгүй тохиолдолд л хүчинтэй сэдэв. Өөрөөр хэлбэл, “Уйгур бол түрэг хэлтэн” гэдэг нь ямар ч эргэлзээгүй нөхцөлд л ийм таамаг дэвшүүлэгдэхээс өөрцгүйд хүрч байгаа хэрэг. Харин уйгурууд язгуураасаа монгол хэлтэн байсан гэдгийг олоод харцгаачих юм бол уйгуржин үсгийг монгол хэлэнд зохицуулсан тухайд ч юм уу, эсвэл монголчууд шууд согдуудаас бичиг үсэг уламжилсан эсэх талаар толгойгоо гашилгах ямар ч шаардлагагүй болно.

Өмнөх зүйл рүүгээ ороход, түрэг хэлтнүүдийн нутгаас зүүнш ба хойш нутагладаг, уугуул хэл нь түрэг бус, хүннүгийн шууд удам хойчис тэгэхээр ямар хэлтэн байж таарах вэ?

XIII зууны Хэрэйд аймгийн нутгаар эрт цагт төвлөн оршиж байсан угсаатан гэсэн үг шүү дээ.

Монголын өндөрлөгт нутаглаж ирсэн, түргээс ондоо хэлээр ярилцдаг угсаатны тухайд бол хэн ч эргэлзэлгүй, монгол хэлтэн л гэж хэлж таарна!

Уйгуруудын эртний үүсэл гарлын тухай домог бөө мөргөлтэй шууд холбогддог. Тэд өөрсдийгөө яг л буриад бөөгийн үзэлтэй ижилхэн “мод-эжий” буюу Ертөнцийн эх модноос төрсөн гэж үздэг байж. Тэр модоо бүр яг л монголоор “бөгү моду” гэдэг байсан нь сурвалжуудад тодорхой үлджээ. Гэтэл Төв Азийн уугуул түрэг хэлтнүүд модыг “агч”, “дархи” гэх мэт үгстэй ойролцоо дууддаг. Бөө модны тухай ойлголт Сибирийн уугуул ард түмнүүдэд өргөн тархсан байдгаас гадна монголчууд бид ч өөрсдөө ойн анчин иргэд тал нутаг руу гарч ирээд нүүдэлчин малчид болцгоосон түүхэн хувьслын, ойн иргэдээс аажмаар талын нүүдэлчдэд хувирсан угсаатны нэг салбар удам шүү дээ!

Сэлэнгэ мөрний эх, Орхон-Туулын бэлчирээр нутаглаж асан уйгурууд гэнэт хүчирхэгжээд Түрэгийн хаант улсыг түлхэн унагаж. Ингээд төрийг нь өвлөн залгаж. Тэгэхээр хожуу Турфаны бичиг сэлтээс уйгур үсгийн түрэг хэлт дурсгалууд олноороо олдсонд гайхаад байх ч юм үгүй. Өвлөж авсан төрийнхөө хуучин эрх баригчдын хэл соёлд автсан гэдэг нь байж боломгүй зүйл огт бишээр үл барам, ердийн л зүй тогтол билээ. Угаас өмнөх төрийн залгамж чанарыг баримталж, тэдний хэлээр гадагш харилцах нь дөхөм. Ийм жишээг XIV зуунаас хойш, Монголын эзэнт гүрэн задарсан хойно ч монгол хэлээр бусад улсууд өөр хоорондоо харилцаж байсантай адилтган үзэж болно.

Турфанаас уйгур үсгээр монгол хэлээр бичсэн “Сулхарнайн үлгэр” олдсон тухайд ч тэс хөндлөн таамаг хэлж бас болно. Энэ нь ч мөн уйгуруудын уугуул хэлний дурсгал байж мэдэхийг бүрмөсөн үгүйсгэх боломжтой гэж үү? Өвөрмонголын

эрдэмтэн Шонхорын нотолсноор бол энэ бичиг нь 1225 оноос хавьгүй өмнөх үед хамаатай гээд байгаа шүү дээ!

Хэл шинжлэл нарийн судлалын ухаан мөн боловч хэл маань өөрөө зарим талаар ихээхэн барьцгүй ойлголт. Уйгурууд түрэгжсэний тухайд гэвэл, хүмүүсийн харилцаан дээр ирэхээрээ ямар ч хэл хоёр гуравхан үеийн дотор хувирчихдаг эмзэг зүйл билээ. Өвөрмонголчууд, буриад, халимагуудын хэлний орчин гээд бидний сэтгэлд ойр бэлээхэн жишээ олон л байна шүү дээ. Түрэг төрийг өвлөснөөс гадна сүүлд Монгол нутгаас ч түрэг хэлтнүүдэд л шахагдаж, ондоо түрэг хэлтний орон зай руу дутааж орсон угсаатанд түрэгжихээс өөр зам ч байгаагүй нь лав. Бүдүүвчлэн таамаглахад, анхнаасаа хиргисүүдтэй нэг дор нутаглаж асан Ойрадын тэлэнгүүд, түүнчлэн Жочийн удмын хаадыг дагаж Казахстанд очсон монголчуудын адилаар л түрэгжсэн хэрэг. Түүнээс биш эрт язгуураасаа бол монгол хэлтэн байжээ. Өдгөө зөвхөн настайчуул нь л ойр зуур монгол үг хэлдэг Иссык-Көлийн ойрадууд ахиад хоёрхон үе өнгөрөхөд өөрсдийгөө түрэг хэлтэн, улмаар түрэг угсаатан гэж үзэцгээхэд хүрэх вий. Тэдний хувьд түрэг угсаатан байх, түрэгжсэн угсаатан байх хоёрын ялгааг харуулагч гол хүчин зүйл болох хэл нь үгүй болчихоор өөр яалтай ч билээ.

Таримын хотгорын баян бүрдүүдэд эртнээсээ нутаглаж асан тохар буюу перс гарлын хэлтнүүдийг уйгурууд эрхшээхдээ өөрсдийн шинээр автсан түрэг хэлээ тэдэнд тулгасан бололтой. Энэ бол харьцангуй түрэгжүүлсэн, түрэг талаас нь харсан хувилбар шүү. Яг үнэндээ Уйгур нь Түрэгт хамаагүй байж мэдэх хувилбарууд ч бишгүй бий. Хожуу үеийн уйгуруудыг энд онцолж яриагүйг анхаарна уу! Тэр тусмаа өнөөгийн Шинжааны уйгурууд бол эртний уйгур нэршлийг өвлөсөн удмынхантай нь ихээхэн холилдсон Цагаадайн улсын хойчис билээ. Нэр өвлөсний тухайд бол хятадууд тэднийг “чантуу” гэдэг нь “мангуу” гэдэг шиг л доромж утгатай учраас нэрээ бушуухан “уйгур-ойгор” болгохыг яарсан аж.

Бидний ярьж буй үе буюу монголчууд уйгуржин бичгийг өөриймшүүлсэн байх магадлалтай VII-X зуунуудад бол тэд бүрэн монгол хэлтэн хэвээр байгаагүй юм аа гэхэд монгол-түрэг завсрын хэлтэн байсан байх магадлал маш өндөр. Юутай ч антропологийн судалгаанууд уйгуруудыг холимог төрхтөн байсан гэж дүгнэдгийг доктор Д.Түмэн 2022 оны 5-р сарын 3-нд МУИС-ийн дугуй танхимд тавьсан лекц дээрээ хэлж байна билээ. Хэл яриа нь бага балчир хүүхдийн эрүү нүүрний тогтцол тодорхой хэмжээгээр нөлөөлдөг гэлцдэг. Тэгэхээр завсрын, дундын холимог хэлтэй болсон нь тэдний холимог төрхөөр дам илэрч байж ч мэдэх юм.

Монголын Найман аймаг уйгуржин бичигтэй байсан тухайд бол, магадгүй, найманчууд өөрсдөө угсаа гарвалын хувьд Уйгурын хойчис байж болзошгүй. Тийм сэжүүр ч олонтаа таардаг. Найман ч, Хэрэйд ч монгол хэлтнүүд болохоос түрэг хэлтнүүд байгаагүй нь тодорхой. (Өнөөгийн Казахстанд хэрэйд, найман, тэр ч байтугай жалайр, хонгирад овогтнууд байдаг нь түрэгжсэн монголчуудын удам хойчис болно) Тэгэхээр Найманы түшмэл Тататунгаагийн Чингис хааны хөвүүдэд багшилж заасан бичиг бол үндсэндээ монгол хэлэнд зориулагдан зохиогдсон, жаахан эртний монгол хэл аялгуунд тохируулсан бичиг байж. Тийм учраас л Чингис хаан уйгур бичгийг “Монгол улсын бичиг” хэмээн тунхаглаж шүү. Энэ бүхнийг ойлгоход энгийн логик сэтгэлгээ л хангалттай. Логик сэтгэлгээ өөрөө баримт нотолгоогоо, ихэнх тохиолдолд сэтгэлгээнийхээ аксиомыг агуулдаг. Логикоор шалгагдсан зүйлийг дахин өөр баримтаар нотлох шаардлага үгүй.

Тэгэхээр уйгур үсэг бол түрэг хэлний бус, монгол хэлний зүй тогтолд анхнаасаа тохирсон үсэг байж. Монголчууд энэ үсгийг хэзээ авсан бэ гэвэл бас л урт яриа хөврөх болно.

Ихэнх түүхч 1204 оны орчим монголчууд уйгур үсгийг Найманаас уламжлан авч, 1206 онд “Улсын бичиг” болгон албан хэрэглээнд оруулжээ гэсэн баримтыг эшилдэг нь хөнгөнөөр хэлбэл инээд хүрмээр, гэнэхэн явдал. Шихихутуг л гэхэд л хоёрхон жилийн дотор сурсан бичгээрээ гүрэн улсын захиргааны бүх хэргийг хөтөлж, шүүх заргын бүх бүртгэлийг тэмдэглэх үүрэг хүлээгээд, мөнөөх “Хөх дэвтэр” нь бүр Англи-Саксоны маягийн хууль зүйн лавлах болоод үлдсэн тэр бүх явцыг бодоод үзээрэй!

Хоёрхон жилийн дотор өөр хэлний бичгийг тухайн хэлэндээ бүрэн зохицуулах журам дүрмийг боловсруулаад, бичгийн түшмэд нь нэг мөр бичих эв зүйгээ олоод, төр улсын хэрэг хөтөлж, бүр шүлэг уран зохиол туурвих хэмжээнд хүртэл төгөлдөршүүлж амжих уу? (Хэлзүйн тогтолцоо нь адилхан гэж үзлээ ч гэсэн монгол, түрэг хоёр нь яалт ч үгүй л тусдаа өөр хэлүүд шүү дээ!)

Амжихгүй гэдгийг хэл шинжлэлийн томоохон эрдэмтэд цөм нэгэн дуугаар хэлдэг. “XIII зууны үед Монголын ярьдаг хэл, бичдэг журам хоорондоо нэлээд ялгаатай болсон байжээ. Жишээ нь, *agula*, *egude* гэж бичээд *aula*, *eude* гэж уншдаг байжээ. Ингэж хэл бичиг хоёрын хооронд ийм их ялгаа гарахад хэдэн зуун жилийн хугацаа хэрэгтэй...” хэмээн Ц.Дамдинсүрэн 1982 онд хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэлдээ цохон тэмдэглэсэн явдал тэдгээр жишээний ердөө нэг нь. Түүнчлэн Г.Рамстед “Чингис хаанаас бүр өмнө уйгур цагаан толгойг хэрэглэж байсан...” гэсэн бол, дээр нэгэнт

эшилснээ ахин товчлон цохож сануулахад Б.Ринчен “Уйгур улсын соёл, төр мандах үед буюу VIII зууны үеэс монголчууд уйгурын үсгийг авч өөрийн үг хэлээ тэмдэглэсэн байх ёстой. Харин Уйгурын төр мөхөж, соёл бууран хөсөрдөхийн үед мөхсөн улсын соёл, гээгдсэн үсгийг монголчууд авч хэрэглэсэн байж яавч таарахгүй...” гэж үзсэн нь гарцаагүй үнэн байх аа.

Бичгийн хэлний эртний өнгө аяс өөрөө маш их мэдээлэл агуулдаг. Тухайлбал, өнөөгийн уртын дууны хэл гэхэд л худам монгол бичгийн хэлтэй тохирсон хэвээрээ л байна.

...Арсланг-ун зулзага инэ

Агуландаа хүчтэй еэ... гэж “Эр бор харцага”-д дуулдаг биз дээ? Бид VIII зууны хэлээрээ дуулж байна гэсэн үг. Анхлан бичгийн хэв маяг буй болж тогтох үедээ ярианы хэлэнд шууд тохирч байсан нь илэрхий тул, монгол хэл яриа худам бичигт бичдэг шиг тэр л дуудлагаараа байсан үед уртын дуу ч мөн монголчуудын өргөн соёл байсныг энэ нь гэрчилнэ. Угаасаа аль эрт Хүннүгээс уламжилсан соёл гэдгийг нь өгүүлсэн домог ч бий шүү дээ.

Энэ бүхнийг нуршсаны эцэст ахин дүгнэхэд: уйгур галиг, бичгийн тиг анх уг бичгийг авах үеийн монгол хэлд ямар ч асуудалгүй тохирч байжээ. Тодорхой хэлбэл, VIII зуунаас хойш согд бичгээ бүрмөсөн хэрэглэхээ больсон согдуудаас VI-VII зууны үед бичиг үсгийг нь авсан байж таарах уйгурууд тэр үедээ бол монгол хэлтэн байжээ. Тиймээс энэ бичигт өөрчлөлт орсонгүй хэдэн зууныг элээжээ гэж үзэх бүрэн үндэслэл байна.

1246 оны Гүюг хааны захидалд дарсан Их Монгол улсын далай хааны тамгаас эхлээд 1289 онд Ил хаан Аргун Францын IV Филипп лэ Бел (1268-1314) ванд бичсэн захидлын тиг бүгд эртний уйгур тигээрээ л байдаг. “Их Монгол улс”-ыг төлөөлж буй, мөнх тэнгэрээр баталгаажсан хэмээх үзлээр баталж буй зарлиг шүү дээ. Тэнгэрч үзэлтэй, бэлгэдлийн

цогц сэтгэлгээтэй эзэнт гүрэн иймхэн зүйлийг анзааралгүй цалгардах уу? Яавч үгүй! Тэгэхээр уйгур бичиг, уйгур галиг, уйгур тиг гэх мэт ойлголт нь ердөө нэршил төдий болохоос Уйгур улсад хамаатай ч юм уу, эс бөгөөс уйгур хэлтэн хэмээх түргийн салаа салбар угсаатны бичиг үсэг гэсэн үг огт биш байх нь.

Чингис хааны үеэс “улсын бичиг” л гэж тунхагласнаас биш, уйгур бичиг гэж албан ёсоор хэлж тогтоосон зүйл үгүй. Энэ нь бараг л аман ярианы нэр томъёо шиг байна. Гэхдээ зохиогч нь яалт ч үгүй уйгурууд учраас “уйгуржин монгол бичиг” гэдэг нэршил энэ чухаг мэдээллээ мөнхөд хадгалаад үлджээ.


Хамгийн гол нь, уйгурууд хятанчуудын нэгэн адил монгол угсаатнууд байж. Бүр Хар Хятаны хойчисыг Тарвагатайн монголчууд хэмээх нь ч бий. Дорнод Түркестанд бэхжсэн, удам хойчис нь өдгөө Турфанд суурьшсан уйгурууд 1800-гаад оны эхэн үед түрэг хэлтэй, ислам шүтлэгтэй болчихсон хэдий ч эртний уйгур үсгээ, өөрөөр хэлбэл монгол бичгийг хэрэглэсээр байсан юм билээ. Мөн л түүхэн баримт шүү.

Монголчуудын түүхийн эх сурвалжийн яндашгүй далай болсон Хятадад харин нүүдэлчдийн бичиг үсгийн асуудлаар ихэнхдээ таг чимээгүй өнгөрөхийг эрхэмлэдэг нь уйгур бичиг үсэг бүр X зуунаас ч өмнө хэрэглэгдэж байсан гэдэг өрнөдийн түүхчдийн нотолгоог дэмжээгүйнх л юм.

XIII зуунд уйгурууд Монгол улсыг талархан дагаж,

...Үүл арилж эх наран үзсэн мэт

Мөлс арилж мөрөн ус олсон мэт... машид баяслаа хэмээн мэдүүлж, улмаар Уйгурын хаан нь Чингис хааны хүргэн болсон түүхтэй. Тэр нь ч бас язгуураасаа монгол аймаг явсны шинж байж мэднэ. Их Монгол улсын төрд уйгурууд дээгүүр алба хашдаг байсныг ч бодсон тэр.



БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИЙН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭЛ



МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ СУДЛАЛЫН НИЙГЭМЛЭГ БОЛОН
IQ ТӨВИЙН ТЭРГҮҮН, МУГЬ, ДОКТОР, ПРОФЕССОР

Ц.ДЭМБЭРЭЛ

БОЛОВСРОЛЫН БА СЭТГЭХ СОЁЛ

Нэг. СОЁЛ - Нийгмийн хөгжлийн явцад хүн төрөлхтөний бүтээсэн эд баялаг, оюун ухааны ололтын цогц. Хойч үеэ сургах, өөрийн мэдлэгээ өвлүүлэх гэсэн хүний оюун ухаантай салшгүй холбоотой, түүний үр дүнд буй болсон хүний мэдлэг, сүсэг бишрэл ба зан чанарын нэгдмэл байдал. СОЁЛ –г одоо хүртэл ингэж томъёолж заншсан буй. Ийм нөхцөлд соёлын агуулга нь: хэл, үнэмшил, сүсэг бишрэл, зан заншил, цээр, хууль, байгуулал, зэмсэг, арга зүй, урлагийн бүтээл, ёслол, зан үйл, бэлэг тэмдэг зэрэг биет ба биет бус зүйлс байдаг.

Монголчууд бид соёл, соёлын үнэт зүйлс, соёлын яам, соёлын ажилтан, гэхдээ иймэрхүү агуулгаар ойлгосоор өдий хүрлээ. Эдгээр нь соёлын талаархи уламжлалт “хуучирсан” ойлголт юм. Хуучирсан гэхийг огт хэрэггүй гэсэн утгаар бус, цаашид нэмэх баяжуулах ёстой, дутуу дулимаг байна гэсэн санаагаар хэрэглэв. Сүүлийн жилүүдэд соёлтой хүн, соёлгүй хүн гэх үгс сонсогдох болов. Соёлтой ба соёлгүй жүжигчин, бүжигчин, хөгжимчин, зохиолч, эрдэмтэн, сайд гэж байх нь. Ажиглажээ суухад, соёлгүй хүн гэх нь мэргэжлийн ойлголт биш ажээ. Эдгээрийг нягтлаваас, соёлтой хүн нь заавал жүжигчин дуучин хөгжимчин яруу найрагч байх албагүй бөгөөд харин ч оюун сэтгэлгээний талын ойлголт бололтой. Хүмүүс, ялангуяа залуус цаг үеэ дагаад, мэдрээд байгаагийн илрэл нь энэ ажээ.

Соёл болон оюун сэтгэлгээний цаад угт БОЛОВСРОЛ байдаг. Боловсролтой, боловсролгүй хүний ялгаа нь тэдний сэтгэх соёлоор илэрдэг. Тодруулбал,.. сүүлийн жилүүдэд боловсролын диплом гэх хавтсыг хаа нэг газраас ямар нэгэн аргаар олзолдог гаж практик монголд төдийгүй өндөр хөгжилтэй орнуудад дэлгэрээд байна.

(Энэ ОЛЗЛОХ гэдэг үг чанаргүй сургалттай, суралцагчдаа диплом гэх хавтсаар хуурч ... бизнес хийдэг сургуулиудад хамаарна). Иймд боловсролыг, ялангуяа, боловсролын түвшинг дипломоор хэмжиж үнэлэх үед алдаа мадаг ихсэнэ. Үүний улмаас боловсрол, түүний түвшинг үнэлэх өөр шалгуур хэрэгтэй болов. Ийм шалгуур нь СЭТГЭЛГЭЭНИЙ СОЁЛ юм.

- Асуулт: 21 –р зуунд соёлтой хүн гэж хэнийг хэлэх болов?
- Хариулт: Соёлтой хүн гэж юуны өмнө соёлтой сэтгэдэг хүнийг хэлдэг боллоо.

Хоёр. Сэтгэлгээний соёл - тухайн хувь хүн, байгууллагын зүгээс аливаад хандах оюунлаг хандлага (оюунлаг байр суурь), түүний төлөв байдал юм. Тодруулбаас, сэтгэлгээний соёл нь тухайн бүлэг - нийгмийн тухайд нэгнийхээ бодол санааг нөгөө бусад нь бүгдээрээ хүндэтгэн үзэж, түүнийг хөгжөөн дэмждэг байхуйц орчин бүрдэхийг хэлнэ. Хаана сэтгэлгээний соёлын орчин бүрднэв, тэнд хөгжил дэвшил ирдэг нь батлагджээ.

СЭТГЭЛГЭЭНИЙ СОЁЛ –ын зарим эх үндсүүд:

1. ЧАДВАР дангаараа хангалттай биш юм. Тэрхүү чадварыг ашиглах хүсэл, нөхцөл, боломж буюу ОРЧИН бүрэлдсэн байх ёстой. ЧАДВАРЫН ОРЧИН гэе. Хэрвээ чадварыг хэрэглэхгүй юмуу, хэрэглэсэн нэгнийгээ (чадварлаг нэгийгээ) бусад нь өөнтөглөн гадуурхдаг бол тэр хүний тэрхүү чадвар цаашид хөгжихгүй болж, улмаар унтарна. Иймд хаана ч, хэзээ ч, ямар ч нөхцөлд ЧАДВАР –ыг ашиглах хүсэл сонирхлыг буй болгох нь онц чухал юм. Тийм орчинг буй болгох нь сургуулиудын эрхэм зорилго болой.

Анхаарах нь: Одоогоор монголын аль ч шатны сургуулиудад ЧАДВАРЫН ОРЧИН бүрэлдээгүй байна. Монгол улсад дөнгөж ЧАДВАР гэх

ухагдахууныг судлаачдын түвшинд ярьж буй. Ингэхдээ ЧАДАМЖ –ийн бүрэлдэхүүний гурвалын сүүлч нь хэмээн авч үзэх төдийгөөр хязгаарладаг.

Ер нь ЧАДВАР гэхээр монголын нийгэм бүхэлдээ эргэлзэнгүй бөгөөд цаашаа хардаг хандлагатай байдалтай байна. Үүний ард манай нийхмийн, ялангуяа судлаач эрдэмтдийн сэтгэлгээний хоцрогдол байгаа юм. Тэгээд ч, өнгөрсөн жилүүдэд, ялангуяа, 2000 оноос өмнө монголын боловсрол бүхэлдээ ЧАДВАР –ыг үзэн ядаж, үлдэн хөөсөн гашуун түүхтэй. Энэхүү ГАЖ уламжлал одоо ч хадгалагдсан хэвээрээ аж. ХХ зуунд БНМАУ –д ЧАДВАР –ыг бус, ҮЗЭЛ СУРТАЛ –ыг тэргүүн зэрэгт үнэлдэг тогтолцоотой байлаа. Тэр үед ЧАДВАР –тай цөөнх үндсэндээ нэг бол үзэл суртлын золиос, эсвэл хөдөөд цөлөгддөг байсан.

2. Нийгэм, түүний гишүүдийн сэтгэн бодохуйг хөгжүүлж, хоорондох ойлголцлыг гүнзгийрүүлэх нь хүй хамтлагын хамтын мэрийлт, хөгжлийг амжилтад хүргэх гол суурь байдаг. Хувь хүмүүсийн болон хүй хамтлагын хоорондох соёлын олон янз байдал, тэдгээрийн хольцыг хүлээн зөвшөөрч, хамтын оюун ухаанаар хүчээ нэгтгэж, нэг нь нийтийн төлөө, нийт нь нэгийнхээ төлөө зүтгэх эх үндэс нь сэтгэлгээний соёл юм. Тухайн нэг хүний сэтгэлгээ нь нөгөө бусдынхаа сэтгэлгээг ойлгож, улмаар хөгжөөн өдөөхүйц байвал нэн сайн. Ингэснээр нийхэм дотооддоо найралтай болдог.

Шүүн тунгаасан нь : СОЁЛТОЙ МЭТГЭЛЦЬЕ. Улс нийхмийн хөгжил болон элдэв бусад асуудлаар манайхан янз бүрийн санаа оноо хэлж байна. Тэдгээр нь тухайн нэг хүн, хэсэг бүлгийн санаа юм. Одоо тэдгээр САНАЛ САНААЧЛАГА –ыг цааш нь улам лавшруулан хөгжүүлэх ёстой. Үүний тулд соёлтой мэтгэлцэж сурах учиртай. Соёлтой мэтгэлцэх нь анхдагч чухал шинэ санаа оноог элдвээр гуйвуулан мушгихгүй, шүүмжлэн довтолж дайрахгүй байх, уг эх асуудал дээрээ төвлөрч улам лавшруулан хөгжүүлэх технологи. Гэтэл, манай нийхэм даяар тэрхүү чухал санаа оноог ор тас үгүйсгэн дайрдаг болжээ. Дайрч довтолохдоо уг асуудал руу бус, тэр санааг хэлсэн хүнрүү нь хандана. Ингээд хүмүүс хоорондын хэрүүл болдог. Жишээ нь, одоогийн байдлаар манай ШУА –нь ЗӨВЛӨЛТ ЗАГВАР –аа хадгалсаар буй. Гэтэл монгол улсын эдийн засаг 1990 оноос зах зээлийн горимд шилжсэн.

Эдүгээ судалгааны их сургууль байгуулах талаар ихэд чухалчлан ярьж байна. Зах зээлийн эдийн засагтай, ардчилсан хүмүүнлэг иргэний нийхэм байгуулах үндсэн зорилготой улсад яагаад ч ЗӨВЛӨЛТ ЗАГВАР –ын ШУА оршин байх үндэсгүй юм. Зүүн европын орнууд аль 1990 –д онд энэ асуудлаа шийдсэн байна. Зах зээлийн

нөхцөлд ШУА нь их сургуулиудтай сэдэв ТӨСӨЛ булаацалдаж, амь зуудаг төрийн байгууллага байж болдоггүй. Болдоггүй юм гэж байдаг. Монголын ШУА цэвэр эрдэм оюуны байгууллага байх ёстой. Тэрээр улс орныхоо хэмжээнд хамгийн сайн СУРАЛЦДАГ БАЙГУУЛЛАГА, эрдэм оюуны ТЭРГҮҮЛЭГЧ байх юм. Энэ бол олон улсын тогтсон жишиг. ШУА –нь эрдэм оюуны суралцдаг тэргүүлэгч байгууллага болох тэр л нөхцөлд манай эрдэмт судлаачид өөрийн гэсэн өмгөөлөн хамгаалагч - дэмжин туслагчтай болно.

Одоогоор манай эрдэмтэд тухайн ажиллаж буй их сургууль, хүрээлэнгүүдийнхээ хөлсний ажилтан хэвээрээ байна. Ийм байж таарах уу?. Би вээр 2012 онд 129 эрдэмтний хамт ШУА –г зах зээлийн горимд шилжүүлэх тухай УРИАЛГА хэвлүүлсэн. Гэтэл манай ШУА, түүний удирдлага, гишүүд, улмаар УИХ –ын гишүүн академичдын зүгээс зөвхөн над руу хандан, төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан олон удаа бүлэглэн дайрч давшлав. Тэд 130 эрдэмтдийнхээ САНАЛ САНААЧЛАГА –ыг цааш хөгжүүлэхийг огтоос мартжээ. Тэдгээр хэтэрхий МЭРГЭН академич – УИХ –ын гишүүн- жарайхаануудад миний толгойн том хэлбэр, нүдний шил зүүж халзарсан төрх, өмнө нь ШУА –д 15 жил ажилласан атлаа ишиг эврээ ургахаар эхээ мөргөнө гэгчээр ШУА –д нүүрлэсэн увайгүй байдлыг нууж дарахын оронд ил тод хэлэх болсон ... зэрэгт анхаарчээ. Бүр сүүлд нь намайг АНУ, Баруун европын тагнуулч болгох дөхсөн. Академич –докторууд нь ингэж хадууран солиорч байхад эгэл ард соёлтой мэтгэлцэж чадах болов уу?. Дүгнэлт: Соёлтой мэтгэлцэхийн эх үндэс нь СЭТГЭЛГЭЭНИЙ СОЁЛ –д суралцахад оршино.

3. Ангийн БАГШ –ийн сэтгэх соёл. Ангийн БАГШ хичээлээ хэрхэн удирдан зохион байгуулж байгаа нь суралцагсадын Сэтгэлгээний Соёлд шууд нөлөөлдөг. Үүнд сургуулийн кинрикулум их үүрэгтэй. Суралцагсадыгаа хэрхэн сэтгэн бодох, ямар аргаар яаж суралцах, юу г сурах ... тухайд БАГШ онцгой үүрэгтэй. Иймд Сэтгэлгээний Соёлын чухал эх үүсвэр нь БАГШИЙН СЭТГЭХ СОЁЛ юм. Сурагч оюутнуудынхаа сэтгэн бодож байгаа арга барил, төрх байдлыг багш нь мэдэж байвал нэн сайн. Ингэснээр шавь маань ЮУ –г ЯАЖ ойлгож ухаарч байгааг мэдэх төдийгүй сэтгэн бодож буй арга барилыг нь яавал улам ахиулах, засах талаар багш чиг баримжаатай болно. Багш нэгийг хэлдэг, түүнийг нь шавь нь өөрөөр ухаардаг байж таарахгүй. Багш асуух, шалгах, бичгийн ажил хийлгэх, хамтарч бүтээх ... зэргээр шавийнхаа сэтгэн бодож буй арга барил, төрх төлвийг мэдэх боломжтой.

4. Сургалтын гадна байх янз бүрийн эх үүсвэр материалуудыг ашиглах нь САЙН СЭТГЭХ –д

тустай. Зөвхөн өөрөө бодоод - бясалгаад суух төдийгүй бусдын бодол сэтгэлгээг танин барих, өөрийн санал бодлоо бусадтай хуваалцах боломжит бүхий л хэрэгслийг ашиглаж, чөлөөтэй сэтгэх замаар гүн бөгөөд шинээр сэтгэж сурна. Ингэж сэтгэлгээний соёлд суралцана.

5. Анги танхимд оюутан сурагчдын сэтгэлгээний соёл зүгшрэх бол сургууль нь багш нарынхаа сэтгэх соёлыг бүтээдэг. Багш нар суралцагсадынхаа сэтгэн бодох, суралцахад шийдвэрлэх нөлөө үзүүлдэг учраас ХХI зуунд СЭТГЭН БОДДОГ БАГШ –ийн үүрэг нөлөө онцгой чухал боллоо.

6. Сэтгэн бодоход ЦАГ ХУГАЦАА хэрэгтэй,.. тэгэх боломж (цаг) - ийг багшийн зүгээс сурагч оюутандаа зориудаар гаргаж өгөх ёстой. Бодох сэтгэхэд зарцуулсан цаг бол хамгийн ашигтай өнгөрүүлсэн цаг болдог.

7. СУРАЛЦДАГ БАЙГУУЛЛАГА байхын үндсийн үндэс нь СЭТГЭЛГЭЭНИЙ СОЁЛ мөн болно. Иймээс суралцдаг (суралцагч) байгууллага, суралцдаг үндэстэн болохыг зорьж буй ямар ч байгууллага, хамт олон сэтгэх соёлд даруй суралцах ёстой ажээ. Суралцдаг байгууллага болох, болгох нь үг уриа биш, ихээхэн хүчин чармайлт шаардсан ажил үйл юм.

Баримт: Байгууллагын, ялангуяа боловсролын байгууллагуудын тухайд сэтгэлгээний соёл он жилүүдийн явцад төлөвшин тогтдог бололтой. Жишээ нь, миний өөрийн мэдэхээр, мэдэрсэнээр, манай улсын МУИС, МУБИС гэх хоёр сургуулийн сэтгэлгээний соёл нилээд ялгаатай байсан. Түүний цаана багш нарынх нь, улмаар оюутнуудынх нь сэтгэх чадварын ялгаа байдаг болох нь илт мэдрэгдэж байв. Тэр ч бүү хэл, нэг сургуулийн доторхи харьяа салбар сургуулиудынх нь сэтгэлгээний соёл нилээд ялгаатай байсан, энэ нь мэргэжлийн онцлогоос хамааралтай байх шиг санагдсан.

8. Хэрвээ бид хичээл бүр дээр сэтгэн бодохуйн хэрэгцээг шат дараалалтай зөв тодорхойлох аваас сурагч - оюутны ойлгоц гүнзгийрч, суралцах үйл явцдаа илүү төвлөрнө.

9. Суралцахуй бол сэтгэлгээний үр дагавар юм. Сэтгэлгээнээс ангид суралцах аваас цааш алхах боломж бараг байхгүй боллоо. Цаг үе өөрөө өөртөө орон зайгаа гаргаж байгааг монголын боловсрол хүлээн авч, ӨӨРЧЛӨГДӨХ цаг тулгарав.

Анхаарах нь: Сэтгэлгээний соёлтой холбогдуулан А.Эйнштейний Сурагчдаа СЭТГЭН БОДОХУЙ –д сургадаггүй сургууль бол сургууль биш, шорон,.. гэсэн сануулгыг иш татах нь олонтаа таарна. Их сэтгэгчийн энэ үгийг монголын боловсролд хандсан хатуу сануулга хэмээн хүлээн авах ёстой.

Гурав. Сэтгэлгээний соёлын бүрэлдэхүүн:

1. Хэл
2. Цаг хугацаа
3. Хүрээлэх орчин
4. Боломж
5. Дэг журам
6. Ирээдүйчлэл – загварчлал
7. Хүлээлт
8. Харилцан нөлөөлөл

Эдгээр нь хамтарч нэгдэж байж л бүлэг, хамт олон, байгууллага, нийхмийн сэтгэх соёл бүрэлдэнэ.

Тунгаан бодсон нь : Монголд эдүгээ ХЭЛ СОЁЛ гэж ярих төдий байна. ХЭЛ чухал нь чухал, гэхдээ дангаараа бүгдийг шийдэх нь үгүй. Тодруулбал, Ирээдүйчлэл – загварчлал – Хүлээлт гэх бүрэлдэхүүнийг харгалзахгүй бол сэтгэх соёл унтарна. Өөрөөр хэлбэл, сэтгэлгээний соёл нь ИРЭЭДҮЙН УХААН –тай гүн холбогдох ажээ. Иймээс ХҮЛЭЭЛТ нь сэтгэх соёлын нэг чухал бүрэлдэхүүн болдог. Гэтэл манай боловсрол, бүр нийхэм маань бүхэлдээ ИРЭЭДҮЙН УХААН – с айж зугтдаг. Хүмүүс ХҮЛЭЭЛТ гэхийг мэдэх нь үгүй, мэдрэх ч үгүй. Монголын боловсрол ТҮҮХ ярьж, ТҮҮХ заадаг. Бүр тэр энэ намын ТҮҮХ гээд салбарлуулан заадаг. Монгол орон ТҮҮХ –р хооллож, түүндээ сэтгэл ихэд ханажээ. Түүхээ хичнээн их үзлээ гээд ХООЛ болох нь үгүй. Хоол ирээдүйгээс ирэхээс өнгөрсөн түүхээс ирэхгүй. Өнгөрснөөр хооллодоггүй билээ. Ирээдүйгээ БОДОХ аваас ХҮЛЭЭЛТ үүснэ. Хүлээлтдээ таарч тохирсон тийм ажил үйлсийг хүмүүс дэмждэг. Гагцхүү, тэрхүү хүлээлт нь найдвартай, биелэгдэхүйц байвал нэн сайн. Ингээд ирээдүйн ухааныг энэ улсад хөгжүүлэх бодит шаардлага үүсэв. БОДОЦГООНО биз ээ. Маргаашаа бодохгүйгээр сэтгэх нь ТЭНЭГЛЭЛ мөн буюу.

Дүгнэвээс, Монголын нийхмийн толгойг бүхэлд нь нь эргүүлэх (сэтгэлгээний хэвшиж тогтсон уламжлалт загварыг өөрчлөх) их ажил биднийг хүлээж байна. Өнгөрсөн жилүүдэд өрнүүлсэн ажил үйлс төдий л ахицтай бус байгаа нь монгол үндэстний, улмаар монгол ТӨР гэх байгууллагын сэтгэлгээний соёлын хоцрогдлоос шалтгаалжээ. Бидний одоогийн байгаа байдал төрх маань ердөө л бидний бодол сэтгэлгээний үр дүн билээ. Сургуулийнхаа анги танхимд л сурагч оюутнууд сэтгэлгээний соёлд суралцдаг. Иймээс анги танхимыг ХУВИРГАН ӨӨРЧЛӨХ ёстой. Энэ нь монголын боловсролын тэргүүний зорилт байх юм.

Дөрөв: Тэмдэглэх нь: Нэг талаас сурагч - оюутан, нөгөө талаас багш - профессоруудын үүрэг функцыг шинэчлэн өөрчлөх, тэднийг харилцааны шинэ горимд шилжүүлэх зорилт тулгарлаа.

Багш бид сурагч оюутныхаа заяагдмал зан

авирыг өөрчилж чадахгүй байж магад,.. тэгэх нь боломжгүй ч юм билүү, гэхдээ бид тэднийгээ насан туршдаа суралцдаг, сэтгэн боддог арга ухаанд сургаж чадна. Тийм чадварыг эзэмшсэн шавь нар маань XXI зуунд нийгэмшин амьдарч чадна.

Багш бид сурагч – оюутнаа идэвхитэй – санаачлагч бөгөөд асуудлаа онож олдог, түүнийгээ зөв шийддэг, тодруулбал, XXI зууны оюунлаг нийгмийн жинхэнэ гишүүн болгоё гэвэл зайлшгүй дараахь төлөв байдлыг хүлээн авах шаардлагатай. Багш – профессор нь дасгалжуулагч – халамжлан хүмүүжүүлэгч - залуурдагч байх аваас сурагч – оюутан нь ойлголцох урлагтай – шинийг санаачлагч - сониуч- өөрийгөө өөрөө чиглүүлж чаддаг буюу XXI зууны ШИНЭ ИРГЭН болж төлөвшинө.

Сурагч оюутнууд маань ахмадууд, багш нар, үе тэнгийнхэнийхээ зүгээс өөрийг нь таньж мэдсэн, үнэлж хүндэлдэг, тэднийг сэтгэн боддог бөгөөд суралцаж чаддаг гэж үзэх, тэгж хандахыг (тоож үзэх, итгэж дэмжих) хүсэж хүлээдэг ажээ. Ингэх аваас сурагч – оюутнуудын суралцах төлөв байдал, түвшин эрс дээшилнэ. Энэ нь ЭЕРЭГ ХАНДЛАГА юм. Хэрвээ Багш ба сургуулийн зүгээс сурагч – оюутандаа ЭЕРЭГ хандах аваас шавь нар нь тус тусдаа ялгаран хоорондоо хагаралдах нь эрс багасч, тэдний зохицол найрсал нь ихэсч, би энэ нийхэм, хамт олондоо хэрэгтэй хүн гэдгээ мэдэрнэ. Ингэж нийхмийн зохицол, дотоод найрсал бүрэлдэнэ.

Тунгаасан нь: Монголчууд хэрэлдэх зодолдохдоо муугүй, засаг төрөө муулах нь гаргуун, өөртөө хир халдаахгүй атлаа өрөөл рүү дайрахдаа даанч дадмаг болжээ. Нийгэмд үүний буруутнаар АРДЧИЛАЛ, ЭРХ ЧӨЛӨӨ –г цохон нэрлэх хандлага сүүлийн жилүүдэд тогтох аястай боллоо. Нийхмийн найрсал зохицлыг бүрдүүлдэг эрүүл хөрс нь ардчилал –эрх чөлөө байдаг. Энэ хөрсгүйгээр бүрэлдсэн нийхмийн дотоод найрсал нь хэврэг юм. Иймд монголын нийхмийн найрсал алдарч байгаа нь өөр учир шалтгаантай. Манай нийхэм өмнөх цаг үед (1990 –д оноос өмнө) дарангуйлагч НАМ ТӨР –ийн буулган дор байсан болохоор түүндээ таарсан захиргаадалтын найрсалтай байв. Захиргаадах аргаар тогтоосон найрсал нь жинхэнэ эрүүл найрсал биш. Тэрээр ДЭГЛЭМ, тэрээр богино настай. Үүнийг бидний өнгөрсөн түүх нотолдог. Эрүүл жинхэнэ найрсалыг ардчилсан зарчмаар хүний эрх, эрх чөлөөг дээдэлж байж тогтооно.

Ингэхдээ нилээд АЖИЛ хийх хэрэгтэй юм.

Ажлын нэр нь : СЭТГЭЛГЭЭНИЙ СОЁЛ. Энэ ажлыг ЕБС –иас эхлэх учиртай. Улмаар их сургуулиуд манлайлан хэрэгжүүлэх үүрэгтэй. Одоогоор энэ үүргээ манай их сургуулиуд гүйцэтгэж чадахгүй байна. Элсэгчид нь сэтгэлгээний соёлын цагаан толгойд суралцаагүй болохоор аргагүй байх.

Тав :Сэтгэлгээний доод ба дээд түвшин гэж бий. Сэтгэлгээний доод, дунд, дээд түвшин гэж гурав ангилсан ч болно. Тэдгээрийн агуулга үндэслэл нь :

- | | |
|-------------------|--------------------|
| 1. Сэргээн санах, | 4. Задлан шинжлэх, |
| 2. Ойлгох , | 5. Үнэлэх |
| 3. Хэрэглэх , | 6. Бүтээх |

гэсэн сэтгэн бодохуйн 6 эрэмбийг суурь эхлэл болгоно. Тэгвэл сэтгэлгээний 3 түвшин үүснэ. Үүнд: Сэргээн санах, Ойлгох нь ДООД, Хэрэглэх, Задлан шинжлэх нь ДУНД, Үнэлэх, Бүтээх нь ДЭЭД эрэмбэд хамаарна. Манай бүх шатны боловсролын агуулга, үнэлгээ нь одоо хүртэл Сэргээн санах, Ойлгох түвшинд эргэлдэж байна. Багш профессорууд заагаад л, сурагч оюутнууд нь цээжлээд л, хэн сайн цээжилсэн нь боловсролын зэрэг цол ахиад л, ингээд манай боловсрол дуусдаг. Бид бүр үүндээ ДАСАЛ ДАДАЛ болчихжээ. Монголын боловсролын ОНОШ: Монголын боловсрол бүхий л шатандаа ДООД эрэмбийн сэтгэлгээний соёлтой байна.

Төгсгөх нь: Хүмүүс сэтгэх соёлоороо хоорондоо ялгарч байна. Зарим хүн гайхалтай хурц тод, уран гоё сэтгэдэг. Тийм хүнийг эгэл бусад нь гайхан биширч, “мөн ч сайхан сэтгэж байна шүү, ёстой соёлтой хүн юм даа, сэтгэх соёл гэж л энэ байхдаа” хэмээнэ, магтана, тэгээд өөрөө баясана, түүнийгээ үгээр илэрхийлнэ, хүний уураг тархи бусдын уураг тархины хэрхэн ажиллаж байгааг мэдэрч өөрөө дотроо баясдаг байх нь. Тархи тархиа үнэлдэг байх нь. Миний тархи тэр хүний тархитай адил л юм чинь би яагаад ингэж уран гоё сэтгэж болохгүй байх билээ гэсэн хөнгөн атаархал төрнө. Эндээс СЭТГЭЛЭЭНИЙ СОЁЛЫГ ХҮН БҮР ЭЗЭМШИХЭЭР ТЭМҮҮЛДЭГ хэмээх дүгнэлтэд хүрнэ. Үүнийг лавшруулбал, ЕБС –н үндсэн зорилго нь сурагчдыг сэтгэлгээний соёлд сургахад оршино гэсэн мөрдлөгөө гармой. Энэ бол дэлхийд тогтоод буй үндсэн жишиг. (Хүмүүс өмссөн хувцас, унасан морь, машин, суудаг орон байраараа ялгарч байсан тэр цаг ард хоцорч, оюуны чадвар, ялангуяа сэтгэх соёлоороо ялгаран тодрох сайхан цаг ойртсоор ...ТВ –н сувгаар логиктой ганган яриа өрнүүлсэн хүн маргааш нь ОД болж чадна, уулзсан хэн ч бөхөлзөнө, нөгөөдөр нь та монголын ерөнхийлөгч болвол би дэмжинэ шүү гэж бахархалтай өгүүлэх тийм цаг айсуу ... хүмүүс оройжин ТВ –н суваг эргүүлж суугаа нь үүний илрэл бус уу, тэд гайгүй ганц нэвтрүүлэг байж магад гээд л хүлээж хайж байгаа юм.)

Монголын боловсрол өөрийн гэсэн өнгө төрхтэй хөгжлийн ЗАГВАР –тай байх ёстой, түүнд манай боловсролын философийн асуудал суурь нь болох учиртай.

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ. ДОКТОР
Л.МӨНХ-ЭРДЭНЭ

ЛИБЕРАЛ БУЮУ ШИНЖЛЭХ УХААНЫ БОЛОВСРОЛ

МУИС-ийн бүтцийн өөрчлөлт, ШУС, шинжлэх ухааны боловсрол:

МУИС-д 2013–2014 онд хийсэн “бүтцийн” гэж нэрлэгдсэн өөрчлөлт МУИС-ийн сургалт, эрдэм шинжилгээний бүтэц зохион байгуулалт, арга барил, агуулга төдийгүй МУИС-ийн үндсэн зорилго, оюутан болон олон нийтийн өмнө хүлээх үүргийг ч хамарсан. Өөрчлөлтийн гол зорилго нь шинжлэх ухааны мэдлэг бүтээх, түгээх хамгийн ухаалаг, оновчтой бүтэц тогтолцоо, практикийг МУИС-д бүрдүүлэх, төлөвшүүлэх явдал байв. Үүний тулд өнөөгийн тэргүүн туршлага болох АНУ-ын судалгааны шилдэг их сургуулиудын жишгээр МУИС-ийг өөрчлөх алхам хийсэн. Өөрчлөлтийн түлхүүр хэсэг нь МУИС-ийн байгаль, нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбаруудыг нэгтгэн Шинжлэх Ухааны Сургууль (School of Arts and Sciences) болгон зохион байгуулж либерал ухаан (liberal arts) гэж заншсан шинжлэх ухааны өргөн боловсрол олгох бүтцийг бүрдүүлсэн явдал. Энэ нь бүхэлдээ “мэргэжилтэй боловсон хүчин” бэлтгэж ирсэн МУИС-ийн үндсэн зорилгыг төдийгүй түүний цөм хэсгийг шинжлэх ухааны өргөн боловсрол олгохоор болгон өөрчилсөн хэрэг байв.

Өөрчлөлтийг хийх суурь, мөн ноцтой үндэслэл ч байсан. Шинжлэх ухааны дийлэнх салбарыг хамарсан манай оронд байгаа цорын ганц сургууль бол МУИС. Тухайн үеийн МУИС-ийн бүтэц, бүрэлдэхүүнийг АНУ-ын судалгааны их сургуулиудтай харьцуулахад МУИС нь хэрэг дээрээ хууль, бизнес гэсэн мэргэжлийн хоёр сургуультай, шинжлэх ухааны факультеттай (arts and sciences) сургууль болох нь илэрхий байсан. Эдүгээ МУИС-ийн ШУС-ийн байгаль, нийгэм, хүмүүнлэгийн ухаанууд нь үнэндээ мэргэжлийн (professional, vocational) эсвэл практикийн (practical) ухаан биш.

Бүгд шинжлэх ухаан, бүгд либерал ухаан. Гэвч БНМАУ/МУИС шинжлэх ухааны салбар ухаан бүрийг мэргэжилд үзэж, мэргэжилтэй боловсон хүчин бэлдэх зорилгынхоо дагуу салбар ухаанаар оюутан элсүүлж, ихэвчлэн тухай салбарын багш бэлтгэдэг байсан сургалтын практик, уламжлал нь МУИС-ийг шинжлэх ухааны салбар ухаанаар багш бэлтгэдэг сургууль, энэ утгаараа мэргэжлийн сургууль мэт болгосон байсан. Тиймээс МУИС-ийг АНУ-ын судалгааны шилдэг их сургуулиудын жишгээр өөрчлөнө гэдэг нь салбар ухааны мэргэжилтэн/багш бэлтгэх чиг баримжаатай сургуулийг шинжлэх ухааны өргөн боловсрол олгох орчин үеийн судалгааны их сургуулийн жишиг, хэлбэрт оруулан зохион байгуулах явдал байсан.

Өөрчлөлтийг хийх ноцтой шаардлага ч байсан. Монголын эцэг, эхчүүдийн хүүхэддээ дээд боловсрол, мэргэжил эзэмшүүлэх, Монголын залуучуудын сурах хүсэл эрмэлзлэл, тэдний МУИС-д даатгасан итгэл найдварыг МУИС өөрийн оршин тогтнох хэрэгсэл болгосон байв. Оюутны төлбөрөөр өөрөө өөрийгөө санхүүжүүлэх “зах зээлийн” гэх журамд шилжснээр МУИС нь Монголын олон нийтэд гэхээсээ илүү өөрөө өөртөө үйлчлэх байгууллага болон хувирсан. Мөн МУИС өөрөө өөрийгөө санхүүжүүлэх нэгжүүдэд задарч, үндсэндээ бие даасан, хоорондоо “зах зээлийн” тооцоотой 15 сургууль, 80 гаран тэнхимд хуваагдсан байсан. Мэргэжлийн хөтөлбөрт оюутан элсүүлэх, хөтөлбөр тус бүрд 30 хүртэл оюутан элсүүлэх квот тогтоосон журам нь үндсэндээ МУИС-ийг санхүүжүүлэх журам байсан төдийгүй тэр нь өөрөө өөрийгөө санхүүжүүлэх нэгж, ба түүний хэмжээг ч тогтоосон хэрэг болсон. Зургаан багш (1,5 доктор) нэг тэнхим-хөтөлбөр МУИС-ийн дундач хэмжээ болсон байв. Квот нь МУИС-ийг олон тооны,

түүний дотор орой, эчнээ гэх мэт, хөтөлбөр зохиоход ч хүргэсэн. Хөтөлбөрийн үндсэн зорилго нь МУИС-ийг санхүүжүүлэх явдал. МУИС-ийн багш нарын ажиглалтаар МУИС үндсэндээ сургалтын дамжаа шиг болж хувирсан байв.

Угаас мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэдэг байсан МУИС нь “зах зээлийн” нөхцөл байдалд ийнхүү улам бүр явцуурсан. БНМАУ-ын үед нэгэнт сургалт үнэ төлбөргүй, оюутнууд хангалттай стипендтэй (тэтгэлэг) суралцдаг төдийгүй ажлын байр баталгаатай байсан тул уг системийг ойлгож болно. Гэтэл “зах зээлийн” үед улам бүр явцуу жижиг тэнхим, сургуулиудад хуваагдсан төдийгүй улам бүр явцуу ижил төстэй хөтөлбөр, улам бүр явцуу мэргэжил, мэргэшил “борлуулах” болсон байв. Олон тооны хөтөлбөрүүд өөр хоорондоо зарчмын ялгаагүйн дээр, хэтэрхий явцуу учир оюутнуудын хөгжил, боловсролд ч, хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад ч тохирохгүй нь илэрхий байсан. Дээрээс нь бакалавр, магистр, докторын шаталсан сургалт нэвтрүүлснээр “мэргэжлийн” бакалаврын 4 жилийн явцуу “хонгил”, улам бүр нарийсах, явцуурах 5 хүртэл жилээр сунгагдсан. 4 жилийн нарийн мэргэжлийн хөтөлбөрийн дараа магистрын 2 жилийн, докторын 3 жилийн хөтөлбөр “зохиох”, хэрэгжүүлэх нь аливаа тэнхимд, түүний дотор 6 багштай, 1-2 доктортой тэнхимд төвөгтэй сорилт болох нь илэрхий. Үндсэндээ МУИС оршин тогтнохын тулд Монголын залуу үед элдэв хөтөлбөр борлуулдаг болсон гэсэн үг. Оюутан залуучуудын тусын тулд үүнийг өөрчлөх шаардлагатай байсан.

Гэхдээ МУИС энэ байдлаараа явцуу хөтөлбөр борлуулсаар байх боломжтой байсан. Явах хүсэлтэй нь ч дийлэнх олонх нь ч байсан. Нөгөө талаар асуудлыг мэддэг хүмүүст нь даатгасан учир эцэг эхчүүд ч, оюутнууд ч асуудал тавиагүй. Асуудалд санаа зовнисон нь МУИС-ийн зарим багш нар. Харин МУИС-ийн удирдлагын авилгал, МУИС-ийн задрал, доройтол Багш нарын холбоо, Реформ баг зэрэг МУИС-ийн багш нарын бүлгүүдийн гомдол, тэмцлийн гол асуудал болж байсан. Эцсийн эцэст багш нарын эдгээр бүлгүүдийн тэмцэл амжилт олж, тэд МУИС-ийн эрх мэдлийг авснаар 2013–2014 оны өөрчлөлтөнд хүргэсэн.

Бүтцийн хувьд байгаль, нийгэм, хүмүүнлэгийн салбаруудыг нэгтгэж Шинжлэх Ухааны Сургууль (School/Faculty of Arts and Sciences), Хуулийн, Бизнесийн сургууль гэсэн мэргэжлийн сургуулиудыг (professional schools) байгуулсан. Мөн МУИС-д байсан чадавх болон ирээдүйн боломжийн үүднээс Хэрэглээний шинжлэх ухаан инженерийн сургуулийг (School of Applied Sciences and Engineering) байгуулсан бол эсэргүүцэл тэмцэл болон элсэлтийн байдлыг харгалзан Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийг эмхлэн

байгуулсан.

Агуулга, зорилгын хувьд “мэргэжлийн” хэмээх нарийн явцуу хөтөлбөрийн элсэлт, сургалтыг халж ШУС-д элсүүлэх, ШУС-ийн хэмжээнд либерал буюу шинжлэх ухааны өргөн боловсролыг 2 жилийн шинжлэх ухааны ерөнхий суурь (general curriculum or liberal arts core curriculum) болон үлдсэн 2 жилийн мэйжор (үндсэн “мэргэшил”) болон майнорын (туслах “мэргэшил”) хамт санал болгохоор төлөвлөсөн. ШУС-д элссэн оюутан шинжлэх ухааны ерөнхий суурийн хөтөлбөрт санал болгосон хичээлүүдээс өөрийн сонирхлын дагуу сонгон суралцаж, шинжлэх ухааны өргөн боловсрол эзэмшихийн хамт өөрийн сонирхол, авьяас, чадварын дагуу аль нэг мэйжор болон майнорыг сонгон цаашид гүнзгийрүүлэн суралцах боломжтой болох байсан. Мөн энэ нь аливаа оюутанд өөрийн биеэр “номыг нь үзэж”, “нүд тайлж”, өөрийн дур сонирхол, авьяас билиг, чадварын үндсэн дээр “өөрийн бодлоор” сонголт хийх боломж олгох. Мэдээж энэ нь ямар нэгэн явцуу хөтөлбөрт харанхуйгаар элсэж, бусдын мэдэлд хувь заяагаа даатгахаас тэс өөр хэрэг. Өөрөө унасан хүүхэд уйлдаггүй гэдэг. Харин унах эсэхээ өөрөө урьдчилан мэдэх нь ухаалаг хэрэг бол унах эсэхээ урьдчилан мэдэх боломж олгох нь хүнлэг хэрэг. Шинжлэх ухааны ёс, либераль ёс.

Гэвч МУИС-ийн мэргэжилтэн бэлтгэх уламжлал, тэнхимүүд хөтөлбөргүй, багш нар ажилгүй болох айдас хоёр давамгайлж, шинжлэх ухааны ерөнхий суурийн хөтөлбөрийг 1 жил болгон танасан төдийгүй, байгаль, нийгэм, хүмүүнлэгийн гэсэн 3 салбараар элсэлтийг зохион байгуулсан. Энэ нь хэрэг дээрээ либерал буюу шинжлэх ухааны өргөн боловсролыг нэрийн төдий болгож, оюутны сонголтыг хязгаарласан хэрэг. Улмаар 2023 оны хавар Боловсролын яам хөтөлбөрт элсэлт авах журам тогтоосон нь либерал ухааны боловсролыг үндсэнд нь цуцалсан хэрэг болсон. Өнөөдөр МУИС өөрийгөө либерал ухааны боловсрол олгож буй мэтээр ойлгодог, сурталчилдаг нь дор хаяж төөрөгдөл.

Либерал боловсрол ба шинжлэх ухаан

Эрх чөлөөт эрхмийн эзэмшсэн байх ёстой “урлаг”, “соёл”, ухаан, ур чадварыг либерал урлаг, ухаан, ур чадвар (artes liberales) гэдэг байсан бөгөөд тэр нь өөрөө боловсрол байв. Сэтгэхүй, хэл ярианы дүрэм, логик, реторик гэсэн суурь гурвал (trivium), арифметик, геометр, хөгжим, астрономи гэсэн дараагийн төвшний дөрвөлөөс (quadrivium) бүрддэг долоон чөлөөт урлаг/ухаан (septem artes liberales, sieben freien Künste, seven liberal arts) нь эртний Грекээс эхтэй бөгөөд дундад зууны их сургуулиудын суурь хөтөлбөр болдог байж. Оюун санааг гэгээрүүлж, тэлж, чөлөөлж, хүнийг эрх

чөлөөтэй болгодог сэтгэхүйн (thinking, speculative), онолын (theoretical) мэдлэг, ухаан, урлагыг либерал ухаан/урлаг гэж үзэж эхнээсээ биеийн хүчний хөдөлмөр, түүнд холбоотой мэдлэг, ур чадвар (manual, practical) болон түүнийг эрхэлдэг этгээдэд (боол, зарц) хамаарах зүйл бус гэж үздэг байж. Үндсэндээ долоон чөлөөт ухаан урлаг нь аливаа хүнийг боловсруулах, чөлөөлөх эрх чөлөөт хүн болгох урлаг, ухаан байж. Тиймээс ч анагаах ухаан, хууль эрх зүй, теологи зэрэг чөлөөт, боловсролт хүн байхын тулд эзэмших шаардлагагүй тусгай мэргэшил, хэрэглээ, ажил, үйлчилгээний ухаануудаас ч ялгагдаг байж. Улмаар шинжлэх ухаан үүссэнээр байгаль, нийгэм, хүмүүнлэгийн ухаануудаар тэлсэн байна. Цэвэр танин мэдэхүй, мэдлэг бүтээхүйд чиглэгдсэн байгаль, нийгэм, хүмүүнлэгийн ухаануудыг либерал ухаанд тооцдог бөгөөд эдгээр ухаанд суралцах, боловсрох хэргийг либерал ухааны боловсрол (liberal arts education), эсвэл либерал боловсрол (liberal education), ерөнхий боловсрол (general education) зэргээр нэрлэх болсон.

Тухайлбал, 1970 оноос эхлээд Багшлахуйг хөгжүүлэх Карнегийн сан (The Carnegie Foundation for the Advancement of Teaching) судалгаагаар нарийвчлах зорилгоор дээд боловсролын салбаруудыг ангилж болсон бөгөөд уг ангиллаар хэл, утга зохиол, бичиг үсэг, биологийн буюу амьдралын ухаанууд (life sciences), математик, физикийн (астрономи, физик, хими, геологи, цаг уур) ухаанууд (physical sciences), сэтгэл судлал, нийгмийн ухаанууд, дүрслэх болон жүжиглэх урлаг, бүс нутаг болон угсаатны судлал, олон болон салбар дамнасан судалгаа, гүн ухаан, шашин судлал зэрэг нь либерал ухаанд ордог (Ferrall: 2011: 9).

Харин эдгээр ухааны аль нэгийг судалснаар либерал боловсролтой болохгүй. Учир нь либерал ухааны боловсрол, түүний зорилго нь шинжлэх ухааны өргөн мэдлэг, боловсролтой, тиймээс аливаад шинжлэх ухааны байр суурь, сэтгэлгээний үүднээс ханддаг, тиймээс шинжлэх ухаанч ухамсартай, тиймээс ч эрх чөлөөтэй хүн, иргэн төлөвшүүлэх явдал. Энэ зорилго нь байгаль, нийгэм, хүмүүнлэгийн ухаануудыг аль болох өргөн хүрээтэйгээр судлахыг шаарддаг. Тиймээс либерал боловсрол олгож буй сургуулиудад эдгээр ухааны

тэнхимүүд ихэвчлэн урлаг, шинжлэх ухааны (arts and sciences) гэж нэрлэгддэг нэг факультетэд зохион байгуулагдсан байдаг бөгөөд 4 хүртлэх жилийн бакалаврын төвшний либерал боловсрол санал болгох бөгөөд бүх тэнхимүүд хамтран шинжлэх ухааны ерөнхий суурийн 2 жилийн хөтөлбөр санал болгодог. Харин энэхүү хоёр жилийн либерал ухааны хөтөлбөрийг дүүргэсний дараа оюутан өөрийн сонирхсон ухаанаар мэйжор болон майнорыг сонгон судалдаг. Ингэснээр оюутан шинжлэх ухааны өргөн боловсролтой, тиймээс шинжлэх ухаанч буюу чөлөөт сэтгэлгээтэй, тиймээс гэгээрсэн, чөлөөлөгдсөн буюу либерал нэгэн болж төлөвших.

Мөн аль нэг салбарын ухааныг гүнзгийрүүлэн судалснаар тухайн салбарын мэргэжилтэй болж байгаа хэрэг огт биш. Харин хүний сонирхол, чадвар бүхнийг хамрах боломжгүйн дээр эрдэм шинжилгээ, шинэ мэдлэг бүтээхүй нь өөрөө судлах асуудлыг зайлшгүй нарийсгах, анхаарлыг төвлөрүүлэхэд хүргэдэгт оршино. Нөгөө талаар их сургуулийн сургалтын хөтөлбөрийг шинжлэх ухааны салбар ухааны (discipline) тэнхимүүд бүрдүүлэх бөгөөд тэдний хувьд салбар ухаанаа хөгжүүлэх, түүний тулд шинэ авьяас билгийг элсүүлэх нь чухал. Чухам ийм учраас аль нэг ухааныг мэйжор болгон гүнзгийрүүлэн судлах болдог. Нэгэнт тухайн салбар ухаан нь шинжлэх ухааны салбар ухаан л бол аливаа оюутан ингэж гүнзгийрүүлэн судалснаар, эсвэл өмнө нь болон эдүгээ МУИС-д байгаа шиг нэг салбар ухааны хөтөлбөрт элсэн суралцаад, улмаар түүгээр докторын зэрэг хамгаалсан ч тухайн этгээд мэргэжил эзэмшиж байгаа хэрэг биш. Харин эрдмийн зэрэгтэй (academic degree) судлаач л болж байгаа хэрэг. Учир нь шинжлэх ухаан нь мэргэжлийн ухаан биш. Мэргэжил эзэмшихийн тулд дээр дурдсан мэргэжлийн ухаанд суралцах хэрэгтэй. Тиймээс оюутныг эхнээс нь нэг тодорхой хөтөлбөрт элсүүлэн сургах практик нь хэрэг дээрээ явцуу, өрөөсгөл, солгой боловсрол л олгож, явцуу, өрөөсгөл, солгой нэгнийг л бэлдэж байгаа хэрэг. Боловсролын энэ практикийн сөрөг үр дагавар нь МУИС төгсөгчдөд төдийгүй, МУИС-ийн багш нар, шинжлэх ухааны зүтгэлтнүүдийн хувьд ч түгээмэл ажиглагддаг.

The liberal arts were defined to comprise the following categories from the CIP: English language and literature/letters; foreign languages and literatures; biological sciences/life sciences; mathematics; philosophy and religion; physical sciences; psychology; social sciences and history; visual and performing arts; area, ethnic, and cultural studies; liberal arts and sciences, general studies, and humanities; and multi/interdisciplinary studies (The Carnegie Classification of Institutions of Higher Education 2001: 3). Хөдөө аж ахуй, эрүүл мэндийн үйлчилгээ (allied health), бизнес, менежмент, коммуникаци, байгаль хамгаалал, байгалийн нөөц ашиглалт (conservation and natural resources), боловсрол (education), инженерчлэл, эрүүл мэндийн ухаанууд (health sciences), аж ахуй, хууль, хууль зүйн судалгаа (law and legal studies), номын сан, архивын ухаан, маркетинг, нийлүүлэлт, цэргийн ухаан (military sciences), хамгаалах үйлчилгээ (protective services) нийтийн удирдлага, үйлчилгээ (public administration and services), болон теологи (theology) зэрэг ажил үйлчилгээ, техник, практик шинжтэй (occupational, technical, practical) ухаануудыг мэргэжлийн (professional/vocational) ухаанд ангилдаг (Ferrall: 2011: 9; see also The Carnegie Classification of Institutions of Higher Education 2001: 2)

Шинжлэх ухааныг мэргэжил, шинжлэх ухаанд суралцахыг мэргэжил эзэмших үйл явц гэж ойлгодог эрхэмүүд либерал боловсрол, ерөнхий суурийн хөтөлбөр нь тэдний шинжлэх ухаан-мэргэжлийг устгалаа гэж буруушаадаг. Энэ буруушаалт, гомдол нь ч хөтөлбөрт элсүүлэх журмын үндэслэл болсон нь мэдээж. Гэвч энэ нь хэрэг дээрээ хөтөлбөртөө элсэлтгүй болж, улмаар ажилгүй болно гэсэн айдасын л үр. Чухам тийм учир жил бүр хөтөлбөрт нь 30 хүртэл оюутан элсүүлэх журам нь тэдний эрх ашигт үйлчилж байгаа юм. Өөрөөр хэлбэл жил бүр 30 хүртэлх хүүхдийн ирээдүйг золиослож байгаа хэрэг. Харин жил бүр гуч гучин хүүхдэд философч, физикч, математикч, биологч, антропологч, археологч, шашин судлаач гэх мэт сахилыг дарж байж хүртээнээр эдгээр ухаанууд хөгжихгүй. Сахил хүртсэн хүүхдүүд ч мэргэжилтэн болохгүй. Тэдний дийлэнх нь филисофич, математикч, физикч болж буюу философи, математик, физикийн ухааны шинэ мэдлэг бүтээж амьдрахгүй. Тийм боломж ч үгүй. Харин тэд боловсролоо солидоггүй л юм бол мэргэжил гэж ойлгосон явцуу, өрөөсгөл, солгой боловсролтойгоо л амьдралыг бэдрэх болно. Хэрвээ тэд өргөн боловсрол эзэмшсэн бол сонгох сонголт, хөрвөх боломж өндөртэйн дээр, өөрөө өөрийгөө удирддаг либерал ардчилсан нийгмийн үнэтэй иргэн, идэвхтэй гишүүн болох байсан.


Гэхдээ хөтөлбөртөө элсэлтгүй болж, улмаар ажилгүй болно гэдэг айдас нь өргүй зүйл бас биш. Харин түүнийг салбарын шинжлэх ухааны усталт

гэх нь өрөөсгөл ойлголт. Аливаа шинжлэх ухаан хэн нэгнийг дарж сахил хүртээнээр бус харин тухайн ухаанд сонирхолтой, авьяас билигтэй нь зүтгэснээр орших, урагшлах. Мэйжор, болон магистр, докторын шаталсан хөтөлбөр нь сонирхолтой, авьяас билигтэй нэгэнд аль нэгэн салбар ухааныг эзэмшихэд хангалттай урт хугацаа. Хэрвээ элсэлтгүй бол энэ нь тухайн тэнхмийн бүрэлдэхүүн, санал болгосон хөтөлбөрт асуудал байгаа хэрэг.

Аливаа шинжлэх ухааны утга учир шинэ мэдлэг, ялангуяа тухайн салбар ухааны өмнө тулгарсан зангилаа асуудлуудаар шинэ мэдлэг бүтээх явдал. Шинэ мэдлэг, ялангуяа шинэ зам мөр гаргасан нээлт хийсэн мэдлэг бүтээж байгаа эрдэмтэд шавьгүй байх нь ховор. Судалгааны их сургуулийн тэнхим хөтөлбөртөө элсэлтгүй болсон нөхцөлд түүний орон тоо нь шинэ мэдлэг бүтээх үйлс болон ерөнхий суурийн боловсролын хөтөлбөрт тухайн тэнхимийн оруулж буй хувь нэмрээр тогтоогдох учиртай. Энэ нь аливаа тэнхим үргэлж шилдэг эрдэмтдийг элсүүлэхийн төлөө байх ёстой гэсэн үг. Харин сургуулийн хувьд хөтөлбөрөө, тэнхимүүдээ өрсөлдөх чадвартай байлгахын тулд шаардлагатай санхүүжилтийг элсэлтгүй ч байсан хуваарилах ёстой гэсэн үг. Чухам эл учир 2013-2014 оны МУИС-ийн бүтцийн өөрчлөлтийг хийсэн боловч харамсалтай нь тодорхой шалтгааны улмаас өөрчлөлт эхний шагандаа царцсан төдийгүй гажуудсан болно.

Эшилсэн утга зохиол

- Victor E. Ferral Jr. 2011. Liberal Arts at the Brink. Cambridge, MA.: Harvard University Press.
2001. The Carnegie Classification of Institutions of Higher Education: A Technical Report. 2000 Edition. Menlo Park, CA.: Carnegie Publications, The Carnegie Foundation for the Advancement of Teaching.



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
Д.ОРГИЛБОЛД

ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ЭРИН ДАХЬ БОЛОВСРОЛ

Боловсрол ямар философтой байх ёстой тал дээр олон тайлбар гаргаж болно. Гэвч 1917 онд тухайн үеийн аль улсаас илүү дэвшилтэд бөгөөд гүнзгий философийн суурьтай эхэлсэн коммунист хувьсгал эцэст нь 1991 онд төгсгөл болсон шиг философи суурь сайн байлаа гээд энэ нь заавал тухайн үзэл нь ялгуулсан байх албагүй.

Үүний адил 1392 онд байгуулагдсан Солонгосын Чусон улс төрийн албаны шалгалтаа 3 хэсэгт хуваажээ.¹ Эхний бичгийн эрдмийн шалгалт нь Күнзийн сургаалаар авч дээд албаны түшмэлд томилдог. Дараагийн зэвсгийн эрдмийн шалгалт нь нум сум харвах, морь унах зэргээр авч цэргийн жанжинд томилдог. Харин үлдсэн элдэв эрдмийн шалгалт нь одон орон, анагаах ухаан, гадаад хэл зэргээр авч харгалзах албанд нь томилдог байсан юм. Мэдээж эдгээр дундаас хамгийн алдартай нь бичгийн эрдмийн шалгалт байсан учир тухайн үеийн язгууртнууд ганц энэ шалгалтад тэнцэж дээд албаны түшмэл болох гэж амьдралаа зориулдаг байсан түүхтэй. Харин өнөө үед Солонгосын залуу үе ажилд орохыг хүсэхгүй бол хүмүүнлэгийн ухааны төрлийн ангид орж амьдралаа үргэж хэлэх хэмжээнд хүртлээ нэгэн цагийн нийгмийн гол цөм байсан хүмүүнлэгийн ухаан тэр дундаа Күнзийн сургаал өөрийн хүчээ алджээ.² Тиймээс боловсролыг ямар нэгэн философи сууриас илүү нийгмийн хэрэгцээ бөгөөд хүний амьдрахад зориулсан зүйл гэж үзээд тодорхойлох юм бол энэ нь илүү олон нийгэм дээр чөлөөтэй шилжин боловсролыг чиглүүлж чадна.

Нэг. Боловсролын тодорхойлолт

Тэгвэл нийгэм гэдэг бүтцийн үүднээс дээд боловсролыг авч үзэх юм бол энэ нь тухайн нийгэмд амьдарч буй хүн тэр нийгэмдээ амьдрахад хэрэгтэй мэдлэгийг заадаг, мөн туршлага суулгадаг

үйл явц гэж тодорхойлж болно. Энд үйл явц гэж тодорхойлсон нь боловсролыг заавал ямар нэг барилга эсвэл орчинд авах шаардлагагүй харин ч боловсролыг олгох боломжтой бүх газар авч болно гэдгийг илэрхийлж байгаа юм. Мөн эндээс дараах хэд хэдэн дүгнэлтийг гаргаж болно

1. Боловсрол бол нийгэмд амьдрахад нь хэрэгтэй мэдлэгийг олгож байгаа учир энэ нь хүн өөрийн нийгэмдээ хүндэтгэхүйтэй (dignity) байхын тулд үндсэн хэрэгцээ нь болно гэсэн үг. Тиймээс ерөнхий боловсролыг зөвхөн улсаас олгоод зогсохгүй үүнд хэрэгтэй бүх дэд бүтцийг гаргаж өгөх хэрэгтэй. Энэ нь улс өөрийн иргэнээ хүн ёсоор амьдруулах үүргээ хүлээж байгаагийн нэг хэлбэр юм.³

2. Тухайн хүний өөрийнх нь амьдарч байгаа нийгэмд зориулах учир боловсрол ямар нэгэн өөрчлөгдөшгүй зүйл биш харин ч нийгмийн өөрчлөлтөд тааруулж ямагт шинэчлэгдэж байх ёстой. Хэдэн зуун жилийн өмнө Монголд мал маллах нь хамгийн чухал байж үүнийг ахуйн хүрээнд зааж байсан бол өнөө үед хүн амын 10 хувьд л энэ мэдлэгийн зарим хэсэг нь хэрэгтэй. Харин оронд нь өнөөгийн нийгэмд цахим хэрэглүүр хэрхэн ашиглахыг сургах нь илүү чухал юм.

3. Боловсрол нь тухайн хүний өөрийн амьдарч байгаа нийгэм буюу өөрийнх нь хамтран амьдрах хүмүүстэй нийлэмжтэй болгож өгөх хэрэгтэй. Энэ нь нийгмийг тогтоон барих эх үндэс болно. Монгол ухаанд суурилсан боловсрол гэж хүмүүс ярьдаг нь үнэн хэрэг дээрээ энэ юм.

4. Монгол улсад амьдрах гэж байгаа хүмүүсийг хамтын нэг нийлэмжтэй болгож үүгээрээ нийгмээ тогтоон барих нь боловсролын нэг үүрэг мөн.

5. Эхний дүгнэлттэй холбоотойгоор хэрвээ

нийгэмд шинэчлэл ирж байгаа бол боловсрол нь хамгийн түрүүлж шинэчлэгч болон нийгэм шинэчлэлийг хор хөнөөл багатай хүлээн авах бэлтгэлийг боловсролоор дамжуулан хангана.

Боловсролыг ийн тодорхойлох ёстой шалтгаан нь Хятад, Солонгос, Японд 19-р зууны эхээр Күнзийн сургаалыг үйлдвэрлэл дээр суурилсан өрнөдийн эрдэм нураасан шиг энэ цаг үед дэлхий дахинд өрнөдийн их сургуулиас үүсэлтэй орчин үеийн боловсрол дахин өөрчлөлтийн өмнө нүүр тулаад байгаа юм.

Хоёр. Хиймэл оюун ухааны эрин

Хиймэл оюун ухааны эрин үе эхлэх нь нэгэнт тодорхой болсон. Үүнийг ухаалаг утасны эрин үед хоцрогдож Apple, Google гэх мэт өрсөлдөгчийнхөө ард ороод байсан Microsoft 2023 онд хиймэл оюун ухааны салбарт ихээхэн хөрөнгө оруулалт хийснийхээ дараа энэ оны эхээр эргэн өрсөлдөгч нараа гүйцсэнээс харж болно⁵. Гэхдээ энэ хиймэл оюун ухаан нь хүчтэй хиймэл оюун ухаан буюу хүний хийж чадах бүхнийг хийж чадаж, хүн шиг сэтгэдэг төрөл байх уу эсвэл сул хиймэл оюун ухаан буюу тодорхой нэг салбарт л хүнээс илүү байж хүн шиг сэтгэж чаддаггүй төрөл байх уу гэдэг хараахан тодорхой бус байна. Мэдээж энэ нь хиймэл оюун ухааны хөгжилд бид бэлдэх хэрэггүй гэсэн үг биш. Бэлдэхдээ аль хэмжээнд бэлдэх нь л тодорхойгүй гэсэн үг юм. Тэгвэл эхлээд баталгаатай нэгэнт гарч ирэхээр болсон сул хиймэл оюун ухаанд зориулж нийгмээ бэлдэх нь чухал болж байна.

Оюутнууд хиймэл оюун ухаан ашиглаад өөрсдийн дипломоо бичих нь асуудал болж байна гэж байгаа ч үнэн хэрэг дээрээ асуудалд орж байгаа нь оюутнууд өөрсдөө юм. Учир нь хиймэл оюун ухаанаар бичүүлчих зүйлийг тэдэнд мөнгө төлж бичүүлэх хүн ирээдүйд олдохгүй. Ямар хүн байсан хамаагүй илүү хямдаар хийх замыг сонгох болохоос илүү мөнгө төлж илүү зарлага гаргахыг хүсэхгүй нь тодорхой⁶. Яг одоо энэ байдал энэ байдал Америкийн Нэгдсэн Улсад үүсэж технологийн компаниуд түүхэндээ байгаагүй хэмжээнд хувьцаагаа өсгөж байгаа ч нөгөө талд ирээдүйн зах зээлд хэрэггүй гэж тооцсон өөрсдийн ажилтнуудаа цомхотгосоор байна⁷. Нэгэн цагт Монголд бас ихэнх ард нь мал хариулж байгаад өнөө үед энэ тоо 3050004 болсон ч малын тоо толгой түүхэн дээд хэмжээндээ очсон шиг мэдээлэл технологийн салбар мөн цаашдаа тасралтгүй өсөх боловч өнөө үе шиг мэргэжлийн чиглэл тэр чигтээ хадгалагдана гэх боломжгүй. Үйлдвэрлэлтэй хамт үйлдвэрлэлийн олон мэргэжил шинээр үүссэн шиг хиймэл оюун ухаантай хамт үүнтэй холбоотой мэргэжил шинээр үүснэ⁸.

Гурав. Гадаадын бэлтгэл

Гадаадын томоохон их сургуулиуд энэ

өөрчлөлтөд зориулж аль хэдийн хиймэл оюун ухааны талаар суралцах хүсэлтэй оюутнуудад зориулсан хичээл, түүнчлэн мэргэжлийн хөтөлбөрийг хүртэл өөрсдийн үндсэн хөтөлбөртөө оруулжээ. Энэ нь хиймэл оюун ухааны салбар зөвхөн мөнгөтэй хөрөнгө оруулагчдын сонирхлоор дуусахгүй мэргэжлийнхэн хүртэл ирээдүйн нийгмийн салшгүй нэгэн хэсэг гэж үзэж байгааг харуулна. Жишээлбэл Солонгосын Сөүлийн Их Сургуулийн хиймэл оюун ухааны нэгдсэн мэргэжил гэхэд компьютерийн инженерийн ангийн үндсэн хичээл, статистикийн ангийн магадлал болон дата судлалын хичээл, бусад инженер болон байгалийн ухааны сургуулийн дата боловсруулах хичээл үүн дээр нэмээд өөрсдийн тусдаа хиймэл оюун ухааны төсөл, хиймэл оюун ухааны хэрэглээ гэх хичээлийг нэмж оруулжээ⁹. Одоогоор зөвхөн хиймэл оюун ухааныг хариуцсан харьяа сургууль байхгүй байгаа учир байгаа харьяа сургуулиудаасаа хамаарал бүхий хичээлийг цуглуулж байгаад энэ мэргэжлийг бүтээж үүнийгээ онцлогоор нь нэгдсэн мэргэжил гэж нэрлэжээ. Харин Америкийн Нэгдсэн Улсын Станфордын Их Сургууль 1985 оноос анх энэ төрлийн мэргэжлээ нээж одоо тусдаа Хүмүүнлэг Шинжлэх Ухааны Сургууль нээн тархи судлал, хиймэл оюун ухааны салбарыг төвлөрүүлсэн¹⁰ бол Массачуссетсын Технологийн Институт өөрийн Компьютерын Сургуулийн харьяа болгож 2022 оноос эхлэн хиймэл оюун ухаан шийдвэр гаргалт хэмээх мэргэжлийг бий болгожээ¹¹.

Дөрөв. Бэлдэх ёстой шалтгаан

Шинэ үйлдвэрлэлийн эрин ирэх үед энэ үйлдвэрлэлд өөрсдийгөө бэлдээгүй аль нэг улс үүний золиос болдог. 20-р зууны эхэн үед нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнээрээ эхний 10 дотор ордог байсан Аргентин улс өнөө үед 60-р байр хүртэл ухарчээ¹². Үүнийг олон хүчин зүйл нөлөөлсөн хэмээн тайлбарладаг ч эдгээрийн дундаас чухал нэг нь 19-р зууны эхэн үед хөдөө аж ахуй дээр суурилж байсан эдийн засаг нийгмийн бүтцээ үйлдвэржилтэд зориулж огт засаагүй нь улс төрийн тогтворгүй байдал төрийн буруу бодлоготой нийлж 100 жилийн уналтыг авчирсан юм¹³. Энэ уналттай адилаар шинэ үйлдвэрлэлийн эрин эхлэх гэж байхад бид өөрсдийн хуучин үйлдвэрлэл дээрээ гацаад байж байх юм бол энэ нь биднийг одоо байгаа байрлалд хэвээр нь байлгах биш хойш ухруулах юм. Улаан хатан хааны эффект хэмээдэг өөрчлөлтөд тааруулж ямагт хувьсаж байх ёстой гэсэн энэ зарчмаар бид өөрсдийн эдийн засгийн ирээдүйгээ одоогоос эхлэн түргэн бэлдэх хэрэгтэй.

Тав. Бэлтгэл

Эдгээрээс харах юм бол хиймэл оюун ухааны эрин үед дараах бэлтгэл бидэнд хэрэгтэй болно.

5.1 Монгол хэлэнд зориулсан хиймэл оюун ухааны хөгжүүлэлт. Монгол хэл дээрх мэдээллийн тоо хэт бага байна¹⁴. Үүнээс болж англи хэлний хэрэглээ тасралтгүй өсөж хуучин цагт орос хэл монгол хэлэнд нөлөөлсөн хэмжээнд англи хэл монгол хэлэнд нөлөөлөх болжээ. Энэ хомсдол өнөө үед шинэ асуудал үүсгэж байгаа нь харилцан ярилцах боломж бүхий хиймэл оюун ухаан аль хэдийн 2011 онд гарсан ч монгол хэл дээр одоо болтол гараагүй байна. Хэрэв энэ чигтээ хоёр талт харилцааны хиймэл оюун ухаан өдөр тутмын амьдралд гүн нэвтрэх юм бол эдгээрийг ашиглахын тулд англи хэлийг мөн өдөр тутам ашиглахаас өөр аргагүй болно. Энэ нь монгол хэлний хэрэглээг бууруулж цаашдаа монгол хэлийг устах аюулд хүргэж болзошгүй учир эх хэлээ хамгаалахын төлөө ирээдүйн энэ бүх хувьсгалын шимийг монгол хэл дээр бас хүртэж чаддаг болгох нь зөвхөн боловсролоор дуусахгүй төрийн хэмжээний том даалгавар мөн.

5.2 Хиймэл оюун ухаанд зориулсан ёс зүйн зохицуулалт, боловсролын зарчим гаргах

Европын холбооноос итгэхүйц хиймэл оюун ухаанд зориулсан гарын авлага дээрээ дараах 3 зарчмыг гаргажээ¹⁵

1. Хуулийн дагуу байх
2. Ёс зүйтэй байх
3. Эрүүл байх

Харин ЮНЕСКО 2019 онд хиймэл оюун ухааныг боловсролд ашиглах тухай гарын авлага гаргасан бол Солонгосын боловсролын яам 2023 онд өөрийн улсын үндсэн хууль, боловсролын хууль зэрэг холбогдох хууль дээр үндэслэн “боловсролын салбар дахь хиймэл оюун ухааны ёс зүйн зарчим” гэж гаргажээ¹⁶. ЮНЕСКО-гийн гарын авлага нь эхлээд хиймэл оюун ухааны боловсролын салбар дахь хэрэглээнд зориулсан зохицуулалтын зөвлөмжийг дараах байдлаар гаргажээ. Эдгээр зөвлөмжийг Монгол улсын нөхцөл байдалд тааруулан тайлбарлах юм бол:

1. Боловсролын салбар дахь хиймэл оюун ухаан нь бүх хүнд хүртээмжтэй байх ёстой. Энэ зарчим нь ялангуяа манай улсын хувьд маш чухал зарчим юм. Учир нь Улаанбаатар хотын хувийн сургуульд сурч байгаа сурагч болон хөдөөгийн сумын төвд байх сургуулийн сурагч хоёрын хооронд асар том чадварын ялгаа гарсан байдаг. Хэрвээ боловсролын салбарт хиймэл оюун ухаан нэвтэрч эхлэх юм бол боломжтой сурагч эсвэл оюутан үүнийг ашиглан өөрийгөө огцом хөгжүүлж энэ ялгаа насан туршид нь багасгаж болохгүй хэмжээнд очих боломжтой учир үүнээс урьдчилан сэргийлж бүх сурагч, оюутан өөрийн нас хүйс гарал үүслээс үл хамааран хиймэл оюун ухааны боловсролыг эзэмшиж чаддаг байх хэрэгтэй.

2. Хүнийг өөрийг нь хөгжүүлэх. Хиймэл оюун ухаан бидэнд том боломж авчирч байгаа ч нөгөө талаас үүнд тааруулж хүнийг хөгжүүлэхээ мартаж болохгүй.

3. Хиймэл оюун ухааны системийг хянах. Хиймэл оюун ухаан нэг талаас боломж авчрах боловч нөгөө талд гамшиг авчирч чадах технологи гэдгийг ойлгох хэрэгтэй. Жишээлбэл үүгээр хийсэн чанар муутай мэдээлэл цахим орчинд аль хэдийн дүүрч эхлээд байна. Тиймээс үүний зөв хэрэглээг хянах нь чухал.

4. Сурагчид хэрхэн ашиглах тухай сургах. Манай улсын суурь боловсролын сургалтын хөтөлбөрт орсон мэдээлэл зүйн хичээлийн хувьд кодчиллын тухай сэдэв байхгүй зөвхөн алгоритм л дурдагдсан байна.¹⁷ Үүгээр зогсохгүй сурах бичиг дээр кодчиллын жишээ болгож одоо нэгэнт өргөн хэрэглэгдэхээ больсон BASIC хэлийг оруулжээ. Гэтэл Өмнөд Солонгос улс 2025 оноос эхэлж бага сургуулиас эхлэн кодчиллол заахаар болсон байна. Мөн үүгээр зогсохгүй мэдээллийн хичээлийн цагийг 2 дахин нэмэхээр болжээ¹⁸. Үүний хажууд манай улс одоог хүртэл анх компьютер хэрэглээнд нэвтэрч байсан үеийн мэдээллийн сэдэвтэй агуулгаа хадгалсан хэвээр байна.

5. Багш нар хэрхэн заах тухай сургах. ЮНЕСКО -гийн 2023 онд шинэчлэгдсэн тайлан дээрээс харах юм бол 2023 оны байдлаар дэлхий даяар 7 улс л (Хятад, Финланд, Гүрж, Катар, Испани, Тайланд, Турк) багш нарт зориулж хиймэл оюун ухааныг хэрхэн заах тухай бэлтгэж эхэлжээ¹⁶. Харин манай улсад хиймэл оюун ухаан бүү хэл сургалтад цахим хэрэглүүр хэрхэн ашиглах тухай сургалт ч чанартай хэмжээнд орохгүй байгааг би өөрийн биеэр хөдөө орон нутагт хийсэн сургалтынхаа үеэр ажигласан юм. Тиймээс хиймэл оюун ухааныг боловсролын салбарт нэвтрүүлнэ гэвэл багш нарт зориулсан сурагчдынхаас тусдаа сургалт бас хэрэгтэй.

6. Одоогийн хиймэл оюун ухаан нь өөрийн цуглуулсан мэдээлэл дундаас олонхын мэдээлэл дээр үндэслэн өөрийн гаргах үр дүнгээ боловсруулдаг. Гэтэл энэ нь нөгөө талаас цөөнхийн дуу хоолой хумигдах аюулыг агуулж байдаг.

7. Одоогийн хиймэл оюун ухаан нь цахим орчин дахь мэдээллийн ихэнх хувь бүрддэг бөмбөрцгийн умард хагаст байх өндөр хөгжсөн улсуудаас өөрийн мэдээллээ авдаг учир энэ нь эдгээр мэдээллийн санд мэдээллээ нөлөөтэй болгож чаддаггүй улсын хувьд өмнө дурдсан цөөнхийн дуу хоолой хумигдах асуудал үүснэ гэсэн үг. Гэхдээ үүнийг тусдаа авч үзэж байгаагийн учир нь хөгжиж буй орнуудын санал, ялангуяа энд бүхэл бүтэн улс орон, түүний соёлын мэдээлэл алдагдах явдал юм. Энэ нь цахим орчинд монгол дээрх мэдээлэл хомс байдаг манай улсад ч гэсэн хамааралтай асуудал

учир үүнийг бид чухалчлан авч үзэх хэрэгтэй.

8. Олон салбар хамтран ажиллах. Энэ нь зөвхөн боловсролын салбар биш үнэндээ бүх салбарын хамтран шийдэх асуудал юм. Учир нь хөдөө орон нутагт хиймэл оюун ухааны сургалтыг хэвийн явуулна гэвэл хөдөөгийн сургуулийг сервертэй нь интернэтээр холбох хэрэгтэй болно. Мөн үүгээр дуусахгүй бүх сурагч оюутанд зориулан хиймэл оюун ухааныг өөрийн сургалтдаа чөлөөтэй ашиглаж болох хэрэглүүрээр хангах нь чухал. Үүнийг зөвхөн боловсролын байгууллага ганцаар шийдэж чадахгүй учир олон салбарын хамтын ажиллагаа хэрэгтэй.

Үүнээс цааш үргэлжлүүлээд боловсрол, судалгааны орчинд хиймэл оюун ухаан ашиглах зааварыг танилцуулжээ. Гэхдээ энэ заавар нь илүү хэрэглээ талдаа учир хэрэглээ нэвтрээгүй манай улсад тийм ч чухал биш юм.

Зургаа. Дүгнэлт

Тэгвэл эндээс дараах эцсийн дүгнэлтийг гаргаж байна.

1. Боловсролын салбар нь тухайн нийгэмд зориулсан хүнээ бэлтгэдэг учир Монгол улсын нийгэмд зориулсан монгол хүнийг монгол соёлд тааруулан бэлдэх нь чухал ч үүнээс чухал нь нийгмийн өөрчлөлтөд тааруулж тохирсон боловсролыг олгох нь мөн чухал.

2. Одоо дэлхий даяар хиймэл оюун ухааны эрин ирж цахим эриний дараагаар дахин нэг өөрчлөлт гарах нь тодорхой болсон учир боловсролын салбар үүнд зориулж өөрийгөө бэлдэх хэрэгтэй.

3. Энэ өөрчлөлт нь одоогоор зөвхөн өндөр хөгжсөн цөөн хэдэн улсын хүрээнд явагдаж байгаа болохоор эдгээр улсын хэт нөлөөнд уусахаас сэргийлэхийн тулд монгол хэлийг дэмждэг хиймэл оюун ухаан гаргах нь чухал.

4. Их сургуулийн сургалтын хөтөлбөр нь энэ салбарын мэргэжлийг агуулах хэрэгтэй бол үүнд нь тааруулж суурь боловсролын хөтөлбөрт цахим технологийн хичээл илүү түлхүү орох шаардлагатай.

REFERENCES

- [1] <과거>, Encyclopedia of Korean Culture
- [2] 정진호. (2022). 인문녀·인문남·교육녀 순으로 취업 어렵다 The JoongAng. <https://www.joongang.co.kr/article/25106289>
- [3] 서미경. (2021). AI□대, 인간의 정체성과 존엄성 교육의 방향. 기독교교육 논총, (67), 157-194, 10.17968/jcek.2021.67.005
- [4] Үндэсний Статистикийн Хороо, МАЛЧДЫН ТОО (2022) Статистикийн мэдээллийн нэгдсэн сан
- [5] Randewich, Noel. (2024) Investors see Microsoft's stock market value leaving Apple behind. Reuters
- [6] Cerullo, Megan. (2024) MONEYWATCH How the AI revolution is different: It threatens white-collar workers CBS news
- [7] Capoot, Ashley (2024). TECH Tech layoffs balloon in January as Wall Street rally lifts Alphabet, Meta, Microsoft to records. CNBC
- [8] Gudliko, Alex. (2023). 20 New And Enhanced Roles AI Could Create. Forbes
- [9] <https://imai.snu.ac.kr>
- [10] <https://symsys.stanford.edu/>
- [11] <https://www.eecs.mit.edu/academics/undergraduate-programs/curriculum/6-4artificial-intelligence-and-decision-making/>
- [12] Ocampo, Emilio. (2014). Commodity Price Booms and Populist Cycles.
- [13] (2014). The Tragedy Of Argentina: A Century Of Decline. The Economist
- [14] Grefenstette, G., Nioche, J. (2000). Estimation of English and non-English language use on the WWW. arXiv preprint cs/0006032.
- [15] (2019). Ethics guidelines for trustworthy AI. European Commission
- [16] (2023). Guidance for generative AI in education and research. UNESCO
- [17] (2019). Бага боловсролын сургалтын хөтөлбөр. БСШУСЯ
- [18] 박성민.(2022.)초등-중학교'코딩교육' 2025년부터필수과목으로. The Dongah

БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИЙН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭЛ



ДОКТОР, Ph.D
Э.ЭНХПҮРЭВ

БОЛОВСРОЛЫГ ЭРГЭН ХАРАХ НЬ

Сурах гэдэг үнэндээ хүний амьдралын гасралтгүй үйл явцын нэг. Олонх хүн хэрхэн сурдгийг ажиглахад, сурах юмаа заасан үг хэллэгийг олж, сонсоод, дараа нь цаад юмны тухай мэдлэгийг тогтоох зам руу орж байна. Энэ нь мэдээжээр сургалтын тогтолцоонд ийм загвар ноёрхож байгаатай ихээхэн холбоотой. Гэтэл, үүний дунд нэг чухал үйл явц орхигдчихоод байх шиг. Тэр юу гэвэл, уг юмаа нэрлэсэн үг хэллэг, нэр томъёог ухаж ойлгох явдал юм. Магадгүй, алгасаж хараад байгаа энэхүү үе шат манай боловсролын тогтолцооны үр дүн санасан хэмжээнд хүрэхгүй явж буйн томоохон шалтгаан. Өөрөөр хэлбэл, энэ санаа маань сурах дадлыг олгож байгаа боловсролын тогтолцоо, ялангуяа ерөнхий боловсролын сургалтын чиг хандлагыг шинэчлэхтэй шууд хамаарна гэж хэлж болно.

Тодруулахын тулд, хамгийн ойрын бөгөөд энгийн жишээ татъя.

Манай салбарын гол нэр томъёо бол “боловсрол”. Магадгүй, өнөөгийн хүний санаанд боловсрол гэдэг үгийг сонсмогц шат шатны сургуулийн барилга, багш, ном, төрөл бүрийн мэргэжил буух болов уу. Хэрэв, монгол хүн боловсрол гэдгийг хэрхэн ойлгож, яаж нэрлэсэн бэ гэдэг бас л сонирхууштай зүйл юм. Энэ үгийн язгуур нь “бол-” хэмээх үйл үг бөгөөд ямарваа нэгэн юм, үйл зохистой хэмжээнд хүрэх гэсэн ерөнхий утгатай. Жишээ нь, хоол хийе гэхэд, түүнд орох найрлага, орцыг идэхэд тохиромжтой байдалд хүрээд ирэхээр хоол болчихлоо гэж хэлдэг. Өөрөөр хэлбэл, түүхий гэдгийн эсрэг ойлголт юм. Үүнийг дэмжих, бас нэгэн баримт гэвэл, монгол бичгийн хэлэнд “бие түүхий, бие болсон” гэдэг хоёр хэллэг бий. Хэрэв хүн цагаан бурхан өвчин тусаад эдгэрсэн бол түүнийг “бие болсон” гэнэ. Учир нь, уг хүн тэр

өвчнийг эсэргүүцэх дархлаатай болсон, түүний бие махбод зохих ёсонд бэлэн болжээ. Харин цагаан бурхан тусаагүй бол бие махбодын нэгэн дархлаа дутуу учир “бие түүхий” гэнэ.

Ийм утгыг нь онцлон үзвэл, монгол хүний хувьд, боловсрол гэдэг “бол”- гэдэг язгуураас гаралтай, цаашлаад боловсон гэсэн үг бүтэж, нийгэмд аж төрөхөд шаардагдах жишиг хэм, зан суртахууныг заасан утга агуулна. Дараа нь үйл үг бүтээх “-р” дагавар залгаснаар, боловсон болох гэдэг үйлийг зааж, эцэст нь “боловсрол” гэдэг нэр үг бий болжээ. Тэгэхлээр, боловсрол гэдгийн язгуур утга учир бол аливаа хүн өөрийн гэсэн оршихуйгаа бүтээхийн тулд шаардлагатай мэдлэг, чадвар, дадал эзэмшихүйг хэлнэ.

Өгүүлсэн зүйлээс, бид юуг ойлгож болох вэ? Боловсрох үйл явцын дунд, шинжлэх ухааны онолын нэр томъёо хийгээд судалж байгаа зүйлийг холбож өгдөг эх хэлний мэдлэг, мэдрэмж дутаж байна. Үүнтэй холбоотойгоор, дараагийн асуулт урган гарч ирнэ. Энэ дутагдал хэр том бэ? буюу асуудлыг өөрөөр дэвшүүлбэл, эх хэлээрээ ойлгох чадвар хэр чухал вэ? Хариуг дараах хэдэн зүйлээр багцалж болно.

Үүнд:

- Сурч байгаа хичээлтэй нь хамаатай үгийг юу гэж ойлгож байгааг нь асуугаад, эргээд хэлнийх нь үүднээс хамтдаа тайлбарлаж өгснөөр, хүүхэд магадгүй урьд нь тухайлан бодож байгаагүйгээ анзаарч, сонирхол төрнө. Яагаад гэдгийг өөрийнхөө оюун бодлоор хайснаар, сэтгэхүй нь хөгжинө. Дээрх жишээгээ эргэн саная. Хэрвээ хүүхдэд “Чи боловсролтой хүн бол. Чи сайн сурах хэрэгтэй” гэж хэлэхийн оронд, “Түүхий хоол шиг түүхий хүн болмоор байна уу? Амттай, болгож чанасан сайхан хоол шиг болсон хүн болмоор байна уу?”

гэж асуугаад, боловсрол гэдгийн утгыг цааш нь тайлбарлаад өгвөл, яаж хүлээж авах бол? Үүнийг л бодох болжээ.

Математикийн хичээл дээр, тэгшитгэл гэдэг сэдвийн нэр тавиад, томъёо загвар үзүүлснээс, тэгшитгэл гэдэг тэнцүүгийн тэмдгийн хоёр талын зүйлийг тэгш байх боломжтой болгоно гэсэн утгатай. Юм тэгш байснаар ямар ач холбогдолтой гэх мэтээр өргөжүүлэн өрнүүлбэл, тэр ухааныг нь олох сэдлийг хүүхэд өөрөө боловсруулах бүрэн чадвартай.

Эндээс ямар дүгнэлт гарах вэ гэхлээр, уг юмыг нэрлэсэн утгаар дөрөөлөн хичээлийг сонирхолтой, учрыг эрэлхийлэх монгол сэтгэхүйг хөгжүүлэх чухал боломжтой.

- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын мэдлэг ямар байгаа талаарх судалгаа бидэнд үүнийг дахин сануулж байна. 2012 оны 10-р сарын 22-нд 10-р ангийн 2000 хүүхдийн дунд авсан математикийн хичээлийн стандартын хэрэгжилтийн шалгалт авахад 100 хувь байхаас дундаж үнэлгээ 19,1 хувьтай гарчээ. Сурагчдын хамгийн их алдсан зүйл өгүүлбэртэй бодлого байна. Энэ юуг харуулж байна гэхлээр, сурагчид эх хэлээрээ байгаа бичвэрийн утгыг бүрэн зөв ойлгож чадахгүй байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл, математик, монгол хэл хоёр тэс өөр зүйл гэж харсан алдаа. Математик үзэх хүнд хэл хэрэггүй, хэл үзэх хүнд математик хэрэггүй гэсэн андуурал.

- Газарзүйн хичээл гэхэд, монголын уул хайрхад, гол мөрнүүд уртраг өргөргийн ямар огтлолцолд оршдогийг олохынхоо өмнө хэн ямар уул нуруу мэдэх, түүний нэр нь яагаад ийм байдгийн учрыг мэдэх нь шууд л үе уламжилсан домог үлгэрээс хариуг олно. Өөрөөр хэлбэл, уран зохиол, монгол хэлний хичээлийн сэдэвтэй холбоотой. Тэр газарт ямар түүхэн үйл явдал болсон нь түүхийн хичээлд хамаатай. Энэ бүгдийн учир начрыг өгүүлэх мэдлэг нь монгол түмний хамгийн олон жил хэрэглэж ирсэн монгол бичгээр бичигдэж үлдсэн гэдэг дээр тулгуурлаж болно. Үндсэндээ, монголчуудын түүх, соёлын өвийн цогц мэдлэг.

Ийм уялдааг оруулж өгснөөр, нэгд, хүүхдийн сонирхлыг татаж болно, хоёрт, сэтгэхүйг хөгжүүлж болно, гуравт, тус тусдаа янз бүрийн хичээлүүдийг салангид ойлгосноосоо үүдэн сурахаасаа халшрах явдлаас сэргийлж болно. Сурагч үзэж байгаа хичээлүүдээ дарамт биш, намайг хүн болгож байгаа миний туслагчид юм байна гэж сэтгэлдээ ойр төсөөлнө. Эцэстээ, сурагч сурах сэтгэлтэй болсон байхад, өөрөө өөртөө эзэн болж чадна гэдэг дээр онцгойлбол илүү үр дүнтэй байх юм.

“Боловсрол”-ыг ингэж илүү ончтой тогтоовол, боловсролын байгууллагуудын уламжлалт гэж хэлж болох, түгээмэл давтагддаг загвараас зайлсхийх

хэрэгтэй болно. Энэ шийдлийг “сургалтын арга барил (технологи), жишиг (стандарт), удирдлага (менежмент)” гэдэг хоёр гол зүйл дээр авч үзэж болно.

1. Сургалтын арга барил (технологи)

Энэ нь багш гэдэг хүн сургууль гэдэг газар ирээд, самбарын өмнө зогсож, сурах бичигт бичсэн зүйлийг хүүхдэд цээжлүүлснээрээ сургалаа, хөгжүүлээ гэж үздэгээ болих нь зүйтэй. Оронд нь, багш сурагчийн мэдлэг бүтээх явцад тусалж, дэмжихийг гол үүргээ гэж ойлгож, ажилладаг сэтгэлгээтэй больё. Сургууль бол тэр үйл явцын орчныг бүрдүүлдэг газар байа. Харин мэдлэг бүтээгч гол эзэн нь сурагч байа. Товчхондоо “хичээл”-ийг “хичээл” гэж ойлгоё. Хэрэв монгол хэлний утгыг бодвол, ангид багштай ном үздэг үйл явцаар тогтчихсон тэр дүр зургаас тэс өөр өнгө харагдана. “Хичээл” гэдэг үйл язгуурт нэр үг бүтээх “л” дагавар залгасан бүтцийг задлахаар, хичээл гэдэг бол чармайж, зүтгэдэг үйл юм гэсэн утга тодорно. Тэгэхлээр, хичээл дээр хичээх ёстой хүн нь хэн байх вэ? Энэ л зарчим юм.

Боловсролын ийм шинэчлэлийн чиг хандлагыг идээшүүлж суулгахын тулд ямар арга хэмжээ хэрэгжүүлбэл одоогийн түвшнээс ахиулах боломжтой байх вэ?

Хүүхдэд үзэх шинэ сэдвийг багш, ном хоёр шууд хэлж өгдөг арга барил буруу байна. Учир нь, хүүхэд тэр сэдэвтэй хамаатай ажлыг өөрөө шийдэхээр оролдох эрхийг нь олгож өгөх хэрэгтэй. Хүүхэд зөв хариуг барагтаа л шууд олохгүй. Багш тухай бүрт буруу гэдгийг нь хэлж өгөөд буцааснаар, хүүхэд биеэ дааж асуудлаа дэвшүүлж сурна. Түүнд байж болох олон арга замыг өөрөө эрэлхийлнэ. Ингэсний эцэст, зуун алдааны дараа нэг зөв гарцыг олж сурах хэвшилтэй болно. Харьцуулахад, харамсалтай нь багшаас, номоос эхлээд өгсөн ганц зөв хариуг “зажлалгүй залгаснаар”, түүний үзүүрт мянган алдаа нь хүлээж байдаг. Тийм болохоор, ингэж бэлэнчилсэн хэвшлээс өөрийн сураагүй буруугаа багшийн буруу гэж бусдад хариуцлагыг тохих сэтгэлгээг аяндаа бий болох аюултай. Харин өөрийн оролдлогоор зөвж олсон зүйлдээ дотно хандана, өөрийнхөө хүчинд урамших итгэлтэй болно. Нөгөө талаас, багш, сурагчийн аль аль нь алдаж байгаагаа муу гэж ойлгохын оронд, сурах үйл явцын завсрын байдал, сурахад тохиолдож болох үзэгдэл гэж хүлээж авах нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл, хичээл гэдгийг жинхэнэ утгаар нь амьдрал дээр хэрэгжүүлнэ гэсэн үг. Хүүхэд сурах явцдаа хүмүүжнэ. Үүнээс улбаалан гарах залгамж холбоо бол “хүмүүжил-сургалт” хоёрын салшгүй холбоо юм. Хүмүүжил бол ердөө сахилга бат биш. “Хүмүүн” гэдэгт үйл үг бүтээдэг “ж” дагавар

бүтсэн үндсэнд цөм утга агуулагдаж буй. “ж” гэдэг дагавар тухайн зүйлийн шинж давамгайлах утгатай болгодог. Жишээлбэл, цөлжих гэвэл цөлийн шинж ихдэх гэсэн утгатай. Ийм жишгээр бодоход, хүмүүжих гэдэг бол хүн байхын эрхэм шинжийг биедээ шингээх гэсэн л үг, хүмүүжүүлнэ гэдэг, хүн шиг хүн болгоно л гэж буй. Иймээс хүн, эрдмээр хүмүүждэг. Хүмүүжил- Сургалт хоёр нэг зүйл.

Анагаах ухааны салбар хүний биеийн эрүүл байдлыг тэтгэх, өвдөж хямарсныг нь эмчилдэг бол боловсролын салбар хүний оюун ухааныг тэжээж, засаж өгдгөөрөө адил. Арга барилын хувьд ч ижил байвал зохилтой юм. Эмч хүнээ оношилж байж эм бичдэг шиг, багш хүүхдээ таньж байж түвшинд нь тааруулах ёстой. Багшийг хэлмэгц ойлгох, хожуу ойлгох гэхчлэн хүүхдийн хүлээж авах түвшин янз бүр. Тэгвэл, үүний жорыг тааруулах, зохицуулах арга нь “бүгдэд хүрэх сургалт”. Үүнийг хүүхэд нэг бүрийн сурах үйл ажиллагааг дэмжиж хөгжүүлнэ гэж ойлгоно. Уг аргаар, хичээлийн жилийн эхэнд сургалтын хөтөлбөрт багш хүүхэд нэг бүрээ таньж, нас бие, сэтгэхүйн онцлогийг тодорхойлоход зориулсан хугацаа олгох хэрэгтэй. Энэ явцад багш хүүхэд тус бүрийн унших, бичих, сонсох, ярих чадамжийг тодорхойлсон баримтыг бий болгоно. Үүний дараагаар, хүүхэд бүрт тохирсон сургалтын хөтөлбөр боловсруулна. Уг хүрээнд, багш тухайн хүүхэд хичээлийн нэг цагт ямар хэмжээний шинэ мэдлэг хүлээн авч чадах боломжтой байна, түүнд нь тохирсон хэмжээгээр оноож өгнө. Жишээ нь, математикийн хичээлээр сэтгэн бодох чадвар, үйлдэл хийх хурд, мэдлэгийн түвшнээс шалтгаалан өдөрт бодох бодлогын тоог тогтоож өгнө. Хэрэв, сэтгэх чадварын хурд сайтай бол өдөрт 25 бодлого, дундаж бол 15 бодлого өгөх; физик, химийн хичээл гэхэд тухайн салбарынх нь 5 үг (нэр томьёо)-г ухаж ойлгох гэх мэт. Ийм жорыг нь багш зөвлөж өгөхөөр, сурагч түүний дагуу сургалтын аливаа хэрэглэгдэхүүн болон сурах бичгийг бие даан өөрөө уншиж, ойлгож судална.

Яаж бие дааж сурах вэ гэхлээр, монгол хэлний болон монгол бичгийн хичээлтэй холбох буюу шинжлэх ухааных нь үг ойлголтыг ухаж ойлгох зорилгоор эрэл хайгуул хийх арга барилыг ашиглах хэрэгтэй юм. Унших гэдэгт, зөвхөн уран зохиол, түүх хэлний хичээл бус, тоо, физикийн хичээл ч зүй ёсоор багтана. Ийм өргөн утгаар авч үзвэл, сурах ёстой мэдлэгийг илэрхийлсэн тэмдэгтүүдийг (байгалийн ухааны хичээл бол тоо, томьёо, нийгмийн ухааны хичээл бол үсгээр илэрхийлсэн үг хэллэг нь тэмдэгт болно) унших нь эхний шат болно. Уншихдаа агуулгыг ойлгож таньж, түүнийхээ үндсэн дээр өөрийн гэсэн бодлоо гаргаж эргэцүүлэн тооцоолж, дүгнэлт хийнэ. Эцэст нь өөрийн хариугаа гаргана. Ингэж бүтээсэн

мэдлэг, чадварын хослолоо ахин дахин хийж дасна. Үүний үндсэн дээр хүүхэд тухайн сэдэв дээр “би болчихлоо” гэж хэлж чадах хэмжээнд хүрнэ. Энэ зорилгоос, ерөнхий боловсролын бага, дунд, ахлах ангийн түвшинд мэдлэг, чадвар, дадлыг хэрхэн томьёолж, бие даан сурах арга барилыг эзэмшүүлэх вэ гэдэг ялгамжааг тогтоох шаардлагатай болж ирнэ. Тэр үндсэн ялгамжаа нь:

- Бага ангид “мэдлэгт суурилсан чадвар” хөгжүүлэе.
- Дунд ангид “чадварт суурилсан мэдлэг” олгоё.
- Ахлах ангид “мэдлэг, чадвар хоёрт тулгуурласан дадал” хэвшүүлэе.

Жишээ нь:

Бага ангид, хүүхэд амьдрал дээр өөрсдөө таньчихсан, мэдэрчихсэн байдаг бэлэн мэдлэг дээр түшиглэе. Жишээ нь, тооны хичээл гэхэд гараараа тоолж, биеэрээ мэдрэх сампин хэрэглэж болно. Тэгэхлээр, хүүхэд хэд хүртэл тоолж чаддаг, түүнийхээ хооронд нэмж хасаж чаддаг байхад нь эхлээд тусална гэсэн үг. Монгол хэлний хичээл гэхэд алимыг бараг бүх хүүхэд бариад хэлбэр дүрсийг, идээд амтыг нь, үнэрлээд үнэрийг нь, удахаараа мууддагийг нь бүх л мэдрэхүйгээрээ таньчихсан байдаг. Үүн дээр нь, тулгуурлаад, үлгэрт алим гарлаа гэхэд бид үлгэрийн номын завсар алимыг хавчуулья гэж саная. Адаглаад номтой харьцуулахад, алим ахархан хугацаанд муудаад хадгалж ч болохгүй. Тийм боломж байдаггүй учраас бид, алим гэдгийг ингэж бичнэ гээд, цааш нь олон үсгээс тэр үгийг нь таниулах зэргээр үргэлжилж болно.

Дунд ангид юу хийж чаддаг, түүнийх нь зарчим, онолын үндсийн тухай мэдлэгийг заах аргаа сайжруулбал зүйтэй. Нэгэнт ерөнхий боловсролын сургуульд суурь шинжлэх ухааны үндсийг үздэг, гүн нарийн онол руу ордоггүй болохоор шинжлэх ухааны үг хэллэгээр нь дөрөөлсөн ерөнхий мэдлэг болгоход чиглэвэл илүү оновчтой, өгөөжтэй болох төлөв бий гэж үзэж байна.

2. Сургалтын жишиг (стандарт)

Сурах хийгээд сургах арга барилын өөрчлөлттэй холбоотойгоор сургалтын жишгийн асуудал гарч ирнэ. Сургалтын жишиг гэдэг энгийнээр, сурч мэдсэн байвал зохих наад захын хэмжээ юм. Одоо манай мөрдөж буй жишиг хичээл тус бүрээр гаргасан байдаг. Үүнийг илүү боловсронгуй болгохын тулд, түүнчлэн дээрх арга барилтай холбохын тулд, энэ жишгийг агуулгаар нь бус, эзэмших чадвараар нь нэгтгэмээр байна. Ингэж үзвэл, дунд болон ахлах ангид орж байгаа 18-22 хичээлийг нийгмийн ухааны ба байгалийн ухааны салбараар нь цогц авч үзэх жишиг хэрэгцээтэй болно. Эдгээрийг холбох эд эс нь хэлний хичээл

байна. Дашрамд дурдахад, эх хэлний, цаашлаад янз бүрийн гадаад хэл мэддэг байх нь гол зорилго бус. Түүгээр дамжуулан ердөө бусад хичээл, бусад шинжлэх ухаанд орох үүд хаалга юм.

Хичээлийн жишгийг чадвараар нь уялдаатай тогтоохын тулд, өмнө өгүүлсэн жишээгээр, газарзүйн хичээл дээр уул усны байрлалыг тогтоохтой хамаарах сэдвийг заах үед монгол хэлний хичээл дээр түүний нэр усыг зөв бичих, түүнтэй холбоотой хэлц хэллэгийг заах, уран зохиолын хичээл дээр холбогдох домгийг уншиж судлах, түүхийн хичээл дээр тэр газар орон ямар түүхэн хүн, үйл явдалтай холбоотой болохыг мэдэх, зургийн хичээл дээр мөн түүнээ дүрслэн зурах, дуу хөгжмийн хичээл дээр уул усны тухай дуу сурах, хөгжмийн нотыг үзэж байхуйцаар өөр зуур нь холбож болох сэжмүүдийг зангидаж өгвөл мэдлэг, чадварын түвшин ахих юм. Ингэхдээ, гадаадын сурах бичгийн орчуулга, хуулбарыг бүтээх бус, түүнээс үлгэрлээд монгол ахуй амьдралаас улбаалсан, цаг үедээ нийцсэн эхтэй байх хэрэгтэй. Жишээ нь, математикийн хичээлийн өгүүлбэртэй бодлого гэхэд, А, Б хоёр хотын хооронд тэдэн км зайтай гэхийн оронд Улаанбаатар, Дархан хоёрын хооронд хэдэн км зайтай байдгаар сэдэвлэн зохиож, давхар танин мэдэхүйг тэлэх явдлыг онцгой анхаарууштай.

Сургалтын жишгийг биелүүлэх хугацааг тогтоож өгдөг. Энэ жишиг бол байж болох дундаж буюу үнэндээ доод үзүүлэлт юм. Тэгвэл, хүүхэд бүрийн хөгжлийн чадамж өөр. Бидний дээр ерөнхийлөн зураглаж буй хүүхэд бүрт хөгжих, хичээх эрхийг гарт нь атгуулах шинэчлэлийн гаргалгаа улмаар хэрэв хүүхэд жишгийг харьцангуй богино хугацаанд жишгээс давсан үнэлгээтэйгээр биелүүлэх боломжтой байвал яах вэ гэдэг асуудлыг дагуулна. Тэгвэл бид, үнэхээр чадаж байвал ерөнхий боловсролын сургалтын цаг хугацааны хүчин зүйлийг уян хатан байдлыг дэмжүүштэй гэж үзэж байна. Энэ нь зөвхөн хувь хүүхдээр зогсохгүй, гэр бүл, багш, улс оронд ихээхэн ашигтай байх боломжтой. Тухайлбал, хувь хүүхдийн сурч мэдэх тэмүүллийг тэтгэх, өөртөө итгэх итгэлийг гэжээх ач холбогдолтой. Эцэг эх, гэр бүлийн бахархал болохын хамтаар хүүхдийн суралцах хугацааны зардлыг өрхийн төсвөөс хэмнэж чадна. Багш, сургууль хүүхдийг дэмжиж ажилласнаараа урамшина. Улсын хэмжээнд, өнөөгийн байдлаар төсвөөс сургуулийн халаалт, цахилгаан гэх мэтийг багтаасан нэг хүүхдийн жилд суралцахад зориулж 1,300,000 орчим төгрөг зарцуулдаг. Үүнийг дэвшин суралцах боломжтой хүүхдийн тоогоор хэмнэх боломж цаана нь харагдаж байна.

3. Сургалтын удирдлага (менежмент)


Өнөөдөр багш нар хүүхдийг сурахад чиглүүлэх ажилдаа бүрэн анхаарлаа зориулж чадахгүй байгаа нь бодит үнэн. Тэдэнд саад болж байгаа зүйлийн ихэнх хувийг элдэв бичиг цаасны ажил эзэлж байна. Үнэнийг хэлэхэд тэр бичиг цаасны ажлын олонх нь үнэхээр шаардлагатай юу гэдэг эргэлзээтэй. Магадгүй ямар нэг газар хураагдаад, хэрэг нь гарахгүй тавиурт үлдэж байж болох. Тэгэхлээр, үүнийг багасгах хэрэгтэй гэж үзэж байна.

Багш нар бас янз бүрийн шалгалт өгдөг. Эдгээр нь ерөнхийдөө ажлын явцыг тодорхойлох зорилготой. Гэтэл ийм шалгалтад ямар нэгэн хэмжээгээр бэлдэх, өгөх явдал нь ажлын явцын бүтээмжийг тодорхой хэмжээгээр бууруулах тал руу хэлбийжээ. Түүнчлэн, багшийг сайжруулахаасаа өөрийг нь хязгаарлах хүлээс болох тийш хандаж байна. Тэгсэн атлаа, явцын ийм олон шалтгалтуудыг нэгтгэсэн эцсийн үр дүнгийн шалгалт эсрэгээрээ сул. Энэ гажуудлыг засахын тулд, мэргэжлийн хяналт гэх мэт сургалтын дундуурх багшийг шалгах шалгалтыг багасгаж, харин оронд нь хичээлийн жилийн төгсгөлд үнэлгээний газраас эцсийн үр дүнгийн ерөнхий шалгалтыг бодтой үнэлэх замаар шийдвэрлэвэл түлхэц болно гэж үзэж байна.

Өнөөдрийн сургалтын үнэлгээний тухай ойлголтыг бас өөрчлөх шаардлагатай байна. Одоо нийтдээ хэвшчихсэн шалгуур бол сурах бичгээр олгосон мэдлэгийг хэрхэн цээжилж тогтоосноор тавьж байна. Тэгэхлээр, үнэлэх зарчмыг, цааш нь сурвал зохих мэдлэгтээ үндэслэн хэрхэн задалж ойлгож байгааг, ойлгосныхоо хэрэг тусыг хэрхэн гаргаж байгаагаар тодорхойлдог болгон сайжруулбал, сурах чөлөөт сэтгэлгээг дэмжихэд тустай юм. Нэг үгээр хэлбэл, юуг мэдсэнийг үнэлэхээсээ яаж мэдсэнийг үнэлэх явдал чухал болно.

Эдгээр санаа, үндсэндээ боловсролыг бие даан сурах чадвар гэдэг томъёоллоор хандуулахад чиглэсэн юм.

ТЭМДЭГЛЭЛ



Бид ирээдүйгээ ямар байлгахыг хүсч байна, хүссэн үр дүнгээ харахын тулд хүүхдүүдэд жишээлж харуулах хэрэгтэй.
Б.Болор

... боловсрол бол нийгмийн институци болон хувь хүмүүстэй харилцаанд ороход бий болж буй соёл, хандлага, хүмүүжил, чадвар, ёс зүй гэдэг утгаараа илүү том хүрээтэй.
Б.Сувд-Эрдэнэ

Жинхэнэ амжилт бол өөртөө дуртай, өөрийгөө ямагт эрх чөлөөтэйгөөр илэрхийлэх, сайн унтаж чаддаг, өөрийн болоод бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, өөрийнхөө зорилгыг мэдэх, түүнийхээ араас үйлдэл хийдэг, өөрийнхөө амьдралд зуун хувь хариуцлага хүлээхэд суралцах, эрүүл бие, сэтгэл зүйг хадгалж сурах, зөв харилцаанд үлдэх, өөрийнхөө амьдралыг өөрөө дүүргэх боломжтой гэдгээ ухаарах явдал юм.
Э.Тамир

Бидний өмнө аль хэдийн боловсруулаад дууссан гэж санагдах онолд эргэлзээд үзээрэй, эргэлзэж болно шүү гэж урамшуулах хүн багшаас өөр хэн байвал тохиромжтой вэ?
Б.Энхжин

Жинхэндээ амьдрал гэдэг бол хязгаарлагдмал зүйлийн төлөөх зогсолтгүй өрсөлдөөн гэхээс илүү ухамсартайгаар даван туулах хэрэгтэй тийм нэг зүйл гэдэгтэй өнөөдрийн бичвэр маань холбогдож байна. Бид үнэхээр зөв замаар явж байгаа эсэхээ мэдэхийн тулд өөрсдийн замаа эргэн нэг харахын ялдамд ирээдүйн үзэл санааг таамаглан түүнд бэлдэх хэрэгтэй байгаа юм.
А.Тулга

Сургах үүрэг гагцхүү багшид оногдсон хэмээн сэтгэх тэдгээр хүн өдөр тутам хэлэх үг, хийх үйлдэл нь угтаа хүүхдэд сургасаар буйг ойлгохгүй байгаа нь үүргээ ухамсарлахуй, рациональ байдлаар сэтгэхүй нь хөгжсөөгүйн шинж. Платоны агуйн ёгтлолоор зүйрлэвээс агуйгаас гараагүй хүн хэрхэн гаднах ертөнцийн талаар ярих билээ.
Г.Хонгорзул

Боловсрол гэдэг мэргэжлийн диплом төдийгүй эрүүл зөв сэтгэхүй, хандлага, шүүн тунгаах ухаан, шинийг мэдэх хүсэл болоод зөв төлөвшил, аливааг энэрэн хайрлах сэтгэл билээ.
Д.Уранзаяа


Боловсролын тухай сэдэв бол улс орон бүрийн санаагаа чилээх хэрэгтэй, дэлхий нийтийн томоохон чухал асуудлуудын нэг билээ.
Д.Номин

БҮЛЭГ IV

ДӨРӨВ БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ ЗАЛУУ ҮЕИЙНХНИЙ БОДОЛ



БОЛОВСРОЛ



**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ФИЛОСОФИЙН III ТҮВШНИЙ ОЮУТАН
Б.БОЛОР**

БОЛОВСРОЛ БОЛ ЭРХ ЧӨЛӨӨ ГЭДГИЙГ ОЙЛГОСОН

Ээж маань арван долоотой байхдаа их сургуульд орж чадалгүй, жил өнжингөө барилга дээр ажиллаж байсан гэдэг. Уг нь дунд сургуулиа төгсөөд Монгол Улсын Их Сургуулийн “Математик”-ийн ангид орохоор шалгалт өгөөд тэнцсэн боловч тухайн үеийн сургуулийн захиргаанаас хагас болон бүтэн өнчин хүүхдүүдийг их сургуульд элсүүлэн суралцуулж дэмжих шийдвэр гаргаад ээж хуваарьгүй хоцорсон юм. Яагаад өөр сургуульд дахиж шалгалт өгөөд орчихож болоогүй юм бол оо гэж боддог байсан ч тэр үед жилд ганц л их сургууль сонгож, шалгалт өгч, хуваарь авдаг байсан юм билээ. Ээж үргэлж л “Хүн сурч чадаж байгаа дээрээ сурах хэрэгтэй. Яг энэ цаг хугацаанд ингэж сурах боломж дахиж олдохгүй. Ээжийнхээ орж

чадаагүй их сургуульд орсон болохоор надаас илүү ихийг хийнэ гэж итгэдэг шүү” гэнэ. Би ээжийг надаас ч илүү боловсролын үнэ цэнийг мэднэ гэдгийг нь мэдэж байсан. Тийм ч болохоор түүнээс л “Боловсрол гэж таны хувьд юу вэ?” гэж асуусан. Мэдээж энэ бичвэрийг бичихэд санаа гаргахын тулд асуусан ч надад “боловсролтой болох хэрэгтэй” гэж хэлдгийн цаана ямар утга агуулдаг, тэр хэрэгтэй зүйл нь түүнийхээр яг юу болоод хэрэгтэй гээд байгааг нь мэдэх давхар санаа төрсөн юм. Ээж хором ч сааталгүйгээр “Тэр чинь эрх чөлөө” гэхэд нь ийм хариулт хэлнэ гэж огт төсөөлөөгүйгээ ойлгосон.

Хүн бүр боловсролыг үнэлэх өөр өөр үнэлэмжтэй. Харин ээжийнхээр эрх чөлөөтэй болохын тулд би боловсрол эзэмших хэрэгтэй

гэж бодов. Бодоод үзэхэд, мэдэхгүй зүйлээсээ хүн айдаг, оролдлого хийж зүрхэлдэггүй, “би үүнийг хийж чадахгүй” гэсэн хүчин мөхөстсөн мэдрэмж авдаг. Харин мэдлэг боловсрол гэдэг бидний харж чадаагүй тэр хэсэгт гэрэл тусгаж, ойлгуулж, ухааруулж, шүүн тунгаах чадвар өгдөг, нэг ёсондоо биднийг эрх чөлөөтэй болгодог тэр зүйл. Тийм болохоор бид олон зүйлийг сурч мэдэж, сурах ёстой цагаа үнэлэх хэрэгтэй. Энэ цаг хугацаа л биднийг боловсролд хөтлөх үнэ цэнтэй хэрэгсэл болдог.

Аа харин хүүхдүүд буюу сурагчид тэр болгон боловсролоос яг ямар үнэ цэн харахаа мэдээд байдаггүй. Мэдээж “сайн сурах ёстой”, “сайн их сургуульд орох ёстой”, “сайн дүнтэй байх нь сайн” гэж мэддэг ч түүнийгээ яаж илүү үнэ цэнтэй болгох, тэр мэдлэг чадвар нь яаж тэднийг хүсэж буй зүйл рүү нь хөтлөх чадвартайг сайн ойлгоогүй байдаг юм шиг. Тэгэхээр суралцагчид өөрсдөөсөө, эцэг эхээсээ, багш нараасаа:

Би яагаад сургуульд сурж байгаа вэ?

Би яг юу сурч байгаа вэ?

Сурч буй зүйл минь надад ямар хэрэгцээтэй вэ?

Яг ямар үр дүнд хүрэхийн төлөө энд (сургуульд) байгаа вэ? гэдгийг асуух эрхтэй.

Хариулт нь тийм ч амархан олдохгүй. Учир нь суралцагч хүүхдүүдэд эдгээр асуултуудад хариулах нь байтугай өөрсдөө ч өөрийгөө ойлгохгүй, юу хүсээд байгаагаа мэдэхгүй үе гарч ирдэг. Дөнгөж л өөрийнхөө хэн болохыг, юу хүсч байгаагаа мэдэрч эхэлдэг нэг ёсондоо амьдралтай танилцаж эхэлж байгаа тэдэнд боловсрол гэж юу гэх асуулт санааг нь нэг их чилээхгүй. Гэхдээ энэ утгаараа би сурагчдыг (дунд болон ахлах ангийн сурагчид) боловсролын талаар юуг ч ойшоодоггүй гэсэн санаа гаргах гэсэнгүй. “Хараахан боловсролын талаар бодох ч болоогүй байна даа”, “Ингээд сурч явж байгаад төгсөх дөхөөд юу хийхээ бодно доо” гэж нухацтай авч үзээгүйгээс хугацаа алдаад байдаг. Яг энэ тухай бүр дээр чиглүүлж, тусалж, зорилгыг нь өөрөөр нь олуулах боловсролын системд хамгийн чухал тусгагдах зүйл гэж бодож байна. Зорилгоо олчихсон сурагч оюутнуудад зорилгодоо хүрэхэд боловсрол хэр нэмэртэйг аяндаа өөрсдөө ухаарна гэж би боддог.

Нэмээд, мэдээж хүмүүсийн анхаарлыг татсан асуудал болох боловсролын хүртээмжтэй, тэгш байдал яригдана. Ерөнхий боловсрол олгох сургуулиуд мэдээж чанартай боловсрол олгох ёстой л гэж бодлогоос яг цаад нарийн ажлын хэсэг энэ талаар ямар бодлого боловсруулдаг талаар мэдэхгүй л дээ. Ямар ч л гэсэн боловсролын чанар одоо байгаагаасаа сайжрах хэрэгтэй гэсэн ерөнхий дүгнэлт хүн бүрт бий. Нэгэнт л амьдралынхаа арван хоёр жилийг зарцуулж байгаа учраас чанартай,

хэрэгцээтэй боловсрол эзэмших хэрэгтэй.

Дан ганц эдгээр асуудлууд ч биш, сурагчдыг боловсрол эзэмшихэд нь ямар бэрхшээл тулгардаг талаар саяхан нээлтээ хийсэн “Баавгай болохсон” киноны дүр Өлзий хүүгийн амьдралаар харуулсан. Мэдээж киноны үйл явдлыг ярих илүүц биз. Хамгийн гол нь хүнд бас хичээгээд ч болохгүй, хэдий юу өөрт нь хэрэгтэй гэдгийг ойлгож ухаарсан ч түүнийгээ хэрэгжүүлж чадахгүй үе тохиодог гэдгийг, хүн бүр ижил амьдралын нөхцөлтэй, туршлагатай байдаггүйг, захын дүүргийн сургуулиуд орхигдчихсон байдаг гэдгийг бүгдийг дэлгээд харуулчихсан. Кинонд гаргасан ихэнхи асуудал ил болон далд байдлаар боловсролын тухай асуудалтай холбогдсон гэж би харж байгаа. Асуудал нэг бүрийг нь шийдвэрлэх гэдэг мэдээж хэцүү, гэхдээ чадах бүх зүйлээ хийж, хичээж, оролдлого хийвэл ахиц гарах нэг асуудалтай байсан салбар яалт ч үгүй боловсролын салбар байсан гэж хувьдаа харсан. Даанч асуудлыг олж харж чадахаас биш түүнийг шийдвэрлэх гарц гаргалгааг олж чадах нь одоо байгаа миний чадвараас хэтэрсэн нь ойлгомжтой. Харин энэ асуудлыг шийдвэрлэж чадах чадвартай хэн нэгэн ирээдүйд үүнийг хараасай гэж найдаж л чадна.

Эцэст нь зөвхөн дотроо боддог “Боловсролыг дан ганц сурагчийн ширээний араас олдоггүй” гэх бодлоо хуваалцмаар байна. Мэдээж бидэнд онолын мэдлэг эзэмших, бодох, сэтгэх, шүүмжлэлт сэтгэлгээгээр хандах чадвар нь чухал ч гэсэн иррационал зүйлс болох мэдрэх, мэдрэмжээ ойлгох, сэтгэл хөдлөлөө зөв илэрхийлэх, хайрлах, энэрэх, бусдад сэтгэлээсээ хандах эдгээр зүйлс “боловсрол” гэх ойлголтод багтах хэрэгтэй.

Магадгүй энд нэр томъёоны асуудал яригдах байх. “Боловсрол” гэдэг үгийн урд эсвэл ард “мэдлэг” гэсэн үг ихэнхи тохиолдолд дагалддаг учраас “Боловсролтой хүн бол мэдлэг ихтэй хүн” гэсэн ойлголт дийлэнх хүмүүсийн дунд байдаг байх аа гэсэн толгой мэдсэн дүгнэлт гаргаад байгаа юм. Дээр дурдсан санаагаа багцлаад хэлбэл, боловсролтой хүн гэдэг зөвхөн их мэдлэгтэй хүн биш, түүнийгээ хэрэгтэй үед, зөв цагтаа ашиглаж чаддаг, өөрөө өөрийгөө ухаарсан, бусдад бас сайхныг хүсч, тусалж чаддаг тийм хүнийг хэлэх байх. Улсын ирээдүйг гэгээтэй сайхан байлгахад хүүхдүүдийг дээр дурдсанчлан боловсролтой хүн болгох нь чухал. Бид ирээдүйгээ ямар байлгахыг хүсч байна, хүссэн үр дүнгээ харахын тулд хүүхдүүдэд жишээлж харуулах хэрэгтэй.

Одоо бид бидний ирээдүй болох хүүхдүүдэд (сурагчдад) хэрхэн хандаж байгаа вэ?

Юу тарьсан түүнийгээ хураана...



**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ФИЛОСОФИЙН III ТҮВШНИЙ ОЮУТАН
Б.СУВД-ЭРДЭНЭ**

БОЛОВСРОЛ БОЛ НИЙГМЭЭ ИЛҮҮ САЙН САЙХАН БОЛГОХ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

Боловсролын зорилго бол улс орныг хөгжүүлэх сэхээтнүүдийг бэлтгэж, өөрсдийн амьдарч буй нийгмээ илүү сайн сайхан болгох ирээдүйн баталгааны тухай асуудал гэж би хувьдаа боддог. Тийм ч учраас боловсролын тухай асуудал эртнээс өнөөг хүртэл хувьсан өөрчлөгдөж буй нийгэмүүдэд маш чухалд тавигдсаар байна. Харин тухайн цаг үеүдэд боловсрол гэж юуг ойлгодог байсан, үүнд хэрхэн хандаж байсан зэрэг нь өөр өөр байдаг. Тухайлбал Грекийн сэтгэгч Аристотель боловсролын талаар тайлбарлахдаа хүүхдийн оюун ухаан төрөх үедээ “цэвэр самбар” мэт байдаг ба тэднийг хүмүүжүүлэх гол зорилт бол хүүхдэд асар олон салбараас мэдлэгийн гол үндсийг өгч тэднийг бие даан сэтгэхэд сургах явдал.

Хүмүүжүүлэгч юуны өмнө ургамлын (хооллох, үржих), амьтны (мэдрэх, сэрэх), оюун ухааны (сэтгэх, танин мэдэх) гэсэн янз бүрийн үүрэг бүхий 3 хэсгийг багтаасан оюун санааг хүүхдэд төлөвшүүлэх ёстой. Санаа бодлын дээрх 3 төрөлд тохирох хүмүүжлийн 3 төрөл нь бие бялдрын, оюун ухааны, ёс зүйн хүмүүжил хэмээн үзсэн байдаг. Миний хувьд түүний боловсролыг ийнхүү тайлбарласантай ихээхэн санал нийлдэг бөгөөд боловсрол бол дотроо хэд хэдэн ойлголтуудыг багтаадаг.

Нийгэм хувьсаж, өөрчлөгдөхийн хэрээр боловсролын талаарх үзэл баримтлал ч өөрчлөгдөж, хөгждөг. Өнөө үед боловсрол гэж юуг хэлж байна вэ, ямар цар хүрээтэй гэдгийн талаар ойлголт их маргаантай болсон бөгөөд боловсрол, мэдлэг гэсэн ойлголтыг зарим хүмүүс ижил мэт ойлгон, боловсролыг дан ганц мэдлэгээр дүгнэх хандлага их ажиглагдаж байна. Жишээлбэл англи хэлтэй, математикийн хичээлдээ сайн аль эсвэл их сургуулийн бакалавр, магистрын дипломтой, гадаад улсад суралцсан бол боловсролтой гээд бодчихдог. Гэхдээ эдгээр нь боловсролыг бүрэн дүүрэн илтгэж чадахгүй болов уу. Энэ бол зүгээр л мэдлэгтэй хүнийг

илэрхийлж буй тус тус хэв маяг. Мэдлэг, боловсрол хоёр нь хамрах хүрээ болон илэрхийллээрээ ялгаатай. Мэдлэг бол дадлага, туршлагаар олж авч буй мэдээлэл хийгээд чадвар. Харин боловсрол бол нийгмийн институци болон хувь хүмүүстэй харилцаанд ороход бий болж буй соёл, хандлага, хүмүүжил, чадвар, ёс зүй гэдэг утгаараа илүү том хүрээтэй. Тийм ч учраас цэцэрлэг, бага анги, дунд анги ахлах анги, их сургууль гээд боловсролын институцууд нь мэдлэг өгөхийн хажуугаар хүнийг боловсролтой болгож төлөвшүүлэх үүрэгтэй бөгөөд энэ үеийн үйл явцыг үр дүнтэй, чанартай байлгах нь боловсролын салбарын нэг тулгамдаж буй асуудал болоод байна. Эдгээрийг шийдвэрлэхийн тулд нэг талд боловсролын бодлого болон түүний хэрэгжилт, сул тал нөгөө талд түүнийг хэрхэн шийдвэрлэвэл зохилтой вэ? Талаар өөрийн саналаа хуваалцъя

Боловсрол нь гэр бүлийн хүмүүжил хүүхэддээ хэрхэн хандах хандлагатай холбоотой. Хүүхдийн боловсрол эзэмших үйл явцад төрөөс таатай орчинг бүрдүүлж тэрхүү орчинд багш нар хичээлээ зааж үүнд эцэг эх тусалснаар хүүхдэд илүү амар болно. Ялангуяа цэцэрлэг, бага ангид хүүхдээ сургаж буй эцэг эхчүүд маань бүгдийг багшид найдаж өөрсдөө хариуцлагаас бултахгүй байх хэрэгтэй. Хүүхэд тань сургууль дээр юу сурсан, юу тэрэнд таалагдаж юу нь таалагдахгүй байсан гээд хүүхдээ сайн сонсож, эргүүлээд зөв зөвлөгөө өгдөг байх нь чухал.

Мөн манай улсад цэцэрлэгийн насны хүүхдийн боловсролыг их дутуу үнэлж анхаарал бага хандуулж буй мэт санагддаг. Яагаад гэвэл цэцэрлэгийн багшийн ажлын цалин бага, үүнийгээ дагаад СӨБ-ын багшийн шалгуур нь асуудалтай. Эндээс миний ойлгосон зүйл бол боловсролгүй хүн боловсрол заана гэж байдаггүй юм байна. Жишээ нь манай улсад цэцэрлэгийн багш хүн хүүхдүүддээ гар хүрсэн, загнасан, цохисон гэх мэт хүчирхийллүүд сүүлийн жилүүдэд хэд хэдэн удаа тохиолдсон. Энэ нь цэцэрлэгийн багшийн боловсролын түвшин

цаашилбал бүхэл бүтэн цэцэрлэг гэж институцийн тухай асуудлыг эргэн харах шаардлагатайг илтгэж байна.

Цэцэрлэг болон бага ангийнхны нэг ангид суралцах хүүхдийн тоо хэтэрхий их үүнийгээ дагаад хичээл нь чанаргүй. Нэгдүгээр ангийн хүүхэд үсэг үзэж уншихад суралцдаг, тоо бодож, нэмж, хасах үйлдлийг заалгаж амархан бага наснаас хариуцлага ихтэй шинэ хэвшил рүү шилждэг. Энэ үед хүүхдэд багшийн анхаарал халамж их шаардлагатай ба багшийн бас нэг үүрэг нь бол тэднийг ойлгох, мэдрэх юм. Гэтэл бага ангийнханд хариуцах багш ганцхан хэрнээ хариуцуулж буй хүүхдүүд нь хэтэрхий их байдаг учраас хүүхэд нэг бүрт хүртээмжтэй байх, бүгдэд нь ижилхэн, ойлгомжтойгоор хичээлээ заана гэдэг бол бүтэшгүй зүйл юм. Багшийн тоо хүүхэд бүрт хүрэлцээтэй байж чадахгүй байна. Иймээс энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд багшийн тоо болон анги танхимыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Хамгийн гол нь мэдлэгтэй, мэдрэмжтэй, ёс суртахуунтай багш нарыг бэлдэх юм.

Дараагийн ярих зүйл бол чанаргүй их дээд сургуулиудаас үүдсэн олон диплом юм. Үүнээс үүдэн нийгэмд их сургууль төгссөн хэрнээ ажилгүй хүмүүсийн тоо олширч байна. Хэрэв их сургуулиа төгсөөд мэргэжлийнхээ дагуу ажил эрхлэх боломж

олдохгүй байна гэдэг нь харамсалтай бөгөөд тэр хүн цаг хугацаа, эд баялаг, сэтгэл санаагаар хохирч үлдэнэ гэсэн үг. Энэ нь боловсролд тэмүүлэхийн утга холбогдолыг үнэгүйдүүлж, хүмүүсийн сэтгэлд эргэлзээ төрүүлэхэд хүргэж байна. Угтаа бол аль ч их, дээд сургуулийн элсэлтийн босго өндөр байж, тус шалгуурыг давж, амжилттай сайн сурсан төгсөгчдөдөө ажлын байраар хангахад нь сургууль нь туслах хэрэгтэй. Ингэж байж бид боловсролын эрэлт нийлүүлэлтийн хоорондох хоосон орон зайг үгүй хийх болов уу.

Мөн боловсролын салбар болон нийгэмд тулгамдаад буй нэг асуудал бол жендерийн асуудал юм. Тухайлбал ерөнхий боловсролын сургууль, коллеж, их дээд сургуулиудад боловсрол эзэмшиж буй суралцагчидыг ажиглаваас тэдний талаас их нь эмэгтэйчүүд байна. Үүнийг би патриархат соёлын хүрээнд бүрэлдсэн жендерийн хэвшмэл хандлагатай холбоотой асуудал гэж бодож байна. Энэ нь гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийлэл болон ганц бие өрх толгойлсон хүмүүсийн тоо олшрох зэрэг олон социал асуудлын нэг шалтгаан нь болох юм. Хүний эрх, жендерийн эрх тэгш байдлын талаар зөв үзэл хандлага бүхий хүнийг юуны өмнө боловсролтой хүн гэж бас хэлэх байх.



**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ФИЛОСОФИЙН III ТҮВШНИЙ ОЮУЦАН**

Э.ТАМИР

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

Ахлах сургуулиа төгссөнөөс хойш эргээд бодоход харамсалтай санагдах зүйлс олон бий. Миний хувьд анги дэвших тусам хүмүүстэй харилцаанд орохоос, алдаа гаргаж бусдад таалагдахгүй байх вий гэдгээс айдаг, чимээгүй хүүхэд болсон. Одоо бодоход тэнд юу сурснаа санадаггүй юм. Хамгийн харамсалтай нь миний хэзээ ч хаанаас ч сурч авч чадаагүй, эргэн тойронд байсан хүмүүсээс хэн нь ч дурдаж байгаагүй өнгөрөөсөн хэр нь надад эрхмээс эрхэм зүйл болох “өөртөө итгэх итгэл”-ээ олж авч чадаагүй өдий хүрсэн явдал. Дөнгөж сүүлийн хоёр жилд л энэ

үгний утга юу болох тухай эргэцүүлж байгаа.

Тэгэхдээ үүнийг ямар нэг ур чадвар эзэмшиж, заавал амжилт гаргаж, өөрийгөө бусдаар хүлээн зөвшөөрүүлж, бусдад өндөр үнэлэгдэж, таалагдаж олж авдаг гэсэн утгаар бус харин ч энэ бүхнээс хамааралгүйгээр юуны өмнө өөртөө итгэх итгэлийн суурин дээрээ өөрт утга учиртай гэсэн зүйлээ хийж үзээд бүтэлгүйтсэн ч хэвээрээ үлдэх дархлаатай итгэлийн тухай ярьж байна. Өөрөөр хэлбэл бид заавал үйлдэл хийж, өөрийгөө баталж олж авдаг тийм болзолт биш тогтвортой шинжтэй итгэлийн тухай юм.

Боловсролтой иргэнийг бий болгоход бага наснаас анхаарах нь маргаангүй юм. Тиймээс сургуулийн нас бол хүүхэд гадаад ертөнцийг таньж мэдэхээс гадна би-гээ сайн ойлгох чадварт суралцах, цаашид өөрчлөгдөх явцдаа ч өөрийгөө анзаарч өөртөө тусалж чаддаг болох. Хүн бүр амжилтад хүрэх албагүй. “Амжилт” гэх ойлголтыг нийгэм өнгөц, буруу тодорхойлдог. Жинхэнэ амжилт бол өөртөө дуртай, өөрийгөө ямагт эрх чөлөөтэйгөөр илэрхийлэх, сайн унтаж чаддаг, өөрийн болоод бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, өөрийнхөө зорилгыг мэдэх, түүнийхээ араас үйлдэл хийдэг, өөрийнхөө амьдралд зуун хувь хариуцлага хүлээхэд суралцах, эрүүл бие, сэтгэл зүйг хадгалж сурах, зөв харилцаанд үлдэх, өөрийнхөө амьдралыг өөрөө дүүргэх боломжтой гэдгээ ухаарах явдал юм.

Төгс төгөлдөр буюу идеал байдал бол миний, чиний, бидний эцэг эх, багш нарын ер нь хэний ч зорилго биш. Угаас төгс бус ертөнцөд хэрхэн хамгийн сайн сайхнаараа амьдрахыг хамтдаа суралцаж, боловсорч, зарим тохиолдолд алдаа дутагдалтай нь алдаа дутагдлынх нь төлөө хайрлах, өөрсдийнхөө жижиг хүмүүсийг өсгөнгөө өөрсдөө ч хүн гэдэг утгаараа боломжит хэмжээгээрээ өсөж, урагшлах тэр үйл явц юм. Боловсорно гэдэг бол нэг цэгт хүрээд зогсох зүйл огтхон ч биш, тасралтгүй үргэлжлэх үзэсгэлэнтэй хэр нь заримдаа тэвчишгүй ч байж болох үйл явц юм.

Дунд сургуулийн хичээлийн хөтөлбөрөөс эрүүл мэндийн боловсролын хичээлийг чанартай болгоход анхаарах, суралцагсад бие махбодтойгоо танилцах, өөрийнхөө бусдаас өөр, муухай гэж боддог хэсгүүдээ хүлээн зөвшөөрөх, бэлгийн зохистой боловсролыг заавал олгох, сэтгэл зүйн эрүүл мэндийн хичээл мөн зайлшгүй оруулах хэрэгтэй: сэтгэл хөдлөлөө мэдрэх, өөрчлөлтийг нь анзаарч ойлгох, удирдах, бусдын оронд өөрийгөө тавьж үзэх, бусдыг сонсож сурахад, сэтгэл хөдлөлүүдийг хооронд нь ялгаж ойлгох тухайд нээлттэй ярилцаж чаддаг болгох нь зөв зохистой.

Суралцагч хэзээ ч ганцаараа хичээгээд сайн боловсрол эзэмшиж чадахгүй. Тиймээс гурван талын оролцооноос шалтгаалж тухайн суралцагчийн суурь тавигдах нь тодорхой юм. Гурвалжны оройд хүүхэд, доод хоёр тулгуур нь эцэг эх, сургууль, багш болж өгнө.

Эцэг хүн хүүхдээ амьдралаас айх айдасгүй, зоримог, шийдвэр гаргах чадамжтай, удирдан чиглүүлж, хүлээн зөвшөөрдөг, хүлээцтэй байж өөрийнх нь чадварт итгэх итгэлийг бэхжүүлж, эцгийн захиргаагүйгээр амьдрах чадварт сургах хэрэгтэй. Эх хүн хүүхдийнхээ өмнө хүлээсэн хариуцлага дээр анхаарч, хайрлан халамжилж, өөрөө амьдралд итгэх итгэлтэй байж, насанд хүргэн өөрөөсөө огт хамааралгүй болгож, ямар ч хүйстэй

байсан амьдрах сайхан гэсэн зөв сэтгэлт хандлагыг төрүүлэх, мөн энэ ертөнцөд амьдарч байгаа маань сайхан гэх сэтгэлийг төрүүлж, өөрөөр хэлбэл чиний төрсөн чинь л хангалттай гэсэн энгийн боловч маш үнэ цэнтэй ойлголтыг төрүүлэх үүрэгтэй. Ийм эцэг эх амьдралд хайртай байж, аз жаргалтайгаар амьдрах итгэл найдварыг урладаг.

Хичээлийн агуулгууд өөр хоорондоо уялдаа холбоотой байж, сургууль, цаашилбал боловсрол гэх нэг том институт үнэт зүйл, эрхэмлэл, зорилгоо нэгтгэн ухамсарлаж, нэг зүгт нэгдэж ажиллах ёстой. Олон төрлийн мэдлэг, ур чадваруудаа нэгтгэж байж сая амьдралдаа ашиглах боломж бүрдэнэ. Амьдралд бэлтгэх гэж л биднийг сургуульд сургадаг биш үү? бага, дунд, ахлах ангид сургаж, сургаж гараад ирэхэд амьдрал гэж тэс ондоо зүйл мэт санагддаг. Суралцсан, мэдсэнээ амьдрал дээр хэрхэн, яаж хэрэглэх тухайд холбосон гүүр байхгүй. Үүнтэй адил багш, суралцагчийн хооронд, мөн суралцагчдын дунд харилцаа холбоо үүсэхгүй бол холбогдож, ойртож, ойлголцож чадахгүй хөндий явсаар дуусдаг. Бага наснаас нь хүүхэд бүрд бие даан, эсвэл бусадтай хамтран сурах чадвар суулгахыг системээрээ зорих хэрэгтэй. Зарим багш нарын болон суралцагчдын хоорондын ялгаварлан гадуурхалтыг багасгах, бүр ул мөргүй болгох тал дээр дорвитой арга хэмжээ авдаг байгаасай. Ядахдаа хүүхдийн өөртөө болоод амьдралд итгэх итгэлийг нь л өөрт нь үлдээчих. Ингэхлээр багш хүн байна гэдэг хэн дуртай нь болдог бус асар өндөр шаардлага, үнэлэмжтэй мэргэжил юм. Амьдралд дурлах гэхээр зөвхөн аз жаргалыг мэдрэх, таашаал авахыг л хэлнэ гэж ойлговол өрөөсгөл болно. Хэцүү хүнд зүйлс, бэрхшээлтэй тулгарсан ч амьдралд дурласан хэвээр байх. Тэгвэл боловсролын тусламжтайгаар бид өөрсдийн аз жаргалыг бүтээдэг гэдэгт итгэдэг.

Эцэст нь дүгнэхэд би зөвхөн өөрийнхөө багахан туршлагадаа тулгуурлаж л бичлээ. Бага нас, тэр дундаа сургуулийн наснаас нь хүүхдүүдийн боловсролд хэрхэн анхаарч, тэдэнтэй яаж харилцахаас бидний ярьдаг боловсролын хэмжээ, ирээдүй маань тодорхойлогдоно.

Нийгмийн олон стандарт, хүмүүсийн харилцаа хүүхдийг том болох тусам нь хэмхэлдэг тиймээс миний хүсэх ганц чухал зүйл бол жижигхэн хүн байх тэр үеэс нь өөрөөр нь үлдээх, бүх утгаараа өөрийнхөөрөө байх зориг, итгэлийг нь л битгий сүйтгэ.

Өөртөө итгэлтэй хүн бол оюун ухаанаар бие даан сэтгэдэг, нийгмийн хэвшмэл сэтгэлгээнд авталгүй өөрийнхөөрөө эргэцүүлэл хийдэг. Кантын хэлсэнчлэн түүнийгээ нийтийн өмнө хязгааргүй эрх чөлөөтэйгөөр ашиглах эр зоригтныг, нэг ёсондоо оюун ухаан нь насанд хүрсэн нэгнийг боловсорсон хүн гэж үздэг.



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ФИЛОСОФИЙН III ТҮВШНИЙ ОЮУТАН

Б. ЗНХЖИН

БОЛОВСРОЛ БОЛ НЬ ХЭЗЭЭ Ч ЗОГСДОГГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Боловсрол нь хэзээ ч зогсдоггүй үйл ажиллагаа учир амьдралын туршид хэрэг болсоор л байдаг гэж санана. Гэхдээ ердийн мэдлэгээс боловсрол тусдаа байх ёстой юм шиг. Учир нь хамгийн ерөнхий байдлаар боловсролтой хүнийг төсөөлөөд хэл гэвээс тодорхой хэмжээнд ном уншиж, бодлоо эргэцүүлэн бичиж, магадгүй хэд хэдэн хэлээр ярьж, хамгийн чухал нь нийгэмд эергээр нөлөөлдөг (үзэл бодлоо илэрхийлж, идэвхтэй байх гэх мэт) хэн нэгэн толгойд минь төсөөлөгдөх юм. Гэхдээ ёс суртахуунгүй үйлдлийг зориудаар хийдэг хэн нэгнийг бол төсөөлөөгүй юм шүү.

Нэгэнт тун өөдрөгөөр нийгэмд эерэг нөлөөлөлтэй иргэнийг төсөөлсөн учраас тэр хэн нэгнийг бий болгохын тулд яах ёстой талаар өөрийн ахархан бодлыг хуваалцъя. Хувийн туршлага минь надад арван жилийн боловсролыг багшийн үг, сурах бичгээс халин гарч сонирхох хүсэлгүй залхуу хойрго, хаалттай сэтгэхүйг төлөвшүүлдэг мэт санагддаг. Улмаар ажил, амьдрал дээр гараад асуудлын зөв бурууг хэлж чадахгүй, амьдарч буй нийгмийнхээ сайн мууг ялгаж чадахгүй ирээдүйг бэлтгэдэг. Нийгэм хүмүүсээс л бүтдэг шүү дээ.

Математикийн хичээл яагаад бидэнд хэрэгтэй юм? гэж тэрсэлж, зөрүүдлэн, сониучирхан асуух дунд ангийн сурагчид уг хичээлийн үнэ цэнийг ойлгуулан урамшуулж салбартаа татаж чадах багш хэд байгаа бол? Магадгүй өөрсдөө ч математикийн үнэ цэнийг ойлголгүйгээр багш мэргэжлээр сурч, амьдралаа залгуулахын тулд багшилдаг хүмүүстэй амьдрал дээр цөөнгүй л таарах юм. (Гэвч энд ЕБС-ийн багш нарын ажил хүнд, хариуцлагатай атал хөдөлмөрийг нь тун бага үнэлдэг гэдэг нь шууд ба шууд бусаар нөлөөтэй л байх).

Бидний ийм асуултыг багш нар гөжүүд гэж үзээд хатуу зэмлэлээр хариу барьдаг байлаа. Эсвэл “математикгүйгээр та нар хол явахгүй шүү!” гэж заналхийлэхээс өөр дорвитой үг хэлэхгүй шүү. Цаашид ийм асуулт асуусан сурагчдад гайхалтай

сэтгэл хөдөлгөм хариулт өгч чаддаггүй юм гэхэд үр ашиг, үүсэл гарлыг нь залхалгүй тайлбарлаж өгдөг байгаасай гэж мөрөөдөх юм.

$E=mc^2$, $2+2=4$, H_2O эсвэл атом электрон, протоноос бүрддэг гэх мэт онолуудаас залхах үе их. Ер нь бидний сурч, боловсрох ёстой байсан 40 минут хэтэрхий хөшүүн, хатуу онолд баригдсан, цаг нөхцөөсөн юм шиг санагддаг байлаа. Их сургуульд орсон хойноо эргээд арван жилээ харвал бүтэн нэг жилийн турш үзсэн хичээлээ нэг улиралд шахаж үзэх ч боломжтой байж дээ. Стандарт 40 минутын ядаж 10 минутыг амттай, үр дүнтэй ашиглан, ярилцлагад зориулдаг байвал сайхан сан гэж мөрөөддөг боловч 30 гаруй сурагчид багадаа хугацаа ч юм болов уу даа.

Байгалийн ухааны хичээлүүд дээр бид сүрхий туршилт хийн, бүхнийг нүдээрээ харж чаддаггүй, монгол хэл уран зохиолын сурах бичиг нь нимгэхэн, хэлний хичээлээ илүү үр дүнтэй, сонирхолтой болгох арга интернэтээр дүүрэн байна. Гэтэл сургалт маань яг л хэвэндээ.

Дүү нар маань залхуу хойрго болж анхаарал төвлөрүүлэх хугацаа нь улам богиноссон. Юм сурна гэдэг бол хөдөлмөр гэдгийг үгүйсгэх гэсэнгүй, гэтэл тэд маань өөрийгөө бүрэн хариуцах, өөрийнхөө өмнөөс хариуцлага хүлээх болоогүй тул асуух, гайхах, сониучирхах насанд нь зориулсан ямар нэг зүйл хийх хэрэгтэй шүү гэдгийг уламжлахыг хүслээ.

Төгсгөлд нь жишээ татах тохиромжгүйг би мэднэ л дээ. Гэхдээ Ньютоны араас Эйнштейн гарсан. Хэдийгээр Аристотель Платоны шавь ч багшаасаа өөрөөр юмсыг тайлбарлахыг хүссэн.

Бидний өмнө аль хэдийн боловсруулаад дууссан гэж санагдах онолд эргэлзээд үзээрэй, эргэлзэж болно шүү гэж урамшуулах хүн багшаас өөр хэн байвал тохиромжтой вэ?



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ФИЛОСОФИЙН III ТҮВШНИЙ ОЮУТАН

А.ТҮЛГА

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭЛ БА ИРЭЭДҮЙН ТААМАГ

Хүн гэдэг цаг хугацаа, орон зай болон бодит ахуйд оршигч мөнийхөө хувьд өөрийн амьдарч буй нийгмийнхээ бүтээгдэхүүн болсон байдаг. Тиймээс ч нийгмээс ангид байх нь зарим нэгэн онцгой тохиолдлуудад бий болохоос бусдаар бараг л боломжгүй. Өөрөөр хэлбэл хүний оюуны үйл ажиллагаа, амьдралын хэмнэл гэх мэт зүйлс тухайн түүхийн цаг үеийнхээ нийгэмтэй хамааралтайгаар оршдог. Өнгөрснийг, ирээдүйг, ер нь юуг ч судлалаа гэсэн тухайн цаг үеийнхээ үүднээс авч үздэг билээ. Түүхийн үечлэл болбоос тухайн цаг үеийн нийгмийн зонхилох шинжийг илэрхийлж байдаг үндсэн нэг шинж. Өнөө бидний амьдарч байгаа зуун бол мэдээлэл, технологийн эрин гэсэн тодотголтой цаг үе мөний хувьд бидэнд хүн төрөлхтний бусад үеүүдээс ялгарах шинжүүд бий гэдгийг хэн бүхэн надаар хэлүүлэлтгүй тунгааж, анзаарч яваа биз. Үүнийг дурдсан шалтгаан гэвээс энэхүү үнэн байдлыг мэдэрч түүнд оршиж байгааг хувьд тулгарах аливаа асуудлуудыг шийдвэрлэх, зөв зохистой үзэл хандлагыг төлөвшүүлэх ямар нэгэн ил зорилго бид бүхэнд байх хэрэгтэйг сануулахын сацуу сайн сайханд хүрэх гэсэн хүн төрөлхтний нийтлэг хүсэлд нийцүүлэх зорилгоор энэ цаг үедээ бага ч гэсэн хувь нэмрээ оруулах санаагаа тусгаж байгаа хэрэг юм. Энэхүү бичвэрийг бичихдээ МУИС-ийн философи, шашин судлалын тэнхимийн зөвлөх профессор, шинжлэх ухааны доктор, профессор, шинжлэх ухааны академийн философийн хүрээлэнгийн судлаач Ц.Гомбосүрэн багшийн 2020 оны хэвлэлтийн “Философи” сурах бичгийн төгсгөлийн эргэцүүллийн зарим хэсгийг суурь болгон, өөрийн санаагаар нэмэн илэрхийлэхийг хичээлээ.

Аливаа онол, арга зүй нь оюун ухааны тусламжтайгаар тайлбарлагдах маш олон тооны объектив шинжтэй зүйл байдгийн хувьд ерөнхийлөн ойлгоход л боломжтой. Хүн төрөлхтний бүтээсэн энэ их онолын мэдлэг агуулгаараа ч тэр нэг биед

хүртэгдэн тайлбарлагдана гэдэг бараг л боломжгүй биз. Гагцхүү биднийг хаашаа хүргэж болох талаар таамаг, цаг үеэ нягт анзаарсны үндсэн дээр туйлын ерөнхий байдлаар дүр зураг үүсэж болох юм. Өнгөрсөн, одоо, ирээдүйн хүний үйл хэргийн тухай сэтгэгчид олон өөр өнцгөөс авч үзсэн байдаг нь түүнтэй танилцах явцад үлдэцтэй байдлаараа бодитойг танихуйд тун чухал үүрэг гүйцэтгэдэг. Хэдий тэр бүх санаа ихэвчлэн субъектив шинжтэй байдаг нь маргаангүй боловч нарийн ухвал хоорондоо маш энгийн зүйлсээр холбогдож нэгэн зэрэг оршин байдгийг олж үзэх болно. Ирээдүйн хүмүүсийн өмнө хариуцлага хүлээх нь зөв үү? гэх мэтээр философидож байгаа нь үнэхээр хүн нийгэм хэмээх бүхэллэг ойлголтыг төлөөлж өөрийн санаа бодлоо илэрхийлснээр бусаддаа нийтээр нь бодох түлхэц өгч буй хэрэг юм.

Мэдлэг, боловсролын утгыг тайлахдаа аль ч өнцгөөс харж болох ч эерэг бус утгатайгаар буух тохиолдол нь хамаагүй бага юм. Аливааг мэднэ, ойлгоно гэдэг нь нэг талын хүнийг хүн болгож байгаа тэр зүйл, өчүүхнээс холдох холдолт, ухамсаргүй үйлдлүүдээс зайгаа барих явдал байх учиртай. Мэдээж ийнхүү авч үзэх байр суурь байсаар ирсэн. Гэтэл хүнлэг бус, төлөвшөөгүй мэдлэг асуудал болоод байгааг бид сүүлийн үеэс л чухлаар авч үзэж байна. Учир нь өнөөгийн хүмүүсийн материаллаг байдалд шүтсэн амьдрал, ёс суртахуунгүй үйлдэлүүд нь дэлхийд экологийн хямрал үүсэх, зөрчил маргаан, сүйтгэлийн эх үндэс болоод байгаа билээ. Жинхэнэдээ амьдрал гэдэг бол хязгаарлагдмал зүйлийн төлөөх зогсолтгүй өрсөлдөөн гэхээс илүү ухамсартайгаар даван туулах хэрэгтэй тийм нэг зүйл гэдэгтэй өнөөдрийн бичвэр маань холбогдож байна. Бид үнэхээр зөв замаар явж байгаа эсэхээ мэдэхийн тулд өөрсдийн замаа эргэн нэг харахын ялдамд ирээдүйн үзэл санааг таамаглан түүнд бэлдэх хэрэгтэй байгаа юм. Ирээдүйд материализм эзотерик мэдлэгт, түүний

дотор шашны зарим мэдээтэй тулгарч буй шинжлэх ухааны ойлголтод тулгуурладаг болох хандлагатай байна. Учир нь хүн энэ ертөнцөд дангаараа биш үнэн хэрэгтээ бидний ойлгоогүй далд зүйлсийн нөлөөн дор оршин байдаг нь хүний амьдралын талбарт олонтаа харагддаг билээ.

Барууны үзэл санаа өөрийн хөгжлийн энэхүү чухал үедээ иррациональ сэтгэлгээг хүлээн зөвшөөрч эхэлсэн нь басхүү учиртай юм. Нийгмийн философийн салбарт синергетикийн шинжлэх ухаан, эзотерик мэдлэг зэргийн үр шимд үндэслэн онол бий болгон хөгжих нь хүн төрөлхтнийг мөхлөөс ангижруулах, манай дэлхийн сүйрлийг зогсоох арга замыг олж тогтоох зэрэг манай үеийнхний тулгамдсан зорилгын хэрэгжилтэд чухал хувь нэмэр оруулах үндэстэй юм. Барууны боловсролын салбарт хувь хүний хөгжил арай өөр түвшинд яригдах болж их сургуулиуд, онцгойлон дурдвал Стэнфордын их сургууль тэргүүтэй томоохон их сургуулиуд бясалгалын хөтөлбөртэй болж байна. Эдгээр нь ухамсрын бясалгал болон төвлөрлийн бясалгал ба энэ нь хүнийг оршихуйгаа ухамсарлах, зөв сэтгэлийг хөгжүүлэх, төвлөрлийг нэмэгдүүлэх гэх мэт чухал ач холбогдолтой гэдгийг ч эрдэмтэд хүлээн зөвшөөрсөн. Хүн асар их эрдэм мэдлэг хураагаад түүнийгээ буруу зүйлд ашиглах тохиолдол байдаг нь өнгөрсөн зуунд болсон дэлхийн томоохон үйл явдлуудтай ч холбогдох бөгөөд үүнийг тухайлан ил задгай тоочихыг урьтал болгосонгүй.

Гагцхүү тэр боловсрол хэмээх зүйлийн утга өөрчлөгдөж зөв мэдлэг, зөв аж төрөх ёсонд суралцаж хүний оронд өөрийгөө тавьж бусдыг ойлгох, энэрэнгүй сэтгэлээр аливаад хандах, эерэг үзэл, хамтарч ажиллах чадвар гэх зэргийг чухалчилан авч үзэх болоод байна. Нөгөөтэйгүүр ёс суртахууныг зөвхөн шашинтай холбож авч үзэх нь хэтэрхий явцуу байх талтай юм. Хүний өөрийн төрөлх зөн муу гэхээс илүү сайн, аюулгүй нөхцөлд илүү татагддаг ба амьдралын төлөөх эрчим хэн бүхэнд байдаг. Тийм ч учраас амьдралынхаа явцад энх тайвныг хүсэж байдгаараа дийлэнх хүн адилхан байдаг. Ёс суртахуун бол бидэнд хүссэн тэр зүйлийг бэлэглэх гол түлхүүр болж байх учиртай. Ёс суртахууныг өөртөө төлөвшүүлснээр гоо зүйн үнэлэмжийн чиг баримжаа өөрчлөгдөх төдийгүй экологийн хямралтай холбоотойгоор гэмээ ухаарах, эзотерик психологийг тууштай зөвшөөрөх нөхцөл бүрдэнэ. Жишээ нь “шилдэг брэнд” гэдэг эдүгээгийн ойлголтын агуулга нь бүтээгдэхүүний хэрэглээний үнэ цэнээс гадна хайрцаг сав, баглаа боодлын чамирхал, сайхан мэдрэмж төрүүлэх үзүүлэлт зэргийн тухай мэдлэгээр нэлээд тодорхойлогдож байна. Тэгвэл орчин үед үрэлгэн, сүйтгэгч үйлдвэрлэлийг өөгшүүлдэг ийм гоо зүйн

үнэлгээг зогсоож, оронд нь байгалийг хайрлах, хамгаалах ёс суртахуун тансаглалаас урьд ухаалаг аж төрөх зэргийн шаардлагад нийцсэн тийм гоо зүйн мэдрэмжийг хүн төрөлхтөнд төлөвшүүлэх бололцоотой юм.

Аливаа зүйл цаг хугацааны шалгарлыг даван туулсны үндсэн дээр өөрчлөгдөх, хөгжих эсвэл асар буруу тийш чиглэх хандлагатай байдаг. Тиймээс аливаа зүйлийн өөрийн үйлдэл болон өөр бусдын нөлөөнд үүсэх тэрхүү үйлдлийг нарийн тооцоолсны үндсэн дээр нийтээр даган дууриаж байх учиртай. Өнөө үе бол нийт хүн төрөлхтний хувьд анхааралтай байх ёстой чухал үе мөн. Монголчуудын хувьд ч мөн тийм. Сүүлийн жилүүдэд дэлхий нийт даяаршиж, соёлын харилцааны хувьд тун ойртох хандлага үүсэж байгаа. Нэг талаар энэ нь сайшаалтай зүйл боловч ондоошил гэдэг зүйлийг бид орхигдуулж болохгүй. Ялангуяа Монголын боловсролын салбарт түүх, ёс уламжлалын талаар тайлбарлан таниулах түүгээрээ бахархаж сурахад чиглэсэн үйл ажиллагаа хөтөлбөр байвал их зүгээр юм шиг санагддаг.

Өнгөрснийг эзэлсэн хүн өнөөдрийг эзэлдэг гэдэг үг байдаг даа. Үнэнхүү утга нь улс төрийн ч юм уу эзэгнэх гэх мэт утгыг илэрхийлээгүй бололтой. Энэ нь өөрийгөө эзлэх, өөрийнхөө үнэт зүйл, үзэл санаандаа эзэн байх гэсэн утгатай болов уу. Гэхдээ энэ өөрсдийн үзэл санаа, үүх түүхээ эзлэхийн өмнө үнэн багтай эх сурвалжаас жишиг аван, тодорхой хүрээ хязгаарыг тогтоож зөв системтэйгээр судлахгүй бол нягтруулах учиртай зүйл бас олон харагддаг.

Энэхүү бичвэрийн хүрээнд хүнлэг энэрэнгүй боловсрол ба Монгол түүх уламжлалаа оюутан залуусдаа зөвөөр сурталчлан таниулах тухай оруулсан нь эдгээр зүйлсийн нягт холбоог бид сайтар судлаж боловсролын салбартаа чухал нэг дэвшил авчрахыг хүсдэг залуус, судлаач бүхний хүсдэг тэр зүйл мөн байхаа гэдэгт итгэлтэй байна.

Хүн өөрийн ухамсарт амьдралдаа дан ганц өнцөгөөс харж, дан ганц хатуу онол барьж өдөр тутамдаа амьдардаггүй. Бид тэнгэр лүгээ харж, инээж, бодож заримдаа буруу үйлдэл ч хийдэг. Амьдралыг нэг л өнгөөр бид хардаггүйн адил нэг л өдөр бүх зүйл ч өөрчлөгддөггүй. Удаан хугацааны туршид хичээл зүтгэлийн үр дүнд хүн сая арай аливаад дөртэй болох нь бий. Тиймээс чөлөөт сэтгэлгээг эрхэмлэж, амьдралыг эерэг сайн сайхнаар харах өнцгийг нь бид бусдадаа хүлээн зөвшөөрч үүх түүхээрээ бахархдаг хүнлэг энэрэнгүй саруулт ухаант Монгол хүн бас дэлхийн ухаалаг иргэнийг бэлтгэх нь бидний боловсролын гол утга учир нь байх болов уу. Бид түүгээрээ ч бусдад үлгэр дууриал болох учиртай.

Цаг цагаараа байдаггүй...



**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ФИЛОСОФИ ХӨТӨЛБӨРИЙН АХИСАН ТҮВШНИЙ ОЮУТАН
Г.ХОНГОРЗУЛ**

БОЛОВСРОЛ ДАХЬ БАГШИЙН НӨЛӨӨ

Маурис Крафт (1984) “education” гэх үг нь латин хэлний сургах (to train), хэлбэржүүлэх (to mold) гэсэн утгатай “educare” болон чиглүүлэх, эхлүүлэх (to lead out) гэсэн утгатай “educere” хэмээх 2 өөр үндэстэй болохыг дурджээ. Ийнхүү боловсролын талаарх маргааны дийлэнх нь этимологийн суурьтай бөгөөд эсрэгцэх байр суурийн нэг талд түүнийг мэдлэг хадгалж, өвлүүлэх, залуу үеэ эцэг эхийн адилаар төлөвшүүлэх байдлаар авч үздэг бол нөгөө талд залуу үеийг хожим тулгарах асуудал, бэрхшээл, өөрчлөлтөд бэлтгэх байдлаар авч үздэг болохыг Рандалл В.Басс, Ж.В.Гүүд нар (2004) онцолсон байна. Шэффлер (1973) боловсролын гүйцэтгэх үүргийг сурагчийн оюун санааг хэлбэржүүлэх байдлаар ойлгохоос таггалзаж, харин ч тэдний оюун санааг чөлөөлөх, шүүмжлэлт эргэцүүлэх чадварыг нь бэхжүүлэх, мөнхүү мэдлэг хийгээд бие даан судлах чадамжийг нь хөгжүүлэхүй байх хэрэгтэй хэмээж байв. Харин миний бие боловсролын зорилго нь мэдлэгийг дамжуулах, шүүмжлэлт сэтгэлгээ, асуудлыг шийдэх чадварыг хөгжүүлэх болон бусадтай зохистой харьцах, өөрийн үнэт зүйлийг тодорхойлох хийгээд бусдын үнэт зүйлийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэлтэй хандах, үүрэг, хариуцлагаа ухамсарлах зэрэг хандлагыг бий болгож, төлөвшүүлэхэд чиглэдэг хэмээн үзэж буй бөгөөд түүнийг хэрэгжүүлэх сургагчийн үүрэгт анхаарал хандуулан бичихийг зорьсон болно.

Хүүхэд насандаа олж авсан туршлага минь харьцангуй бага бөгөөд хэт их хараа хяналттай эцэг эх, найз нөхөдгүй байдал намайг зожиг нэгэн болоход ихээхэн нөлөөлсөн. Удаан хугацааны туршид өөртэйгөө тэмцэлдсэний дүнд одоо л бусадтай илүү танил болж, аюулгүй мэдрэмж авсны дараагаар бодлоо илэрхийлж сурч байна. Онц сурлагатан биш атлаа тийм янзаар л бусдад үзэгдэж, утга учрыг нь ойлгож, судалж үзэлгүй л цээжилж, тогтоож явсаар оюутан насандаа шүүмжлэлт сэтгэлгээ гэх зүйлтэй танилцсан юм. Ном унших тусам уншсан бүхнээ харалган байдлаар шууд хүлээн авахаа больж,

шүүж, шийдэж эхэлсэн би философийн текстүүд уншихдаа зохиогч нь ямар байр суурь баримталж бичсэн, бусад онолуудтай хэрхэн холбогдохыг олж харахыг хүсдэг болов. Тэгэхээр, дээр дурдсан мэдлэг, чадвар, хандлага нь бие биеэсээ тусдаа бус, харилцан уялдаа холбоо бүхий байдлаар хөгждөг бөгөөд тэрхүү нарийн холбоог анзаарч ойлгосон сургагчийн (educator) мэрийлт, арга барил нь онцгой ач холбогдолтой болохыг боловсролын албан болон албан бус хэлбэрийн хүрээнд авч үзье.

Албан бус боловсролыг гэр бүл, орчин тойрноосоо олж авдаг тул хүүхдийн анхны сургагч болох эцэг эх буюу асран хамгаалагчийн гаргадаг түгээмэл алдаа, дутагдлыг анзааран харъя. Нэгдүгээрт, хүүхдэдээ зааж өгөөгүй зүйлдээ унтууцах нь элбэг бөгөөд бидэнд энгийн, ойлгомжтой, хялбар, өчүүхэн санагддаг зүйл бусдад тийм биш байх боломжтойг ойлгох хэрэгцээ шаардлага байсаар байна. Аль хэдийн туршлагаараа олж авсан зүйлээ (тэр бүр хүүхдэд ээлтэй, зохистой аргаар биш боловч) ямар аргаар олж авахыг хүссэн, тухайн чиглэлд судлагдсан аргуудаас аль нь зохистой, тийм л аргаар олгох явдал нь магад бидний үр хойчийнхоо төлөө хийж чадах зүйл болов уу. Жишээлбэл, хурдан унтахыг тулган шаардахын оронд булчингуудаа суллаж, бодолд хэт авталгүйгээр унтахад туслах аргуудыг хайн судалж, зааж өгөх нь хэтдээ нойргүйдэлд өртөх магадлалыг нь бууруулж, зөв хэмнэлтэй амьдрахад нь туслалцаа үзүүлнэ хэмээн бодном. Хоёрдугаарт, хүүхдээ юу ч мэддэггүй, жаахан хэмээн үзэх нь тухайн хүүхдийн танин мэдэхүйн чадвар хөгжих үйл явцад томхон шиг хаалт хийж буйтай адил болохыг ойлгохгүй явдал их. “Туравхан настай хүүхдүүд юу гэж ном унших вэ дээ”, аль эсвэл “Чи юугаа мэдэх вэ дээ” хэмээн хэлэх эцэг эхийг харах үед хүүхэд бага сартайгаасаа л ном уншуулах дуртай байдгийг (гагцхүү хүүхдийн хөгжлийн аль шатанд ямар номыг яаж уншиж өгөх аргыг мэдэх нь чухал), тэдэнд тайлбарласаар байвал олон зүйлсийн талаар

эргэцүүлж, бүр хариултаа ном, интернэт ашиглан өгөх шаардлагатай бэрх асуултууд ч асуудгийг мэдэх би хүүхдүүдийг нь өрөвдөх сэтгэл төрсөн юм. Сургах үүрэг гагцхүү багшид оногдсон хэмээн сэтгэх тэдгээр хүн өдөр тутам хэлэх үг, хийх үйлдэл нь угтаа хүүхдэд сургасаар буйг ойлгохгүй байгаа нь үүргээ ухамсарлахуй, рациональ байдлаар сэтгэхүй нь хөгжөөгүйн шинж. Платоны агуйн ёгтлолоор зүйрлэвээс агуйгаас гараагүй хүн хэрхэн гаднах ертөнцийн талаар ярих билээ.

Албан боловсролыг бид цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль болон их сургуулийн хүрээнд олж авдаг тул энд багш нар чухал үүрэгтэй. Өөрийн туршлагаасаа дүгнэн хэлбээс ойлгуулалгүйгээр цээжлүүлэх, судлуулалгүйгээр итгүүлэх явдал нь дийлэнх багш нарын гаргадаг том алдаа болов уу. Ном дээрх текстийг хуулж бичдэг, цээжлээд эргүүлж ярьж өгдөг, аль эсвэл зургийг нь хуулж зурдаг байсан бидэнд шүүмжлэлт сэтгэлгээ бус магад түүнтэй эсрэгцэх дуулгавартай, номхон, дуураймтгай байдлыг бий болгож, хий хоосон “онц сурлагатан”-ыг үйлдвэрлэхүйд чиглэдэг байсан гэхэд хилсдэхгүй. Дуулгавартай байдал нь сургагчийн хувьд амар тайван орчныг бий болгодог нь гарцаагүй. Харин хэтдээ хүүхдийн сониуч зан, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх нь асар ач холбогдолтойг ухааран, боловсролын үйл ажиллагаанд тусгах зайлшгүй шаардлага байсаар байна. Ийнхүү үзвээс багш хүн гагцхүү өөрийн сурсан, аль эсвэл сурах бичигт бичиж үлдээсэн мэдээллийг л дамжуулагч биш ажээ. Түүнчлэн, олж мэдсэн бүхнээ бусдад тэр чигт нь наах нь дэндүү механик. Бусдад тулгарч буй сорилт, бэрхшээлийг энэрэн мэдрэх симпатиагаас (sympathy) илүүтэйгээр мэдрэмжийг нь ойлгож, хуваалцах чадвар болох эмпати (empathy) багш хүний эзэмшсэн байх хэрэгтэй онцлог чадваруудын нэг байх. Учир нь

багшийн хандлага сурагчдад нөлөө үзүүлдэг байх боломжтой. Тухайн хичээл суралцагчдад хэр үр өгөөжтэй хүрч байгааг анзааран, эргэн өөртөө рефлекс хийж, хүртээмжтэй, бүтээлч байдлаар заах арга зүйг эрэлхийлэх нь эргээд суралцагчдын чадварыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Энд л боловсролын үр нөлөө оршиж байж мэдэх юм. Дуглас Яасек, Кайлум Ижаз (2020) нарын үзсэнээр боловсролд хувирган өөрчлөх чадвар бий хэмээн хүн төрөлхтөн итгэдэг, тиймээс ч сургалтын анги танхимд сургагч багшийн мэрийлт нь суралцагчдын дотоод хүчин чадлыг нээн хөгжүүлэхэд чиглэсэн байх хэрэгтэй.

Боловсрол хэзээ ч дуусдаггүй гэдэг. Тэр утгаараа бид хэзээ нэг цагт илүү дээр, боловсронгуй нийгмийг цогцлоож чадна хэмээн өөдрөгөөр харж ч болох юм. Гэхдээ энэ нь одоо буй асуудлуудыг үл тоон, хэт өөдрөг үзлээр өөрийгөө хууран далдалж, шийдвэрлэх, хүчин чармайлт гаргахаас зайлсхийнэ гэсэн үг биш. Нийгмийн аль ч түвшинд, насны хязгаарлалтгүйгээр боловсрох хэрэгцээ шаардлага тулгамдсаар байна. Нэг л сургагч өөрт байгаа хувирган өөрчлөх чадварыг ойлгон, үйлдэл хийж эхлэхэд эргэн тойрон дахь хэд хэдэн хүнд нөлөөлөх боломжтой. Боловсрол олгох гэж зорьж буй хүн өөрөө боловсорсон байх шаардлагатай бөгөөд үүнд өөрийн хяналт, бусдыг энэрэх сэтгэл, тууштай судлах эрмэлзэл, сэтгэлийн хат, рациональ сэтгэлгээ багтдаг гэж бодож байна. Түүнчлэн боловсорсон байна гэдэг нь бүрэн төгс болж, гүйцсэн гэсэн үг биш, гагцхүү заадаг бус, бусдаас мөн суралцдаг, өөрийн мэддэг гэж боддог зүйлдээ эргэлздэг байх хэрэгтэй. Энэ бүх чадвар, хандлагыг бид олон эх сурвалж, туршлагаас хуримтлуулж, шүүн тунгаах замаар олж авах бөгөөд хүний өөрөө шийдвэр гаргах чадвар магадгүй хамгийн суурь чадвар болдог болов уу хэмээн бодном.



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ФИЛОСОФИЙН III ТҮВШНИЙ ОЮУТАН
Д.УРАНЗАЯА

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ МИНИЙ БОДОЛ

Намайг Д.Уранзаяа гэдэг. Би Хэнтий аймагт төрж бага балчир үеэсээ л надад тусалж намайг дэмжиж миний авьяас чадварыг үнэлдэг аав ээж,

багш, найз нөхдийн дунд өөртөө итгэлтэй, сурч боловсрох хүсэлтэй бие хүн болон төлөвшсөн. Тиймээс ч одоо Монгол улсын их сургуульд

философи хөтөлбөрт элсэн суралцаж өөрийн үзэл бодлоо илэрхийлэх боломж олдож байгаад би баяртай байна. Би өөрийн боловсролын тухай сэтгэгдлээ бичихдээ хэд хэдэн удаа шинээр эхлүүлээ. Анх өөрийн боловсролын тухай бодол, суралцах явцад тулгамдаж буй асуудлаа бичих гэж байсан ч харин сүүлд нь үнэхээрийн бичмээр байгаа зүйл маань надад боловсрол эзэмшихэд тулгамдаж буй асуудал биш өөр бусдад тулгамдаж ч байж болох асуудлын талаар болон боловсролын тэгш байдлын талаар бичихийг хүслээ.

Хүн бүрийн өссөн орчин, гэр бүлийн харилцаа, бие бялдрын хөгжил, оюун бодол өөр байдаг шүү дээ. Гэсэн хэдий ч түүнээс үл хамааран бүхий л хүүхдэд танин мэдэх хэрэгцээ байдаг. Үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд сурах арга барил эзэмших хэрэгтэй болдог. Манай орны хувьд хүүхдийн танин мэдэх хэрэгцээг харгалзан сургуулийн өмнөх боловсрол, бага, дунд болон ахлах ангийн боловсрол олгохыг хуульчлан заасан байдаг. Тиймээс хүүхдийн энэхүү танин мэдэх хүсэл нь багшаас зөвхөн онолын мэдлэгээс гадна асуудлыг ойлгож мэдрэх, энэрэх буюу аливааг хийе гэх сэтгэл хандлага болон үүнийгээ үйлдэл болгох оролцох чадваруудыг суралцах шаардлагатай болгож байна. Иймээс багш хүн өөрөө төлөвшсөн, өөрийн эрхэлж буй үйл хэрэгтэй мэргэшсэн, хүсэл тэмүүлэлтэй байх хэрэгтэй болж байна.

Сайн багш гэж чухам хэн бэ? гэх асуултын хариулт энэ байж болох юм. Цэцэрлэгт байх үеэс минь л ангийн багш маань нийгмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулж миний суурь чадваруудыг сайтар хөгжүүлжээ гэж боддог. Тиймээс ч ерөнхий боловсролын сургуульдаа орсон цагаасаа эхлээд сэргэлэн цовоо байж урлаг, спорт, хичээлийн олон үйл ажиллагаанд амжилттай оролцсоор ирсэн. Өнөөдрийн өөрт байгаа эрдэм мэдлэгийг олж авах нь саад бэрхшээлгүй байгаагүй ч багш нарынхаа тусламжтайгаар суралцахуйн тэрхүү үйл явцыг даван туулсаар ирсэн. Гэвч надад байсан шиг энэ боломж хүүхэд бүрт байна уу гэвэл үгүй байгаа юм. Сайн багшийн шавь болох нь аз шиг зүйл биш байгаасай гэж хүсэж байна. Намайг чиглүүлж зөв төлөвшилтэй болоход минь


чиглүүлсэн шиг тийм багш нар олон байгаасай. Яагаад гэвэл сурч боловсрох нь бидний үндсэн эрх шүү дээ.

Мөн хүүхэд бүрийн зан ааш, хувийн чадвар өөр байхаас гадна хувийн болон нийгмийн шалтгаанаас үүдэн сурч хөгжих үйл явцад нь бэрхшээл тохиолдож байгаа хүүхдүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэж тодорхойлдог. Тиймээс ч тэдэнд шаардлагатай тусгай хэрэгцээт боловсролыг ч бас анхааран авч үзэж, бидний бодлыг сонсож байгаа шигээ тэднийг ч бас орхигдуулалгүй тулгарч буй асуудлуудыг нь шийдвэрлэж, цаашдын боловсролын системийн шинэчлэлт алхмууддаа анхааран тусгаж өгөөрэй гэж Таниас гуймаар байна

Бид бусдад хүлээн зөвшөөрөгдөж, хүндлэгдэж сурч боловсрох эрхээ эдлэж байгаа шиг бусад хүүхдүүд ч бас энэхүү эрхээ эдлэх хэрэгтэй. Бид аливаад өөрчлөлт шинэчлэлт хийхдээ нэг хэсгийг орхигдуулвал энэ эсрэгээрээ ухралт болох байх гэж бодож байна. Хэдий бид нийгмийн бүхий л асуудлыг шийдвэрлэж чадахгүй ч гэсэндээ сургалтын орчинд эрх тэгш хүлээн зөвшөөрөгдөж, боловсрол эзэмших хэрэгтэй. Тэдэнтэй нийгмийн харилцаанд орох арга хэлбэрүүдийг ч мөн би сурч мэдмээр байна

Намайг дунд ангид суралцаж байхад амьдрах ухаан гэх хичээл ордог байсан. Энэхүү хичээлийн цаг дээр бид өөрсдийгөө танин мэдэх хичээлээс гадуурх үйл ажиллагааны санаагаа дэвшүүлэн анги хамт олондоо хэрэгжүүлэх боломж олдоог байсан. Магадгүй энэхүү хичээлийн хөтөлбөрт аутизмтай хүүхэдтэй хэрхэн харилцах вэ? гэх зэрэг зүйлсийг оруулж ирэх юм бол хөгжлийн ямар нэг бэрхшээлтэй хүүхдүүдтэй харилцах аргад суралцан цаашлаад нэг анги танхимд хамтдаа суралцаж нийгэмд ч гадуурхал багасах болов уу? гэж бодож байна.

Боловсрол эзэмших, шинэ зүйлсийг судлах нь амар хялбар үйл явц биш гэсэн хэдий ч өөрийнхөө юуг мэдэхгүйгээ мэдэх тэр мэдрэмж, толгой нуруу жаахан өвдөх ч аливаад шимтэн суралцаж шинийг гайхан бодохын сайхныг хүн бүр мэдрээсэй. Боловсрол гэдэг мэргэжлийн диплом төдийгүй эрүүл зөв сэтгэхүй, хандлага, шүүн тунгаах ухаан, шинийг мэдэх хүсэл болоод зөв төлөвшил, аливааг энэрэн хайрлах сэтгэл билээ.





**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ФИЛОСОФИ ХӨТӨЛБӨРИЙН АХИСАН ТҮВШНИЙ ОЮУТАН
Д.НОМИН**

БОЛОВСРОЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Боловсролын тухай сэдэв бол улс орон бүрийн санаагаа чилээх хэрэгтэй, дэлхий нийтийн томоохон чухал асуудлуудын нэг билээ. “Ирээдүйг харахыг хүсвэл түүхийг унш” гэх үг байдаг шиг, аливаа асуудлыг ойлгож, түүний талаар цогц ойлголттой болохыг зоривол ТҮҮХИЙН ТУРШИД аль цаг үед ямар асуудал онцлог байсан, тэр нь хэрхэн дараа үедээ, нөхцөл байдалдаа өөрчлөлт, сайн муу нөлөөллийг авч ирсэн талаар тодорхой утгаар түүх рүү хандаж үзэх хэрэгтэй санагдлаа. Жишээлбэл:

Өрнө дахинд:

- Месопотам, Египет (МЭӨ 2900 орчимд) зэрэг иргэншлүүдэд одоогоор олоод буй анхны бичгийн системийг хэрэглэж байсан учир харьцангуй тухайн ард түмний бичигдсэн түүхээс боловсролын асуудалд хэрхэн хандаж байсныг баримтуудаас таамаглах бололцоо үүссэн байна. Эдгээр соёл, иргэншлүүдэд анагаах ухаан, тоо тооцоолол, одон орон, барилга байгууламж өнөөгийнхөөр инженерийн сэтгэлгээ болоод мэдлэгтэй түүнийгээ хэрэглэж ашиглах, тайлбарлах чадвартай хүмүүсийг боловсролтой хүн хэмээн үздэг байсан байна.

- Эртний Перс, Визант, Грек, Ромын эзэнт гүрэнд бичиг үсэг, заримд нь урлагийн боловсрол яруу найраг, бие бялдрын хөгжил (Спарт), ёс суртахуун зэрэг агуулгыг илүү эрхэмлэдэг боловсролтой хэмээн бусад эрдэм, ухаанаас илүүд үзэх хандлагатай байсан байна.

Дорно дахинд:

- Эртний Инд мөрний соёл иргэншил, Эртний Хятадын соёл, иргэншил зэрэг дорно дахины эртний суурин соёлуудад бичиг, тэмдэглэл байдлаар өнөөг хүртэл үлдсэн түүхийн баримтуудаас тухайн ард түмнүүдийн өөрсдийнх нь болоод ойр харилцаа холбоотой байсан улс орнуудынхан шашин шүтлэг, ертөнцийг үзэх үзэл, хэл соёл, төрт улс зэрэг тухайн үеийн бодит байдлын талаарх мэдээ сэлтийг барагцаалж харах боломжтой. Тэдгээрээс

үзвэл Хятадын анхны төрт улс Шан улсын үед ертөнцийн талаарх болон ёс суртахууны талаарх сэдвүүд хүмүүсийн харилцаа хандлага, зан үйл, хөгжим зэрэг агуулгатай холбогдож чухлаар авч үздэг байв. Жоу улсын үед гэхэд ёс суртахуун, зурхайн ухаан, амьдралын (Ин, Янь) тэнцвэрийн ойлголт, Хавар намар, Байлдаант улсын үед Күнз, Лаозын сургаал номыг мэддэг, түүнийг тайлбарлаж чаддаг, зарим тохиолдолд цээжилсэн хүн төрийн албаны шалгалтыг тэдгээр гол ном зохиолуудыг мэддэг гэдгээ шалгуулж орох зэргээр боловсролын системтэй үйл ажиллагааг боловсруулан ажиллаж байсан болохыг түүхээс харж болохоор байдаг.

- Эртний Энэтхэгт Хөдөө аж ахуйн чадвар, өөрсдийн шүтлэгийн олон бурхадын талаарх (шашны төрлийн мэдлэг) зонхилж байгаад Хиндү шашны ойлголт Брахман түүний дуулал, яруу найраг, бясалгал, даян хийдэг ухаантан мэргэд зэрэг хүмүүсийг дээд кастын хүмүүс ариун эрхэм хэмээн үздэг хандлага байсан. Мөн түүнчлэн философи мэдлэг, ёс суртахуун, хууль хэв журмын мэдлэг чадвартай хүмүүсийг боловсролтой хэмээн үздэг байжээ.

Харин орчин үед улс орнууд, тэр тусмаа Монголчууд бид Японы боловсролын системийг нэлээд зөв ХҮН-дээ төвлөрсөн оновчтой тогтолцоо гэж үзэж байгаа хандлага ажиглагдсан. Энэ талаар Японы боловсролын түүх судлаач, өөрөө мөн сургууль удирдаж ажилладаг Окита Юкүжи профессорын олон жилийн судалгааны агуулгыг багтаасан “Япончуудыг бүтээсэн боловсрол” бүтээлдээ Япон улсын боловсролын тогтолцоо хэн нэгэн сайн бодлого хэрэгжүүлээд хөгжсөн биш болохыг маш ойлгомжтойгоор тод томруун харуулсан байсан. Харин ч энэ ард түмний амьдралыг туулсан олон жилийн туршлага, соёл, түүнийгээ дараа үедээ өвлүүлэн үлдээх тэр урт удаан үйл явцтай ихээхэн холбоотой болохыг, мөн ямар чиглэлд хөгжих хүсэл алсын зорилго шийдэж

байгааг “Япон зүрх, Барууны тархи” зэрэг чиг шугамаа хэрхэн тодорхойлсон болохоос санаа авч болох. Харин ч бүр Эдогийн үеийн (1603 - 1868) Япон орон 260 орчим жил дэлхийгээс хаалттай байсан үедээ илүү төлөвшиж өөрсдийн бусдаас ялгарах онцлогоо танин мэдсэн байна.

Миний санал:

1. Тэгэхээр манай улс боловсролын асуудлаа бодлогын түвшинд авч үзэхийн тулд эхлээд маш сайн ойлголтыг тодруулах судалгаа хийх хэрэгтэй санагдаж байна. Улс орнууд аль цаг үед ямар ямар асуудал боловсролын төв асуудал нь байсан, түүнтэйгээ холбоотой ямар бодлого хэрэгжүүлсэн, тэр бодлого амжилттай хэрэгжихэд хүмүүст юу гол нөлөөлсөн байж болох ... зэрэг Дэлхийн улс үндэстнүүд түүхийн туршид боловсрол гэдэгт юу юуг хамааруулан ойлгож ирсэн болохыг тодруулах үйл ажиллагаа хэрэгтэй санагдаж байна.

2. Монгол улсад түүхийн туршид боловсрол гэх утгаар юуг ойлгож байв? Тэр нь илүү амьдралд чиглэсэн практик ач холбогдолтой байна уу? Гэтэл энэ чадвар ухааныг дэлхийд юуг боловсрол гэж ойлгож байгаатай нийцүүлэхэд ямар зүйл дутагдалтай байна вэ? (Хэлний асуудал, академик хэлбэр, судалгаа, эдийн засгийн нөөц боломж ... зэрэг яаж, хэрхэн нөлөөлж байна)

3. Бидний алсдаа бүтээхийг зорьж буй зүйл юунд чиглэж байгаагаа тодруулах хэрэгтэй санагдаж байна. (Хүмүүжил, хандлага, сэтгэлгээ, ёс суртахуун, мэдлэгийн цар хүрээ – энэ агуулгадаа юуг хамааруулах нэн чухал, мэдлэгээрээ бусдад хэрэгтэй, бусдын амьдралд үнэ цэнийг бүтээх зүйл яаж хийх, бүтээхэд чиглүүлэх ... өөрөө хийх ур чадварт сургахад чиглэх эсэх ...)

Миний бодлоор эдгээр асуудлыг тодруулах явцад анхны энэ асуудал илүү оновчтой гарч ирэх юм шиг санагдаж байна.

ТЭМДЭГЛЭЛ

A large rectangular area with horizontal ruling lines, intended for writing a summary. The lines are evenly spaced and cover the majority of the page below the title.



9 789919 900465